

# ПРАКТИК ХРИСТИТГЭЛИЙН АМЬДРАЛ

Shepherds Global Classroom нь дэлхий даяар өсөн нэмэгдэж буй христитгэлт удирдагчдад зориулсан сургалтын хөтөлбөрөөр дамжуулан Христийн Биенийг сургаж бэлтгэх зорилготой үйлчлэл юм. Бид дэлхийн улс орон бүрийн сүнслэг сургагч багш нарын гар дээр 20 курс хөтөлбөрийг хүргэх замаар тухайн орон нутаг, уугуул иргэдийн сургалтын хөтөлбөрийг олшруулж нэмэгдүүлэхийг зорьж байна.

Энэхүү хичээлийг дараах холбоосоор үнэгүй татаж авах боломжтой: <https://www.shepherdsglobal.org/courses>

Курс хичээлийг боловсруулсан: Dr. Stephen K. Gibson

Зохиогчийн эрх © 2021 Shepherds Global Classroom

Англи хэл дээрх Эхний хувилбараас монгол хэлнээ орчуулсан Л. Амартүвшин, А. Ариунаа

Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Гуравдагч талын материалууд нь тус тусын зохиогчийн эрх болон зөвшөөрөлтэй.

Бүх эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи 2019 хувилбараас ашиглав.

### **Зөвшөөрөлтэй холбоотой заавар:**

Дараах зааврын дагуу энэхүү курс хичээлийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэ төлбөргүйгээр хэвлэж, тараах боломжтой. Үүнд: (1) Хичээлийн агуулгыг ямар ч байдлаар өөрчилж болохгүй; (2) Олшруулж хэвлэхдээ ашгийн төлөө зарж болохгүй; (3) Боловсролын байгууллагууд сургалтын төлбөр авч болох ч энэхүү хичээлийг үнэгүй ашиглах/олшруулж хэвлэх боломжтой; (4) Shepherds Global Classroom байгууллагын зөвшөөрөл, удирдамжгүйгээр хичээлийг орчуулж болохгүй.

# Гарчиг

Ангийн удирдагчдад зориулсан зөвлөмж .....	5
(1) Христитгэлийн үнэнч байдал .....	7
(2) Бурханд дуулгавартай байдлыг хэрэгжүүлэх нь .....	19
(3) Ажил .....	29
(4) Харилцаа .....	39
(5) Бурханы удирдамж .....	49
(6) Гэрлэлтийн талаарх Библийн үзэл баримтлал .....	59
(7) Гэрлэлтийн ариун нандин байдал .....	69
(8) Христитгэл ба байгаль орчин .....	83
(9) Мөнгө .....	89
(10) Шударга байдал .....	101
(11) Хүмүүний үнэ цэн .....	111
(12) Төр засаг .....	123
(13) Итгэгч хүний бие махбод .....	131
Санал болгох эх сурвалжууд .....	141
Даалгаврын тэмдэглэл .....	143



## Ангийн удирдагчдад зориулсан зөвлөмж

Хэрэв та бүлгээр суралцаж байгаа бол материалыг ээлжлэн уншиж болно. Ингэхдээ үе үе зогсож, хэлэлцүүлэг хийгээрэй. Ангийн удирдагчийн хувьд та судалж буй материалаас гадуур яриа өрнүүлэхгүй байхад анхаарах үүрэгтэй. Хэлэлцүүлэг бүрд тодорхой хугацаа зааж өгөх нь тустай.

**Хэлэлцүүлгийн асуултууд** болон **ангийн үйл ажиллагааг** ► тэмдгээр тэмдэглэсэн. Хэлэлцүүлгийн асуултуудын хувьд, ангийн удирдагч асуултыг асууж, суралцагчид хариулах боломжийг олгоно. Хэрэв нэг суралцагч л голдуу анхны хариултыг өгч, бусад нь ярьдаггүй бол удирдагч асуултыг өөр хүнээс асууж чиглүүлнэ.

Курс хичээлд **Бичвэрийг** маш өргөн ашигладаг. Ангид чангаар унших хэрэгтэй Бичвэрийн эшлэлүүдийг ► тэмдгээр тэмдэглэсэн бөгөөд суралцагчаас бүлэгт хандан уншиж өгөхийг асуугаарай. Хаалтанд өгөгдсөн бусад Бичвэрийн эшлэлүүд нь текстэд өгүүлж буй санааг дэмжих бөгөөд эдгээрийг хичээлийн явцад заавал унших шаардлагагүй. Жишээлбэл: (1 Коринт 12:15).

Хичээл бүрийн төгсгөлд **даалгаврууд** өгөгдсөн. **Даалгавруудыг** дараагийн хичээлээс өмнө биелүүлж, тайлагнах ёстой. Хэрэв суралцагч даалгавраа биелүүлээгүй бол дараа нь хийх боломжтой. Гэсэн хэдий ч, удирдагч суралцагчдыг хуваарийн дагуу хийхэд урамшуулснаар тэд ангид суралцах хичээлээсээ ихийг сурах боломжтой болно. Курсын төгсгөлд **даалгавруудаа** бүрэн хийснийг тэмдэглэх маягт хавсаргасан байгаа.

Энэхүү курсын нэг зорилго нь суралцагчдыг багш болоход бэлтгэх юм. Ангийн удирдагч нь суралцагчдад заах ур чадвараа хөгжүүлэх боломжийг олгох хэрэгтэй. Жишээлбэл, ангийн удирдагч нь хичээлийн богино хэсгийг үе үе суралцагчдаар заалгаж болох юм.

Хичээл бүрийн төгсгөлд бүлгээрээ хуваалцах чиглүүлэг өгөгдсөн байгаа. Ангийн удирдагч хэлэлцүүлгийн хугацаа ямар байхыг товлон. Олон хичээл суралцах материалтай холбоотой цөөнгүй хэлэлцүүлгийг багтаасан.

Түүнчлэн хичээл бүрийн төгсгөлд богино залбирал байх бөгөөд суралцагчид үнэнийг амьдралдаа хэрэгжүүлэхийн төлөө Бурханаас асууж залбирна. Ангийн удирдагч суралцагчаас ангид зориулаад залбирлыг уншиж өгөхийг асуугаарай.

Хэрэв суралцагч нь **Shepherds Global Classroom** байгууллагаас **гэрчилгээ** авахыг хүсвэл тухайн хичээлүүдэд хамрагдаж, **даалгавруудаа** бүрэн хийсэн байх шаардлагатай. Курсын төгсгөлд **даалгавруудаа** бүрэн хийснийг тэмдэглэх маягт хавсаргасан байгаа.



# 1-р хичээл

## Христитгэлийн үнэнч байдал

### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах ойлголт, чадварт суралцсан байна:

- (1) Библид өгүүлдэг 'ертөнц' гэдэг нь ямар утга учиртай болохыг ойлгох.
- (2) Хүний амьдралд нөлөөлдөг 'ертөнцийн' үнэт зүйлсийг таньж ялгах.
- (3) Итгэгч хүний бодол нь үл итгэгч хүнийхээс яагаад, мөн хэрхэн өөр байх ёстойг тодорхойлох.
- (4) Итгэгч хүн үнэнч байдлаар амьдрах нь юу гэсэн утгатайг тайлбарлах.
- (5) Амьдралын нарийн ширийн бүх хэсэгт христитгэлийн үнэн хэрэгжих ёстойг олж харах.

### Үнэнч байдлын номлогч Иохан Хрисостом

Иохан Хрисостом (НТ 370-аад он)<sup>1</sup> нь бурханлаг пастор байсан бөгөөд хүчирхэг номлол, илтгэх чадвараараа "алтан амт" хэмээн олны дунд алдаршжээ. Тэрээр эгэл ардын дунд хайрлагдсан, Зүүн Ромын Эзэнт гүрний хамгийн алдартай номлогч байв. 398 онд тэр нийслэл хот Константинопольд (одоогийн Истанбул, Турк) ирснээр 100'000 гаруй гишүүн чуулгантай үндэсний чуулганы удирдагч пастораар үйлчлэх болжээ.

Иохан бусдыг ялгаварладаггүй зан байдлаараа танигдсан нэгэн байлаа. Тэр ажлын өрөөгөө хотын нийт хүн амын төлөө үйлчилдэг газар болгосон юм. Тэр зөвхөн чинээлэг иргэдийн төлөө биш, ядуусыг хооллох, эмнэлэг байгуулах, бэлэвсэн эмэгтэйчүүдийг тэтгэх зэргээр үйлчилсэн. Тэр мөн авилгад автсан Бага Азийн пастор харгалзагчидтай нүүр тулж, тэдний ёс суртахуунгүй байдал, мөнгө санхүүг буруу захиран зарцуулж буй байдлын эсрэг тууштай номлож байв. Иохан Константинополь хотын язгууртнууд театрт ихээр очих болсныг сүйрэл хэмээн сэрэмжлүүлсэн. Театрт очих нь үхлийн вирусыг дэгдээх мэт хэмээн тэр харьцуулсан байдаг. Иохан хэлэхдээ,

Хэрэв чи театрт толгойгоо задгайлж, алтаар чимэглэсэн хувцас өмсөж, уян зөөлөн байдлаа гайхуулсан ичгүүргүй эмэгтэй тайзан дээр зоримог алхлан гарч ирээд, ёс суртахуунгүй дуу дуулахыг, хөлөө шидлэн гунхан бүжиж, ичгүүр сонжуургүй зүйлийг яривал... хүнд тохиолддог л зүйлээс өөр юу ч тэнд болоогүй гэж хэлэх үү?... Театрын хөшиг хаагдаж, хүмүүс гэртээ харьсны дараа тэдгээр дүр төрх чиний сэтгэлд амилж, тэдний алхаа, үг яриа, харц, байр байдал, эрээ цээргүй

<sup>1</sup> Gerald L. Sittser. *Water from a Deep Well*. (Downers Grove: InterVarsity Press, 2007), 135

хөдөлгөөн нь харагдсаар байх болно... чи тэндээс мянга мянган шархыг тээгээд гэртээ харина. Гэхдээ чи ганцаараа харихгүй. Янхан ил биш, үл үзэгдэх байдлаар чамтай хамт явна... ингэхдээ тэр чиний зүр сэтгэлд, мөс чанарт, чиний дотор Вавилоны зуухыг асаадаг... тэнд чиний гэр бүлийн амар амгалан, зүрх сэтгэлийн цэвэр ариун байдал, гэрлэлтийн аз жаргал чинь шатах болно!

Баян чинээлэг хотын иргэдэд Иохан сэрэмжлүүлж хэлэхдээ,

Та нарын шүүгээ дүүрэн хувцастай ч, Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн бидэнтэй адил хүмүүс гудманд нүцгэн зогсож, хүйтэнд дагжин чичирч зогсохыг зөвшөөрч байгаа нь мунхаглал, олон нийтийн солиорол юм... Чи тарган цатгалан, үдэш бүр сархад зооглон, дулаан хөнжил, зөөлөн орон дээр унтдаг. Та нар Бурханы бэлгүүдийг буруугаар ашигласныхаа хариуг хүртэнэ гэдгээ бодох болоогүй юу... Учир нь бид цуглуулсан байж болох ч, бидний мөнгө Эзэнийх юм. Тийм ч учраас танд ихийг байлгахыг Эзэн зөвшөөрчээ. Гэхдээ энэ бүхнийг та үрэхийн тулд биш, харин хэрэгцээтэй хүмүүст тараан өгөхийн тулд байгаа биш үү.

Иохан Хрисостом эцэстээ Хар тэнгисийн зүүн эрэг рүү хөөгдөж, улмаар замдаа насан эцэслэжээ (НТ 407). Амьсгал хураахын өмнөх түүний сүүлчийн үг нь "Бүх зүйлийн төлөө Бурханд алдар нь байх болтугай, Амен" гэжээ.

### **Библид өгүүлдэг 'ертөнц'-ийн талаар ойлгох нь**

Иохан 17-р бүлэг нь цовдлогдохынхоо өмнөхөн залбирсан Есүсийн залбирал юм. Энэ залбирал нь Түүний дагалдагчиддаа санаа тавьсан, агуу хайрынх нь илэрхийлэл байлаа. Тэрээр мөн элч нарын мэдээ сургаалыг хүлээн авах итгэгчдийн төлөө ч залбирсан (20-р эшлэл) бөгөөд үүнд өнөөгийн итгэгчид ч хамаатай.

► Нэг суралцагч Иохан 17:14-18 эшлэлийг бүлэгт уншина.

Есүс өөрийгөө энэ ертөнцийнх биш гэж хэлсэн нь ямар утга учиртай вэ? Тэр Бурханы Хүү байсан бөгөөд тэнгэрээс газарт ирснийг, анхнаасаа энэ дэлхийнх биш байсныг бид мэддэг. Гэсэн хэдий ч, Тэр өөрийгөө энэ ертөнцийнх биш гэж хэлэхдээ энэ дэлхийн гадна хаа нэгтээгээс ирсэн тухай хэлээгүй. Дагалдагч нарыг ч мөн адил энэ ертөнцийнх биш гэж хэлсэн юм. Харин Тэр газар дэлхий дээр, хүмүүн эцэг эхээс төрж, улс орныхоо иргэн болон өсөж хүмүүжсэн эрчүүдэд хандан үүнийг хэлж байна.

Тэгвэл дагалдагчид нь энэ ертөнцийнх биш гэж хэлсэн нь Есүсийн хувьд ямар утга учиртай вэ? Ертөнцийн талаар Библи юу өгүүлдгийг бид ойлгох хэрэгтэй.

► Нэг суралцагч Ефес 2:1-3 эшлэлийг бүлэгт уншина.

Эдгээр эшлэл ертөнцийнх шиг амьдрах нь Сатаны удирдамжийг даган амьдрахтай адил гэдгийг бидэнд харуулдаг. Түүнчлэн ертөнцийн хүмүүс нүгэлт хүслээ дагадаг бөгөөд Бурханы уур хилэнг хүртэнэ гэдгийг бид мэддэг. Итгэгч хүмүүс шинэ амьдралыг хүлээн авдаг бөгөөд цаашид ертөнцийнхөн шиг амьдрахгүй.

► Нэг суралцагч 1 Иохан 2:15-17 эшлэлийг бүлэгт уншина.

1 Иохан захидалд ертөнцийг бузар тогтолцоо гэж хэлсэн. Түүнийг болон түүнд байгаа зүйлсийг хайрлаж болохгүй гэж хэлсэн байна. Буруу хүсэл болон сэдлүүд нь ертөнцийн хувьд ердийн зүйл юм. Нүгэлт хүслийг ертөнцийн хүсэл тачаал гэж энд хэлсэн.

Сатаныг ертөнцийн захирагч (Иохан 16:11) гэж нэрлэдэг. Энэ нь яг үнэндээ ертөнц түүний мэдлийнх гэсэн үг биш юм. Тэр Бурханд тэрслэгчдийн удирдагч бөгөөд ертөнцийн хүмүүс түүнийг дагадаг. Тэр аль хэдийн ялагдсан бөгөөд түүнийг тууштай дагадаг хүмүүс ч мөн яллагдах болно.

Ертөнцийн найз байснаар Бурханы дайсан болдог (Иаков 4:4).

Ертөнц нь Бурханаас тусгаарлагдан унасан, нийтлэг зүйлээрээ нэгдсэн, сая сая хүмүүсээс бүрддэг. **Нэгд, тэдэнд буруу хүсэл сэдэл байдаг.** Тэд орчлон ертөнцийг Бүтээгчээс илүүтэй ертөнцийн зүйлсийг хайрладаг. 1 Иохан 2:15-16 эшлэлд “Ертөнц... бүү дурла... Учир нь ертөнцөд байгаа бүхэн тухайлбал, махбодын хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардамнал нь Эцэгээс бус, харин энэ ертөнцөөс ирдэг юм” гэжээ.

**Хоёрд, тэдний буруу хүсэл сэдэл нь буруу үйлдэлд хөтөлдөг.** Энэхүү амьдралын хэв маяг нь шударга ёс, өршөөл энэрлийг гаргуунд гаргаж, өөрийгөө сэтгэл хангалуун байлгахад төвлөрдөг (Амос 5:11-15; 21-24). Тэд хүсдэг зүйлээ шаардан, өөрсдийнхөөрөө зөв бурууг тодорхойлж, өөрсдийн замаар явдаг. Хэдийгээр тэдний шашин олон хэлбэртэй ч, ертөнцийн бүх хүн өөрсдийгөө шүтэж (хүний оюуны чадавхи, хүний мэргэн ухаан, хүний хүсэл сонирхол, хүний сайн сайхан, хүний хүч чадал) мөргөлийн төв болгодог (Ром 1:25). Тэд Бурханы эрх мэдэлд дургүйцэж, өөрсдийн хийхээр шийдсэн зүйлээ зөвтгөхийн тулд амьдралын гүн ухаанд итгэдэг. Тэд юу зөв болохыг мэдэж, үүнийг хийхийг эрэлхийлдэггүй. Харин тэд хүссэн зүйлээ хийснийхээ дараа үүнийгээ зөвтгөх арга замыг хайдаг.

Үл итгэгч сэтгэл зүйч, зөвлөгчид гэмшил, Бурханы уучлалгүйгээр хүмүүсийн гэм буруугийн асуудлыг шийдвэрлэх гэж хичээдэг. Ертөнцийн гүн ухаантнууд Бурхангүйгээр амьдралын зорилгыг тодорхойлох гэж оролддог. Ертөнцийн шинжлэх ухаанч хүмүүс Бүтээгчийг үгүйсгээд, бүх зүйлийн үүслийг тайлбарлахаар оролддог. Энэ ертөнцийн улс төрчид, нийгмийн ажилтнууд нүгэл нь бодит асуудал гэдгийг үгүйсгэдэг хэрнээ нүглийн төрөлхийн, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх гэж оролддог. Ертөнцийн загвар зохион бүтээгчид мэдрэмжийг шүтэж, анхаарал татахуйц хувцас бүтээхийг л зорьдог. Ертөнцийн зугаацуулагч хүмүүс нүгэл, ёс суртахуун, шашныг онигоо болгон ярьдаг. Ертөнцийн пасторууд нүгэлд хүлцэнгүй ханддаг бурханд итгэх бөгөөд өөрсдийнхөө баян чинээлэг байдал, аз жаргал, өөртөө итгэх байдалд л хамгийн их анхаардаг.

Колоссай 2:8 эшлэл бидэнд энэ ертөнцийн гүн ухаан, мэхлэлд автаж дээрэмдүүлэхгүй байхыг сэрэмжлүүлсэн. Луйварчин худал хуурмаг үзэл санааг зарж, бусдыг дээрэмддэг.

Ертөнц хүмүүсийг буруу үзэл санаанд итгүүлснээр, тэдний Бурхантай харилцах харилцаа, сүнслэг ашиг тус, тэнгэрийн улсыг ч дээрэмддэг.

Энэ ертөнцийн гүн ухаан, хянаж жолооддог сэдлүүд нь ертөнцийн хүмүүсийн амьдралын хэв маягаар нь илэрч байдаг. Тэдний үг яриа, хандлага, хувцаслалт, зугаацдаг зүйлс болон үйлдэл нь бүгд зүрхэн дэх нүгэлт байдлыг нь илэрхийлдэг.

Христийг дагадаг хүмүүс нийгмийнхээ ёс суртахууныг дагаж болохгүй. Христийг дагадаг хүмүүс нийгмээсээ өөр байх болно.

Ахуй соёлууд нь *ертөнц* гэж Библид нэрлэгддэг тогтолцооноос бүрддэг. Хүмүүс олон үеэрээ нэг газар суурьшихдаа соёлыг бүтээдэг. Тэд аюулгүй байдал, эд баялаг, тогтвортой гэр бүл зэрэг сайн зүйлсийг хүсдэг ч, тэдгээрийг Бурханы Үгэнд захирагдах байдлаар биш, харин ертөнцийн гүн ухаанаас хайж, олохыг илүүд үздэг. Тэгэхээр үүнээс харвал, Христийг дагагч хүмүүс өөрийн ахуй соёлыг бүрэн хэмжээнд дагах боломжгүй гэсэн үг юм. Зарим соёлд Библийн зарчмуудын нөлөө их тусгагдсан байдаг ч, аль ч үндэстний соёл бүхэлдээ христитгэлийнх байдаггүй.

► Энэ хүртэл суралцаж байгаа зүйлсэд үндэслэн хэлбэл, Есүсийн дагалдагчид нь 'ертөнцийнх биш' гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Итгэгчид нүгэлт хүслүүдээ болон хувийн ашиг сонирхлыг (амбиц) дагадаггүй. Тэд юуны түрүүнд Бурханыг баярлуулахыг хүсдэг. Тэдний хайрлаж, татагддаг зүйлс хэдийн өөрчлөгдсөн бөгөөд үргэлжлүүлэн өөрчлөгдсөөр байна (Филиппой 1:9-11). Бурханы хууль тэдний зүрх сэтгэлд бичигдсэн юм (Иеремиа 31:33). Бурханы тушаалууд нь итгэгчдэд дарамт биш, харин баяр баясгалан байдаг (1 Иохан 5:1-3, Дуулал 19:7-11). Итгэгчдэд мөнхөд байх эрхэмлэх зүйлс бий (Матай 6:33). Тэд зан байдлаараа уруу таталтыг эсэргүүцэж, нүглийг ялах хүсэлтэй гэдгээ харуулдаг.

Өөртэй нь адил зүйлсийг сонирхдоггүй учраас ертөнцийн хүмүүс итгэгчдийг хачин жигтэй гэж боддог (1 Петр 4:4). Сүнслэг байдлаараа өөр хүнийг ертөнц үзэн ядах болно гэж Есүс хэлсэн байдаг (Иохан 17:14). Ертөнц өөрт нь харьяат биш хүмүүст дайсагнадаг. Тэд ойлгодоггүй, зөвт байдалд дургүйцдэг бөгөөд нүгэл нь тэднийг буруутгадаг. Тийм учраас Есүс "Ертөнцөд та нар зовлонтой байна" гэж хэлсэн (Иохан 16:33). Элч Паул "Христ Есүс дотор итгэл сүсгээр амьдрахыг хүсэгч бүх хүн хавчигдах болно" (2 Тимот 3:12) гэж хэлсэн байдаг.

► Нэг суралцагч 2 Коринт 6:14-18 эшлэлийг бүлэгт уншина.

Итгэгч хүн ертөнцөөс ялгаатай, тусгаар байхыг Библи зааж сургадаг. Энэхүү ялгаатай байдал нь хүний хандлагаас эхэлдэг бөгөөд Есүс энэ талаар уулан дээрх сургаалдаа заасан. Тэр итгэгч хүний хандлагыг даруу, нүгэлд харуусдаг, дөлгөөн, зөв шударга, энэрдэг, зүрх сэтгэлийн цэвэр ариун байдал, амар тайван, мөн хавчлага зовлонг тэсвэрлэх хэмээн тодорхойлсон байдаг. Ялгаатай хандлагаас ялгаатай үйлдэл бий болдог. Жишээлбэл, итгэгч хүн буруу зүйл хийхийг шаарддаг түншлэл, хамтын ажиллагаанд оролцож болохгүй. Бурхан ертөнцөөс тусгаар байдаг нэгний Эцэг нь байх

болно гэж амласан. Ертөнцийн найз байснаар Бурханы дайсан болдог гэсэн эшлэлийг бид харж байснаа санаж байна уу (Иаков 4:4).

► Нэг суралцагч Матай 5:13-16 эшлэлийг бүлэгт уншина.

Ертөнцөөс тусгаар байна гэдэг нь итгэгч хүн нийгмээс тусгаарлагдаж, өөрийн хамт олныг байгуулах ёстой гэсэн үг биш юм. Есүс өөрийн дагалдагчдыг ертөнцөөс гаргаж авахын төлөө залбираагүй гэдгээ хэлсэн байдаг (Иохан 17:15). Түүнчлэн Тэр өөрийн дагалдагчдыг ертөнцийн гэрэл ба давс гэж хэлсэн юм. Үүгээрээ дагалдагчид нь нийгэм дунд ил, бодитоор байх ёстой гэдгийг Тэр хэлжээ. Итгэгч хүмүүс засаг захиргаа, орон нутгийнхаа ажил хэрэгт оролцох ёстой. Гэхдээ тэдгээр нь буруу зүйл хийхэд хүргэх оролцоо байвал мэдээж оролцох ёсгүй.

Жералд Ситцер эртний христитгэлд энэ нь ямар байдлаар илэрч байсныг тайлбарлахдаа:

2-р зууны үед амьдарч байсан Афины философич Аристидес Христэд итгэгчид бусдаас ялгагдаж байсан олон шинж чанарыг дурдсан байдаг. Итгэгчид үлгэр жишээ (амлалтандаа итгэмжтэй), үнэн зөв, сэтгэл хангалуун, эцэг эхээ хүндэлдэг, хөршөө хайрладаг, цэвэр ариун, хавчлага зовлонг тэсвэрлэдэг, танихгүй хүмүүст энэрэнгүй хандах зэрэг зан чанараараа ялгарч байсныг тэрээр тэмдэглэжээ. Тэд бэлэвсэн эмэгтэйчүүд, өнчин хүүхдүүдийг асран халамжилж, боолууддаа ч ер бусын энэрэнгүй ханддаг байжээ. "Тэдний хайраас болж Христэд итгэхээр ятгагдсан эрэгтэй, эмэгтэй боолууд... Хэрэв тэд итгэгч болвол, тэднийг ямар ч ялгаварлалгүйгээр ахан дүүс гэж үздэг байжээ."<sup>2</sup>

## **Жинхэнэ итгэл**

Жинхэнэ христитгэл нь хүний амьдралаар илэрдэг болохыг Иаков захидал онцолдог. Иаков Бурханы Үгийг сонсоод түүнийг хэрэгжүүлдэггүй хүн өөрийгөө хуурч байна гэж хэлсэн байдаг (Иаков 1:22). Зарим хүн христитгэлийн үнэнийг илүү мэддэг учраас өөрийгөө бусдаас илүү дээр гэж боддог. Тэд үүнийг дуулгавартай дагадаггүй учраас энэ нь үнэн биш юм.

Зарим хүн маш шашинлаг байдаг ч, тэдний шашин нь ямар ч үнэ цэнгүй, хоосон гэж Иаков хэлсэн байдаг. Харин бусдын хэрэгцээнд тусалж, өөрсдийгөө ертөнцөөр бохирдуулахгүй, цэвэр ариун байлгадаг хүмүүс Бурханыг баярлуулдаг (Иаков 1:27).

► Нэг суралцагч Иаков 2:14-26 эшлэлийг бүлэгт уншина.

Зарим хүн аврал нь үйлсээр бус, итгэлээр ирдэг учраас бидний биеэ авч явах байдал хамаагүй гэж боддог. Тэд хандлага, амьдралын хэв маяг нь үл итгэгч хүнийхтэй адил байсан ч хүн авралын итгэлтэй байх боломжтой гэж үздэг. Иаков захидлын эдгээр эшлэл нь яг ийм хүмүүст хандан хэлэгдсэн юм.

<sup>2</sup> Gerald L. Sittser. *Water from a Deep Well*. (Downers Grove: InterVarsity Press, 2007), 54

*Итгэл* нь дангаараа хангалтгүй гэж Иаков хэлжээ. Учир нь чөтгөрүүдэд хүртэл зөв итгэл байдаг ч, тэд Бурхантай зөв харилцаанд байдаггүй (эш.19). Бурханд итгэдэг хэрнээ Түүнд захирагддаггүй нэгэн бол сайнмэдээг сонссон ч гэмшдэггүй хүн юм.

21 болон 24-р эшлэлийг зөв тайлбарлах нь чухал. Эдгээр эшлэл Абрахам үйлсээрээ зөтгөгдсөн бөгөөд хүн итгэл ба үйлсийн хамт зөвтгөгддөг гэж хэлдэг. Энэ нь аврал нь зөвхөн нигүүлслээр, үйлсээр бус гэдгийг онцолдог бусад Бичвэртэй зөрчилдсөн мэт санагдаж болох юм (Ефес 2:8-9, Галат 2:16, Ром 3:28). Гэвч Иаков *зөвтгөгдөх* гэдэг үгээр хүн итгэл ба үйлсээр *аврагдсан* гэсэн утгаар хэлээгүй, харин хүний авралын итгэлийг үйлс ба итгэл нь *харуулдаг* гэдгийг хэлсэн. Хүн үйлсээр аврагддаггүй, гэхдээ тэр хүн бурханлаг амьдралаар амьдардаггүй бол түүнд авралын итгэл байхгүй гэсэн санаа. Хүний амьдрал итгэлтэйгээ нийцэхгүй байгаа бол түүний итгэл үхмэл гэж Иаков хэлдэг (эш.26).

Түүнчлэн Иаков нэг модонд хоёр өөр жимс ургадаггүй, нэг булгаас хоёр өөр төрлийн ус гардаггүйтэй адил хүний амнаас нэгэн зэрэг ерөөл, хараал гарах ёсгүй гэж хэлсэн байдаг (Иаков 3:9-12). Хүний биеэ авч явах байдал нь түүний христитгэлтэй тогтмол нийцэж байх учиртай.

#### **Үнэнч байдлын** талаарх ойлголт

Ром 2:21-24 эшлэлд Паул, Бичвэрийг эзэмшсэн атлаа түүнийг дуулгавартай дагадаггүй иудей хүмүүст хандан ярьсан бөгөөд тэд өөрсдийгөө харь хүмүүсээс дээгүүр гэж боддог байжээ. Паул тэднээс “Бүү хулгайл гэж номлоод та хулгайлдаг уу?” гэж асуусан. Түүнчлэн тэрээр “Хуулиар сайрхагч та өөрөө хуулийг зөрчсөнөөрөө Бурханыг гутааж байгаа юм биш үү?” гэжээ. Тэд өөрсдийгөө шашинлаг хүмүүс гэж өргөмжилдөг ч, сайн зан чанаргүй байсан нь харь үндэстнүүд Бурханыг болон Бичвэрийг гутаан доромжлох үг хэлэхэд хүргэжээ.

Хэрэв хүн үнэнч байгаа бол түүний биеэ авч явах байдал нь итгэл үнэмшилтэй нь нийцдэг. Жишээлбэл, шударга хүн шударга байдлыг өөрийн бүх үг яриа, үйлдэлдээ хамтад нь шингээсэн байдаг. Харин өөрийгөө шударга гэж хэлчихээд шударга бус зүйлийг хийдэг хүн үнэнч хүн биш юм.

*Үнэнч* байдал гэдэг ойлголтыг хүний зан чанарт хамааруулж хэрэглэдэг. Зарим орны хэлэнд энэ нэр томъёог барилгын бүтэц зэрэг бусад зүйлсийг тодорхойлоход ч ашигладаг.

► Барилгын бүтцэд үнэнч байдал гэдэг үгийг ашиглах нь юу гэсэн утгатай вэ?

Барилга бат зогсож байх нь л маш чухал юм. Тэр өөрийн жин болон дотор нь явагдах үйл ажиллагааны ачааллыг даадаг байх ёстой. Хэрэв барилга нурах аваас хүмүүс, эд хөрөнгө хохирч, тухайн барилгын үнэ цэн алдагдана. Барилгын хувьд үнэнч байдал гэдэг нь байгууламжийн бүхий л бүтцэд бат бэх барилгын зарчмууд жигд хэрэгжсэн байхыг хэлдэг.

Түүнчлэн барилга удаан хугацаанд оршин тогтнох нь сайн. Байшин барьсан хүн өөрийнх нь амьдралын туршид энэ нь бат бэх байгаасай гэж хүсдэг. Харин томоохон бизнесийн байгууллага болон засаг захиргааны барилгууд маш их хэмжээний хөрөнгө оруулалтаар баригддаг учраас хэд хэдэн үе дамжин оршин тогтнохыг хүсэж хүлээдэг.

Хэрэв барилгад хазайлт үүсэж, нурах эрсдэл учирвал түүнд үнэнч чанар дутсаныг илтгэнэ. Зарим тохиолдолд газар хөдөлсний дараа барилга босоогоороо үлдсэн ч аюултай байх боломжтой. Тийм барилгын хувьд мөн л үнэнч байдал алдагдсан байдаг.

Чухал барилга барихын өмнө заавал зураг төсөл, нарийвчилсан төлөвлөгөө гаргадаг. Хамгийн чухал нарийн ширийн хэсгүүд нь тухайн барилга хэрхэн бат бэх зогсоход нөлөөлдөг. Барилгын бүх хэсэг хоорондоо холбогдож, нэг нэгнээ дэмжих ёстой.

Барилгачин барих явцдаа төлөвлөгөөг ягштал дагах нь маш чухал байдаг. Хэрэв тэр зардлаа хэмнэхийн тулд бүтцэд зайлшгүй шаардлагатай хэсгийг орхигдуулбал барилга маш аюултай байдалд орно.

► Үнэнч хүн байна гэдэг нь ямар хүнийг хэлэх вэ?

Есүс байшингийн бат бэх чанарын талаар жишээ ашигласан байдаг. Тэрээр Бурханыг сонсоод дуулгавартай дагадаг хүнийг хадан дээр байшингаа барьсан хүнтэй зүйрлэсэн. Салхи шуурга дэгдэхэд ч тэрхүү байшин бат бэх үлддэг. Харин Бурханыг дуулгавартай дагадаггүй хүнийг элсэн дээр байшингаа барьсан хүнтэй зүйрлэжээ (Матай 7:24-27). Зөвхөн үнэнийг сонсож, мэдэх нь хангалтгүй.

► Нэг суралцагч Иаков 1:22-25 эшлэлийг бүлэгт уншина.

Бурханы Үгийг сонсоод хийдэггүй хүмүүс өөрсдийгөө мэхэлж байна гэж Иаков хэлсэн. Тэрээр үүнийг Библийн үнэнийг мэддэг ч, түүгээр тогтмол амьдардаггүй хэрнээ өөрийгөө сайн хүн гэж боддог хүмүүст хандан хэлж байна. Ийм хүмүүст үнэнч чанар байдаггүй.

Бурханы Үгийг уншихдаа толинд өөрийгөө харсан ч, харж байгаа зүйлээсээ болоод өөрчлөгддөггүй хүнтэй адил байж болохгүй гэдгийг Иаков мөн хэлсэн. Бурханы үнэн хувьсган өөрчилдөг. Бурханы Үг рүү ширтэн харахдаа бид өөрсдийн алдаа дутагдлыг олж хардаг бөгөөд Бурханы Сүнс бидний зан чанар, биеэ авч явах байдлыг Түүний үнэнд нийцүүлж өөрчлөхийг Түүнд зөвшөөрөх учиртай.

Үнэнч байдал нь амьдралын хэв маягаар илэрдэг. Итгэгч хүн өөрийнх нь хандлага, үйлдэл нь Бурханы үнэнд нийцэхгүй байгааг ухамсарласан бол өөртөө хэзээ ч сэтгэл ханахгүй.

### **Үр жимсний шалгуур**

Есүс олон хуурамч эш үзүүлэгчид гарч ирнэ гэж хэлсэн. Ийм хүмүүс шашны удирдагчийн байр суурь хүсдэг эсвэл үйлчлэлийг бизнес болгохыг зорьдог ч, тэдэнд Христийн зан чанар байдаггүй. Есүс тийм хүмүүсийг үр жимсээр нь танина гэж хэлсэн

(Матай 7:15-18). Үр жимс гэдгээр амжилтыг хэлээгүй. **Харин үр жимс нь тухайн модны шинж байдлын төрөлх илрэл юм.** Хүний үр жимс гэдгээр түүний дотоод зан чанар илэрч байгаа амьдралыг хэлдэг. Хэрэв хүн Сүнсний үр жимс гаргахгүй (Галат 5:22-23, 1 Коринт 13), эсвэл нүгэлт амьдралаар амьдарч байгаа бол тэр нүгэлт зан чанартай хүн бөгөөд сүнслэг удирдагч биш юм (1 Коринт 6:9-10, 2 Коринт 11:13-15).

Элч Петр итгэгч хүмүүс урьдын хүсэл тачаалдаа захирагдалгүй, харин хийж байгаа бүх зүйлдээ ариун байх ёстой гэж хэлсэн юм (1 Петр 1:14-15).

Сайн үр жимс гаргана гэдэг нь хүн христитгэлийн бүх зарчмуудыг өөрийн зан байдалдаа төгс хэрэгжүүлэх тухай ойлголт биш юм. Бид бүгдээрээ Бурханы үнэнд суралцах үйл явц дунд байсаар байна. Ногооны талбайд ажиллаж буй хүүхэд андуураад өөр ургамлыг сугалж болох юм. Бурхан бидний чин сэтгэлийн алдааг шүүдэггүй. Гэсэн хэдий ч, нигүүлсэл нь хүн нүглээ гэмших боломжийг олгосоор байдаг. Элч Иохан бидэнд хүн үнэний дагуу амьдарч, гэрэл дотор алхаж байхдаа цэвэрлэгддэг хэмээн хэлжээ (1 Иохан 1:7).

### **Удирдлага дахь үнэнч байдал**

Удирдагчид бусад хүний хийх шаардлагагүй тийм шийдвэрүүдийг гаргадаг. Удирдагч хүний хариуцлага ба боломжууд нь соригдох олон боломжуудыг бий болгодог. Удирдагчийн шийдвэр олон хүний амьдралд нөлөөлдөг учраас чухал онцгой байдаг.

Үйлчлэлийн удирдагч хүн Есүсийн үлгэр дуурайлыг дагаж, Бурхан болон хүмүүст үйлчлэхээр дуудагдсанаа санах хэрэгтэй. Түүний зорилго нь бусдаас сайшаал хүртэж, бусдаар үйлчлүүлдэг олны танил хүн болох биш юм.

Хэрэв чуулганд Бурханыг чин сэтгэлээсээ мөргөн хүндэлдэггүй хүмүүс олонх байвал тэд чуулганы хүндэтгэлийн цуглааныг үзүүлбэр төвтэй байлгахыг оролддог. Ийм хүмүүс сүнслэг төвлөрлөөс илүүтэй авьяас чадварыг дээдэлдэг. Тэд жинхэнэ сүнслэг удирдагчдын оронд уран бүтээлчдээр чуулганы хүндэтгэлийн цуглаанаа удирдуулахыг хүсдэг. Тэд мэдрэхүйн үзүүлбэрээс цэнгэл таашаал авдаг. Тэд диско клубт ч тоглоход бэлэн, мөргөл хүндэтгэлийн шалгуур хангахгүй, дахин төрөөгүй хөгжимчдийг ажиллуулахад бэлэн байдаг. Пастор хүн чуулганы мөргөл хүндэтгэлийг хамгаалах үед жинхэнэ мөргөгчид татагдаж, үйлчилж эхэлдэг.<sup>3</sup>

► Хэрэв хэн нэгэн хүн Ням гарагт чуулганд очихдоо, Баасан гарагийн орой нь диско клубт харсан хөгжимчдийг дахин харвал тэр чуулганы талаар юу гэж бодох бол?

Удирдагч хүн өөрийгөө ёс суртахууны нийтлэг дүрэм өөрт нь үйлчлэхгүй гэж бодох уруу таталтад орж болох юм. Зарим пасторууд өөрсдийн ахуй соёлд байдаг ертөнцийн удирдагчидтай адил чуулганыхаа эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй буруу харилцаанд ордог.

---

<sup>3</sup> Христэч мөргөл хүндэтгэлийн талаар бүрэн эхээр нь Shepherds Global Classroom байгууллагын *Introduction to Christian Worship* курсыг дараах вебсайтаас <https://www.shepherdsglobal.org/courses> үзнэ үү.

Зарим чуулган пасторуудынхаа байр сууриас болж, тэдний ёс суртахуунгүй үйлдлийг буруугаар хүлцэн тэвчдэг.

Түүнчлэн пастор хүн чуулганыг өөрийн өмч гэж үзэх уруу таталтад орж ч болох юм. Хэрэв тэр ингэж боддог бол ажлаа сайн хийдэг хүмүүсийг бус, зөвхөн өөрийг нь тойрон хүрээлж, өөрт нь үнэнч хүмүүсийг л албан тушаалд томилох болно. Ийм пастор төрөл саднаа илүүд үзэж, өөрийнх нь дараа хэнд чуулганыг өвлүүлэхийг сонгодог. Тэр чуулган дахь өөрийн дэмжигчдийн нүгэл, алдааг халхалж, чуулганы мөнгө санхүү, эд хөрөнгийг өөрийнх мэт захиран зарцуулдаг.

### **Чуулганы гэрчлэл**

Чуулган үнэнч байдлыг шаардахаа болих үедээ завхарч эхэлдэг. Чуулганы гишүүд ертөнцийн хүсэл шуналыг хуваалцахдаа, тэд ертөнцийнхтэй адил удирдагчдыг хүлээн зөвшөөрч байдаг. Тэд шашны удирдагчдынхаа нүгэлд хүлцэнгүй ханддаг. Тэр ч бүү хэл, чин сүсэг бишрэлтэй итгэгчид ч үнэнч байдал болон сайн үр жимсний зайлшгүй шаардлагыг ойлгодоггүй учраас нүгэлт удирдагчдыг дагах боломжтой. Ийм зүйл тохиолдох үед ертөнцийн хүмүүс чуулганд хяналтыг тогтоож, чуулган өөрийн гэрчлэлээ алддаг.

Хуурамч сүнслэг удирдагчид чуулганыг бизнес болгодог хэмээн элч Петр сэрэмжлүүлсэн байдаг (2 Петр 2:3). Чуулган өөрийн нийгэмдээ танигдаж, алдартай болох үед ертөнцийн хүмүүс чуулганд байр суурь олж авахыг сонирхдог. Тэд мөргөл хүндэтгэлийн хэлбэр, шашны удирдлагын арга барилд суралцсан ч, нүглээ гэмшиж, Христийн авралыг хүлээн аваагүй хүмүүс юм. Сайн онол сургаалгүй чуулган ийм хуурамч удирдагчдыг таньж чаддаггүй.<sup>4</sup>

Чуулган өөрийн ялгаатай байдлыг алдах үедээ юу болдгийг Есүс тайлбарлахдаа давсны талаарх жишээг ашиглажээ (Матай 5:13). Давс амтаа алдвал элс, хайрганаас дээрдэх зүйлгүй болдог.

Чуулган нийгэмтэйгээ адил болчихвол нийгмээ өөрчилж чадахгүй.

Чуулган Библийн үнэнийг дагахын оронд ертөнцийн хэв маягт уусвал, ертөнц чуулганыг шоолж тохуурхах болно.

### **Бурханыг төлөөлөх нь**

*Теологи* гэдэг нь Бурхан, хүн төрөлхтөн, нүгэл, Христ, авралын талаарх онол сургаалуудыг багтаасан бидний христитгэлийн тогтолцоо юм. Бурханы талаарх бидний итгэл үнэмшил бусад бүх итгэл үнэмшлийн үндэс суурь болдог.

Бурхан өөрийгөө бидэнд илчилсэн анхны зорилго нь Тэр ямар Бурхан болохоо бидэнд харуулах байв. Бурхан өөрийгөө хамгийн түрүүнд *ариун* хэмээн тодорхойлсон. Ариун байдал буюу *кадош* гэсэн еврей үг Хуучин гэрээнд 600 гаруй удаа гардаг. Жишээлбэл,

<sup>4</sup> Хуурамч сүнслэг удирдагчдын талаар 2 Петр 2 болон Иуда захидалд бичигдсэн байдаг.

Исаиа Бурханыг дахин давтан “Израилын Ариун Нэгэн...” гэж дуудсан. Бурханы ариун байдал нь мөргөл хүндэтгэлийн гол сэдэв байсан (Дуулал 99:3, 5) бөгөөд Бурханы ард түмэн зөвхөн хүч чадлынх нь төлөө биш, харин ариун байдлынх нь улмаас Түүнийг мөргөн хүндэтгэсэн юм.

Түүнчлэн Бурхан өөрийгөө *хайр* гэж илчилсэн. Хуучин гэрээнд Бурхан өөрийнхөө талаар Мосе болон Израилд илчилж байгаа олон багц хэсгийн нэг нь Гэтлэл 34:6-7 юм. Энэ хэсэгт Бурхан өөрийнхөө талаар “... өрөвч, нигүүлсэнгүй Бурхан, уурлахдаа удаан, энэрэл хайр ба үнэнээр бялхам билээ. Тэрээр энэрэл хайрыг мянга түмэнд хадгалж, хилэнц, гэмт үйлдэл болон нүглийг уучилдаг. Гэсэн ч Тэр шийтгэлгүй орхихгүй...” хэмээн тодорхойлсон байдаг. Бурханы ариун байдал ба хайрыг хамтад нь сахих нь маш чухал юм. Бурханы мөн чанарыг тодорхойлоход түгээмэл ашиглагддаг нэг нэр томьёо бол “ариун хайр” юм. Бурхан ариун учраас Тэр биднээс ариун байдлыг шаарддаг. Бурхан хайр учраас Тэр биднийг өөр шигээ ариун болгох арга замаар хангаж өгсөн юм.

Хүмүүс эхлээд нигүүлслээр хувьсан өөрчлөгдөхөөс нааш Бурханыг мөргөн хүндэтгэх болон Түүнд үйлчлэх нь зохистой биш гэдгийг Бурханы ариун байдал харуулдаг. Эш үзүүлэгч Исаиа номлож байсан нүгэлтнүүдийнхээ адил нэг зүйлийг өөрөөсөө олж харсан бөгөөд тэр нь түүний цэвэр бус зүрх сэтгэл байв (Исаиа 6:5). “Бузар уруул” гэдгээр цэвэр бус зүрх сэтгэлээс гардаг үг, үйлдлүүдийг илэрхийлдэг. Энэхүү цэвэр бус байдал нь Исаиаг Бурханы оршихуйд байх зохисгүй болгожээ. Исаиа өөрийнхөө нөхцөл байдлыг зөвтгөхийг оролдоогүй бөгөөд Бурхан ч түүнийг зөвтгөсөнгүй. Харин эш үзүүлэгчийнхээ гэмшилд Бурхан нигүүлслээр хариулсан. Энэ нь нүглийг хүлцэн тэвчдэг бус, харин ариусгаж, хувьсган өөрчилдөг нигүүлсэл юм (Исаиа 6:6-7).

Израилын Бурхан хуурамч бурхдаас өөр ялгаатай байсан бөгөөд Тэр өөртөө онцлог ялгаатай мөргөл хүндэтгэлийг шаарддаг байв. Дуулал 24-д ямар хүн Эзэний оршихуйд орох нь зөвшөөрөгдөх талаар Давид дүрсэлсэн байдаг. Бурхан хэнийг мөргөн хүндлэгч хэмээн хүлээн авдаг вэ? “Цэвэр гартай, ариун зүрхтэй...” (Дуулал 24:4) нэгнийг. Хүн бүрийг мөргөн хүндлэгч гэж Бурхан хүлээн зөвшөөрдөггүй. Мөргөн хүндлэгч гэдэг нь зүгээр л гараа өргөж, сэтгэл хөдлөлөө мэдэрдэг хүн биш юм. Нүгэлт хүн энэ шалгуурт тэнцэхгүй.<sup>5</sup>

Бурхан өөрийнхөө ариун байдлыг өөрт нь мөргөн хүндлэгчдээс шаардах ариун байдлын үндэс шалгуур гэж хэлсэн “Та нарын Бурхан ЭЗЭН Би ариун учраас та нар ариун байгтун” (Леви 19:2, Леви 11:44-45, Леви 20:26, Леви 21:8). Бурхан эртний Дорнын бурхад, эсвэл хожуу үеийн Грек, Ромын домогт гардаг бурхадтай адилгүй. Эдгээр домогт тэдний бурхдыг завхарсан, залилж мэхэлдэг, харгис хэрцгий хэмээн тодорхойлсон байдаг. Эдгээр бурхад нь хүний мөн чанарын бүх сул талыг агуулдаг. Хананд буусан сүүдэр шиг тэд хүний дүр төрхийн хэтрүүлж гажуудуулсан тусгал юм.

---

<sup>5</sup> Христэч мөргөл хүндэтгэлийн талаар бүрэн эхээр нь Shepherds Global Classroom байгууллагын *Introduction to Christian Worship* курсыг дараах вебсайтаас <https://www.shepherdsglobal.org/courses> үзнэ үү.

Ийм бурхад ёс суртахууны хэм хэмжээ, зан чанарын шалгуурыг шаардахгүй бөгөөд тэдэнд мөргөгчид нь бузар муу, харгис хэрцгий хүмүүс байдаг.

Харин Израилын Бурхан бол хүний дүр төрхийн тусгал биш юм. Тэр зохиомол биш, харин өөрийгөө хүмүүст илчилсэн Бурхан байв. Тэр өөр бөгөөд тийм ч учраас Түүнд мөргөн хүндлэгчид өөр байх учиртай.

Бурханы хэм хэмжээ Шинэ гэрээнд ахин давтан хэлэгдсэн: “Та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун. Яагаад гэвэл “Би ариун учраас та нар ариун байгтун” гэж бичигдсэн юм” (1 Петр 1:15-16). *Зан байдал* гэдэг үг нь бидний хандлага, үйлдэл, амьдралын бүхий л хэсгийг илэрхийлдэг. Бурхан өөрт нь мөргөн хүндлэгчдийг зөвхөн *ёслол* төдий ариун байхыг, эсвэл яг үнэн байдал нь тийм биш хэрнээ *ариун* гэж дуудуулахыг хүсдэггүй. Тэр өөрт нь мөргөн хүндлэгчдийг жинхэнэ ариун амьдралаар амьдрахыг хүсэн хүлээдэг.

Бурханыг бид хэрхэн ойлгодог, мөн Түүнтэй ямар харилцаанд байгааг бидний хандлага, үйлдэл маань харуулдаг. Иудейчүүд Бурханы хууль биднийх хэмээн бардамнахад элч Паул тэдэнд хуулийг зөрчсөнөөрөө Бурханыг гутаан үл хүндэтгэж байна гэж хэлээд, тэдний биеэ авч явах байдлаас болж, хүмүүс тэдний талаар ч, мөн тэдний Бурханы талаар ч муу зүйлийг ярьдаг болсон (Ром 2:23-24) хэмээжээ.

Та ямар Бурханыг төлөөлдөг вэ? Хүмүүс таны Бурханыг ямархуу гэж боддог бол? Хэрэв та Бурхан ариун бөгөөд уучлагч, нигүүлсэнгүй гэдгийг хүмүүс мэдээсэй гэж хүсдэг бол таныг ингэж амьдарч байгааг хүмүүс харах хэрэгтэй юм.

Онол сургаалыг бүрэн хэмжээнд, тогтвортой заадаг пасторууд чуулганд хэрэгтэй байна. Пастор хүн үндсэн онол сургаалыг үл тоомсорлож болохгүй. Үе үеийн бүх хүн, шинээр итгэлд ирж буй хүмүүс тэдгээрийг сонсох шаардлагатай. Үүгээр зогсохгүй, төлөвшсөн итгэгчдэд ч сануулах хэрэгтэй. Пасторын номлол нь зөвхөн сэтгэл хөдөлгөсөн, уур амьсгал бүрдүүлэх зорилготой эрч хүчтэй үзүүлбэр төдий байх ёсгүй. Харин тэр Бурхан хэн болохыг, итгэгч хүний амьдрал Бурханы талаарх Библийн ойлголт, тэдгээрийн бүхий л нарийн ширийн зүйлстэй хэрхэн нийцэх учиртайг зааж, тайлбарлах ёстой юм.

Чуулган нийгэм, ахуй соёлоо хувьсган өөрчлөх учиртай. Харин энэ нь Бурханы талаарх Библийн ойлголт бидний амьдралын бүхий л нарийн ширийн хэсэгт хэрэгжих үед л биеллээ олдог.

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

- ▶ Энэхүү хичээлийн ямар ойлголт таны хувьд шинэ байсан бэ? Итгэлийн амьдралдаа өөрчлөлт авчрах ямар төлөвлөгөө танд байна вэ?
- ▶ Танай ахуй соёлд чуулганууд ихэвчлэн тоолгүй өнгөрөөдөг ямар Библийн ойлголт байна вэ? Энэхүү ойлголтыг таньдаг хүндээ та хэрхэн тайлбарлах вэ?

## **Залбирал**

Тэнгэрлэг Эцэг минь,

Таны зан чанартай нийцэх амьдралаар Таныг дээдлэн хүндлэхийг би хүсэж байна. Танд үл захирагдах энэ ертөнцөд би Таныг төлөөлөхийг хүсэж байна.

Миний амьдралыг Таны үнэний дагуу байлгаж соёрхооч. Итгэгч хүний амьдралын хэсэг байх зохисгүй зүйлсийг өөрчлөхөд надад туслаач.

Таны хүчирхэгжүүлэгч Сүнс болон хувьсган өөрчилдөг нигүүлсэлд баярлалаа.

Амен

## **1-р хичээлийн даалгавар**

(1) Саяхныг хүртэл таны бодол, үйлдэлд нөлөөлж байсан ертөнцийн үнэт зүйлийн талаар нэг догол мөрөнд багтааж бич. Амьдралын энэ хэсэгт хандсан Бичвэрийн 2 эшлэлийг олж, тэмдэглээрэй. Эдгээр Бичвэрийн дагуу хэрхэн амьдарч эхлэх талаараа нэг догол мөрөнд багтаан бич.

(2) Тит 2:11-14 эшлэлийг судал. Энэ багц хэсэгт үндэслэн христитгэлийн үнэнч байдлын талаар товч толилуулга бэлтгэ. Амьдралын бүхий л нарийн ширийн хэсэгт Библийн үнэн яагаад хэрэгжих ёстойг тайлбарлахдаа энэ багц хэсгийг ашигла. Дараагийн хичээл эхлэх үед толилуулгаа хуваалцаарай.

## 2-р хичээл

# Бурханд дуулгавартай байдлыг хэрэгжүүлэх нь

### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах ойлголт, чадварт суралцсан байна:

- (1) Христигэлийн хайр ба итгэгчийн хувийн амьдрал хоорондын практик харилцааг олж харах.
- (2) Итгэгч хүн өөрийн амьдралаа Бичвэрийн зарчмын дагуу болгох ёстой 10 талбарыг эргэцүүлж тунгаах.
- (3) Итгэгч хүн амьдралын хэв маягтай холбоотой асуудалд Бичвэрийн зарчмыг хэрэгжүүлэхдээ яагаад бусдаас өөр байх 2 шалтгааныг тайлбарлах.
- (4) Амьдралын хэв маягтай холбоотой шийдвэрийг гаргах 9 зарчмыг (хичээлд өгөгдсөн) тоймлон суралцах.

### Дуулгавартай хүүгийн түүх

Нэгэн африк ээж модны сүүдэрт тоглож байгаа хүүгээ шалгахаар гэрээсээ гарчээ. Гэтэл тэр харсан зүйлдээ итгэж чадсангүй. Нэгэн аварга том хорт могой хүүгийнх нь дээрээс мөчирт дүүлжлэгдэн хазах гэж байлаа. Хүүдээ хашгирч сэрэмжлүүлбэл хүү нь цочиж дээш хараад хазуулж болзошгүй байсан тул ээж нь түүнд тайвнаар “Миний хүү, яг одоо газарт доошоо хэвтээрэй” гэж хэлэв. Хүү гайхсан хэдий ч, тэрээр дуулгавартай байхад суралцсан учраас ээжийнхээ үгэнд оров. Дараа нь ээж нь түүнд “Хүү минь, хэвтсэн чигээрээ над руу мөлхөөрэй” гэв. Хүү энэ удаа дахин ээждээ дуулгавартай байснаар хорт могойноос холдож, аврагджээ.

Тэр хүү яагаад ээжийнхээ хэлсэн зүйлийн шалтгааныг ойлгоогүй хэрнээ дуулгавартай дагасан бэ? Ээж нь хүүдээ дуулгавартай байхыг хэдийн зааж сургасан бөгөөд хүүг дуулгаваргүй байхад нь засаж залруулдаг байсан учраас хүү ээжийгээ хүндэлдэг байжээ. Түүнчлэн ээж нь түүнд хайртай гэдгийг тэр мэддэг учраас ээждээ итгэж найдсан юм. Бид Бурханд бүрэн дуулгавартай байх ёстой. Зөвхөн Түүний залруулгаас айсны улмаас биш, харин Тэр биднийг хайрладаг гэдгийг бид мэддэг учраас тэр юм.

### Хайрын өдөөлт

► Бурханыг ихээр хайрладаг хүний амьдралд ямар үр дүн гарах вэ? “Бурханыг би ихээр хайрлавал, би... ийм байх болно” хэмээн энэхүү асуултад хариулан өгүүлбэрийг төгсгөж бичээрэй.

Бурханыг хайрлахад гардаг нэг үр дүнгийн талаар Филиппой 1:9-11 эшлэлд:

Хайр чинь мэдлэг ба бүхий л хэрсүү ухаанаар улам бүр бялхах болтугай гэж би залбирдаг. Ингэснээр та нар алив сайныг ялган таньж, Христийн өдөр хүртэл цэвэр, гэм зэмгүй байх бөгөөд Бурханы алдар ба магтаалын төлөө Есүс Христээр ирэх зөвт байдлын үр жимсээр дүүрэн байх юм.

Эдгээр эшлэлд итгэгч хүний амьдралд тасралтгүй үргэлжлэх үйл явцын тухай өгүүлж байна. Тэр хүний хайр үргэлжлэн өсөн нэмэгдсээр байх ёстой. Бурханы төлөөх түүний хайр өсөн нэмэгдэхийн хэрээр хамгийн сайн нь юу болохыг ялгах чадвар нь улам хүчтэй болж, өргөжин тэлдэг. Тухайн хүн хамгийн сайн нь юу болохыг ялгаснаар, амьдралаа хамгийн сайн зүйл дээр төвлөрүүлж чаддаг. Итгэгч хүн чин сэтгэлээсээ, гэм зэмгүй байхад энэхүү үйл явц явагдах учиртай аж.

Дөнгөж төрсөн нялх хүүхэд өмнөө байгаа он жилүүдийн турш өсөж суралцах хэрэгтэй байдаг шиг итгэлд ирсэн цаг мөчөөс эхлэн бид суралцаж өсөх хэрэгтэй болдог. Учир нь бидний амьдралыг чиглүүлэх бүх үнэнийг бид хараахан ухаарч ойлгоогүй байдаг. Дээрх эшлэлд Христийг дагаад тодорхой хугацаа өнгөрсөн хүмүүст хандан Паул бичжээ. Хэдий тийм боловч, тэднийг Бурханыг улам ихээр хайрласаар байхыг, тэрхүү хайраар дамжуулан Бурханы хүслийг ухаарч, дуулгавартай байхын төлөө Паул залбирсан юм.

Бид үргэлжлүүлэн Бурханы өгдөг ялгах чадвараар өөрсдийн амьдралыг сайжруулахыг хүсэн тэмүүлэх учиртай. Зөвхөн шашинлаг ёс заншлын хувьд биш, харин амьдралынхаа бүх талбарт Түүнд дуулгавартай байхыг Бурхан биднээс хүсдэг.

Хэрхэн амьдрах талаар мэдэж болох бүхнийг би аль хэдийн мэдсэн гэж бид тааварлах ёсгүй. Түүнчлэн амьдралынхаа бүх талбарыг төвхнүүлж болгосон ч гэж бид үзэх учиргүй.

### **Итгэгч хүн амьдралдаа сайжруулах ёстой зарим талбар**

#### **(1) Болгоомжтой байдал (Сургаалт үгс 22:1, Матай 5:14-16)**

Бусад хүмүүсээс битгий хийгээсэй гэж хүсдэг тийм зүйлээ та хийдэг үү? Таны хийдэгтэй адил зүйлийг хийж байгаа пастораа харахдаа урам хугарч байсан уу?

#### **(2) Өөрийгөө хянах (Сургаалт үгс 16:32, Сургаалт үгс 25:28; Галат 5:22-23)**

Та хийх ёстой зүйлээ хангалттай хийх хэмжээнд өөрийн дур хүсэл, мэдрэмжээ хянадаг уу? Эсвэл таны мэдрэмж үл итгэгч хүмүүсийн хийдэг шиг тийм зүйлийг үйлдэхэд хөтөлж байна уу?

#### **(3) Эрүүл мэнддээ анхаарах (1 Коринт 6:19, 1 Коринт 10:31)**

Таны бие махбод Бурханы төлөө ажиллахад зориулагдсан юугаар ч орлуулшгүй багаж зэмсэг болохын хувьд та биедээ анхаарал тавьдаг уу? Таны бие махбод нэгэнт Бурханд хамаатай учраас үүнийг гэмтээх учиргүй. Та үүнд анхаарал болгоомжгүй хандаж болохгүй.

#### **(4) Зугаацдаг зүйлсийн сонголт (Колоссай 3:17, 1 Коринт 6:12)**

Таны зугаацаж хөгжилддөг зүйлс буруу хандлага, буруу бодолд хүргэх уруу татлага болж байна уу? Нүглийг хөгжилтэй, сэтгэл татам байдал болгон харуулах ямар ч зүйлсэд болгоомжтой хандаарай.

#### **(5) Дэг журам (Ром 13:9, Колоссай 3:19, 1 Тимот 2:8, 1 Петр 3:2)**

Хүмүүс Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн бөгөөд мөнхийн хувь тавилантай учраас бусдад хүндэтгэлтэй хандаарай. Эелдэг байх ёс заншил харилцан адилгүй ч, тухайн хүнд танил байдлаар эелдэг байдлаа илэрхийлэхэд суралцах ёстой. Хэдийгээр зарим хүн ийм хүндлэлийг хүртэх ёсгүй ч, та эелдэг хандах учиртай.

#### **(6) Ёс зүйтэй ажил хөдөлмөр (Сургаалт үгс 20:23)**

Та бүх гэрээ хэлцэлдээ бүрэн үнэнч, шударга ханддаг уу? Та аливаа зүйлийг яг байгаагаар нь тодорхойлдог уу эсвэл энэ нь үнэн биш гэж бусдыг бодоход хүргэдэг үү?

#### **(7) Цаг баримтлах (Галат 5:14)**

Цаг бол маш үнэ цэнтэй эх сурвалж бөгөөд бид үүнийг Бурханы төлөө ашиглах ёстой. Та өөрийн болон бусдын цагийг үнэлж, ажлын хуваарийг мөрддөг үү?

#### **(8) Хувцаслалт (1 Тимот 2:9, 1 Петр 3:3-4)**

Таны хувцаслалт дараах үнэ цэнийг харуулдаг уу?

- Эмх журам – биеийн хэсгийг хангалттай далдлахуйц
- Төлөв даруу – бусдын анхаарлыг татах, өмсөж буй зүйлээрээ бусдыг гайхшруулж бишрүүлэхийг бүү оролд.
- Арвич хямгач – хэрэглээнээсээ давсан өндөр үнэтэй хувцас авахгүй байх

#### **(9) Хэл яриа (Колоссай 4:6, Ефес 4:29)**

Таны хэл яриа Бурханд болон бусдад хүндэтгэлтэй, эрүүл байдаг уу? Дэлхийн хүмүүс садар самуун байдалтай холбоотой нэр томъёо, үгсийг ихэнх яриандаа хэрэглэдэг бөгөөд Бурханы талаар ярихдаа ч ийм үгсийг ашигладаг.

#### **(10) Найдвартай байдал (Дуулал 61:8; Сургаалт үгс 20:6, Сургаалт үгс 28:20)**

Та амлалт зориулалтаа хэр сахидаг вэ? Таныг ярьдаг шигээ хийдэг хүн гэж хүмүүс хардаг уу? Амлалт тань таныг тав тухгүй болгох үед та амлалтаа мартдаг уу?

Олон хүмүүс өөрсдийн өсөж хөгжих хэрэгцээг нухацтай авч үздэггүй. Тэд Бичвэрийн шууд хэлэгдсэн тушаалуудад л зөвхөн хариуцлагатай байх ёстой гэж үздэг ч, тэдгээр тушаалд олон олон амьдралын хэрэгжүүлэлт байдгийг ухаардаггүй.

Бурханыг хайрлах хайр маань өсөн нэмэгдэхийн хэрээр бид өсөж сайжирдаг гэдгийг мэдэх нь чухал юм. Энэ хичээлийн эхэнд уншсан эшлэлийг бид нухацтайгаар тунгаан бодох хэрэгтэй (Филиппой 1:9-11). Бидний хайр өсөн нэмэгдвэл зөвийг үйлдэх сонголт, ялган таних чадвар маань өсөж сайжрах учиртай.

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

- ▶ Бурхан таны сайн биш хандлага, зуршил, үйлдлийг харуулах үед таны гаргасан шийдвэр болон өөрчлөлтийн талаарх жишээг хуваалцана уу?
- ▶ Таны амьдралын хэв маягт өөрчлөлт орох хэрэгтэй ямар нэг зүйл байгаа юу? Та үүнийг хийх үү?
- ▶ Бурханыг баярлуулдаг гэдэгт баттай биш ямар нэг зүйлийг та хийсээр байна уу?
- ▶ Амьдралдаа гаргах ёстой өөрчлөлтийн талаар таны залбиралд Бурхан харуулахыг та үнэхээр хүсэж байна уу?

Тэгвэл энэ долоо хоногт залбиралд өөрийгөө зориулж, нээлттэй зүрх сэтгэлээр Бурхан танд өөрийн үнэ цэн ба амьдралдаа гаргах ёстой өөрчлөлтийг харуулахын төлөө хүсэн гуйгаарай. Та үүнд өөрийгөө зориулах уу? Та үүнийг хийсэн эсэхийг би дараагийн долоо хоногт танаас асуух болно.

### **Библийн зарчмуудыг хувьчлан хэрэгжүүлэх нь**

▶ Итгэгч хүмүүсийн дунд байдаг ялгаатай байдлыг та анзаарч байсан уу? Ялангуяа тэдний хийдэг болон хийдэггүй зүйлтэй холбоотой практик асуултаар энэ нь илүү тодорхой болдог. Яг адилхан Библи хэрэглэдэг хэрнээ тэд хоорондоо яагаад ийм ялгаатай байдаг вэ? Нэгэнт итгэгчдийн дундах ялгаатай байдал нь дэндүү их юм бол бидний хийж байгаа зүйлд энэ нь тийм ч хамаатай гэж үү? Яагаад?

Библийн зарчим болон үнэ цэнээр амьдрах талаар нарийн ширийн зүйлс дээр бүх итгэгчид санал нэгддэггүй. Гэсэн хэдий ч, Христийг дагаж байгаа хүн итгэж байгаа зүйлийнхээ дагуу амьдарч байгаа эсэхдээ нухацтай хандах ёстой.

Биеэ авч явах байдал, зугаацдаг зүйлсийн сонголт, хувцаслалт зэрэг нь бүгд хүний зүрх сэтгэлд ямар нэг зүйл гажуудаж, хазайсныг харуулдаг.

Хамгийн зөв сайн амьдралын хэв маягийг ялган танихын тулд итгэгч хүн бүр санаж байх ёстой зарим зарчмуудыг энд танилцуулья.

### **Амьдралын хэв маягт нөлөөлөх шийдвэрийг гаргах зарчмууд**

#### **(1) Итгэгч хүнд өгөгдсөн Библийн бүх тушаалыг бид дуулгавартай дагах ёстой.**

Есүс Матай 5:19-д хэлэхдээ,

Тиймээс эдгээр тушаалын хамгийн өчүүхнийг нь ч болов үл тоомсорлон, бусдад тийн заасан хэн боловч тэнгэрийн хаанчлалд хамгийн өчүүхэн нэгэн гэгдэх

болно. Харин эдгээрийг сахиж, ийн заасан хэн боловч тэнгэрийн хаанчлалд агуу нэгэн гэгдэх болно.

Бид зүгээр л өөрсдийнхөө бодлоор энэ хамгийн чухал нь гэж сонгох боломжгүй юм. Чухал биш хэмээн үл тоомсорлох ямар ч Бичвэрийн тушаал гэж үгүй.

## **(2) Бурханы тушаалууд нь бидний сайн сайхны төлөө юм.**

Дэд хууль 10:12-13,

Израил аа! ЭЗЭН Бурхан чинь чамаас юуг шаарддаг вэ? Зөвхөн ЭЗЭН Бурханаасаа айн эмээхийг, Түүний бүх замаар явахыг, Түүнийг хайрлан бүх зүрх, бүх сэтгэлээрээ ЭЗЭН Бурхандаа үйлчлэхийг мөн чиний сайн сайхны төлөө өнөөдөр миний чамд тушааж байгаа ЭЗЭНий тушаал, зарлигуудыг дагаж мөрдөхийг л шаарддаг бус уу?

Дуулал 84:11,

Учир нь ЭЗЭН Бурхан нар бөгөөд бамбай юм. ЭЗЭН нигүүлсэл ба алдрыг өгдөг. Тэрээр шулуун шударгаар явагчдаас ямар ч сайныг нуун дардаггүй.

Бурхан биднээс ямар ч сайн зүйлийг нуудаггүй, мөн Тэр бидэнд хор хөнөөл учруулах ямар ч тушаалыг өгдөггүй. Түүний хязгаарлалтгүйгээр бид сайн сайхан байх боломжгүй юм. Түүний удирдамжаас татгалзах нь бид Түүний хайр болон мэргэн ухаанд нь эргэлзэж буй хэрэг болно. Бид хүний санаа бодлуудыг дагахын оронд Түүний Үгийн заавруудыг дуулгавартай дагахдаа Бурханы мэргэн ухаан болон сайн сайханд нь үнэнхүү итгэж найддаг гэдгээ баталдаг.

## **(3) Христигэлийн эрх чөлөө нь Бурханд дуулгавартай байхаас ангид эрх чөлөө биш юм.**

Паул 1 Коринт 9:21-д итгэгчдэд хандан бичихдээ:

Хуульгүйчүүдийг олж авахын тулд (хэдийгээр би Бурханы хуулиас ангид бус харин Христийн хуулийн дор байдаг атлаа) хуульгүйчүүдэд [Мосегийн] хуульгүй нэгэн адил.

Бид Мосегийн хууль болон Бурханы ёс суртахууны шаардлагуудыг (зөвтгөлийн арга зам) аль алиныг нь агуулсан хуулиас чөлөөлөгдсөн юм. Учир нь бид Бурханы тушаалыг биелүүлснээр бус, харин нигүүлслээр аврагдсан. Түүнчлэн бидний нүглийг уучилсан учраас бид хуулийн ял, шийтгэлээс ч чөлөөлөгдсөн юм.

Гэсэн хэдий ч, бид Бурханд дуулгавартай байх болон хайрлах шаардлагаас чөлөөлөгдөөгүй. “Үнэндээ ах дүү нар аа, та нар эрх чөлөө өөд дуудагдсан юм. Гэхдээ та нар эрх чөлөөгөө махбодын төлөөх таатай боломж болгож бүү ашигла. Харин бие биедээ хайраар үйлчил” (Галат 5:13). 1 Коринт 9:21 (дээр дурдсан) эшлэлд хэлсэнчлэн бид Бурханы эрх мэдлийн дор байх болсон. Бидний төлөөх Түүний хүсэл нь Библид илчлэгджээ.

Зарим хүмүүс Бурханы хуулийг сахих нь нүглийн уучлалыг хүлээн авах арга зам, эсвэл сүнслэг төлөвшилд хүргэх арга хэрэгсэл хэмээн буруу итгэдэг. Харин жинхэнэ үнэн бол хуулийг сахиснаар биш, нигүүлслээр итгэлээр дамжуулан бид аврагдсан юм (Ефес 2:8-9).

Хэдий бид өөрсдийн хийсэн зүйлийн үр дүнд зөвтгөгдөөгүй ч, бид амьдралынхаа бүх нарийн ширийн зүйлсэд Бурханыг дагаж дуулгавартай байх ёстой. Учир нь бид Түүгээр зөв болгогдсон юм. “нүглээс чөлөөлөгдөн, [та нар] зөвийн боолууд болсон” (Ром 6:18).

Бид Бурханыг хайрлаж, Түүний нигүүлсэлд талархаж явдаг учраас бид баяртайгаар Түүнийг дуулгавартай дагадаг (1 Иохан 5:3). Зөвтгөгдсөн хүмүүсийн дуулгавартай байдал нь Түүний төлөөх хайрын нотолгоо юм (Иохан 14:15).

**(4) Хэрэв бид Бурханыг хайрладаг бол Түүний хүслээс татгалзахгүй, харин үүнийг илүү мэдэхийг хүсдэг.**

1 Иохан 5:2-3-д хэлэхдээ,

Бид Бурханыг хайрлаж, тушаалуудыг нь сахихдаа үүгээр Бурханы хүүхдүүдийг хайрладгаа мэднэ. Түүний тушаалуудыг сахих нь Бурханыг хайрлах явдал юм. Түүний тушаалууд хүнд дарамт биш.

Иеремиа 31:33-д “Израилын гэртэй Миний байгуулах гэрээ энэ юм... Би хуулиа тэдний дотор хийж, Би тэдгээрийг зүрхэн дээр нь бичнэ” гэжээ.

Бурханыг хайрладаг хүн “Үүнийг хийсний төлөө Бурхан намайг буруутгах болов уу?” гэж асуухгүй, харин “Юу Бурханыг илүү баярлуулах бол?” эсвэл “Хамгийн сайн зүйл нь юу байж болох вэ?” (Филиппой 1:10, Тит 3:8) гэж асуудаг.

**(5) Бичвэр нь амьдралдаа тогтоох тодорхой дүрэм журмын үндэслэл болдог.**

Библи зөвхөн ерөнхий зарчмуудыг өгдөггүй. 2-р даалгавар дээр христитгэлийн амьдралдаа анхаарал болгоомжтой хандах үндэслэлийг хэлж өгдөг багц эшлэлүүдийг жагсаасан байгаа. Тэдгээрийн зарим нь христэч амьдралын хэв маягийг тодорхойлох удирдамж болдог.

**(6) Амьдралын нарийн ширийн зүйлсийн талаарх дүрэм журмууд нь бидний хамгийн чухал итгэл үнэмшил биш юм.**

Фарисайчууд ийнхүү жижиг зүйлсийг ихэд онцлон алдаа гаргасан юм. Есүс Матай 23:23-д тэдэнд хандан,

Хоёр нүүрт хуулийн багш нар ба фарисайчууд та нар золгүй еэ! Та нар гаа, гоньд, зирааны аравны нэгийг хүртэл өгдөг атлаа хуулийн чухал нөхцлүүд болох шударга ёс, өршөөл, итгэлийг орхигдуулдаг. Чухамдаа бусдыг нь ч орхилгүй, эдгээрийг үйлдэх ёстой байсан юм.

Энэ эшлэлд ямар нэг үнэнийг өөртөө хамаагүй гэж өнгөрөөх тухай биш, харин зарим зүйлс бусдаасаа илүү чухал хамаатай гэдгийг хэлсэн юм. Бид хамгийн чухал зүйлсийн талаар хамгийн их санаа тавих учиртай.

**(7) Дүрэм журмыг сахих нь Бурханыг хайрлаж, Түүнд дуулгавартай байгааг нотлох хангалттай нотолгоо биш юм.**

Фарисайчуудтай хэлэлцсэн энэхүү яриандаа Есүс (Матай 23:25),

Хоёр нүүрт хуулийн багш нар ба фарисайчууд та нар золгүй еэ! Та нар аяга тавагнахаа гадна талыг нь цэвэрлэдэг ч дотор нь дээрэм тонуул, хувийн сонирхол дүүрэн аж.

Хүн маш дэг журамтай, чанд амьдралын хэв маягтай байж болох ч, Бурханыг хайрладаггүй, Түүнийг бүрэн дагахгүй амьдарч болно. Эсрэгээр, Бурханыг бүрэн зүрх сэтгэлээр хайрладаг хэрнээ зарим хэм хэмжээ, тэдгээрийн учир шалтгааныг хараахан харахгүй байх боломжтой. Тэгэхээр чанд, журамтай хүн илүү сүнслэг байх албагүй юм.

**(8) Бусдын гэрчлэлд итгэх байдал маань тэдний амьдралын жижиг нарийн ширийн зүйлсээс хамаардаггүй.**

Ром 14:10-д Паул итгэгчдээс ийн асуужээ.

Тийн атал та юунд ах дүүгээ шүүнэ вэ? Бас та юунд ах дүүгээ басамжилна вэ? Бид бүгдээрээ Бурханы шүүх суудлын өмнө зогсох болно шүү дээ.

Энэхүү эшлэл нь амьдралын практик асуудлуудын талаарх итгэгчдийн өөр өөр үзэл баримтлалыг тусгасан багц хэсгээс гаралтай. Христийг дагадаг хүн хийж болох, болохгүй зүйлсийн талаар санал зөрөлддөг, үндэслэл сайтай мэтгэлцээнүүд цөөнгүй байдаг.

Бичвэрийн тодорхой эшлэлийг хөрвүүлж байгаа бидний тайлбартай өөр нэгэн итгэгч санал нийлэхгүй байж болно. Магадгүй бидний хувьд хор хөнөөлтэй, татгалздаг зүйлсийг өөр хэн нэгэн тэгж харахгүй ч байх боломжтой. Энэ нь магадгүй, түүний амьдралын өөр талбарт Бурхан ажиллаж буйтай, эсвэл Бурхан түүнийг өөр ялгаатай ахуй соёлд байлгаж байгаатай холбоотой байж болох юм. Энэ нь тухайн хүн жинхэнэ итгэгч биш гэсэн үг биш.

► Та дараах өгүүлбэрийг уншаад юу гэж бодох вэ? “Бурхан хүн бүрд хэрхэн амьдрах талаарх үнэнийг харуулдаг учраас бүх итгэгчид адилхан амьдралаар амьдрах ёстой.”

Христийн дагалдагчид амьдралын практик асуудлууд дээр хэзээ ч санал нэгтэй байгаагүй. Бурханыг хайрладаг, бурханлаг амьдралаар амьдардаг хүмүүс ч гэсэн онол сургаалын нарийн ширийн зүйлс болон тэдгээрийн хэрэгжүүлэлт тал дээр бүгд санал нэгтэй байдаггүй. Бид тэднийг Бичвэрийг өөрөөр хөрвүүлж, өөрөөр хэрэгжүүлж байгаа учраас итгэгчид биш гэж хэлэх нь буруу юм. Тэдний бодол ойлголт нь буруу гэж бид

бодсон ч гэсэн тэднийг чин сэтгэлээсээ итгэж байгаагаар нь хүлээн авах боломжтой. Ариун Сүнсний ажил бүх итгэгчдийг яг адилхан амьдралын хэв маягтай болгодоггүй.

Бид түүнчлэн бусад итгэгчдийн үзэл бодлоос суралцахдаа нээлттэй байх учиртай. Бардам зангаасаа болоод миний Бичвэрийн хөрвүүлэг болон хэрэгжүүлэлт үргэлж төгс зөв байдаг гэж бид бодоход хүрдэг. Даруу, суралцдаг, бусдыг хүлээн авдаг чанар Христитгэлийн эв нэгдлийг хөгжүүлж, Христийн Биеийг босгон байгуулдаг.

**(9) Олон янзын бодол санаанд хүлээцтэй хандах нь өөрийн бодолдоо хайхрамжгүй хандах шалтаг биш юм.**

“Хүн бүр өөрийн бодолдоо бат итгэлтэй байг” (Ром 14:56).

“Харин эргэлзэгч нэг нь идэх аваас яллагдана. Учир нь тэрээр итгэлээр бус байна. Итгэлээр бус алив бүхэн нь нүгэл юм” (Ром 14:23).

Хүн мөс чанарынхаа эсрэг үйлдэж, зөрчих үедээ маш их гарз хохирлыг амсдаг. Хэрэв хүн буруу гэж боддог зүйлээ хийхээр шийдэхэд, тэр нүглийн гэм буруутан болдог. Бурханы өгсөн гэрэлд алхдаг нэгэн ерөөлтэй еэ (1 Иохан 1:7).

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

Энэ сэдвийн дагуу ярилцлагыг эхлүүлэхэд ямар нэгэн хүндрэл байхгүй. Зарим суралцагчид итгэгч хүн биеэ авч явах талаар чуулган тодорхой дүрэм журамтай байхыг онцолж болно. Харин зарим суралцагчид бие биеийнхээ ялгаатай байдалд хүлээцтэй хандахыг онцолж ч болох юм.

Дээр дурдсан 9 зарчим тус бүрийг тэгш шударгаар авч үзэхийг хичээгээрэй.

- ▶ Эдгээр зарчмын алийг нь олон хүмүүс мартдаг вэ?
- ▶ Эдгээр зарчмын алийг нь та хамгийн их мартдаг вэ?

### **Залбирал**

Тэнгэрлэг Эцэг минь,

Таныг хайрлах хайр минь үргэлж өсөн нэмэгдэхийг би хүсэж байна. Надад хандсан Таны хүслийг би илүү сайн ойлгохыг хүсэж байна.

Таныг хамгийн ихээр баярлуулдаг зүйлийг ялгаж сурахад надад туслаач. Тэгвэл би цэвэр ариун, гэм зэмгүй амьдралаар амьдарч чадна.

Өөрчлөх хэрэгтэй зуршил, хандлагуудаа олж харахад болон Таныг алдаршуулдаг хандлага, дадал хэвшлийг олж авахад минь туслаач.

Бурханы алдрын төлөө би үр жимс ургуулахыг хүсэж байна.

Амен

## 2-р хичээлийн даалгавар

(1) 1 Коринт 13-р бүлгийг судал. Энэхүү бүлэгт хайрладаг хүний талаар болон тийм хүн бусдын төлөө байдгийг тодорхойлжээ. Таны амьдралыг хайрынхаа дагуу байлгаж, таныг хэрхэн өөрчлөхийг хүсэж байгаагаа Бурхан танд харуулах болтугай. Амьдралдаа өөрчлөлт гаргахад Бурхан туслаасай гэсэн зарим өөрчлөлтийг жагсаан бичнэ үү.

(2) Итгэгч хүн хэрхэн биеэ авч явах талаарх Бичвэрийн үндэслэл болох дараах эшлэлүүдийг судлаарай:

- 1 Коринт 6:19-20
- 1 Коринт 10:31
- 1 Коринт 11:14-15
- 1 Тимот 2:9-10
- 1 Петр 3:3-4
- Дуулал 19:14
- Дуулал 101:3

Багц эшлэл бүрийн үндсэн утгыг бич. Эдгээр эшлэлд үндэслэн, таны хэрэгжүүлэхийг хүсэж байгаа амьдралын хэв маягийн талаарх нарийн ширийн зүйлсийг тодорхойлно уу.



## 3-р хичээл

### Ажил

#### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах ойлголт, чадварт суралцсан байна:

- (1) Библид ажлын талаар юу заадгийг тайлбарлах.
- (2) Христэд ажил мэргэжлийн ёс зүйтэй холбоотой шинж чанаруудыг таньж мэдэх.

#### Бурханы ажилчин, ах Лоренс

Ах Лоренс нь 1600-аад оны үед сүмд амьдарч байсан эгэл жирийн санваартан юм. Тэр маш энгийн ажил хөдөлмөрөөрөө олонд танигджээ. Түүний хувьд төмс арилгаж, аяга таваг угаах нь Бурханы хайраас ундрах үйл хэрэг бөгөөд эдгээрийг хийхдээ тэр Бурханы оршихуйг оюун бодлоосоо хэзээ ч холдуулдаггүй байв. Тэр бүхий л амьдралынхаа төвд Бурханыг байлгасан бөгөөд ажил хөдөлмөр нь ч тийм байжээ.

*Бурханы оршихуйг амьдралдаа дадлагажуулах нь* хэмээх маш товч байдлаар бичигдсэн номыг олон сая хүмүүс уншсан байдаг. Энэ ном ах Лоренстой хийсэн ярилцлага, түүний захидлуудыг багтаажээ. Тэрээр “Бид ариусгагдахын тулд ажлаа өөрчлөх шаардлагагүй бөгөөд харин тэдгээрийг өөрсдийнхөө төлөө хийхийн оронд Бурханы төлөө хийх учиртай” гэж хэлсэн байдаг.

► Ажил гэж юу вэ? Энэ нь ямар нэг зүйлийг хийхийн тулд хөлсөөр зөвхөн *хөдөлмөр эрхлэх* төдий зүйл мөн үү?

Мэдээж ажилд хөдөлмөр эрхлэлт гэсэн ойлголт багтахас гадна, өөртөө болон өрөөлд санаа тавих, өөрт байгаа зүйлсийг зохицуулах, бүтээгдэхүүн бий болгох, ашиг орлогын төлөө бизнес хийх, мөн үнэ хөлсгүй бусдад туслах ч багтдаг.

► Итгэгч хүн ажил хөдөлмөр хийх ёстой юу? Яагаад?

Олон хүмүүс хангалттай мөнгөтэй болчихвол ажил хийх шаардлагагүй болно гэж боддог. Тэдний хувьд хамгийн аз жаргалтай амьдрал бол юу ч хийхгүй, эрх дураараа байх явдал юм.

#### Ажлын талаарх Библийн ойлголт

Бурхан бүтээлийн эхэнд дэлхийг хэрхэн бүтээснийг бодож үзье. Энэ нь анх төгс байжээ (Эхлэл 1:31). Бурханы бүтээсэн анхны хүмүүсийг төгс төгөлдөр орчин угтан авсан. Бурхан анхны хүмүүст ажил хөдөлмөрийг даалгав (Эхлэл 1:28). Бурхан анхнаасаа хүн ажил хийхгүйгээр бүх хэрэгцээ нь хангагдсан байхаар дэлхийг бүтээж болох байсан ч,

Тэр тэгсэнгүй. Хүмүүсийн хувьд хамгийн сайн сайхан амьдрал нь ажил хөдөлмөртэй холбоотой болохыг Бурхан мэддэг.

Бидний ажил хөдөлмөрийг бусадтай харилцах байдлаар Бурхан төлөвлөсөн. Хүмүүс бие биенийхээ өмнө хариуцлага хүлээх, нэг нэгнээсээ хамааралтай байх, давуу талаараа сул дорой нэгэнд туслах, хамтдаа бэрхшээлтэй нүүр тулах, зөрчлийг шийдвэрлэх, алдааг засах, бусдыг сургах болон бусдаас сурах зэргээр хамтарч ажиллахад суралцдаг.

Бурхан хүмүүст газар дэлхийг захирч, хяналтдаа байлгах эрх мэдлийг өгсөн бөгөөд үүнийг Бурханы алдрын төлөө хөгжүүлэх үүрэг хариуцлагыг ч олгожээ. Энэхүү үүрэг даалгавар нь хөдөө аж ахуй, мал сүрэг, газрын баялаг олборлолтыг хөгжүүлэх болон технологийн хөгжилд хөтөлсөн юм.

Бидний дотор Бурханы мөн чанартай адил зарим чанарууд байдаг учраас Тэр биднийг байгаль дэлхийгээс дээгүүр бүтээжээ. Дуулал 8:6-8-д хэлэхдээ,

Та түүнд [хүмүүн] мутрынхаа бүтээлүүдийг захируулж Та бүх юмсыг түүний хөл дор тавьсан нь хонь үхэр бүгд, мөн хээрийн араатан амьтад, тэнгэрийн шувууд болон далайн загас усан замаар сэлэгч бүхэн юм.

Анхны нүглийн улмаас дэлхий өөрчлөгдөж, ажил хөдөлмөрт олон хүндрэл, зүдүүр үүсэх болжээ. Энэ нь Бурханы анхдагч загвар төлөвлөгөө байгаагүй юм (Эхлэл 2:17-19). Хэдий тийм боловч, бидэнд ажил хөдөлмөр хэрэгтэй байхаар Бурхан биднийг бүтээсэн гэдгийг ойлгох ёстой.

Бидний ажил Бурханы бүтээлийн ажилтай адил төстэй. Ажил бол хүрээлэн буй орчноо өөрчлөх хүний арга зам билээ. Амьдралаа залгуулах нь ажил хөдөлмөрийн цорын ганц зорилго биш юм. Хүмүүст хүрээлэн буй орчноо өөрчлөх инстинкт байдаг. Тэд гэр орноо сайжруулж, хогоо эмхэлж хаядаг. Ажил хөдөлмөр хийх дургүй хүн бол эргэн тойрноо өөрчлөх хүсэлгүй, энэ чадвартаа буулт хийж байгаа хүн юм. Өөрөөр хэлбэл хүн байхын нэгэн чухал хэсгийг орхигдуулж байна гэсэн үг.

► Арчилж тордоггүй, навсгар гэр орон, хашаа хороог харахдаа та юу боддог вэ?

Хүний доторх Бурханы дүр төрхийн нэг хэсэг нь *ажил* бөгөөд үүнд бүтээх, төлөвлөх, зохион байгуулах болон үйлдвэрлэх чиг хандлага багтдаг. Иймд итгэгч хүний хувьд бүх ажил эрхэм нандин зүйл юм. Эзэнийг баярлуулахаар хийгдэж буй бүх ажил мөргөл хүндлэлийн үйлс мөн (Колоссай 3:17, 23). Есүс, Эцэг маань ажилласаар байна, тиймээс Би ч ажилладаг хэмээн хэлжээ (Иохан 5:17).

Ажлыг бид гашуун эм уухтай адил таагүй хэрэгцээ гэж бодох ёсгүй. Ажил нь зөвхөн амь зуухад л шаардагдах зүйл биш юм. Энэ нь хүн төрөлхтөнд хандсан Бурханы загвар төлөвлөгөөний нэг хэсэг билээ.

2 Тесалоник 3:10-д биднийг ажил хийх ёстой гэж хэлсэн байна. “Бид та нартай хамт байхдаа хүртэл ‘Хэн ажил хийхийг үл хүснэ, тэр нь бүү идэг’ гэж тушаадаг байсан.”

Хэрэв миний хийж байгаа ажил ач холбогдол муутай санагдвал би яах ёстой вэ? Махатма Ганди “Таны хийж байгаа зүйл ач холбогдолгүй санагдаж болох ч, та үүнийг хийж байгаа нь л хамгийн чухал ач холбогдолтой” гэж хэлсэн байдаг. Хэн нэгэн үйлчилгээний ажил хийхээр байгууллагад ажилд орсон гэж төсөөлье. Шал угаах нь ач холбогдолгүй санагдаж болох ч тэр хүн чухал сонголт гаргаж байгаа юм. Өдрийг зүгээр дэмий өнгөрөөж, хэнд ч тус нэмэр болохгүй байхаас илүү сонголтыг тэр өдөр бүр ажилдаа явснаар гаргаж байгаа хэрэг. Гэр бүл, найз нөхдийнхөө хүч хөдөлмөрийг сорж амьдрахын оронд тэр хүн өөрийгөө хангаж, хариуцлага хүлээх сонголтыг хийж байна. Тэрээр гэр бүл, хүүхдүүдээсээ тусламж асуухын оронд өөрөөс нь хамааралтай тэдгээр хүмүүст санаа тавьж чадна. Эдгээр анхаарал хандуулах зүйлс ажил нь дангаараа чухал биш санагдаж болох ч, хүн үүнийг хийхээр сонгож байгаа нь чухал болохыг бидэнд ойлгуулдаг.

Үнэхээр ажил хийж чадахгүй олон хүмүүс байдаг болов уу? Үгүй. Цалин хөлс авахуйц ажил хийх боломжгүй хүн байж болох ч, бусдын хэрэгцээнд туслах ямар нэг зүйлийг тэр хүн хийж чадна.

Христийг дагадаг хүмүүс өөртөө болон өрөөлийн өмнө хариуцлага хүлээдэг учраас ажил хийх ёстой. Өөрсдийн хийж чадах зүйлээ хийх хүсэлгүй, хэрэгцээгээ бусдаар хангуулахаар бусдын гар харж болохгүй.

Итгэгч хүн эхлээд гэр бүлдээ хариуцлагатай байх ёстой. “Харин хэн нэгэн нь өөрийнхнийгөө, ялангуяа гэр бүлийнхнээ тэтгэдэггүй бол тэрээр итгэлээ үгүйсгэсэн хэрэг бөгөөд итгэгч бус хүнээс ч дор юм” (1 Тимот 5:8).

Бусдын хэрэгцээнд тусалж чадахын тулд итгэгч хүн ажил хийх ёстой гэж Бичвэрт тушаасан байдаг. “Хулгайлсан нь цаашид бүү хулгайл. Харин ч гачигдалтай хүнд хуваалцах юмтай байхын тулд [өөрийн] гараар сайныг үйлдэж, хөдөлмөрлөн зүтгэ” (Ефес 4:28). Юу ч төлөхгүйгээр авч байгаа хулгайч нэгнийг ажил хийгээд бусдад өгч чадах нэгэнтэй эсрэгцүүлж харуулж байна. Итгэгч нь зөвхөн хулгай хийдэггүй хүн байгаад зогсохгүй, бусдад өгөхийн тулд ажилладаг нэгэн юм.

Хэн ч таныг ажилд авахгүй байсан ч та хийх ажил олж чадна. Бусдын хэрэгцээнд тусалж чадах арга замыг хайж олоорой. Юу ч хийхгүй, хэн ч өөрт нь туслахгүй байна гэж гомдоллож сууснаас энэ нь илүү дээр юм.

Итгэгчид өөрийгөө болон гэр бүлээ хангахын тулд, мөн хэрэгцээтэй нэгэнд өгч чадахын тулд ажиллах ёстой.

### **Бидний хэрэгцээг хангадаг Бурханы ердийн арга зам**

► Би ажил хийхгүй, Бурхан миний хэрэгцээг хангах болно гэж ярьдаг хүмүүст та юу хэлэх вэ?

Намрын сүүлээр та ногооны талбайдаа алхаж явна гэж төсөөлье. Хэсэг том талбайд төмс, байцаа, хүнсний олон төрлийн ногоо гарц сайтай, өвлийн хэрэгцээнд хангалттай хэмжээгээр ургасан байхыг харав.

Үүнийг харахдаа та гайхамшиг тохиожээ гэж хэлэх үү? Олон мянган тариаланчдын хувьд ийм зүйл намрын сүүлээр тохиолддог шүү дээ. Тэд ногооны талбайгаа эргэж, боловсорч буй ногоонуудаа олж хардаг. Ингэхдээ тэд гайхаж, цочирддоггүй. Учир нь хэдэн сарын өмнө тэд хөрсөө сийрэгжүүлж, үрээ суулгаад хэдэн сарын турш усалж, хогийн ургамлыг түүж арчилдаг. Ингээд тэд хүсэн хүлээсэн ногоо нь боловсорч гүйцсэнийг хардаг.

“Энэ нь ердөөсөө ч гайхамшиг байгаагүй” гэж та хэлж болно. Гэхдээ, хүмүүсийн нэгийг нь ч бий болгоогүй, сая сая ургамлыг Бурхан ургуулдаг гэдгийг мартаж болохгүй. Дуулал 104:14 эшлэлд “Тэрээр мал сүрэгт зориулан өвсийг, хүний хэрэгцээнд зориулан ургамал ногоог ургуулдаг нь газар шорооноос хүнсийг гаргуулахын тулд агаад” гэж хэлсэн. Бурхан үүнийг хийдэг бөгөөд харин хүмүүс хөрсийг бэлтгэж, үр суулган, шаардлагатай усалгааг хийснээр үүнд бэлтгэдэг.

Есүс өвчтэй хүнийг эдгээсэн, нарыг байранд нь зогсоосон түүх шиг, Бурхан байгалийн хуульд захирагдахгүй, ер бусын байдлаар үйлддэг гэж олон хүмүүс боддог. Харин энэ тохиолдолд ургамал ногоо боловсрох нь гайхамшиг биш, харин энэ нь ердийн зүйл юм.

Бид гайхамшигийг хүсэмжлэхдээ юмсыг үйлддэг Бурханы ердийн арга замыг дэндүү амархан мартдаг. Өнөөдөр олон арван сая хүмүүс ногооны талбайдаа ургацгүй, идэх зүйлгүй байсаар байна. Тэд хүнс ногоог ургуулдаг Бурханы арга зам болох ажил хөдөлмөрт оролцдоггүй. Хүнсийг ургуулдаг үйл явц нь Бурхан ердийн арга замаар ажилладаг гэдгийн л нэг жишээ юм. Жишээлбэл, хүний хэрэгцээг хангадаг Бурханы ердийн арга зам нь хүний ажлаар дамжуулан хийгддэг. Сургаалт үгс 14:23 эшлэл бидэнд заахдаа, “Зүтгэл бүхэн ашиг авчирдаг” гэсэн бол Сургаалт үгс 19:15-д “Лазан хүн өлсөхийн зовлонд өртөнө” гэж сэрэмжлүүлсэн байдаг.

Бурхан өөрт нь ямар нэг зүйлийг хангаж өгөөсэй гэж хүсдэг хүмүүс бий. Харамсалтай нь тэд ажиллах боломжоос татгалздаг. Учир нь эдгээр нь тэдний хийхийг хүсдэг зүйлс биш байдагтай холбоотой.

Та ажил хийх хүсэлтэй ч, хэн ч таныг ажилд авахгүй байвал яах вэ? Та бусдад тусалж чадах ажил бий. Ийм ажлаар дамжуулан таны зарим хэрэгцээ хангагдах боломжтой. Та ажил эрхлээгүй байгаа ч, танд цаг хугацаа байгаа. Тиймээс өөрийн эргэн тойрныг хараад тусламж хэрэгтэй нэгэнд тусалж болохгүй гэж үү?

Ажил хөдөлмөр эрхэлдэггүй, өдөржин юу ч хийхгүй, зүгээр сууж цаг нөхцөөдөг хүнийг төсөөлж үзээрэй. Түүнд үнэхээр хийх үнэ цэнтэй зүйл байхгүй гэж үү? Түүний хөрш, айл саахалтын хүмүүст тусламж хэрэгтэй л байгаа. Түүний хашаа хороо эсвэл гудамж талбайд нь цэвэрлэх ажил, хаях хог байж л байгаа. Хүнс ногоо тарих жаахан газар олдох л байх. Мэдлэгээ нэмэгдүүлэхийн тулд унших ном ч олдох боломжтой. Хэн нэгний

төлөө залбирч чадна. Юу ч хийхгүй суугаад байгаа хүн ганцхан ажилчинтай бөгөөд тэрээр юуг ч хөгжүүлдэггүй, юуг ч бүтээдэггүй. Тэр өөрөө сайн ажил олгогч биш учраас бусдыг удирдан зохион байгуулах боломж түүнд олдохгүй ч байж мэднэ.

Олон газар оронд ихэнх хүмүүсийг ажилд авахгүй байх нь элбэг учраас тэд солилцож болох ямар нэг зүйлийг үйлдвэрлэх, эсвэл бусдад ямар нэгэн үйлчилгээг санал болгодог. Эдгээр нь бүгд Бурхан биднийг хангадаг арга замууд юм.

### **Ажил эрхлэлтийн талаарх Библийн зарчмууд**

Үнэнч шударга, хариуцлагатай байх зарчим нь итгэгчид ажил хөдөлмөртөө хэрэгжүүлэх ёс зүйг хангаж өгдөг.

► Итгэгч хүн ажил олгогчтой харилцахдаа хэрхэн Библийн зарчмыг хэрэгжүүлэх вэ?

Шинэ гэрээнд ажилчдад зориулсан заавар чиглүүлэг өгөгдсөн байдаг. Шинэ гэрээ бичигдэх үеийн олон ажилчид нь боолууд байжээ. Өнөөгийн ажилчин хүн өөр өөр ажил олгогчтой ажиллах боломжтой тул тухайн үеийн боолоос ялгаатай. Энэхүү эрх чөлөө нь тэдэнд ажил олгогчийн нөхцлийг хүлээн авах эсвэл татгалзах боломжийг олгодог. Гэсэн хэдий ч, хэрэв тэд тодорхой ашиг сонирхлын төлөө ажиллахаар тохиролцсон бол тэр ажил олгогчтой байх хугацаандаа сайн ажилчин байх ёстойг Бичвэр шаарддаг.

Та хийхийг хүссэн ажлаа сонгох боломжгүй тийм нөхцөлд ажилладаг байж болно. Магадгүй та дарамттай нөхцөлд ажиллахаас өөр аргагүй ч байх боломжтой. Гэхдээ танд Христийн хандлага байх учиртай. Зарим хүмүүс ажиллах хүсэлгүй байгаагаа харуулж удаан, муу ажилладаг. Ийм хүн чөлөөтэй ажиллаж чаддаггүй. Та дарамтгүй чөлөөтэй хийхийг хүсвэл ажлаа сайнаар, урамтайгаар хийх хэрэгтэй. Ингэж чөлөөтэй, урамтай ажиллах үед хэн ч таныг хий гэж албадахгүй.

Таныг хэн ч ажилд аваагүй ч гэсэн та өөрөө өөрийнхөө зөвлөгч, чиглүүлэгч юм. Та өөрөө өөртөө ямар төрлийн ажилчин байсан бэ?

### **Ефес 6:5-8 — Хариуцлагатай байх зарчим**

► Нэг суралцагч Ефес 6:5-8 эшлэлийг бүлэгт уншина. Энэ багц эшлэлийн утгын талаар ярилцаж, дараах жагсаалтад өөрийн ажиглалтыг нэмээрэй.

Ефес 6:5-8 эшлэлийн зарим хэрэгжүүлэлтүүд:

1. Ажилчин ажил олгогчид дуулгавартай хандана. Зөвхөн харж байх үед нь биш, харин бүх цаг үед. Энэ нь мөн шалгахгүй юм чинь гээд нарийн ширийн зүйлсийг хайхрахгүй хийхэд ч хамаатай (“...нүдэн дээр үйлчлэлгүй...”).
2. Ажилчин хүн ажлаа Бурханы төлөө мэт хичээнгүй, чанартайгаар хийж гүйцэтгэх ёстой (“...Христийн боолууд ёсоор Бурханы хүслийг зүрх сэтгэлээсээ үйлд...”).
3. Ажилдаа итгэмжтэй байснаараа ажилчин Бурханы ерөөлийг хүлээн авдаг (“тэрээр Эзэнээс түүнийгээ буцааж авна...”).

## **Тит 2:9-10 — Үнэнч шударга байх зарчим**

► Нэг суралцагч Тит 2:9-10 эшлэлийг бүлэгт уншина. Энэ багц эшлэлийн утгын талаар ярилцаж, дараах жагсаалтад өөрийн ажиглалтыг нэмээрэй.

Тит 2:9-10 эшлэлийн зарим хэрэгжүүлэлтүүд:

1. Ажилчин ажил олгогчийн заавар чиглүүлэгт хүндэтгэлтэй хандана (“...зөрж эсэргүүцэлгүй...”). Ажилчин хүн ажил олгогчийнхоо талаар хүндэтгэлгүй байдлаар бусад ажилчдад яривал үр дүнд нь юу болох вэ?
2. Ажил олгогч нь түүнд их төлөх ёстой гэж бодсон ч гэсэн, ажилчин түүнээс хулгай хийх ёсгүй (“...шамшигдуулалгүй...”).
3. Ажилдаа итгэмжтэй хандах нь сайнмэдээний төлөөх гэрчлэл болдог. Харин итгэмжгүй байдал нь сайнмэдээг үнэ хүндгүй болгодог (“...Тэгвэл хүмүүс бидний Аврагч Бурханы сургаалыг бүх талаар хүндэтгэнэ...”).

► Зарим хүмүүс ажилдаа үнэнч шударга ханддаггүй ямар төрлийн жишээг мэдэх вэ? Итгэгч хүн үүнээс хэрхэн өөр байх ёстойг тайлбарла.

Тит ба Ефес захидлуудад ажилчин ажил олгогчийнхоо төлөө хэрхэн ажиллах талаар өгүүлсэн байдаг. Түүнчлэн ямар нэг зүйлийг барьж байгуулах, засварлахын тулд хэн нэгнийг хөлслөн ажиллуулахад ч мөн адил зарчим үйлчилнэ. Тэрээр хэн нэгнийг өөрт нь хийхийг хүсдэг шигээ чанартай ажлыг хийх ёстой. Худалдаа хийдэг хүн борлуулж буй зүйлийнхээ согог алдааг нууж, худалдан авагчид сайн чанартай гэж ойлгуулах ёсгүй.

### **Ажил олгогчийн хүсдэг чанаруудыг хөгжүүлэх нь**

Ажил олгогчид ажилчнаас ямар чанарыг хүсдэг вэ? Судалгаагаар хийж буй ажлынхаа талаар эерэг хандлагатай хүмүүсийг ажил олгогчид хүсдэг болохыг тогтоосон байна. Суралцахад бэлэн, найдвартай хүмүүсийг тэд хүсдэг. Хүмүүс гол төлөв чадвар, сурсан зүйлээсээ илүүтэй хандлагаасаа болж тухайн ажилд тэнцсэн байдаг. Бурхан мөн адил ажилдаа хандах бидний хандлагыг анхаардаг талаар бид Бичвэрээс хэдийн харсан.

Таныг үнэ цэнтэй ажилчин болгох тийм чанаруудыг хөгжүүлээрэй. Та үйлчлэхэд бэлэн байх ёстой. Танд үнэнч, найдвартай, тэвчээртэй чанар хэрэгтэй. Зарим ажилчид зөвхөн өөртөө хэрэгтэй зүйлсийг л боддог. Танд туслахын тулд ажил олгогч таныг ажилд аваагүй. Харин таныг өөрт нь туслуулахын тулд ажилд авч байгаа. Та ажил олгогчийнхоо үнэ цэнтэй хүн нь байх учиртай.

Ажилчин магадгүй, “Надад илүү хөлс төлвөл би илүү найрсаг, шударга байж, тусламаар байна” гэж ажил олгогчдоо хэлж болох юм. Гэтэл ажил олгогч найрсаг бус хүнийг илүү найрсаг байлгахын тулд ажил санал болгодоггүй. Түүнчлэн үнэн ч бус хүнийг үнэнч байлгахаар тэд хөлс төлөхгүй. Тэд найрсаг, тусч, үнэнч хүнийг л ажилд авна.

Харин чуулганд энэ бүхэн өөр байдаг. Хүмүүст туслахаасаа өмнө тэд эхлээд бидэнд өгч, найрсаг байхыг бид хүлээдэггүй. Түүнчлэн таныг сайн зүйл хийхээс ч өмнө Бурхан танд хүрч, таныг ерөөсөн юм. Харин та хүлээж авсан энэхүү ач тусын төлөө, нигүүлсэлд нь хариу үйлдэх хэрэгтэй болдог. Инээж, өгч, үйлчилж сураарай.

Өөрийн чанар чансааг хөгжүүл. Хүмүүстэй ажиллахдаа тэдэнд байгаа чадваруудаас суралц. Та бусдад үйлчлэлийг санал болгох боломжтой. Магадгүй та борлуулах бүтээгдэхүүнийг ч бий болгож чадна. Хүнсний ногоо тарих ч боломжтой. Хамгийн чухал нь, та ашиг хүртэхгүй байсан ч бусдад туслах хандлагатай байх хэрэгтэй. Бурхан тийм хүний үйлчлэлийг ерөөх болно.

Үйлчлэх гэдэг нь юу гэсэн үг вэ? Хэн нэгний ашиг тусын төлөө та өөрийн эрч хүч, цаг хугацаа, боломж нөөцийг ашиглахыг үйлчлэх гэдэг.

Та ажил олгогчийн дор ажиллаж байна уу, үгүй юу гэдгээс шалтгаалахгүй, үйлчлэх нь өөрийн зарим давуу байдал, эрхээ хойш тавихыг танаас шаарддаг. Жишээлбэл, та бусдын төлөө ажиллаж байхдаа, хүссэнээрээ унтах цагаа өглөө бүр гаргаж чадахгүй байх, хийхийг хүссэн зүйлдээ цаг гаргах боломжгүй ч байж мэднэ. Таныг ажилд авсан зорилгын төлөө та амьдралынхаа зарим талбарыг нийцүүлэх хэрэгтэй. Таны эрхэлж байгаа ажил бусадтай хэрхэн харилцах, ямар хувцас өмсөхөд ч нөлөөлдөг.

Үйлчлэхэд бэлэн байх нь олон ашиг тусыг танд авчирна:

1. Энэ нь таны зарим хэрэгцээг хангах харилцаа холбоог бий болгодог. Гол төлөв энэ нь урьдаас таамаглах аргагүй тийм байдлаар явагддаг. Тиймээс энэ нь таны төлөө ямар нэгэн зүйл хийж чадах хүмүүст зөвхөн тусалж байгаа хэрэг биш юм.
2. Энэ нь таныг Христийн Бие болох чуулганы дотор үнэ цэнтэй газарт аваачих болно.
3. Энэ нь таныг хэн нэгэн ажилд авахыг хүсдэг тийм хүн болгодог.

Бусдад туслах арга замыг хайдаг шинэ хандлагыг та өөртөө бий болговол юу болох вэ? Есүс "Авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй" (Үйлс 20:35) гэж хэлсэн байдаг. Та үүнд үнэхээр итгэдэг үү? Та үүнд итгэдэг шигээ амьдардаг уу?

Зөвхөн өөрийн хэрэгцээг л бодохоос илүүтэй бусдын хэрэгцээнд санаа тавих тухай сүнслэг зарчим байдаг (Филиппой 2:4). Мөн практик зарчим ч бий. Гэхдээ та нэг зүйлийг санаарай, ажил олгогч нар ихэвчлэн ажилд авсан хүмүүстээ туслахын тулд үүнийг хийдэггүй. Тэдний хэрэгцээг хангаж чадна гэж бодсон хүнээ л тэд ажилд авдаг. Хүн зөвхөн өөртөө ямар нэг зүйлийг хийлгэх тухай л бодож ажилд авдаг бол энэ нь тийм ч үнэ цэнтэй байж чадахгүй.

Хүмүүс ажиллах хүсэлтэй байх үед л олон зүйл болдог. Эдгээр ашиг тус нь гэнэтийн, хүсэн хүлээгээгүй байх үед тохиолдвол гайхамшиг мэт санагдаж болох юм. Гэсэн хэдий ч, Бурхан таны амьдралд эдгээр ашиг тусыг авчрахдаа энгийн арга замыг хэрэглэдэг.

Хэрэв та Бурханы танд өгөх дуртай арга замаар тусламжийг хүлээн авахдаа хойрго хандаж, ажиллах хүсэлгүй байвал Түүнээс гайхамшиг хүсэж, найдан хүлээх нь тэр ч бүү хэл залбирах нь ч гэсэн цагаа дэмий үрсэн хэрэг байх болно.

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

- ▶ Ажил олгогчийн сайн ажил хэрхэн сайнмэдээний төлөөх боломж болсон талаарх түүхийг хэн нэгэн хуваалцаж болно.
- ▶ Хөршдөө тусалснаар христитгэлийн хайр халамжийн сайн жишээ болсон түүхийг хэн нэгэн хуваалцах боломжтой.
- ▶ Ажил хайж байгаа хүмүүст туслах ямар боломж бололцоо байгаа талаар бүлгээрээ ярилцаарай.

### **Залбирал**

Тэнгэрлэг Эцэг минь,

Бүтээлчээр ажиллах завшааныг надад олгосон Танд баярлалаа. Бусдад туслах боломжийг олж харахад надад туслаач. Өөрийнхөө болон бусдын өмнө хариуцлага хүлээн ажилласнаар хэрэгцээг минь хангаж өгнө үү.

Нөөц боломжоор намайг хангаж, ерөөж өгөөч. Ингэснээр би бусдын хэрэгцээнд тусалж, чуулгандаа өгч, гэр бүлээ тэтгэж чадна.

Өөрийн хүлээсэн бүхий л үүрэг хариуцлагадаа үнэнч, найдвартай байхад надад туслаач. Хэрэв энэ нь Таны хүсэл бол, илүү агуу боломж, үүрэг хариуцлагын төлөө намайг бэлтгэж өгнө үү. Надад үргэлж итгэмжтэй ханддаг Танд баярлалаа.

Амен

### 3-р хичээлийн даалгавар

(1) Эдгээр эшлэлийг судал:

- Сургаалт үгс 6:6-11
- Сургаалт үгс 10:4-5
- Сургаалт үгс 12:11, 24, 27
- Сургаалт үгс 13:4, 11
- Сургаалт үгс 14:23
- Сургаалт үгс 18:9
- Сургаалт үгс 20:13
- Сургаалт үгс 22:29
- Сургаалт үгс 24:30-34
- Сургаалт үгс 26:13-16

Ажил болон залхуурлын талаарх санаа, хэрэгжүүлэлтээ нэг хуудсанд багтаан бич.

(2) Дараах сэдвүүдээс нэгийг сонгож, ангийнхаа нэг суралцагчийн хамтаар толилуулга бэлтгэх (Ангийн удирдагч баг болгонд сэдвийг хуваарилж болно). Дараагийн хичээлийн цагийн эхэнд толилуулгаа хуваалцаарай.

- Хүний доторх Бурханы дүр төрх ба ажил
- Өөрийн болон бусдын төлөөх хариуцлага ба ажил
- Итгэгч хүн хэрхэн ажиллах ёстой талаар (Энэхүү толилуулга Ефес 6:5-8 ба Тит 2:9-10 эшлэлд үндэслэгдсэн байх).
- Хүмүүсийн хэрэгцээг хангадаг Бурханы нийтлэг арга зам
- Ажил ба бусадтай харилцах харилцаа



## 4-р хичээл

### Харилцаа

#### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах ойлголт, чадварт суралцсан байна:

- (1) Бусадтай харилцахдаа хайр, амар тайван, хүндэтгэлийн зарчмыг хэрэгжүүлэх.
- (2) Итгэгч хүн хэл яриагаараа бусдыг ерөөж, Бурханыг алдаршуулахын тулд Бичвэрийн 9 дүрмийг хэрэгжүүлэх.

#### Робинзон Крузо ба түүнийг гайхшируулсан харилцаа

Робинзон Крузогийн тухай уран зөгнөлт зохиолд нэгэн хүн усан онгоцны сүйрэлд өртөж, сэлсээр нэгэн эзгүй аралд хүрч амьд үлдэж чаддаг. Арал дээр тэр олон сар ганцаараа байж, өөртөө оромж, хувцас хийн, хоол үндтай залгахыг сурчээ. Нэгэн удаа тэр тэнгисийн эргээр алхаж явахдаа хүний мөр олж хараад гайхан цочирдов. Арал дээр өөрөөс нь гадна хүн байж таарав. Тэр хүн найз эсвэл дайсан болохыг Робинзон мэдэхгүй байлаа. Тэр хүн ямар зантай, ямар хэлээр ярьдаг, ямар үндэстэн болохыг, яагаад энд байгааг нь мэдэх боломжгүй байв. Арал дээрх түүний амьдралыг энэ хүн хэрхэн өөрчилж болох талаар ямар ч төсөөлөл түүнд байсангүй. Харилцаа нь хүний амьдралд асар их нөлөө авчирдаг учраас Робинзон хөлийн мөрийг харах үедээ найдвар, бас айдсыг давхар мэдэрчээ.

#### Сүнслэг хөгжилд үзүүлэх харилцааны нөлөө

1-р зууны чуулганд эрэгтэй, эмэгтэй, харь үндэстэн ба иудейчүүд зэрэг олон соёл, анги давхаргын хүмүүс хамрагдаж байсан бөгөөд тэд маш олон зөрчил, асуудал дунд ажилладаг байв. Элч Паул бие биенээ хүлээж аваарай хэмээн тэдэнд хэлсэн байдаг (Ром 15:7).

► Хүн арал дээр ганцаараа амьдарч байна гээд төсөөлж үзье. Тэр хэн нэгнийг тэвчихэд суралцах болов уу? Тэр хэн нэгнийг уучилж чадах уу?

Та бусад хүмүүстэй харилцахгүйгээр христитгэлийн тэвчээртэй чанарыг хөгжүүлж чадахгүй. Та бусадтай харилцахаас нааш уучилж, бас уучлагдах боломжгүй юм.

► Христитгэлийн өөр ямар чанар, үйл ажиллагаа бусадтай харилцахыг шаарддаг вэ?

Эдгээр нь бусадтай харилцах үед л тохиолддог. Бидний чанар чансаа зөвхөн харилцаагаар дамжин хөгжиж, илэрхийлэгдэх боломжтой. Энэ нь бидний харилцаа сүнслэг хөгжилд маань маш их нөлөөтэй гэсэн үг юм.

Библи олон төрлийн харилцааны удирдамж зааврыг өгсөн байдаг. Эхнэр ба нөхөр, эцэг эх ба хүүхдүүд, ажилчин ба ажил олгогч, пастор ба чуулган, ахмад ба залуу хүмүүсийн харилцаанд зориулсан тусгай зааврууд бий.

Хүний аль ч төрлийн харилцаанд хэрэгжүүлж болох, Бичвэрийн хамгийн багадаа 3 зарчим бий: хайр, хүндэтгэл ба амар тайвны зарчим.

### **Амар тайвны зарчим**

“Бүх хүнтэй эвтэй байхыг болон ариуслыг мөшгөгтүн. Үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй болой.” (Еврей 12:14)

Энэ эшлэлд харилцаа ямар чухал болохыг онцолжээ. Бүх хүнтэй эвтэй байх нь ариун байдалтай маш ойр холбоотой.

► Бусадтай амар тайван байхын тулд ямар зүйлсийг бид эрэлхийлэх хэрэгтэй вэ?

Амар тайвныг эрэлхийлэх нь та өөрөө өртэй хүн болгондоо тохируулж харилцах юм (Ром 13:7). Та хүндэлж, дагаж, талархаж явдаг хүмүүстээ үүнийг өгөх ёстой. Хэрэв ингэхгүй бол та зөрчил үүсгэж буруутан болно. Хэрэв та бусдад төлөх ёстой зүйлээ төлдөггүй, амлалтаа биелүүлэхгүй, хариуцлага хүлээдэггүй бол амар тайвныг эрэлхийлэхгүй байгаа хэрэг. Та бусдад өгөх ёстой зүйлээ өгөөгүйгээ ухаарвал, та уучлал эрж, өөрийн хүлээсэн үүргээ чадахаараа биелүүлэх ёстой.

Түүнчлэн амар тайвныг эрэлхийлэх нь зөвхөн өртэй хүмүүстээ өгөхөөс илүү зүйлийг танаас шаарддаг. Энэ нь өргүй хүмүүсийг ч хайрлаж, сайн хандах тухай юм.

► Нэг суралцагч Тит 3:2-3 эшлэлийг бүлэгт уншина.

Итгэлд ирээгүй хүмүүс буруу хандлага, буруу сэдэлтэй байдгийг бид ойлгож, ууч, тэвчээртэй байдлаар хандах ёстой.

Зөрчил байгаад хэрэв та амар тайвныг хүсэж байвал, эвлэрлийг эрэлхийл. Уучлах хүсэлтэй байгаарай. Амар тайвныг сэргээх боломжгүй гэж яаран бүү тааварлаарай. Та аль болох харилцаагаа тасалж, тэр чигтээ салахгүй байхыг хичээх хэрэгтэй.

Есүс, танд бурууг учруулсан хүн дээр очих ёстой бөгөөд түүнд юуг буруу хийснийг нь тайлбарлаарай хэмээн хэлсэн байдаг (Матай 18:15). Хэрэв та энэ асуудлыг сөргөлдөх хэмжээний биш, жижиг асуудал гэж үзвэл энэ тухай бусдад хэлэхгүй байх, буруутай нэгэнд дургүйцэхгүй байх нь дээр.

Заримдаа хүмүүс бусад итгэгчдийн тэдэнд хийсэн буруу зүйлээс болж уучлах тал дээр тэмцэлддэг. Итгэгч бус хүмүүс бидэнтэй буруу харьцахыг бид ойлгож болох ч, итгэгч хүмүүс бидний эсрэг ямар нэг буруу зүйл хийхийг ойлгох нь хэцүү байдаг.

Есүс, хүмүүс бидэнтэй ахин давтан буруугаар харьцах үед ч уучлах сэтгэлээ хадгалсан хэвээр байх ёстой гэдгийг хэлсэн байдаг (Матай 18:21-22). Хүмүүс чуулганаа орхиж, сүнслэг амьдралдаа буулт хийхэд хүрдэг нийтлэг нэг шалтгаан бол бусад итгэгчдийн

буруутай үйлдэлд дургуйцсэн гомдол байдаг. Гомдол нь өөр нэг төрлийн сүнслэг уналтыг дагуулдаг.

Хүн уучлахаас татгалзах үедээ өөрийн амьдралын талбарыг Бурханы эрх мэдлийн эсрэг байлгадаг. Учир нь Бурхан биднийг уучлахыг шаарддаг (Ефес 4:32-г унш). Тэрхүү талбар нь бидний амьдралын бусад талбарт Сатан нөлөөлөх орон зай болдог. Хэрэв хүн уучлахаас татгалзвал, тэрээр яваандаа хамааралгүй мэт санагдах сорилтуудыг ч эсэргүүцэх чадваргүй болдог.

Хүний хувийн гэм буруу нь өөрийн эрхийг дээдлэх байдалд үндэслэгддэг. Учир нь бид тодорхой хандлага, хүндлэлийг авах зохистой гэж итгэдэг. Харин түүнийгээ авч чадахгүй болох үед бид гомддог. Бид авч байгаагаасаа ч илүүг хүртэх ёстой гэж итгэдэг.

Золин авахыг ухаарах нь бусдыг уучлах түлхүүр юм. Золин авах нь буцааж худалдан авах гэсэн утгатай. Нэгэнт Бурхан биднийг золин авч, бид Түүнийх болсон учраас бидний эрх ч Түүнд хамаатай болсон. Бид ухамсартайгаар өөрсдийн эрхийг Бурханд өгөх учиртай. Та залбирахдаа “Эзэн минь, миний бүх эрх Таных болсныг би мэддэг. Тиймээс Та тэдгээрийг хариуцаж, зөвхөн надад юу байх нь сайн гэж харж буй зүйлээ надад өгөөч” гэж хэлж болно. Тийнхүү хүмүүс танд сайн хандвал, танд энэхүү нэр хүндийг зөвшөөрсөн Бурханд та талархаж чадна. Харин хэн нэгэн танд муугаар хандвал, таны эрхийг хариуцаж байгаа Бурханыг та санаарай. Бурхан тэр цаг үед тухайн эрхийг танд байлгалгүйгээр таныг хөгжүүлж чадна гэж харсан гэсэн үг.

Бусдыг уучилснаар, та Бурханд захирагдаж, Тэр хүссэнээрээ таныг хөгжүүлэх боломжийг олгодог. Өөрийн эрхээс татгалзаж, Бурханд буулт хийх энэхүү зарчмыг бүх төрлийн харилцаандаа хүн хэрэгжүүлэх боломжтой (уучлалтай холбоотой бусад эшлэлийг үз, Колоссай 3:13, Матай 6:15 ба Ром 12:19).

### **Хайрын зарчим**

Бидэнд өртэй хүнд ч бид хайраар хандах учиртай. Учир нь бид нигүүлслийг хүлээн авсан бөгөөд Бурханд өртэй болсон юм. Бид Түүнд буцааж төлж чадахгүй бөгөөд энэ нь Түүнд ч хэрэггүй юм. Харин бидний хүлээж авсан тэрхүү хүртэх зохисгүй хайрыг бусдад өгөөрэй гэж Тэр бидэнд айлдсан.

“Нэг нэгэндээ хайртай байхаас өөрөөр хэнд ч... өргүй бай” (Ром 13:8).

Хайр нь тэр хүнийг жинхэнэ итгэгч гэдгийг нотолдог.

Хэн нэгэн нь “Би Бурханыг хайрладаг” гэж хэлчхээд, ах дүүгээ үзэн яддаг бол тэр худалч. Учир нь харагдаж байгаа ах дүүгээ хайрладаггүй хүн харагдахгүй байгаа Бурханыг хайрлаж чадахгүй (1 Иохан 4:20).

Христэд итгэгчдийн дунд нэгэн онцгой хайр байх бөгөөд таны бусад итгэгчдэд хэрхэн хандаж, үйлдэж байгаа нь Есүст хувьчлан хийж байгаа үйл юм. Шүүлтийн өдөр Тэр

ийнхүү хэлэх болно. “Үнэнээр Би та нарт хэлье. Та нар энэ ах дүүсийн минь дорд нэгэнд ийн үйлдсэн бол Надад хийсэн хэрэг” (Матай 25:40).

Түүнчлэн христитгэлийн хайр нь зөвхөн итгэгч хүмүүсийн төлөө л байдаггүй. Матай 5:44-45-д Есүс хэлэхдээ,

Харин Би та нарт хэлье. Дайснуудаа хайрла, та нарыг хавчигчдын төлөө залбир. Тэгснээрээ та нар тэнгэр дэх Эцэгийнхээ хүүхдүүд болно. Учир нь Тэрээр муу хүн дээр ч, сайн хүн дээр ч нараа мандуулж, зөвт дээр ч, зөвт бус дээр ч бороо оруулдаг юм.

Зарим хүмүүс өөрийг нь гомдоосон хүмүүст сайн хандахад хэцүү байдаг. Гэхдээ бүдүүлэг байх шалтаг хэзээ ч байдаггүй. Тэдний хүртэх ёстойчлон бид ханддаггүй. Тэд үүнийг хүртэх ёстой ч бай, үгүй ч бай бид тэдэнд хайр ба сайхан сэтгэлээр ханддаг (1 Коринт 16:14). Бид үл итгэгч байхдаа Бурханы хайранд тохирохгүй хүмүүс байснаа санах хэрэгтэй. Гэсэн хэдий ч Бурхан биднийг хайрласан юм (Тит 3:2-3).

### **Хүндэтгэлийн зарчим**

► Хэрэв би танд бохир, урагдсан 100 доллар үнэгүй өгвөл та авах байсан уу? Бохир, урагдсан учраас та авахаас татгалзах уу?

Үүний нөхцөл нь тааруу байсан ч үнэ цэнтэй хэвээр байгаа учраас та үүнийг авах байх.

Хүн Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн учраас хүн бүр хүндэтгэл хүлээх зохистой (Эхлэл 1:27). Бурханы дүр төрх хүнийг төрөлхийн үнэ цэнтэй болгодог.

Зарим хүмүүс оюуны өндөр чадамжгүй байж болно. Зарим нь ур чадвар дутуу, сайн сургагдаагүй, эсвэл энгийн жишгээр амжилттай, ашигтай болгох ямар нэг зүйл байхгүй ч байж болно. Гэсэн хэдий ч, тэд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн учраас үнэ цэнтэй хэвээр юм.

Магадгүй зарим нь өөрийн мунхаг сонголтоор үнэ цэнээ зарим талаар үгүй болгосон ч бай, бүх хүнд энэхүү чухал үнэ цэн бий. Сургуулиа дуусгалгүй дундаас нь орхисон, эрүүл мэндээ хохироосон, эсвэл муу зуршилд автсан аль нь ч бай, Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн хүн учраас үнэ цэнтэй юм.

Хүн бүрийн дотор байдаг Бурханы дүр төрх, төрөлх үнэ цэнийн улмаас хүн хоорондын харилцаандаа хүндэтгэлтэй хандах ёстой. Хамгийн багадаа л эелдэг байх хэрэгтэй.

Манипуляц болон хуурч мэхлэх нь буруу зүйл юм. Учир нь хүн бүр мөнхийн үр дагавартай сонголтыг гаргадаг бөгөөд шийдвэр гаргахад бодит хүчин зүйлсийг мэдэх шаардлагатай тулгардаг. Хүн буруу шалтгаанаар ямар нэг зөв зүйтэй зүйлийг хийхэд хүрсэн байлаа ч энэ нь амжилт биш юм. Учир нь тэр хүн зөвийг сонгоогүй учраас тэр юм.

Хэдийгээр хүмүүс биеэ буруу авч явж байгаа ч гэсэн бид аль болох тэдэнд хүндэтгэлтэй хандахыг хичээх ёстой. Хүмүүсийн алдааг засахдаа, гэм бурууг нь шийтгэхдээ (үүнийг

үйлдэх зохих эрх мэдэлтэй хүмүүсийн хувьд) бид Бурханы мөн чанарын зарим хэсгийг тээж байгаа мөнх орших нэгэнтэй харилцаж байгаа гэдгээ ухамсарлах хэрэгтэй.

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

Эдгээр зарчмыг хэрэгжүүлэх олон арван жишээ байх учиртай.

- ▶ Хэн нэгэнд амар тайвныг эрэлхийлсэн жишээ байгаа эсэхийг асууж, хуваалцана уу.
- ▶ Гомдсон хүмүүсээ уучлах шийдвэрийг гишүүдээсээ хүсэж, хуваалцаарай.
- ▶ Хүртэх ёстойгоос нь илүү их хайрыг хэн нэгэнд харуулсан жишээг асууж ярилцах.
- ▶ Биеэ буруу авч явж байгаа нэгэнд хүндэтгэлтэй хандах нь юу болохыг ярилцаарай.

### **Харилцан ярилцах Библийн зарчим**

- ▶ “Илднээс ч хүчтэй үзэг бий” гэсэн эртний үг байдаг. Энэ нь юу гэсэн утгатай вэ?

Санаа бодлоо солилцож, ятгаж, харилцахад хүч оршдог. Хүмүүсийг хүчилж биш, харин өдөөснөөр та ихийг гүйцэлдүүлж чадна. Санаа бодол, үзэл баримтлал тархаж, олон хүнд нөлөөлөх боломжтой.

Үгийн хүч сайн зүйлийг ч, мөн хор хөнөөлийг ч учруулдаг талаар Библид хэлсэн байдаг (Иаков 3). Авралын төлөвлөгөө нь хүмүүн элч нарт даалгагдсан бөгөөд сайнмэдээний хүч чадлаар төгсгөл шатандаа явж байна.

Бид хэрхэн үг яриагаа хор хөнөөлийг биш, харин сайныг гүйцэлдүүлэхэд ашиглаж чадах вэ? Библийн зарим зарчмууд бий.

#### **(1) Хэтэрхий их бүү ярь.**

“Мунхаг нэгэн олон үгтэй...” (Номлогчийн үгс 10:14).

“Үг олшроход алдаа зайлшгүй хэрсүү ухаантай нь хэлээ захирна” (Сургаалт үгс 10:19).

“Дуугүй байваас мунхаг ч мэргэнд тооцогдоно амаа хамхиваас тэрээр ухаалаг мэт харагдана” (Сургаалт үгс 17:28).

Иймээс хэтэрхий их бүү ярь. Хэт их ярьдаг хүн өөрийн үгийг ч, өрөөлийн үгийг ч зүй зохистойгоор үнэлдэггүй. Тийм хүн үнэхээр хэлмээр байгаагүй зүйлээ хэлдэг бөгөөд бусад хүмүүс ч бас адилхан ингэж хэлдэг гэж тааварладаг. Тэрээр мэдлэггүйгээр үзэл бодлоо илэрхийлдэг. Та ямар нэгэн мэдэхгүй зүйлийнхээ талаар үзэл бодлоо ярих шаардлагагүй бөгөөд үзэл бодол бүр ижил үнэ цэнтэй байдаггүй.

#### **(2) Бодохоосоо өмнө бүү ярь.**

Таныг харамсахад хүргэх үгсийг мэдрэмждээ захирагдан бүү хэл.

“Хайрт ах дүү нар минь, үүнийг мэдэгтүн. Хүн бүр сонсохдоо түргэн, ярихдаа удаан, уур хилэнд алгуур байг” (Иаков 1:19).

“Мунхгийн уур тэсрэмтгий мэргэн нь түүнийг тэвчимтгий” (Сургаалт үгс 29:11).

“Уурлахдаа удаан нь ухаан дүүрэн түргэн зан гаргах нь мунхаглалыг өргөмжлөхтэй адил” (Сургаалт үгс 14:29).

### **(3) Эхний харцаар нөхцөл байдлыг бүү шүү.**

“Сонсохоосоо өмнө хариу хэлэх нь мулгуу агаад ичгүүртэй” (Сургаалт үгс 18:13).

“Өөр нэгэн ирж, түүнийг шалгаахаас нааш өмнө нь ирж хэрэг явдлаа ярьсан хүний зөв мэт байдаг” (Сургаалт үгс 18:17).

Ихэнх зөрчлүүд үл ойлголцлоос болж үүсдэг. Цаг хугацаа, анхаарал хандуулснаар гол төлөв тэдгээрийг шийдвэрлэх боломжтой. Үнэнч шударга байдлаараа танигдсан хүн таны ямар нэг зүйл буруу байгааг хэлвэл, тэр хүнийг яаран бүү шүү.

“Бусдын хэрүүлд хөндлөнгөөс оролцох нь өнгөрч яваа нохойг чихнээс нь зулгаахтай адил” (Сургаалт үгс 26:17).

### **(4) Хошигнолд болгоомжтой ханд.**

Үгс нь нөлөөтэй учраас хяналтгүй хошигнол нь галзуу хүний гарт буй зэвсэгтэй адил юм.

“Галтай мод, үхлийн сумаар тоглогч галзуу мэт хөршийгөө гүтгэн мэхэлчхээд 'Би тоглосон юм' гэх хүн байдаг” (Сургаалт үгс 26:18-19).

Хүмүүс таны тоглоомоор хэлсэн үгэнд итгэж, ноцтой алдаа гаргахад бүү хүргэ. Та жинхэнэ нухацтай хандаагүй зүйлээ жинхэнээсээ мэтээр бүү ярь. Тэгвэл тэд танд дахиад хэзээ ч итгэхгүй. Хүмүүсийн өөрчилж чадахгүй согогийг бүү шоол. Хэн нэгний алдаа уналтыг тоглоом наргиа бүү болго. Нүглийг өчүүхэн зүйл мэт харагдуулдаг тийм хошигнол онигоог бүү ярь.

► Хошигнолын өөр ямар буруу хэрэглээ байдаг вэ?

### **(5) Буруу хүнд үүнийгээ бүү хэл.**

“Илүү үгтэн нууцыг задруулдаг итгэлт хүн хэргийг нууцалдаг” (Сургаалт үгс 11:13).

“Түлээгүй бол гал унтарна хов зөөгчгүй бол хэрүүл маргаан намжина” (Сургаалт үгс 26:20).

Ямар нэг зүйлийг хэлмээр байсан ч, та үүнийг хэлэх зөв хүн нь биш байж болно. Үүнийг хамгийн түрүүнд хэлэх ёстой эрх мэдэл бүхий хүний оронд та ярих ёсгүй юм.

Хүмүүсийн алдааны талаар бүү дэлгэрүүлж түгээ.

Хувийн мэдээллийг нь бусдад хэлдэг хүнд хүмүүс итгэж найдахгүй.

“Өөрийн хэргийг хөрштэйгөө л шийд бусдын нууцыг бүү задруул” (Сургаалт үгс 25:9).

Хулчгар хүн дэг журмын дагуу явахын оронд буруу хүмүүст учир шалтгаанаа ярьдаг. Матай 18:15-17.

### **(6) Шүүмжлэлд болгоомжтой ханд.**

Шүүмжлэх тохиромжтой цаг ба арга зам гэж бий.

“Далдлагдсан хайраас ил зэмлэл дээр. Андын чинь учруулсан шарх итгэмжтэй...” (Сургаалт үгс 27:5-6а).

Таны шүүмжлэл сүйтгэхийн тулд биш, харин босгон байгуулахын тулд байгаа эсэхийг нягтал. Тэдэнд санаа тавьж, туслах хүсэлтэй байгаа гэдгээ та харуулах ёстой. Ихэвчлэн шүүмжлэхээсээ өмнө эрүүл харилцаандаа анхаарах нь чухал байдаг.

### **(7) Бүү мэхэл.**

“Бие биедээ бүү худал ярь. Яагаад гэвэл та нар хуучин хүнээ муу зуршилтай нь тайлж...” (Колоссай 3:9).

Мэхлэл нь итгэлийн амьдралд биш, харин нүгэлт амьдралд зохицдог.

“Худалч уруул ЭЗЭНд жигшүүр хуудуугүй үйлстнүүд Түүнд таалал” (Сургаалт үгс 12:22).

### **(8) Хэл яриагаа эрүүл цэвэр байлга.**

“Садар самуун яриа, мунхаг үгс, шалиг наргиа нь зохимжгүй. Харин оронд нь талархлын үг ярь” (Ефес 5:4).

Нөхцөл байдлыг албан ёсны байдлаар, зөвөөр шийдвэрлэхээс бусад тохиолдолд өнгөрсөн болон одоогийн дуулиан шуугиантай зүйлсийн талаар бүү ярь. Нууцаар ярих ёстой онигоог бүү ярь. Дэлхийн хүмүүс сексийн нэр томьёо, биеийн далд хэсгийг хэт онцолсон зүйлсийг яриандаа түгээмэл ашигладаг бол итгэгч хүмүүсийн хувьд энэ нь зохимжгүй. Түүнчлэн стресс, хямралтай үедээ та чин сэтгэлээсээ Бурханаас тусламж гуйгаагүй л бол, Бурхан болон Есүсийн талаар үг хэллэг ашиглах нь үл хүндэтгэсэн хэрэг юм.

### **(9) Хүмүүсийг хагаралдуулах зүйлсийг бүү ярь.**

“Замаасаа гажигч эвдрэлцлийг тарина хов жив тараагч дотнын нөхдийг салгана” (Сургаалт үгс 16:28).

“Энэ зургаан зүйлийг ЭЗЭН үзэн яддаг энэ долоо дахийг нь ч Тэрээр жигшдэг... [долоо дахь нь] Ах дүүсийн дунд эвдрэлцлийг тараагч нар” (Сургаалт үгс 6:16, 19).

Бусдын хүч хөлсөөр өөрийгөө илүү сайхан болгох гэж бүү оролд. Бусдын дунд зөрчил бүү үүсгэ. Бусдын үр нөлөөтэй үйлчлэлийг хов жив тарааж бүү хорло.

Ярихаасаа өмнө “Энэ нь үнэн үү?” гэдэгт анхаарахаас гадна “Яагаад би үүнийг хэлж байгаа вэ?” гэдэгт ч мөн анхаар.

### **Дүгнэлт**

Итгэгч хүн бусдыг үгээрээ хохироосноо ухаарвал уучлал эрэх хүсэлтэй байх ёстой. Хэлсэн зүйл нь яг үнэн биш байснаа ухаарвал итгэгч хүн үүнийгээ залруулах хэрэгтэй.

Бусдын хэлсэн өвтгөх, гомдоох үгс нь таны хэлэх буруу үгсийг зөвтгөхгүй.

Бага багаар засаж сайжруулах боломжтой үг яриатай холбоотой алдаанууд бий. Үүнийг та ярихаасаа өмнө бодоход суралцсанаар засаж болно. Түүнчлэн хүний зүрхэнд нуугдсан бусдыг хохироох сэдэлтэй алдаанууд ч байдаг. Хэрэв та ийм төрлийн үг яриаг хэлсэн бол Бурханаас уучлалт гуйж, таны зүрх сэтгэлийн энэ хандлагыг цэвэрлэж өгөхийг асуух хэрэгтэй.

Таны зүрх сэтгэлийн талаар үг яриа тань ихийг илчилдэг (Лук 6:45). Христитгэлийн үнэ цэнтэй нийцэхгүй зүйлийг ярьж, итгэлийн гэрчлэлээ битгий үнэгүйдүүлээрэй.

Та үг яриагаараа эргэн тойронд байгаа хүмүүсээ ерөөж чадна. Ихэнх үйлчлэл харилцаанаас бүрддэг. Хэрэв та Библийн зарчмуудыг дагавал таны үг ярианы нөлөө гайхалтай өсөн нэмэгдэх болно.

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

- ▶ Ихэнх хүмүүс өөрийнхийг бус, харин бусдын ярианы алдааг олж хардаг. Ангийн удирдагч эдгээр зарчмуудаас хэрэгжүүлж чадаагүй өөрийн алдаа, сул талын нэгийг жишээ болгон хуваалцах боломжтой.
- ▶ Бүлгийн гишүүдээс сайжруулахад Бурханы тусламж хэрэгтэй, сул тал болж байгаа зарчмаас нэгийг сонгоод ярихыг асуугаарай.

## **Залбирал**

Тэнгэрлэг Эцэг минь,

Библийн хайр, хүндэтгэл, амар тайвны зарчмуудыг бүх харилцаандаа дагаж амьдрахад надад туслаач.

Миний эсрэг буруу зүйлийг хийдэг нэгнийг би уучилдаг байхыг хүсэж байна. Надтай зөрчилддөг тэдгээр хүмүүстэй эвлэрлийг эрэлхийлэхэд надад туслаач.

Таны дүр төрхөөр бүтээгдсэн тул бүх хүмүүсийг хүндэлж сурахад туслаач. Хэл яриа минь их нөлөөтэйг санаж, хэлэх үгэндээ хариуцлагатай байхад надад туслаач. Миний үг яриа хохироох биш, харин сайныг гүйцэлдүүлэхийг би хүсэж байна.

Таныг дээдэлсэн гэрчлэлтэй амьдрахыг би хүсэж байна.

Таны үнэнийг ярих завшааныг надад олгодог Танд баярлалаа.

Амен

## **4-р хичээлийн даалгавар**

(1) Иаков 3-р бүлгийг унш. Энд дүрслэгдсэн харилцааны гайхалтай боломжуудын талаар ажигла. 13-18 эшлэл дэх хүний сүнслэг нөхцөл байдлаас хэл яриа хэрхэн хамаардгийг анзаар. Ефес 4:25-32 эшлэлийг унш. Эдгээр эшлэлд хариулт болгон нэг догол мөр залбирлаа бичээрэй.

(2) Ефес 5:22–6:9 эшлэлийг судал. Олон төрлийн харилцаанд хэрхэн хандаж үйлдэх талаарх тодорхой зааврыг жагсаан, тайлбарла. Эдгээр заавар нь энэ хичээлийн хайр, амар тайван ба хүндэтгэлийн зарчимтай хэрхэн холбоотой болохыг тайлбарлан бич.

(3) Дараах асуултаас 3-ыг сонгоод, тус бүр нэг догол мөр хариулж бич:

- Бурхан биднийг харилцаандаа эвтэй байхад дуудсан гэдэг үнэний практик хэрэгжүүлэлт юу байж болох вэ?
- Өөрийнхөө авралыг хадгалахад бусдыг уучлах нь яагаад зайлшгүй чухал юм бэ?
- Хүн өөрийн эрхийг Бурханд өгнө гэдэг нь юу гэсэн утгатай вэ?
- Хүртэх ёсгүй нэгнийг хайрлах бидний хайрын өдөөлт нь юу вэ?
- Бүх хүн Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн гэдэг үнэн бидний бусадтай харилцах харилцаанд хэрхэн нөлөөлөх ёстой вэ?



## 5-р хичээл

### Бурханы удирдамж

#### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах ойлголт, чадварт суралцсан байна:

- (1) Шийдвэр гаргахад маань Бурхан хэрхэн тусалдгийг ойлгох.
- (2) Бурханы хүслийг ялган таньж, зөв шийдвэр гаргахад бэлэн байхад суралцах.
- (3) Удирдамж хайхдаа гаргадаг алдаанаас зайлсхийх.

#### Палугийн цунами ба харилцаа холбооны бүтэлгүйтэл

2018 оны 9-р сард Индонезийн Палу арлын орчим газар хөдөлж, цунами (асар том давалгаа) Палу хотыг чиглэжээ. Өндөр барилгын орой дээр байсан нэгэн хүн давалгааг хараад доор гудамжинд байгаа хүмүүст сэрэмжлүүлж хашгирсан ч, ихэнх хүмүүс түүнийг үл тоомсорлов. Харамсалтай нь үүний дараа 4,000 хүн нас барж, 10,000 гаруй хүн шархаджээ.

Энэ явдлаас 10 жилийн өмнө (2008 онд) Индонезийн засгийн газар далайд цунами илэрвэл анхааруулах мэдээ илгээх зориулалттай цахилгаан мэдрэгчтэй 22 хөвөгч дохиоллыг байрлуулж байжээ. Гэсэн хэдий ч, ирэх жилүүдэд нь эдгээрийг арчилж засварлаагүйн улмаас бүгд ажиллагаагүй болсон байна. Үүнээс болж 2018 оны цунамигийн талаар ямар ч анхааруулах дохио ирсэнгүй.

#### Захирагчтайгаа харилцаатай байх нь

► Цэрэг армийн бүх тээврийн хэрэгсэлд байдаг нэг зүйл юу вэ?

Танк, цэргийн машин, онгоц бүрд радио холбоо байрлуулдаг. Энэхүү радио холбоог цэргүүд дуртай хөгжмөө сонсохын тулд биш, харин харилцаа холбооны зориулалтаар ашигладаг.

Дайн тулалдаанд ялалт байгуулахад харилцаа холбоо зайлшгүй шаардлагатай. Фронт дээр тулалдаж буй цэргүүд бүх талбарыг харж чадахгүй. Журмын нөхөд нь хаана явааг, дайсан нь хаана байгааг тэд мэдэхгүй байх боломжтой. Аль зүгт гал нээх, аль зүг рүү давших ёстойг захирагчтай харилцахгүйгээр мэдэж чадахгүй.

Дайны талбарт олон цэргүүд “нөхөрсөг гал”-д буюу өөрсдийн бууны суманд өртөж амь эрсдэх тохиолдол гардаг. Харилцаа холбоо муу байснаас болж, пуужин харвалт болон бөмбөгдөлт байндаа тусалгүй, өөрийн талд хохирол учруулах тохиолдол ч их гардаг байна.

Орчин үеийн тулаанд дайсны харилцаа холбооны гол төвийг устгах нь чухал стратеги юм. Үүнийг амжилттай гүйцэтгэсэн тал ихэнхдээ ялалт байгуулдаг.

Бид ч ялгаагүй сүнслэг тулааны талбарт байна. Чөтгөр биднийг уруу татаж, мэхлэхийг оролддог. Энэ ертөнц биднийг өөрийн үнэт зүйлс, амьдралын хэв маягтаа татдаг. Заримдаа бидний эргэн тойронд буй хүмүүс Бурханы төлөө амьдрахад саад болж, биднийг мохоодог. Бид яг л дайсны газар нутагт цөөн нөхөдтэй, олон дайсантай хамт байгаа цэргүүдтэй адил юм.

**Бурхан биднийг энэхүү сүнслэг тулаанд ялаасай гэж хүсдэг. Залбирал нь бидний Захирагчтайгаа харилцах харилцааны хэрэгсэл юм.**

Хэрэв тулааны талбарт нэг цэрэг тушаалыг үл тоож, өөрийнхөөрөө явбал юу болох вэ? Тэр сайныг биш, харин хор хөнөөлтэй зүйлийг хийх болно. Түүнд найдаж байсан хүмүүст туслахын оронд эцэст нь олзлогдох, эсвэл алагдах ч боломжтой.

Сүнс дотор цаг үргэлж аливаа залбирал ба гуйлтаа өргө. Үүний тулд хамаг ариун хүмүүсийн төлөө бүхий л цөхрөлтгүй оролдлого, гуйлтаараа сэргэг бай (Ефес 6:18).

Паул итгэгч хүний сүнслэг зэвсгийг тухайн үеийн цэрэг армийн хуяг дуулгатай зүйрлэн тайлбарласан багцлалын төгсгөл хэсэгт энэ эшлэл гардаг. Бидний дайснууд бол бие махбодынх бус, харин сүнслэг дайснууд гэдгийг тэр хэлжээ.

Хэрэв Паулын цаг үед цэргүүд радио холбоо ашигладаг байсан бол тэрээр сүнслэг цэрэг хүний өөр нэг хэрэгсэл болгон 'залбирал'-ын жишээг татах байсан болов уу. Хуяг дуулгыг тайлбарласны дараа тэрбээр *залбирал* нь сүнслэг хуяг дуулгатай хамт хэрэглэгдэх ёстой гэдгийг хэлсэн байдаг.

Сүнслэг хорон муугийн эсрэг тулалдахдаа бид залбиралтайгаар, Захирагчтайгаа харилцаатай байх учиртай. Бид тэвчээртэй байж, залбиралд соргог, сэрэмжтэй байхаар дуудагдсан.

Өөрийг нь сонсдог хүмүүсийг удирдан чиглүүлнэ гэдгээ Бурхан амласан.

Бүхий л зүрхээрээ ЭЗЭНд итгэ өөрийнхөө ойлголтод бүү түшиглэ, алхам бүрдээ Түүнийг таньж мэд амьдралын замыг чинь Тэр шулуун болгоно (Сургаалт үгс 3:5-6).

Хүний алхмууд ЭЗЭНээр тогтоогдох агаад замд нь Тэр баярладаг (Дуулал 37:23).

Христийг дагадаг хүн ертөнцийн хүмүүстэй адил шийдвэр гаргадаггүй. Зарим хүн зөвхөн өөрийн ашиг сонирхол, шуналдаа хөтлөгддөг. Ийм хүмүүс "Миний хувьд зөв гэж бодсон зүйлээ л би хийх ёстой" гэж хэлдэг. Энэ нь бусад хүмүүс тэднийг хянахыг зөвшөөрөхгүй, харин өөрийн хүсэл зорилгоо нэгдүгээрт тавих ёстой гэсэн утгатай юм. Тэдний хувьд эрх чөлөө нь өөртөө төвлөрсөн байхыг хэлдэг. Харин Христийг дагагч

хүмүүсийн хувьд өөр бөгөөд тэд Бурханыг баярлуулж, амьдралаараа бусдыг ерөөхийг хүсдэг.

Зарим хүн бүх хариултыг өөрийнхөө дотроос хай гэж бидэнд зөвлөдөг. Шийдвэр гаргахад бидний мэдрэмж, инстинкт маань хангалттай удирдамж болно гэж тэд итгэдэг. Түүнчлэн тэд залуу хүмүүсийг уламжлал болон ахмадын зөвлөгөөг хүлээн авалгүй, үл тоомсорлохыг уриалдаг. Шашны ёс суртахууныг ч тэд уландаа гишгэдэг. Ийм төрлийн зөвлөгөө нь орчин цагийн Холливудын зугаа цэнгэлийн соёлд түгээмэл ажиглагддаг. Тэд эрх мэдэл, уламжлалын эсрэг тэрслэн, мөрөөдлөө дагаснаар амжилтанд хүрэх залуу хүний түүхүүдийг онцолдог. Харамсалтай нь ийм шийдвэрүүд гуниг харуусал, сүйрэлд хүргэдэг бодит үнэнийг тэд харуулдаггүй.

Зарим соёлд хувь хүний шийдвэр нь томоохон гэр бүл, овог, төрөл садны хүмүүсээр хязгаарлагддаг. Хувь хүмүүс ажил мэргэжлээ өөрчлөх, өндөр боловсрол эзэмших, гэрлэх болон тухайн бүс нутгийг орхих зэрэг шийдвэрийг бүлгийн зөвшөөрөлгүйгээр гаргах боломжгүй байдаг. Хүн шашнаа солих нь ийм соёлд хамгийн хэцүү сонголт өөрчлөлт байдаг. Энэ соёлд хэрэв хүн Христийн дагалдагч болж, нутгийн хүмүүсийнхээ ойлгохгүй тийм зарчмыг дагаж эхэлбэл, тэр хавчлага зовлон амсах боломжтой. Ийм нөхцөлд байгаа итгэгч хүн мэргэн ухаан болон удирдамжийн төлөө залбирах ёстой.

Бурханы удирдамж бүхий л үед хэрэгтэй бөгөөд бид өөрсдөө үргэлж анзаарч чадахааргүй тийм арга замуудаар Тэр биднийг удирдан чиглүүлдэг. Бид Түүнийг бодохгүй байсан ч, харин Тэр биднийг хэзээ ч мартдаггүй. Гэхдээ заримдаа бидэнд Бурханы удирдамжийг тусгайлан хайх, сонголтоо бодитоор харахад Түүнээс тусламж гуйх хэрэгтэй үе байдаг. Бурхан бидний явах чиглэлийг санамсаргүй байдлаар өөрчлөхийг ч хүсэж болох юм.

► Бурханаас онцгой удирдамж хэрэгтэй болдог ямар үе бидэнд байдаг вэ?

Бид дараах нөхцөлд Бурханаас удирдамж хайх ёстой:

- 1. Амьдралыг бүхэлд нь өөрчлөх шийдвэр гаргах үедээ:** гэрлэлт, ажил мэргэжил, боловсрол, нутгийн чуулганд зориулах шийдвэр.
- 2. Практик шийдвэр гаргах үедээ:** ажиллах боломжууд, хаана амьдрах талаар болон томоохон худалдан авалт хийхдээ.
- 3. Үйлчлэлээ төлөвлөж, хийх үедээ:**<sup>6</sup> хувь хүний дуудлага, хаана хэнтэй хамт үйлчлэх, заах болон номлох сэдвийн талаар.

---

<sup>6</sup> Үйлс 16:6-9-д Ариун Сүнс Паул, Силас хоёрт илгээлтийн аяллын үеэр онцгой удирдамж заавар өгсөн талаар өгүүлдэг.

4. **Чуулганы амьдралд оролцох үедээ:**<sup>7</sup> хэрхэн мөргөн хүндлэх, юунд суралцах, юуг өргөх, газар дэлхий дээрх Христийн Биеийн нэг хэсэг байх талаар.

### **Та Бурханы удирдамжийг хэрхэн илүү сайн ялган таньж чадах вэ?**

**(1) Залбирлаар Бурхантай ойр байх** (Филиппой 4:6). Хэрэв та амьдралынхаа ихэнх хэсгээс Бурхантай ярих яриаг хасвал, та өөрийн хязгаарлагдмал ойлголт болон хандлагаа л дагаж амьдрах болно.

**(2) Бичвэрийн тов тодорхой үнэнээс илүүтэй өөрийн бодол эргэцүүлэлд бүү итгэж найд.** Дээрх эшлэлд "Өөрийнхөө ойлголтод бүү түшиглэ" (Сургаалт үгс 3:5) гэж хэлсэн.

**(3) Энэ нь Бурханы хүсэл гэж тодорхой мэдэж байгаа зүйлээ үргэлж дуулгавартай дага.** Энэ нь таны ойлголтыг сайжруулах болно. Бурханы Үгийг дуулгавартай дагадаггүй хүн Бурханы хүслийг үнэхээр хүсдэггүй. Учир нь Бурхан өөрийн хүслээ Бичвэрээр дамжуулан илэрхийлдэг. Хэрэв та Бурханы хүсэл гэж мэддэг зүйлийнхээ зөвхөн хэсгийг нь дагавал, та улам ихээр будилж эргэлзэхэд хүрнэ. Гэрэл тань харанхуй болж хувирна (Лук 11:35).

Эдгээр нь Бурханы хүсэл гэж бид мэддэг:

- Өдөр бүр загалмайгаа үүрч, Есүсийг дагах (Лук 9:23)
- Зүрх сэтгэлдээ үнэнийг хэлж, зөвийг хийх (Дуулал 15:2)
- Итгэмжит, сүнслэг удирдагчдыг хүндлэх (1 Тесалоник 5:12-13).
- Бүхий л цагт баяр хөөртэй байх (1 Тесалоник 5:16).
- Тасралтгүй залбир (1 Тесалоник 5:17).
- Бүх зүйлд таларх (1 Тесалоник 5:18).
- Сүнсийг бүү бөхөө (1 Тесалоник 5:19).
- Эш үзүүлэгийг бүү басамжил (1 Тесалоник 5:20).
- Бүхнийг шалга (1 Тесалоник 5:21).
- Сайнаас зуур (1 Тесалоник 5:21).
- Ёр муугийн алив хэлбэрийг цээрлэ (1 Тесалоник 5:22).
- Бүрэн ариусгагдсан бай (1 Тесалоник 5:23).

Түүнчлэн олон тушаалуудыг 'хайр' гэсэн ганцхан үгэнд багтаан хэлсэн байдаг (Ром 13:8-10). Бурханы хүсэл гэж мэддэг зүйлээ хийж эхлэх үед бидний олон шийдвэр ач холбогдол багатай болох нь тодорхой харагддаг.

**(4) Тэвчээртэй бай.** Бурхан үүд хаалгыг нээж, таны төлөө нөхцөл байдлыг бэлтгэх хооронд та тэвчих хэрэгтэй байж болох юм. Тэвчээргүйгээсээ болж яаран бүү шийдвэр

---

<sup>7</sup> Анхны чуулган, Ариун Сүнс тэдний мөргөл хүндэтгэлийг чиглүүлж, онол сургаалыг нь хамгаалж, асуудлыг шийдвэрлэхэд нь тусалж, номлол сургаалыг нь хүчирхэгжүүлдэг гэдгийг мэддэг байжээ. Үйлс 15:28, Үйлс 5:3-5 ба Үйлс 6:10 эшлэлийг үз.

гарга. “ЭЗЭН дотор дуугүй байж, Түүнийг тэвчээртэйгээр хүлээ” (Дуулал 37:7). Та буруу гэдгийг нь мэдэж байгаа зүйлээ яаралтай санагдсанаас болж хэзээ ч бүү хий.

**(5) Сайн зөвлөгөөг сонс.** “Дайтваас мэргэн удирдамжийг дага зөвлөхүүд олон аваас ялалт ирнэ” (Сургаалт үгс 24:6). Бурхан таныг амьдралдаа томоохон шийдвэр гаргаасай гэж хүсэхдээ ихэвчлэн таны хувьд чухал хүмүүсээр дамжуулан үүнийг харуулдаг. Хэрэв таныг сайн мэддэг, танд санаа тавьдаг, бурханлаг, ахмад насны хүн таны хийх гэж байгаа зүйлийг алдаа гэж хэлвэл та яаран шийдэж болохгүй.

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

► Бурханы удирдамжийн дагуу шийдвэр гаргасан нэг жишээг хуваалцана уу. Энэ нь зөв шийдвэр байсан гэдгийг Бурхан танд хэрхэн харуулсан бэ?

► Буруу шийдвэр гаргасан талаарх жишээг ч хуваалцах нь тустай. Бурханы удирдамжийг илүү сайн дагахад туслах 5 зарчмын аль нэгийг нь дагаагүй юу?

Бусдад бас хуваалцах боломж олгоорой.

### **Бурханы удирдамжийг хайхдаа гаргадаг алдаанаас зайлсхийх**

Чарльз Столкер гэдэг нэгэн номлогч өөрийн түүхийг хуваалцсан юм. Нэгэн удаа түүнийг өглөө залбирч байхад нь Бурхан “Би чамайг Хятад руу яваасай гэж хүсэж байна” гэж түүнд хэлжээ. Столкерт Хятад руу явах мөнгө, холбоо харилцаа байгаагүй учраас тэр ихэд гайхсан. Гэсэн хэдий ч, тэрхүү сэтгэгдэл маш хүчтэй байсан тул тэр аяллын цүнхээ бэлдээд аяллаа эхлүүлэх буудал руу гарч явжээ. Гэтэл буудалд нэгэн танихгүй хүн түүнд дөхөж ирээд “Та Чарльз Столкер мөн үү?” гэж асуугаад “Таны Хятад руу явах тасалбарыг өгүүлэхээр намайг илгээсэн юм” гэжээ.

► Энэ нь Бурхан бидэнд өөрийн хүслийг харуулдаг *ердийн* арга зам мөн үү? Хэн нэгэн хүн Бурханы хүслийг үргэлж ийм байдлаар хайх нь асуудалтай юу?

Зарим хүмүүс шийдвэр гаргах бүрдээ ер бусын удирдамж хүсэж хүлээдэг. Тэд ердийн нөхцөл байдал, учир шалтгаанаар тунгааж бодохоос татгалздаг. Учир нь тэд Бурханы хүсэл нь бүх нөхцөл байдал, ухаан бодлын эсрэг байх боломжтой гэж тааварладаг.

Бурхан бидний шийдвэрт ер бусын илчлэл харуулах ёстой гэж шаардах нь буруу юм. Учир нь Тэр өөрийн хүслийг ихэвчлэн ийм байдлаар харуулдаггүй. Хэрэв хүн ухаан бодол болон нөхцөл байдлыг үл тоомсорлоод, өөрийн төсөөлөл, сэтгэл хөдлөлөө дагаж байгаагаа ‘Бурханы удирдамжийг би хүлээн авсан’ гэж бодоход хүрч магадгүй.

Бичвэр бидэнд ямар нэг зүйлийн талаар тушаасан эсвэл хориглосон бол энэ нь Бурханы хүсэл гэж бид мэддэг. Гэсэн хэдий ч, амьдралд тодорхой байдлаар тушаагаагүй, хориглоогүй олон шийдвэрийг бид гаргах хэрэгтэй болдог. Хүн хаана амьдрах, ямар ажил хийх, мөнгө санхүүгээ хэрхэн зарцуулах талаар яаж мэдэх вэ?

► Бичвэрт тодорхой удирдамж өгөөгүй шийдвэр дээр, онцгой илчлэлгүйгээр хүн хэрхэн Бурханы хүслийг мэдэж болох вэ?

Зарим хүмүүс Бурханы хүслийг ухаан бодол, нөхцөл байдлаас ангид байдлаар мэдэх ёстой гэж хүлээдэг учраас Бурхан тэдэнд удирдамжаа ухаан бодол оролцохгүй тийм арга замаар өгнө гэж боддог. Ийм хүмүүсийн хувьд Бурхан өөрийн хүслийг тэдэнд харуулахын тулд ямар нэгэн тэмдэг өгөөсэй гэж асууж магадгүй. Эсвэл Библиэ санамсаргүй байдлаар нээгээд, таарсан дурын нэг эшлэлийг өөрийн нөхцөл байдалд хэрэгжүүлэх ч боломжтой.

### **Сайн шийдвэр гаргахад тустай практик зөвлөмж**

Жон Весли Бурханы хүслийг танихад хэрэгтэй практик зааврыг өгсөн байдаг. Тэрээр Библид илчлэгдсэн, Бурханы ерөнхий хүсэл нь бид ариун байж, сайныг үйлдэх хэмээн хэлжээ. **Тиймээс бид тодорхой нэг шийдвэр гаргахдаа аль сонголт нь биднийг илүү ариун байхад туслах, мөн аль нь бидний үр нөлөөтэй байдлыг улам их болгох вэ гэдгийг бодолцох ёстой.**

**Бид туршлагаараа ямар нөхцөл байдал бидний сүнслэг байдалд тустай, ямар нь аюултай гэдгийг сурдаг.** Зарим нөхцөл байдал нь хүн бүрийн хувьд аюултай байдаг бол, харин бусад нь зарим хүмүүсийн хувьд аюултай байдаг. Бид аль болох өөрсдийгөө сүнсний хувьд хүчтэй байхад туслах нөхцөл байдалд байлгаж, уруу татах нөхцөл байдлаас зайлсхийх хэрэгтэй (1 Коринт 10:12-13).

**Түүнчлэн бид ухаан бодол ба туршлага, мөн бусдын зөвлөгөөгөөр бидний үр нөлөөтэй байдлыг улам их болгох сонголт аль нь болохыг ялган таньж чаддаг.**

Бурхан өөрийн хүслийг ердийн үед онцгой илчлэлээр харуулдаггүй. **Тэр биднээс нөхцөл байдлыг ажиглаж, анхааралтай бодож цэгнэн, Бичвэрийн зарчмуудыг хэрэгжүүлэхийг хүсдэг.** Түүнчлэн биднийг анзаарч мэдээгүй байх үед ч Ариун Сүнс удирдан чиглүүлдэг. Ихэнх шийдвэр дээрээ бид илчлэл хүлээхийн оронд мэргэн ухаан ба ойлголтын төлөө залбирах учиртай.

Бурханаас онцгой удирдамж хүлээн авдаг гэж ярьдаг хүмүүс заримдаа бусдын үгийг сонсохоос татгалздаг (Сургаалт үгс 12:15). Хүмүүс тэдний шийдвэрийн талаар асууж шалгаахад тэд уурлаж магадгүй. Тэд даруу дөлгөөн байдлын оронд бардам, зөрүүд зан гаргадаг.

► Нэг суралцагч 1 Петр 5:5-6 эшлэлийг бүлэгт уншина.

Онцгой тохиолдлоос бусад үед хүн 'Бурхан надад яг ингэж хийхийг хэлсэн' гэж хэлэхгүй байсан нь дээр юм. Ингэж хэлсэн хүнд бусад хүн зөвлөх, бодол санал хэлэхэд хэцүү болдог. Харин үүний оронд 'Бурханы тусламжтайгаар хамгийн сайн шийдвэр гаргахаар хичээж байна' гэж хэлэх нь илүү дээр.

Веслигийн зарчмуудаас гадна, өөрийн сонголтуудын талаар бодохдоо дараах зүйлсийг анзаараарай:

- 1. Энэ нь Бичвэрийн тов тодорхой тушаалуудтай нийцэж байна уу?** Өөрийнх нь Үгэнд дуулгаваргүй байхыг Бурхан хэзээ ч хүсдэггүй.

2. **Энэ нь Бичвэрийн чухалчилдаг зүйлстэй нийцэж байна уу?** Бурханы хувьд юу чухал болохыг Библи харуулдаг. Таны шийдвэр чухал зүйлсийг эхэнд тавьж байна уу?
3. **Энэ нь нөхцөл байдлыг бодитоор харах байдалтай нийцэж байна уу?** Энэхүү шийдвэрийн төлөө Бурхан таныг хэрхэн бэлдэж ирснийг та харж чадах уу?
4. **Энэ нь учир шалтгаантай юу?** Заримдаа Бурхан ойлгомжгүй мэт санагдах зүйл рүү таныг дагуулж магадгүй. Гэсэн ч энэ тохиолдолд Тэр хүслээ тодорхой болгож өгнө. Бурханы хүслийг ялган таних хэрэгсэл болохын хувьд учир шалтгааныг хэзээ ч битгий үгүйсгэ.
5. **Энэ нь бурханлаг үйлдэл мөн үү?** Ямар ч нөхцөл байдлыг онцгой тохиолдол болгоод ердийн үед Бурханыг баярлуулахгүй зүйлсийг хийж болно гэж бодож болохгүй.
6. **Энэ нь өөрийгөө хайрладаг шиг өрөөлийг хайрлахтай нийцэж байна уу?** Аминч сэдэл нь таны ялган таних чадварыг гажуудуулна.
7. **Энэ нь сайн нөлөөг авчрах уу?** Таны хийж байгаа зүйлийг бусад хүн хийвэл ямар байх вэ? Сайн байх болов уу?
8. **Энэ нь бурханлаг зөвлөгчдөөр баталгаажсан уу?** Бид өөртэйгээ санал нэгдэх найз нөхдийг олоход амархан. Харин хамгийн ухаалаг, сүнслэг санагддаг хүмүүс таны энэ шийдвэрийн талаар юу хэлэх бол?

Хэрэв Бурханы хүсэл нь маш ер бусын зүйл байвал, таныг эргэлзүүлэхгүйгээр Тэр танд үүнийгээ мэдүүлж чадна. Өнгөрсөн цаг үед зарим хүмүүс тэнгэрэлч, үзэгдэл, шатаж буй бут гэх мэт зүйлсээр тодорхой баталгааг хүлээн авч байсан. Бурхан таныг эргэлзэхэд хүргэхгүй дотоод баталгааг ч өгөх боломжтой. Харин Бурханаас тодорхой үг, мэдээг хүлээн аваагүй тохиолдолд зөв сонголтыг ялган танихын тулд найдвартай зарчмуудыг дагах хэрэгтэй. Шийдвэр бүр дээрээ онцгой илчлэл хүлээх хэрэггүй. Хэрэв та зөв чухал зүйлсийн талаар чин сэтгэлээсээ, залбиралтайгаар эргэцүүлж бодож байгаа бол Бурхан таны шийдвэрийг итгэмжтэйгээр удирдан чиглүүлэх болно.

Ром 12:1-2 эшлэлд Паул бичихдээ,

Иймд ах дүү нар аа, Бурханы өрөвч сэтгэлээр та нараас хичээнгүйлэн гуйя. Өөрсдийн биеийг Бурханд тааламжтай, амьд, ариун тахил болгож өргө. Ингэх нь та нарын сүнслэг мөргөл мөн. Энэ үеийн явдалд нийцэлгүй, харин оюун санаагаа шинэчилж, өөрчлөгдөгтүн! Тэгвэл Бурханы сайн, тааламжит, төгс төгөлдөр хүсэл юу болохыг таних болно.

Эдгээр эшлэлд хүний сүнслэг нөхцөл байдал түүний шийдвэрт хэрхэн нөлөөлдгийг харуулсан. Бурханы хүслийг олохын тулд хүн эхлээд Бурханд бүрэн зориулагдсан байх учиртай. Итгэгч хүний шийдвэрүүд нь ертөнцийн шийдвэрүүдээс өөр юм. Учир нь итгэгч

хүн ертөнцтэй нийцдэггүй, харин өөрчлөгдөж, шинэчлэгдсэн оюун санаагаар шийдвэр гаргадаг.

Бурханы удирдамжийг ялган таних хамгийн чухал хүчин зүйл бол сэдэл юм. Хэрэв хүн аливаа зүйлийг хийх үү, үгүй юу гэдгээ шийдэхийн тулд л зөвхөн Бурханы хүслийг хайвал тэр хүн будилж магадгүй. Харин хүн Бичвэрийн дагуу болон учир шалтгаант арга замаар Бурханы хүслийг хайвал, мөн түүнийг хийх тууштай шийдвэртэй байвал Түүний хүслийг алдахгүй.

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

► Веслигийн зарчмыг хэрэгжүүлэх зарим жишээг ярилц. Жишээлбэл, хамт цагийг өнгөрөөх найз нөхдөө сонгох, ажлаа сонгох, эсвэл болзох талаар (гэрлээгүй хүн бол). Аль нөхцөл байдал нь намайг ариун байхад болон илүү үр нөлөөтэй байхад туслах талаар бод.

► Зарим хүн тодорхой төрлийн хүмүүс дунд, эсвэл тодорхой газарт Христэд итгэгч хүнийхээ мөн чанарыг хадгалж чаддаггүй юм шиг санагддаг. Жишээ авч, ярилцаарай.

► Дараах сэдвүүдийг мөн ярилцах боломжтой:

- Шийдвэр гаргахад сэдэл ямар үүрэгтэй байдаг талаар
- Тэмдэг хүлээдэг алдааны талаар
- Дотоод мэдрэмждээ хэт их найдахын аюул

## **Залбирал**

Тэнгэрлэг Эцэг минь,

Та миний төлөө сайн зүйлсийг төлөвлөсөнд баярлалаа. Миний харж чадахаас ч илүүгээр алхмуудыг минь Та удирдан чиглүүлдгийг би мэднэ.

Залбирлаар Тантай ойр байхад надад туслаач. Надад харуулдаг үнэнд тань анхааралтай хандахад туслаач.

Би ариун байж, Таны алдрын төлөө чадах бүхнээ хийхийг хүсэж байна.

Миний сэдлүүдийг цэвэр болгооч, ингэснээр тэдгээр нь Таны хүслээс намайг холдуулахгүй байг. Миний амьдралд байлгаж байгаа мэргэн зөвлөгчдөөр дамжуулан намайг удирдан чиглүүлээч.

Би шийдвэр гаргах болгондоо Танд итгэж найдахыг хүсэж байна. Би бүх зүрхээрээ Таныг дуулгавартай дагахыг хүсэж байна.

Надад хамгийн сайныг хүсдэг Танд баярлалаа.

Амен

## **5-р хичээлийн даалгавар**

(1) Сургаалт үгс 3:1-12 эшлэлийг судал. Энд дүрслэгдсэн чухалчлах зүйлс, хандлага болон зан чанарын талаар бич. Та эдгээр шинж чанаруудыг хувьдаа хэрхэн хөгжүүлж болох талаар бичээрэй (Нийт 1-2 хуудас бичнэ).

(2) Иаков 4:13-17 эшлэлийг нягтал. Нөхцөл байдлуудаас дээгүүрх Бурханы хэмжээлшгүй байдлыг анзаар. 16-р эшлэлд дурдсан ёрын муу зүйл буюу "ихэмсэг зан" гэж юу вэ? Энэ багц хэсэг ирээдүйг төлөвлөх талаар юу хэлж байгааг нэг догол мөрөнд бич.

(3) Залбирал ба шийдвэр гаргах хоорондын харилцааны талаар хоёр догол мөрөнд бич. Дараах асуултад хариул:

- Биднийг шийдвэр гаргахад залбирал хэрхэн нөлөөлөх ёстой вэ?
- Залбирал болон шийдвэр гаргахтай холбоотой зайлсхийх ямар алдаанууд байдаг вэ?



## 6-р хичээл

# Гэрлэлтийн талаарх Библийн үзэл баримтлал

### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах ойлголт, чадварт суралцсан байна:

- (1) Гэрлэлтэд зориулсан Бурханы төлөвлөгөө, зорилгыг ойлгож хүлээн авах.
- (2) Бурхан эмэгтэй хүнийг ямар үнэ цэнтэй гэж хардгийг ойлгох.
- (3) Бурханы зарчмуудыг гэрлэлтдээ дагахын тулд өөрийгөө зориулах.

### Өөрийгөө бүрэн зориулсан хүн Эрнандо Кортес

Эрнандо Кортесын зан чанар болон хувийн ашиг сонирхол нь бидний суралцах жишээ биш юм. Гэхдээ, зорилгынхоо төлөө бүхнээ зориулсан нэг үйл хэрэг нь жишээ болж чадна. 1519 оны хавар тэрээр одоогийн Мексикийн нутаг дэвсгэрийг эзэмших судалгааны багийг удирдан явжээ. Испанийн засаг захиргаа 11 хөлөг онгоц, 700 орчим хүнээр энэхүү ажиллагааг дэмжсэн байна. Тэнгисээр олон сар аялсны эцэст Кортес болон түүний хүмүүс Мексикийн эрэгт хүрчээ. Тэдний дараагийн сорилт нь хуурай газраар нийслэл хотод хүрэх байв. Газраар явах энэхүү аялал нь хүнд хэцүү, аюултай гэдгийг Кортес мэдэж байлаа. Тэр хүмүүстээ буцах сонголт байхгүй гэдгийг ойлгуулахыг хүсэж, бүх хөлөг онгоцыг шатаав. Ингэснээр Испани руу буцах боломжгүй болсон ч, нөгөөтэйгүүр урагшлах хүчтэй сэдлийг бий болгожээ. Үүнтэй адилхан гэрлэж байгаа хүн бүр үүнд өөрийгөө бүрэн зориулах ёстой. Нэгэнт гэрлэсэн л бол өөр сонголт байхгүй гэдгийг ухаарах хэрэгтэй.

### Танилцуулга

Библийн дагуух гэрлэлт нь үзэсгэлэнтэй сайхан зүйл юм.<sup>8</sup> Харин үүний гоо сайхныг мэдэрч, сайн сайхныг нь амсахын тулд хосууд Библи гэрлэлтийн талаар юу заадгийг нягталж, улмаар сурсан зүйлээ дагахыг зорих учиртай. Сэтгэл тэнүүн гэрлэлтийг бий болгоход хичээл зүтгэл, золиос хэрэгтэй.

► Ямар нэг ашиг тус хүлээж гэрлэсэн ч, үүндээ зориулалт гаргах шаардлагатайг анзаараагүй байсан бол хуваалцана уу?

Гэрлэлтийг ойлгохын тулд бид үүний эхлэл рүү буюу Эхлэл ном руу буцах ёстой. Бүтээлийн түүх гэрлэлтийн талаар бидэнд заадаг.

---

<sup>8</sup> Энэхүү хичээлийг Tim Keer боловсруулсан.

## Библийн дагуух гэрлэлт

### Библийн дагуух гэрлэлт нөхөрлөлийн төлөө байдаг

“ЭЗЭН Бурхан —Хүн ганцаараа байх нь сайн биш. Би түүнд тохирох туслагчийг буй болгоё гэжээ” (Эхлэл 2:18).

Бурхан Эцэг, Хүү, Ариун Сүнс гурвалаар нөхөрлөлд оршдог шиг Тэр биднийг нийгмийн харилцаанд байхаар бүтээсэн. Бид харилцан ярилцахаар, дотно байдал, нөхөрлөлийн төлөө бүтээгдсэн. Ганцаараа байх нь сайн биш гэж Бурхан хэлсэн!

Эхлэл номын үйл явдлуудыг тодруулсан хэсэг бүрээс гэрлэлтийн эрхэм нандин чанарыг харж болдог. Бурхан эрэгтэй хүний нэгэн хавиргыг авч, үүгээр үзэсгэлэнтэй эмэгтэйг бүтээсэн юм. Тэрхүү эмэгтэй нь өөр нэгэн бодгаль буюу эрэгтэйн адил Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн, үнэ цэн нь адил, эр хүнийг бүрэн болгодог бөгөөд харин бүтээгдсэн загвар нь өөр нэгэн юм. Тэрхүү эмэгтэйг “Бүтээгчийн хамгийн эцсийн, хамгийн төгс бүтээл болгон эр хүнд хүндэтгэлтэйгээр авчирсан.”<sup>9</sup>

#### **Гэрлэлт нь баяр баясгалантай нэгдэл юм.**

Адам “Энэ чинь л яснаас минь авсан яс” (Эхлэл 2:23) гэж хэлэхдээ хүндэтгэл болон баяр хөөрөө илэрхийлсэн. Адам “Эцсийн эцэст нэг боолтой боллоо! Одоо хоол хийлгэж, хувцсаа угаалган, нуруугаа бариулж, гэрийн ажлаа хийлгэх хүнтэй боллоо!” гэж хэлсэн үү. Үгүй. Харин тэрээр “Эцэст нь намайг бүрэн болгох туслагч!” хэмээн хэлсэн.

#### **Гэрлэлт нь ижил тэгш эрхтэй хүмүүсийн нэгдэл юм.**

“...түүнд тохирох туслагчийг” (Эхлэл 2:18). Бурхан эмэгтэй хүнийг эрэгтэй хүнд төгс тохируулж, түүнийг бүрэн болгохоор бүтээсэн.

Матью Хенри “Эмэгтэйг Адамын хавирганаас, түүний хажуугаас бүтээсэн бөгөөд толгойноос нь бүтээсэн бол тэр түүнийг захирах байсан. Түүний хөлнөөс бүтээсэн бол тэр түүнийг гишгэх байсан. Харин хажуугаас нь бүтээсэн нь түүнтэй адил тэнцүү байхын тулд, түүний гарын доох нь хэсгээс бүтээсэн учраас хамгаалуулахын тулд, түүний зүрхэнд ойр бүтээгдсэн учраас хайрлуулахын тулд бүтээсэн юм”<sup>10</sup> гэж хэлсэн байдаг. Эмэгтэй хүн эр хүнээс дор ч биш, мөн дээр ч биш, харин түүнтэй адил тэнцүү нэгэн юм.

#### **Гэрлэлт нь гэрээний нэгдэл юм.**

“Ийм учраас эр хүн эцэг эхээ орхиод, эхнэртэйгээ нийлж, хоёул нэг махбод болдог” (Эхлэл 2:24). Хүчирхэг гэрлэлт нь романтик харилцаан дээр (романтик мэдрэмж төрдөг, бас үгүй болдог), эсвэл таашаал дээр (хэдий энэ нь эрүүл гэрлэлтэд баяр баясгалан авчирдаг ч), эсвэл хувийн хэрэгцээ ханамж дээр (хэдий энэ нь хүчирхэг гэрлэлтэд

<sup>9</sup> *Ellicot's Commentary for English Readers* (Эхлэл 2:22-ын тэмдэглэл). 2020 оны 12 сарын 29-нд <https://biblehub.com/genesis/2-22.htm> вебсайтад хандсан.

<sup>10</sup> *Matthew Henry's Commentary on the Whole Bible*

үнэхээр дүүрэн байдаг ч) тогтдоггүй. Гэрлэлтийн гайхамшигтай давуу тал ашиг тус нь хүчирхэг гэрлэлтийн шалтгаан биш, харин үр дүн юм. Гэрлэлт нь гэрээний ганхашгүй суурь буюу нэг эрэгтэй, нэг эмэгтэйн хооронд насан туршдаа бие биедээ онцгой зориулалт гаргах амлалт дээр үндэслэгддэг.

Гэрлэлт нь ил тод, итгэж найддаг, бие биеэ хүлээн зөвшөөрдөг харилцаа байх ёстой. “Тэр хүн, бас эхнэр нь хоёулаа нүцгэн байсан бөгөөд тэд ичсэнгүй” (Эхлэл 2:25). Нүгэл анхны хосыг гажуудуулаагүй байсан учраас тэдний гэрлэлтэд шүүлт, ичгүүр, айдас байгаагүй юм. Шинэ гэрээ бидэнд “Гэрлэлтийг бүгд хүндлэгтүн. Ор дэр чинь бүү бузартаг” (Еврей 13:4) гэж сургадаг.

Аюулгүй байдал байхгүй, үл итгэлцэл, хардалт, айдастай, хосууд гэрлэлтдээ зориулах бие биенийхээ шийдвэрт баттай биш бол хүчирхэг гэрлэлт байх боломжгүй юм. Харин хүчтэй гэрлэлт нь хань ижлийн нэг нь нас барснаар дуусгавар болох бат бэх андгай тангаргийг шаарддаг (Ром 7:1-2).

Бурхан гэрлэлтийг нэг эрэгтэй, нэг эмэгтэй хоёрын насан туршийн гэрээ байлгахаар зорьдог (Матай 19:3-6). Үл итгэгч хань ижил нь салж явбал итгэгч хүн боолчлол хүлээсэн дор байхгүй гэж Паул хэлсэн байдаг (1 Коринт 7:15). Харин итгэгч хүн үл итгэгч хань ижлээсээ салахыг эрэлхийлэх ёсгүй (1 Коринт 7:12-14, 16). Паул үүний өмнөхөн Эзэн ч мөн адил зүйлийг хэлдэг гэж бичихдээ, итгэгч хүн хань ижлээ орхих, салах сонголтыг гаргах ёсгүй бөгөөд хэрэв тийм зүйл тохиолдвол өөр хүнтэй гэрлэх ёсгүй гэжээ (1 Коринт 7:10-11, Матай 5:31-32, Матай 19:9).

Гэрээний хайр бол өөрийгөө зориулдаг, хүндэлдэг, хэдий харилцаа хэцүүдэж муудах үед ч үзэсгэлэн гоог бүтээж байдаг хайр юм (1 Коринт 13). Сул амлалт зориулалт нь хичээл зүтгэлгүй, сэтгэл зүйн холбоогүй, хөндий байдал, уруу таталтыг төрүүлдэг.

Эхнэр нь хариу өгөхгүй, хүндэтгэхгүй, өвдөж зовсон үед ч нөхөр нь түүнийг хэзээ ч орхих ёсгүй бөгөөд энэ нь нөхөр хүн гэрээний хайраа харуулах амьдрал юм. Харин нөхөр нь түүнийг хайрлахгүй байсан ч, Христийн улмаас нөхрөө хүндэтгэж, дуулгавартай байхыг сонгох нь эхнэр хүн гэрээний хайраа харуулах амьдрал юм.

Нөхрийн хайр нь эхнэрийн хүндэтгэлийг олдог бол, эхнэрийн хүндэтгэл нь нөхрийн хайрыг олдог. Улмаар тэд үргэлж өсөж хөгждөг!

► Хэрэв хүмүүс гэрлэснийхээ дараа гэрлэлтээ аз жаргалгүй байна гэж дүгнээд шийдвэрээ өөрчлөхийг хүсвэл ямар асуудлууд гарах вэ? Хүн өөрийн гэрлэлтийг насан туршийн гэж итгэхэд бүрэн зориулалт нь ямар ялгааг авчрах вэ?

**Библийн дагуух гэрлэлт нь нөхөн үржихүйн буюу бүтээлийн орчин юм.**

“Харагтун, үр хүүхэд ЭЗЭНээс ирэх өв, умайн үр жимс нь шагнал юм” (Дуулал 127:3).

Хүүхдүүд нь Бурханы бэлэг хэдий ч, нөгөө талаараа тэд бас эцэг эхийн Бурханд зориулах бэлэг юм. “Гэвч өчүүхэн ч гэсэн Сүнстэй хэн нь ч тэгэхгүй. Бурханлаг үр удмыг Бурхан эрэлхийлж байхад тэр хүн юу хийж байгаа нь тэр вэ? Тиймээс сэтгэлээ анхаар.

Хэн ч залуу насныхаа эхнэрээс бүү урваг” (Малахи 2:15). Бурхан итгэгч нөхөр, эхнэрийн нэгдлээс бурханлаг хүүхдүүдийг хүсдэг.

Зарим хүн хүүхэдгүй амьдралын хэв маягийг илүүд үздэг ч, эцэг эхчүүд бурханлаг хүүхэдтэй байхад Бурхан баярладаг.

Зөвхөн хүүхэдтэй болох тухай биш, харин бурханлаг хүүхдүүдтэй байхыг Бурхан хүсдэг гэдгийг энд тэмдэглэх нь чухал. Бурхан эцэг эхчүүдийг хүүхдээ Христийг дагахад сургахаар дуудсан.

### **Библийн дагуух гэрлэлт нь Христийн төлөө байдаг**

Ефес 5:30-32-д Ариун Сүнс Христийг ирэх хүртэл нууцлагдан буй үнэнийг гэрлэлтийн гүн гүнзгий утгаар илчилсэн байдаг. Гэрлэлт бол Есүс Христ ба Түүний чуулган хоорондын харилцааг тусган харуулдаг газар дээрх зураглал юм.

Паул итгэгчдийг Сүнсээр дүүрэн байхад уриалж, энэ хэсгийг эхлүүлсэн (Ефес 5:18). Энэхүү хам сэдвийн хүрээнд тэр дараах зааврыг өгчээ:

Итгэгчид Есүст захирагддагийн адил (Ефес 5:24, 32; түүнчлэн 1 Петр 3:1-г үз), **сүнсээр дүүрэн сүйт бүсгүй** нь Эзэн дотор өөрийн болзоот залууд (өөрийн “тэргүүнд”) захирагдах болно. Үүгээрээ тэр Есүсийг болон нөхрөө хүндэтгэж байгаагаа харуулдаг.

Эхнэр хүн бүр нөхөртөө захирагдахдаа Эзэнийг санаж байх нь маш чухал юм. Тэр зөвхөн нөхрийнхөө төлөө биш, харин Эзэний төлөө, Түүнд захирагдаж байгаа юм. Түүний харц ямар ч өө сэвгүй Нэгэн болох Есүсийг ширтэн хардаг. Эхнэр хүний нөхөртөө захирагдах байдал нь Есүсийг хүндлэх мөргөлийн үйл юм.

Библийн дагуух захирагдах байдлыг хайрын адил хүчээр тулгах боломжгүй. Библийн дагуух захирагдах байдал нь Христийг эмээн хүндэтгэдэг эхнэр хүний нөхөртөө өгдөг бэлэг юм (Ефес 5:33). Бүх зүйл дээр захирагдах нь Есүсийг хүндлэх мөргөлийн үйл мөн.<sup>11</sup>

Эхнэр хүний нөхөртөө захирагдах байдал нь түүнийг хүндэтгэж буй үйл (33-р эшлэл) бөгөөд Сүнсээр дүүрэн амьдралын нэг хэсэг (Ефес 5:18-21) юм. Намуун зөөлөн сүнснээс гардаг энэхүү хүндэтгэл нь Бурханы мэлмийд маш эрхэм нандин (1 Петр 3:4-5) билээ.

**Сүнсээр дүүрэн болзоот залуу нь** Есүс өөрийн чуулганыг хайрладаг шиг сүйт бүсгүйгээ хайрлах болно (Ефес 5:25). Тэр эхнэрээ өөрийн бие мэт хайрлах ёстой (Ефес 5:28-29). Есүс чуулганы төлөө өөрийгөө өгсөн шиг, Сүнсээр дүүрэн нөхөр хүн өөрийгөө золиослох хайрыг харуулах ёстой. Энэ нь түүний захирагдаж байгаа үйл юм (Ефес 5:21). Нэгэн Библийн тайлбарлагч энэ талаар:

---

<sup>11</sup> Библийн дагуух захирагдах байдлын талаар дэлгэрүүлж харахыг хүсвэл Shepherds Global Classroom байгууллагын *Spiritual Formation* курсын 10-р хичээлийг үзэх боломжтой.

Тэрээр (Есүс) чуулганыг аврахын тулд загалмай дээр зовсны адил, бид өөрсдийгөө үгүйсгэж, эхнэрийнхээ аз жаргалыг тэтгэхийн төлөө хөлсөө урсгаж, зовлонг үүрэхэд бэлэн байх ёстой юм. Нөхрийн үүрэг бол эхнэрийнхээ амьжиргааг хангахын төлөө чармайн ажиллаж, хэрэгцээг нь хангах, шаардлагатай бол өөрийн тав тух, амралтаас татгалзаж, эхнэрээ өвдөх үед нь асрах, аюулаас халхлах, хэрэв тэр эрсдэлд байвал хамгаалж, цухалдах үед нь тайвшруулж, өөрийг тань түлхэж байхад ч түүнд наалдан ойр байх, сүнслэг зовлон туулах үед нь хамт залбирах, түүнийг аврахын төлөө амиа ч өгөхөд бэлэн байх явдал юм. Яагаад заавал ийм байх ёстой гэж? Хэрэв тэд хөлөг онгоцны сүйрэлд өртөж, аврагдах цорын ганц банз мод тэнд байсан гэж төсөөлвөл, нөхрийн хувьд ямар ч эрсдэлтэй учрах бай хамаагүй эхнэрээ түүн дээр тавьж, түүнийг аврахыг хүсэхгүй гэж үү? Гэхдээ үүнээс ч илүү зүйл нь нөхөр хүний амьдралынх нь хамгийн агуу зорилго бол эхнэрийнхээ авралыг эрэлхийлэх явдал гэдгийг ухамсарлах ёстой. Тэр эхнэрийнхээ сүнс сэтгэлд хэрэгтэй бүхнийг төвхнүүлэх учиртай... Мөн тэрээр үлгэр дуурайлыг харуулж, шаардлагатай бол зөвлөж, эхнэрийнхээ хувьд авралын замыг аль болох амар, дардан байлгах ёстой. Хэрэв нөхөр хүнд Аврагчийн Сүнс хийгээд өөрийгөө үгүйсгэх чанар байгаа бол гэр бүлийнхээ авралын төлөөх ямар ч золиос түүнд хэтэрхий их санагдахгүй.

12

Христ өөрийн сүйт бүсгүй болох чуулганаа ариусгадаг шиг нөхөр нь эхнэрийнхээ ариун байдлыг эрэлхийлэх ёстой. “Тэр чуулганыг ... цэвэрлэн, ариусгаад ... [мөн] түүнийг ямар ч толбо, үрчлээс мэт элдэв юмгүй... ариун гэм зэмгүй байлган Өөрийнхөө өмнө...” (Ефес 5:26-27).

Эрт цагт хаадын сүйт бүсгүйчүүдийг гоо сайхны арчилгаагаар бие махбодыг нь ариусган бэлддэг байжээ. “Эмэгтэйчүүдэд зориулагдсан арван хоёр сарын гоо сайхны үйлчлэл буюу миррийн тосны зургаан сар, тэгээд үнэртэн болон эмэгтэйчүүдийн оо энгэсгийн зургаан сарыг...” (Естер 2:12-г үз). Ийнхүү онгон бүсгүй нөхөртөө зориулагдахад бэлэн болдог байжээ.

Сүнслэг утгаараа нөхөр нь эхнэрийнхээ хөгжин цэцэглэлтэд хэрэгтэй итгэмжит байдал, болзолгүй хайр, ойлголцол, залбирал, зөвлөгөө, заах болон энэрэл зэрэг бүхнээр хангах ёстой юм.

Нөхөр эхнэрээ ийм хайраар хайрлах үед тэр эхнэрээсээ аз жаргалыг хариуд нь хүлээн авдаг. Паул “Эхнэрээ хайрлагч нь өөрийгөө хайрладаг” (Ефес 5:28) гэж хэлсэн. Өөрийгөө золиослон ийнхүү хайрладаг нөхөр хүн ихэнх тохиолдолд эхнэрээсээ хүндэтгэл, анхаарал халамж, үнэнч байдлыг хүлээн авдаг төдийгүй, Эзэн ч түүнийг шагнах нь гарцаагүй.

► Эхнэртээ сүнслэг дэмжлэг үзүүлэхийн тулд нөхрийн тодорхой хийх ёстой зүйл юу вэ?

---

<sup>12</sup> Albert Barnes, *Commentary on Ephesians*, (5-р бүлэг)

## **Хосууд гэрлэлтээ бэхжүүлэх арга замууд**

### **(1) Тэд Бурханы анхдагч загвар төлөвлөгөөг баяртайгаар хүлээн авч, гэрлэлт дэх тус тусын өвөрмөц үүрэгт талархалтай хандах.**

Нөхөр хүн эхнэрээ Бурханаас ирсэн бэлэг, өөрийг нь бүрэн болгох туслагч гэдгийг санаж байх ёстой. Тэр эхнэрийнхээ аюулгүй байдал, бие, сэтгэл санаа, сүнсний сайн сайхан байдлын төлөө амьдралаа зориулах учиртай. Тэрээр эхнэртээ талархахыг сонгож, эхнэр нь энэ бүхнийг хүртэх ёсгүй санагдсан үед ч түүнийг хайрлах ёстой. Учир нь эхнэрийнх нь дотор болох зүйлийг зөвхөн Бурхан л өөрчилж чадна гэдгийг тэр ухаарах хэрэгтэй юм. Бурхан нөхрийн дуулгавартай байдал болон итгэлийг өргөмжлөх болно.

Эхнэр хүн нөхрийг нь түүний тэргүүн болгосон Бурханы сонголтыг хүндэтгэж, чадах бүхнээрээ, бүх талаараа нөхрөө хүндэлж, түүний удирдлагыг дээдлэх ёстой. Нөхөр нь алдаа гаргах үед, энэ бүхнийг хүртэх ёсгүй санагдсан үед ч эхнэр хүн түүнийг хүндэлж, захирагдахыг сонгох учиртай. Түүнчлэн нөхрийнх нь хувьд өөрчлөгдөх ёстой зүйлийг Бурхан өөрчилж өгөхийг залбирч гуйх хэрэгтэй. Бурхан эхнэрийн дуулгавартай байдал болон итгэлийг өргөмжлөх болно.

### **(2) Гэрлэсэн хосууд сүнслэг болон бие махбодын дотно байдлаа хөгжүүлж тордох хэрэгтэй.**

Тэд айдас, шүүмжлэл, хүчирхийлэл, бусадтай харьцуулах, тачаал, зөвхөн өөртөө таашаал авах, дорд үзэл гэх мэт зүйлгүйгээр бие биенээ таньж мэдэх хэрэгтэй. Тэд Бурханы өмнө болон нэг нэгнийхээ өмнө илэн далангүй, үнэнч байдлаар амьдрах ёстой.

### **(3) Гэрлэсэн хосууд шалгуурыг давж чадахгүй бүдрэх үедээ Бурханы нигүүлслийн жишээг дагах хэрэгтэй.**

Адам, Ева хоёр нүгэлд унаж, ичгүүр харууслыг мэдрэх үед Бурхан тэднийг бүтэлгүйтлээс нь золин аврах хүч чадлаа илчилсэн юм. Бурхан нэгэн амьтныг тахил болгон зольж, арьсаар нь Адам Ева хоёрын нүцгэн биеийг халхлах дээл хийж өгчээ (Эхлэл 3:21). Энэхүү хайрын үйлдэл нь Бурханы нигүүлслийн дүр зураг бөгөөд Христээр золин аврах амлалтыг харуулдаг. Христ биднийг уучлагдаж, сэргээгдэх боломжтой болгодог. Хэдий хосууд гэрлэснийхээ дараа бүтэлгүйтсэн ч, Христээр дамжуулан ичих зүйлгүйгээр дахин ойр дотно байдалдаа эргэн очиж чадна.

## **Эмэгтэйчүүдийг хүндэлсэн Есүсийн үлгэр дуурайл**

1-р зууны үеийн Ромын ертөнц болон иудеизмд эмэгтэйчүүдийг эрчүүдээс дорд үздэг байжээ. Эмэгтэйчүүдийг дорд үзэх явдал дэлхийн олон соёл, гэр бүлүүдэд түгээмэл хэвээр байна. Эмэгтэйчүүдийг үл хүндэтгэх, бэлгийн хэрэгсэл болгон ашиглах зэрэг хүчирхийлэл үйлдэгдсээр байна. Харин Есүс эмэгтэйчүүдийг өндрөөр үнэлдэг байсан нь бидний хувьд үлгэр дуурайл болох ёстой.

Христ эмэгтэйчүүдийн нэр төр, үнэ цэнийг эрчүүдтэй ижил тэгш гэж үздэг байсан. Есүс "Бүтээгч анхнаас нь тэднийг эр эмээр нь бүтээснийг..." (Матай 19:4, Эхлэл 1:27) хэмээн айлджээ. Эмэгтэй хүн эрэгтэйн адил Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн. Эрчүүдийн адил өөрийгөө ойлгох, тодорхойлох, эрх чөлөөтэй байх, хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх чадвартай юм. Есүс эмэгтэйчүүдийг эрэгтэй хүний хүслийг хангах хэрэгсэл гэж үзээгүй, харин жинхэнэ хүмүүс гэж үздэг байв. Тэрээр эмэгтэйчүүдийг хүн хэмээн үзэж, тэдний төлөө дэлхийд ирсэн гэдгээ хэлсэн (Лук 8:1-3).

Жеймс Борланд, Жон Пайпер, Вейн Грудем нар Сайнмэдээний дөрвөн номд тэмдэглэгдсэн, Есүс эмэгтэйчүүдийг өндрөөр үнэлж, хүндэтгэсэн тодорхой жишээнүүдийг дараах байдлаар тайлбарлажээ:

### **(1) Есүс олон нийтийн газар эмэгтэйчүүдтэй шууд байдлаар харилцдаг байсан.**

Есүсийн цаг үед эрчүүд эмэгтэй хүнд ийнхүү хандах нь энгийн зүйл байгаагүй (Иохан 4:27). Дагалдагч нар нь Есүсийг Сухар худгийн дэргэд самари эмэгтэйтэй ярилцаж байхыг хараад гайхсан (Иохан 4:7-26). Тэрээр завхайрсан эмэгтэйтэй чөлөөтэй ярилцжээ (Иохан 8:10-11). Есүс Наин хотын бэлэвсэн эмэгтэй (Лук 7:12-13), цус алддаг өвчтэй эмэгтэй (Лук 8:48, Матай 9:22, Марк 5:34) болон цугласан олны дундаас Түүнийг дуудсан эмэгтэйтэй (Лук 11:27-28) олон нийтийн газар ярилцсан талаар Лук тэмдэглэсэн. Есүс 18 жилийн турш өвчтэй байсан эмэгтэйд (Лук 13:12) болон загалмай руу явах замдаа бүлэг эмэгтэйчүүдэд (Лук 23:27-31) хандан өгүүлсэн байдаг.

### **(2) Есүс эмэгтэйчүүдтэй ярилцаж буй байдлаараа тэднийг хүндэтгэж, өндрөөр үнэлдэг байснаа харуулсан.**

Тэрээр ухаалаг, санаа тавьсан байдлаар тэдэнтэй ярилцдаг байв. Матай, Марк, Лук нь Есүс цус алддаг өвчтэй эмэгтэйг "охин" гэж дуудсан, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйд "Абрахамын охин" (Лук 13:16) хэмээн хандсан талаар дурдсан байдаг. Есүс тэднийг "Абрахамын охид" гэж дуудсанаараа "Абрахамын хөвгүүд"-тэй адил сүнслэг хэмжээнд өргөмжилж буй юм.

### **(3) Өөрсдийн нүглийн төлөө хувийн хариуцлага хүлээхийг сануулахдаа Есүс тэдний төрөлх үнэ цэнийг харуулсан юм.**

Энэ нь худгийн дэргэдэх эмэгтэй (Иохан 4:16-18), завхайрсан эмэгтэй (Иохан 8:10-11) болон Түүний хөлийг тосолсон нүгэлт эмэгтэйтэй (Лук 7:44-50) харилцсан байдлаас харагддаг. Есүс тэдний нүгэлд тоомжиргүй хандаагүй, харин нүүр тулсан юм. Түүний үйлдэл нь эмэгтэй хүн бүр хувийн эрх чөлөөтэй, сонголтынхоо төлөө хариуцлага хүлээдэг, нүгэл, гэмшил, уучлалын асуудлыг өөрөө шийдвэрлэх ёстойг илэрхийлсэн.

### **Эмэгтэй хүнийг үнэлсэн Есүсийн хандлагыг өнөөгийн чуулган хэрхэн дагах вэ?**

Эмэгтэйчүүдийн үйлчлэл болон гэр бүл дэх Библийн дагуух үүрэг хариуцлагын талаар чуулган, урсгал чиглэлүүдийн дунд байнга яригдаж байгаа ч, Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн хүмүүсийнх нь хувьд тэдний үнэ цэн, тэгш эрх **хэзээ ч** эргэлзээтэй байх

ёсгүй. Есүс эмэгтэйчүүдийг үнэ цэн, нэр төртэй хүмүүс гэдгийг байнга илэрхийлж байсан. Есүс эмэгтэйчүүдийг амиллынхаа анхны гэрч нар байхаар дуудсан (Иохан 20:17). Тэрбээр тэдний нөхөрлөл, залбирал, итгэлийн үйлчлэл, санхүүгийн дэмжлэг, гэрчлэлийг нь үнэлдэг байсан. Есүс эмэгтэйчүүдийг хүндэлж, тэдэнд зааж, ухаалгаар үйлчилж байв.

### **Шинэ гэрээнд эмэгтэйчүүдийг хүндэлсэн талаар**

Есүс эмэгтэйчүүдийг хүндэлсэн үлгэр дуурайлыг Ариун Сүнсний амьдралаас харж болно. Пентэкостын өдөр Ариун Сүнс хөвгүүд, охид, эрэгтэй, эмэгтэй зарц нар дээр асгарсан (Үйлс 2:17-18). Ариун Сүнс хэнийг ч ялгаварлаагүй.

Ром 16-р бүлэгт Паул Фойбе хэмээх эмэгтэйг чуулганы үйлчлэгчээр (1-р эшлэл), Приска болон Акул хоёрыг Христ Есүсийн хамтран зүтгэгч буюу түүний амь насны төлөө өөрсдийгөө эрсдэлд оруулсан хүмүүс (3-4-р эшлэл), Мариаг шаргуу хөдөлмөрлөсөн (6-р эшлэл), Иуниаг элч нарт сайн танигдсан хүн (7-р эшлэл), мөн бусад эмэгтэйчүүдийг ч сайшаан бичжээ.

1 Тесалоник номд Паул Бурханы бүтээсэн энхрий зөөлөн, эхийн хайрыг "бид та нарын дунд эх хүн хүүхдүүдээ асрах мэт зөөлөн байсан" (1 Тесалоник 2:7) хэмээн бичсэнээр эмэгтэйчүүдийг сайшаажээ. Ефес номд тэрээр нөхрүүдэд хандан эхнэрээ "Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил", мөн өөрийн бие шиг (Ефес 5:25, 28) хайрлахыг тушаасан юм. Петр нөхрүүдэд "эхнэр чинь эмэгтэй хүн тул... эхнэртэйгээ ойлголцож амьдар... түүнийг хүндэтгэ" (1 Петр 3:7) хэмээн уриалсан байдаг.

Эртнээс чуулганд эмэгтэйчүүдийг үнэ цэнтэй гэж үздэг байсан нь тодорхой харагддаг бөгөөд эрчүүдэд эмэгтэйчүүдийг хүндэтгэхийг заадаг байсан. Сүнслэг удирдагчид эдүгээ цагт эмэгтэйчүүдийн төлөө зогсож, тэднийг хүчирхийлэхийн эсрэг зогсох цаг болжээ. Эмэгтэйчүүдийг Бүтээгчийн онцгой дүр төрхөөр бүтээгдсэн хүмүүс гэж үзэх цаг болжээ. Чуулганд болон гэр бүл дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүргийн ялгааг заахдаа энэхүү байр сууринаас хандах ёстой бөгөөд эс тэгвээс бидний зааж буй сургаал хүчирхийлэлд хөтлөх зам ч болж болно.

### **Дүгнэлт**

Гэрлэлт нь хүний бүтээл биш, Бурханы бүтээл. Тиймээс бид зааврыг энэ дэлхий, ахуй соёлоос биш, харин Бурханаас хүлээн авах ёстой. Бидний гэрлэлтийг хүчтэй, тэсвэртэй, үр нөлөөтэй болгохыг Тэр л мэддэг. Гэсэн хэдий ч Ариун Сүнсгүйгээр бид байх ёстой нөхөр, эхнэр болж чадахгүй!

## Хэлэлцүүлгийн асуултууд

- ▶ Гэрлэлтийг бэхжүүлэхийн тулд чуулган ямар зарчмуудыг заах ёстойг тайлбарла. Таны байгаа газар ямар ойлголт нь илүү дутагдаж байна вэ?
- ▶ Таны ахуй соёлд эмэгтэй хүнтэй ялгаатай хандах явдал байдаг уу?
- ▶ Танай улсад буй чуулганууд эмэгтэйчүүдэд ялгаатай ханддаг уу? Чуулган болон нийгмийн хандлагын хооронд ялгаа бий юу?
- ▶ Есүсийн харуулсан үлгэр дуурайлд үндэслэн, өөрчлөгдөх шаардлагатай ямар нэгэн ёс заншил байна уу?

## Залбирал

Тэнгэрлэг Эцэг минь,

Гэрлэлт хэмээх гайхамшигтай бэлгийг бидэнд өгсөн Танд баярлалаа. Бид Таны төлөвлөсөн гэрлэлтээр амьдрахын тулд шаардлагатай зориулалтыг гаргахад туслаач.

Христ чуулганыг хайрласны адил хайрыг харуулахад бидэнд туслаач.

Нэг нэгнээ хүндэтгэх тал дээр нийгэм соёлын таамаглалуудаас ч хальж цаашлахад бидэнд туслаач.

Баяр хөөртэй, бат бэх харилцааг боломжтой болгодог Ариун Сүнс Таны ажилд баярлалаа.

Амен

## 6-р хичээлийн даалгавар

(1) Таны амьдарч буй нийгэмд тогтсон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгааг тодорхойлно уу. Эдгээр ялгааг Библийн үнэнд суурилсан мэдлэгээр дамжуулан хэрхэн шинэчилж болох вэ?

(2) Энэ хичээлийн явцад танд шинэлэг санагдсан 2 зарчмыг сонго. Зарчим тус бүрийг өөрийн үгээр тайлбарлан нэг догол мөр бичээрэй.

(3) Дараах сэдвээс нэгийг сонгож, товч толилуулга бэлтгэ (ангийн удирдагч суралцагч бүрд сэдвийг хуваарилж болно). Дараагийн хичээл эхлэхээс өмнө толилуулгаа хуваалцаарай.

- Гэрлэлт дэх нэгдлийг Бурхан төлөвлөсөн нь
- Гэрлэлтийн талаарх Библийн зорилгууд
- Гэрлэлтээ бэхжүүлэх арга замууд
- Эмэгтэйчүүдийн талаарх Библийн үзэл санаа
- Гэрлэлтэд зориулж Бурханы өгсөн үүргүүд болон эдгээрийг биелүүлэхийн тулд Ариун Сүнсээр дүүрэн байхын ач холбогдол



## 7-р хичээл

# Гэрлэлтийн ариун нандин байдал

### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах ойлголт, чадварт суралцсан байна:

(1) Гэрлэлтэд зориулсан Бурханы төлөвлөгөө болон элдэв асуудлаас хамгаалж, ивээл ерөөл авчирдаг гэрлэлтийн зарчмуудыг ойлгоно.

(2) Гэр бүлд зориулсан Бичвэрийн удирдамжийг тайлбарлаж сурна.

### Амлалтаа сахигч Робертсон Маквилкин

Доктор Робертсон Маквилкин 12 жилийн турш Японд сайнмэдээний үйлчлэл хийжээ. Хожим нь Columbia International University-ийн ректор болсон бөгөөд тэрээр алдартай зохиолч, илтгэгч, сурган хүмүүжүүлэгч хүн юм. Түүний эхнэр Мюрэй альцхаймер өвчнөөр өвдөж, байнгын асаргаа шаардлагатай болтлоо хүндэрсэн тул Маквилкин эхнэрээ асрахаар их сургуулийн ректорын албан тушаалаа өгчээ. Тэрээр энэ талаараа гэрлэх үедээ өгсөн ам тангаргаа биелүүлж байна гэж хэлжээ. Түүний хувьд эхнэрээ халамжлах нь их сургуулийн ректорын албан тушаалаас эрхэм чухал байсан юм.

### Гэрлэлт бол Бурханы санаачилсан бүтэц юм

Бурхан анхны эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээснийхээ дараа гэрлэлт хэмээх бүтцийг санаачилжээ.

► Нэг суралцагч Эхлэл 2:21-24 эшлэлийг бүлэгт уншина. Эдгээр эшлэлд гэрлэлтийн талаар юу өгүүлж байна вэ?

Бурхан гэрлэлтийг хүмүүст гарцаагүй хэрэгтэй зүйл болгон бүтээсэн юм. Тиймээс гэрлэлт нь хүний мөн чанарт яг тохирдог. Бурханы бүтээсэн юм бүхэн, шаарддаг бүх зүйлс нь үргэлж бидний сайн сайхны төлөө байдаг (Дэд хууль 6:24). Гэрлэлтэд зориулсан Түүний төлөвлөгөө ч бас бүх хосуудад сэтгэл хөдлөл, харилцаа, сүнслэг сайн сайхан байдлыг авчирна гэдгийг Тэр мэдэж байсан.

Гэрлэлт бол Бурханы зан чанар, харилцааны тусгал байхаар бүтээгдсэн юм. Бурхан Эцэг, Бурхан Хүү, Бурхан Ариун Сүнс үргэлж хоорондоо харилцаатай байсан, харилцаатай ч байх болно. Хэн хэн нь өвөрмөц үүрэг хүлээдэг боловч Гурвалын бодгаль бүр мөнхөд нэгдмэл, нэг мөн чанартай. Гурвалын хоорондын харилцаанаас бид дотно, үнэнч, итгэмжтэй бас тууштай хайрыг олж хардаг. Эхнэр нөхөр бүр цэвэр ариун харилцаатай, насан туршдаа бие биедээ өөрийгөө зориулсан байх нь Бурханы төлөвлөгөө юм.

Бурхан эрэгтэй эмэгтэй хүмүүс эцэг эхээ орхиж, гэрлэлтээр хоорондоо нэгддэг гэсэн. Гэрлэлт нь бүх харилцаанаас хамгийн хүчтэй, хамгийн дотно, нөхөрлөл ба хамтралын харилцааг хоёр хүний дунд үүсгэдэг.

Гэрлэлт бол хоёр хүний жижиг түншлэл биш, харин амьдралаараа нягт холбогдсон, нэг хүн мэт тооцогдох нэгдэл юм. Энэ холбоо нь тэдний хувь хүний шинж чанарыг арилгахгүй. Харин хос хоёрын дунд өвөрмөц нэгдлийг бий болгодог.

### **Гэрлэлт насан туршид үргэлжлэх ёстой**

Бурхан гэрлэлтийг насан туршийнх байхаар бүтээсэн. Тиймээс хуримлах үедээ хосууд амьд байгаа цагтаа бие биедээ үнэнч байхаа амладаг.

Есүс фарисайчуудтай ярьж байхдаа гэрлэлтийн талаар дурдаж байсныг Библид тэмдэглэсэн байна.

► Нэг суралцагч Матай 19:3-8 эшлэлийг бүлэгт уншина.

Бурхан гэрлэлтийг насан туршийнх байлгахаар бүтээсэн боловч Бурханыг дагадаггүй хүмүүсээс болж салалт бий болсон гэж Есүс хэлсэн юм.

Бурхан үүнийг насан туршийнх байлгахаар бүтээсэн олон шалтгаан байдгийн заримыг нь бид дээр дурдсан. Түүнчлэн гэрлэлт нь хүүхдүүдийн төлөө насан туршийнх байх ёстой. Гэрлэлтэд зориулсан Бурханы төлөвлөгөөг дуулгавартай дагах нь хүүхдүүдийг өсгөх хамгийн сайн орчныг бий болгодог. Эцэг эхчүүд нь Бурханыг хүндэтгэдэг, Бурханы зарчмуудыг дагадаг гэр бүл бурханлаг хүүхдүүдийг өсгөдөг (Малахи 2:15).

Хүүхэд насанд хүрэхэд нэлээд хэдэн жил шаардагдана. Бурхан хүний амьдралыг ингэж бүтээсэн учраас энэ хугацаанд хүүхдүүд эцэг эхээсээ хайр халамж, удирдамж, дэмжлэг авч өсдөг. Амьтад ганц хоёр жилийн дотор өсөж бойждог бол хүний хувьд өсөж төлөвшихөд илүү их хугацаа шаардагдана. Тиймээс Бурхан гэр бүлийг хүүхэд өсгөх газар болгож бүтээсэн юм. Харин гэр бүлүүд үнэнч, хариуцлагатай эцэг эхээр дутагдвал нийгэмд олон асуудал үүсдэг.

Гэрлэлт бол бүхэл амьдралаа бие биедээ зориулах хосын амлалт юм. Улс орон бүрд гэрлэлтийг чухалд тооцож байгаагаа гэрлэх ёслолоор дамжуулан илэрхийлдэг. Гэрлэх ёслол бол хосууд насан туршдаа зориулалт гаргана гэдгээ олны өмнө зарлаж буй хэрэг юм.

Дэлхийн олонх улс оронд гэрлэлтийг бүртгэдэг. Түүнчлэн гэр бүлийн тухай хуульд өмч хөрөнгө, хүүхдүүдээ асран халамжлах, өв хөрөнгөний асуудлыг ч тусгадаг.

Энд олон гэрлэлтэд хэрэглэж байсан хуримын тангарагийн нэгэн жишээг оруулъя:

Энэ өдрөөс эхлэн би Бурханы ариун зарлигийн дагуу сайн, муу, баян, ядуу, өвчтэй, эрүүл ямар ч үед чиний дэргэж байж, үхэл биднийг салгах хүртэл эхнэр/нөхөр чамайгаа хайрлан, эрхэмлэнэ гэдгээ би амлаж байна.

Хүн үргэлж романтик мэдрэмжтэйгээ байгаад байхгүй. Тиймээс гэрлэлт нь хувирч өөрчлөгддөг мэдрэмж дээр суурилах ёсгүй. Гэрлэлтийн тангараг бол эхнэр нөхөр хоёр нөхцөл байдлыг үл харгалзан, ямар ч үед хоёр биедээ үнэнч байхаа амлаж байгаа амлалт юм.

### **Гэрлэлт христэч хамтрал болох нь**

► Нэг суралцагч 2 Коринт 6:14-18 эшлэлийг бүлэгт уншина.

Эдгээр эшлэлд итгэгч хүн итгэдэггүй хүмүүстэй хэт дотно холбоотой болбол Бурханд өгсөн амлалтад нь саад учирдаг гэдгийг сануулж байна. Итгэгч хүн Сатаныг мөргөн хүндэлдэг хүнтэй цуг мөргөл хүндэтгэл өргөж болохгүйтэй адил, үл итгэгчдийн амьдралын хэв маяг, үнэт зүйлсийг дагаж болохгүй юм. Энэ сануулга бизнесийн хамтралаас эхлээд олон янзын харилцаанд хамаатай.

Гэрлэлт бол хүний хамгийн дотно хамтралын харилцаа юм. Итгэгч хүн итгэгч бус хүнтэй гэрлэх тухай бодож ч болохгүй (1 Коринт 7:39, 2 Коринт 6:14-18). Ер нь итгэдэггүй хүнтэй гэрлэсэн итгэгч хүн хүүхэд өсгөх, амьдралын элдэв асуудал дээр шийдвэр гаргахдаа маш их саад бэрхшээлтэй тулгардаг.

Хэрэв эхнэр нөхөр хоёулаа итгэгч боловч, өөр өөр урсгалын чуулганд хамрагддаг бол сүнслэг ойлголтууд дээр санал нэгтэй байгаа эсэхээ шалгах ёстой. Түүнчлэн гэрлэсний дараа нэг чуулганд хамрагдах хэрэгтэй.

► Гэрлэлт яагаад хайраа зарлах үед биш, харин ам тангараг өгөхөд эхэлдэг вэ?

### **Бурханы ёс суртахууны хэм хэмжээ**

► Нэг суралцагч Еврей 13:4 эшлэлийг бүлэгт уншина.

Эдгээр эшлэлд гэрлэлтийг хүндэтгэх ёстой талаар зааж байна. Бэлгийн харилцааны нүгэл нь гэрлэлтийг үл хүндэтгэж буй хэрэг юм. Бурхан бэлгийн ёс суртахуунгүй явдлыг шүүх болно.

Бэлгийн харилцааны нүгэлд тачаангуй төсөөлөл, садар самуун, завхайрал, ижил хүйстэнтэйгээ явалдах, садар самуун зураг, бичлэг үзэх зэрэг нь багтана. Эхнэр юмуу нөхрөөсөө өөр хүнтэй бэлгийн харилцаанд орж байгаагаар хүсэж төсөөлөх нь тачаангуй төсөөлөл юм. Харин гэрлээгүй хүмүүсийн дундах бэлгийн харилцаа нь садар самуун явдал бол, гэрлэсэн хүмүүсийн дундах бэлгийн харилцаа нь завхайрал юм. Ижил хүйсийн хүмүүс дундах бэлгийн харилцааг гомосексуал харилцаа гэдэг. Нүцгэн шалдан, бэлгийн харилцааг харуулсан зураг, өгүүллэг, бичлэг үзэх нь порнограф юм. Энэ бүхэн гэрлэлтийн харилцааг зөрчсөн нүгэл болно.

Махбодыг маань уруу татдаг хүсэлд автах нь илүү сайн аргаар шийдэж өгөх Бурханы хангамжийг буруугаар ашиглаж байгаа хэрэг юм. Гэрлэлт доторх бэлгийн харилцаа л Бурханы өмнөх цор ганц хууль ёсны бэлгийн харилцаа мөн. Ёс бус бэлгийн харилцаа нь эхэндээ амтлаг боловч, эцэстээ сүнслэг хүслийг

бууруулж, сүйрэлд хүргэдэг хор юм. Тиймээс үүнээс болж бидний ариун, зөвт байдал болон Бурханы оршихуйд мэдрэмтгий байх чанар маань мохдог.<sup>13</sup>

Сургаалт үгс номын маш олон эшлэлд бэлгийн харилцааны ёс бус байдал хүний амьдралыг сүйрүүлж, үхэл рүү хөтөлдөг гэдгийг сануулдаг (Жишээлбэл, Сургаалт үгс 2:16-19, мөн Сургаалт үгс 6:24-29, 32-33).

Хүмүүс хүйсээр ялгаатай бүтээгдсэн гол зорилгын тухайд Робертсон Маквилкин ийнхүү бичжээ.

...бодол санаагаараа хийсэн зүйлс бодитоор хийсэн мэт ноцтой нөлөөтэй. Бурхан эрэгтэй эмэгтэй хүмүүсийг зүгээр л бүтээсэн юм биш. Харин тэднийг өөрийнхөө мөн чанарын тусгал болох бие биеийнхээ төлөөх дотно, насан туршийн холбоонд байлгахгаар бүтээсэн юм. Энэхүү эрхэм дээд зорилгыг биелүүлэхийн тулд дотно харилцаа нь онцгой, амлалт нь насан туршийнх байх ёстой. Эс бөгөөс үүнийг нэгдмэл байдал гэхгүй. Үнэнч байх нь оюун бодлоос эхэлнэ. Тиймээс онцгой дотно харилцаа, удаан үргэлжлэх амлалт, харилцан итгэл нь эхлээд бодол санаанд зөрчигддөг.<sup>14</sup>

► Суралцагчид 1 Коринт 6:9-11, 15-20 мөн Матай 5:27-30 эшлэлийг бүлэгт уншина.

Ямар ч нийгэмд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн харилцааны талаар уламжлалт соёлын чанартай үзэл бодол бий. Гэхдээ эдгээр үзэл бодол нь ямагт Библийн ёс суртахууны хэм хэмжээнээс доогуур байдаг. Ихэнх соёл уламжлалд нийгмийг эмх журамтай байлгахад шаардлагатай дүрэм байдаг боловч бэлгийн харилцааны нүглийн хувьд илэрхий асуудал үүсгэхгүй, эсвэл нийтийн дунд дуулиан гаргахгүй л бол зөвшөөрдөг. Харин Библийн ёс суртахууны хэм хэмжээ нь өөр юм.

Харамсалтай нь зарим чуулган Библийн ёс суртахууны оронд тухайн улсынхаа соёлын үзэл санааг дагадаг. Тэд нүгэл нь илэрхий эсвэл хэнэггүй загнаж байгаа хүмүүсийг шийтгэдэг боловч, нүглээ сайтар нууж чаддаг хүмүүсийг тэвчээд өнгөрдөг.

Тэгвэл эдгээр эшлэлд ийм нүглийг үйлдсээр байгаа хүмүүс жинхэнэ итгэгч биш төдийгүй, тэнгэрийн хаанчлалд орохгүй хүмүүс юм гэжээ. Коринтын зарим итгэгчид урьд нь ийм нүгэл үйлдэж байсан боловч, аврагдсаны дараа үүнийгээ больсон байв.

Өөрийгөө итгэгч гэж хэлдэг атлаа эдгээр нүглийг зөвтгөдөг бол түүний аливаа сургаал нь хуурамч юм. Хэрэв хүн Христийг дагадаг гэж хэллээ ч, бэлгийн харилцааны нүглийг үйлдсээр байгаа бол тэр хүнийг чуулганаас хасаж, итгэгч хэмээн үзэхгүй байхыг Бичвэрт заасан байна (1 Коринт 5:11-13).

Чуулганы удирдагчид биеэ авч явах тал дээр сайн үлгэр дуурайл үзүүлэх ёстой. Хэрэв чуулган магтаалын удирдагч нартаа зохисгүй хувцаслах, чуулган дээр тачаангуй бүжиг

<sup>13</sup> Gary Thomas, *Sacred Marriage* (Grand Rapids, MI: Zondervan, 2000), 210

<sup>14</sup> Robertson McQuilkin, *An Introduction to Biblical Ethics* (2<sup>nd</sup> edition), (Wheaton, IL: Tyndale House Publishers, Inc., 1995), 216

хийх мэтийг зөвшөөрдөг бол бэлгийн ёс бус хүслийг хэвийн гэж хэлсэнтэй адил юм. Үүгээрээ бэлгийн харилцааны нүглийг ноцтой зүйл биш гэж үзэж байгаа хэрэг.

Бусдыг татах зорилгоор биеэ ил гаргасан хувцас өмссөн хүнийг сайхан хувцасласан хэмээн үздэг хэв маяг зарим нийгэмд байдаг. Чуулганы гишүүд ч заримдаа онцгой арга хэмжээний үеэр энэ алдааг гаргах нь бий. Тэд нийгмийнхээ загварын хандлагыг дагах нь сайхан хувцаслаж буй хэрэг гэж боддог бололтой. Ийм буруу ойлголтыг чуулган засаж өгөх ёстой. Итгэгч хүн бусдад буруу хүсэл төрүүлэх шалтгаан болж болохгүй. 1 Тимот 2:9-10 эшлэлд итгэгчид сахилга баттай, цэвэр ариун амьдралаар амьдарч байгаа төдийгүй, нүгэл үйлдэх, эсвэл бусдыг нүгэлд уруу татахыг хүсэхгүй гэдгээ илэрхийлсэн хэв маягаар хувцаслаж, биеэ зөв авч явах ёстой. Христэд итгэгчид өөрсдийгөө зохистой хувцаслалт, даруу зан, биеэ хянах чадвараар гоёх учиртай юм.

### **Нүгэлтэнд үзүүлэх тусламж**

Галат 6:1-д нүгэл үйлдсэн гишүүнээ чуулган засаж авах үүрэгтэй гэж хэлжээ. Гэхдээ засаж авч байна гээд тухайн хүнийг үйлчлэлд үлдээх, эсвэл хурдан буцааж томилох ёстой гэсэн үг биш. Шинэчлэн засах гэдэг бол чуулганы нөхөрлөл, сүнслэг халамжид эргүүлэн авахыг хэлж байна. Хэрэв тухайн гишүүн үнэхээр гэмшиж байгаа бол, Бурхан ч, чуулган ч түүнийг уучилна. Улмаар чуулган түүнийг хүчтэй байж, ялалттай амьдрахад нь туслах сүнслэг дэмжлэгийг үзүүлж, хариуцах ёстой.

Хэрэв гэрлээгүй бүсгүй жирэмсэн болбол чуулган сүнслэг сэргээлтийнх нь төлөө алхам хийлгүй, халамж нөхөрлөлөөсөө түлхэж болохгүй. Хэрэв бүсгүй гэмшиж, сүнслэг зааврыг хүлээн авбал уучилна. Эмэгтэйн холбогдсон нүгэл нь эрэгтэйд нь ч бас адил тооцогдоно. Эмэгтэгийнх нь нүглийн үр дагавар илэрхий байдаг учраас заримдаа хүмүүсээс илүү хатуу ширүүн харилцаа хандлагыг амсдаг.

Зарим нийгэмд эцэг эхчүүд гэрлээгүй охиныхоо жирэмслэлтээс ичиж зовоходоо төрөөгүй хүүхдийг хөнөөж, гэр бүлийнхээ нэр төрийг аврах гэж оролддог. Гэхдээ аллага хийх сайн шалтгаан гэж огтхон ч байдаггүй (Гэтлэл 20:13). Төрсөн, төрөөгүй хүүхэд бүр Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн (Эхлэл 9:6, Дуулал 139:13-14). Тиймээс тэр охины хүүхдийг хамгаалж, өсгөх ёстой юм.

Чуулган бол итгэлийн гэр бүл бөгөөд нүглийг буруушаагаад өнгөрөх хангалтгүй. Харин гишүүдээ халамжлах ёстой. Жишээ нь, буруу нүгэлт үйл ажиллагаагаар санхүүгээ хангадаг хүн байвал түүнд санхүүгийн өөр эх сурвалж олоход нь тус дэм үзүүлж болно.

*Бодит нөхцөл байдал...*

Хэдэн охин олон хүнтэй чуулганд хамрагдаж, найрал дуунд дуулдаг байв. Гэхдээ охидын гэр бүл ядуу байсан тул тэд мөнгө олох гэж эрчүүдтэй ёс бус харилцаанд ордог байжээ. Тийм нөхцөлд чуулган юу хийх ёстой вэ?

► Амьдралын нүгэлт хэв маягаа орхиход нь туслахын тулд танай чуулган хүмүүсийн төлөө юу хийх ёстой вэ?

## **Порнограф**

Бэлгийн дур хүслийг төрүүлэх зорилгоор нүцгэн бие эсвэл бэлгийн харилцааг харуулсан аливаа бичвэр, зураг, видеог порнограф гэнэ.

Интернэт нь порнографийг хаанаас ч амархан олж үзэх, тараах боломжийг олгодог. Технологийн хэрэглээ маш өргөн болсон учраас энэ асуудал дээр хэрхэн хандах талаар христитгэлийн зарчмуудыг сураагүй хүмүүст маш их уруу таталт ирдэг. Төлөвшсөн олон пасторын хувьд залуу байхад нь интернэт байгаагүй учраас ийм уруу таталттай тулгарч байгаагүй байх. Магадгүй залуу үеийнхэн юутай тулгараад байгааг тэд сайн ойлгохгүй байж мэднэ.

**Порнограф нь буруу.** Яагаад гэвэл порнограф нь хүнийг садар самуун, завхай, гажууд бэлгийн харилцааны хэлбэрийг төсөөлөн таашаал авахад хүргэх зорилготой хийгддэг. Үүгээр хүний нүгэлт хүслийг өдөөдөг бөгөөд Бурханы жигшдэг ёс суртахуунгүй үйлдлээс таашаал авахыг уриалж, үүнийг хийх боломжийг нээж байдаг.

**Порнограф нь донтуулдаг.** Порнограф үздэг хүмүүс үүндээ маш хүчтэй татагдах мэдрэмжтэй болдог бөгөөд улмаар амьдралаа үүнгүйгээр төсөөлж ч чадахгүй болдог. Улмаар порнографаас олж авдаг элдэв төсөөлөлгүйгээр амьдрал нь хоосон, сонирхолгүй мэт болно. Бусад бүх донтолтын нэгэн адил хүсэл нь хэрэглээ болж, хэрэглэгч нь амьдралынхаа сайн сайхныг ийм юмны төлөө золиосолж эхэлдэг.

**Порнограф нь үйл явцтай.** Порнограф үздэг хүнд улам л эрээ цээргүй, гажуудсан юм үзэх хэрэгцээ үүсэж байдаг. Ингээд өмнө нь ой гутаж, айж байсан тийм төсөөллөөсөө таашаал авч эхэлдэг.

**Порнограф нь гэмтээдэг.** Порнограф үздэг хүн энгийн харилцаанаас таашаал авч чадахаа болино. Хүсэл нь гажууд болж, хэзээ ч хангагдаж чадахгүй болтлоо гэмтдэг. Улмаар бусдыг мэдрэмжгүйгээр хүчирхийлэгч болж хувирдаг.

Пасторууд болон эцэг эхчүүд залуучуудад донтолтын аюулын талаар анхааруулах ёстой. Хүүхдүүдэд уруу таталтыг эсэргүүцэх чадвар дутмаг, мөн төлөвшөөгүй байдаг учраас эцэг эхчүүд интернэтийн хэрэглээнд нь хязгаарлалт тавих ёстой. Порнограф үзэх хүсэлтэйгээ тэмцэлдэж буй хүмүүс итгэл даах бурханлаг хүнтэй холбоо тогтоож, өдөр тутмын ялалт, бүтэлгүйтлийнхээ талаар мэдээлж байвал зохино. Төлөвшсөн итгэгч хүнтэй ингэж байнгын уулзалт хийх нь ийм асуудалтай тэмцэж буй хүнд амлалтаа сахих болон ариун байдлаар ялалт байгуулахад нь тус болно.

► Хүмүүсийг порнографын донтолтоос хамгаалахын тулд ямар аргыг санал болгох ёстой вэ? Чуулган тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

## **Ижил хүйстний харилцаа**

Зарим хэсэг бүлэг хүмүүс гэрлэлтийн талаарх Библийн эрх мэдэл, Библийн тодорхойлолтыг үгүйсгэдэг. Тэд ижил хүйстний харилцааг чөлөөтэй сонгож болно гэцгээдэг.

Харин Библид ижил хүйстний харилцааг буруу гэж үздэг.

► Хамтдаа Ром 1:26-27, 1 Тимот 1:10, мөн 1 Коринт 6:9-10-г уншина.

Хамгийн бузар нүглийн жагсаалтыг дурдсан Библийн энэ гурван багц эшлэлд ижил хүйстний харилцааг оруулсан байна. Эдгээр нүглийг үйлддэг хүмүүс Бурханы эрх мэдлийг үгүйсгэж байгаа хэрэг.

Зарим хүн өөрийгөө төрөлхийн ижил хүйстэндээ татагдах шинж чанартай төрсөн гэж боддог. Улмаар ижил хүйстний харилцаанд өөрсдийнхөө хүсэл сонголтоор татагдаагүй, цаанаасаа ингээд байгаа учраас буруу юм байхгүй гэгцээдэг.

Харин Библид хүнийг төрөлхийн нүгэлт хандлагатай гэсэн юм (Исаиа 53:6). Тиймээс Бурхан биднийг санаатай үйлдсэн нүглээсээ гэмшин эргэхийг уриалдаг (Исаиа 55:7). Угаасаа хүн нүгэлт мөн чанартай төрдөг учраас төрөлхийн хүсэл маань биднийг зөв зүгт удирдаж чадахгүй. Хэрэв хүн төрөлхийн садар самуун, хүчирхийлэгч, хулгайч зан авиртай бол үүнийг төрөлхийн юм гээд зөвтгөж болохгүй шүү дээ.

## **Гар хангалга**

Зарим гэрлээгүй хүмүүс бэлгийн дур хүслээсээ болж гар хангалга хийдэг. Бэлгийн дур хүслээ намжаах зорилгоор бэлэг эрхтнээ оролдож таашаал авахыг гар хангалга гэнэ.

Садар самуун бичлэг үзэх, сексийн төсөөлөлд автах нь нүгэл мөн (Матай 5:27-28, Матай 15:19-20). Библид гар хангалгын талаар яг тодорхой буруушаасан юм байхгүй боловч, гар хангалга нь тачаангуй бодол, садар самуун зүйл үзэх, үйлдэхэд хүргэж болно.

Гар хангалга хүнийг донтуулдаг учраас үүнийг хэдий чинээ их хийнэ, төдий чинээ улам их хийхийг хүснэ.

Биеэ барьж чадахгүй гар хангалга хийдэг хүн сэтгэл хөдлөл, харилцааны доголдолтой, эсвэл өмнө нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан гэх мэт гүнзгий асуудалтай байдаг.

► Суралцагчид 1 Коринт 6:12-13, 18-20 мөн 1 Тесалоник 4:1-8 эшлэлийг бүлэгт уншина.

Бурхан эхнэр нөхөр хоёрыг сэтгэл хөдлөл болон сүнсээр нэгтгэх зорилгоор гэр бүлийн харилцаан дахь сексийн харилцааг бүтээсэн юм (1 Коринт 6:16-20, Малахи 2:15).

Олон хүн гар хангалга хийх нь гэрлэх хүртлээ бэлгийн харилцаанд орохгүй байхад тусалдаг гэж үздэг. Гэхдээ донтож, гар хангалга хийх зуршилтай болсон бол ирээдүйн гэрлэлт дэх бэлгийн харилцаанд нь муу нөлөө үзүүлдэг.

Гар хангалга хийх нь таашаал өгдөг ч эхнэр нөхөр хоёрыг бие махбодын болон сэтгэл санааны хувьд нэгтгэдэг бэлгийн харилцааны гол зорилгыг алдагдуулдаг.

Тиймээс гэрлэлтээр зөвшөөрөгдсөн эрүүл, хэвийн бэлгийн харилцааг үүгээр орлуулж болохгүй.<sup>15</sup>

Гэрлээгүй хүн гар хангалга хийх асуудалтай болсон бол яах ёстой вэ? Тэрээр хэт их бэлгийн дур хүслээ дарахын тулд хийж байсан байлаа ч, үүнээс зайлсхийх нь хамгийн сайн арга юм. Гар хангалгатай холбоотой уруу таталтууд маш их байдгаас гадна, ийм байдлаар бэлгийн харилцааг нөхөх нь Бурханы анхнаасаа бүтээсэн бэлгийн зөв харилцааны зорилготой зөрчилддөг.

- Хэрэв амьдралд нь ямар нэг ёс бус зүйл байгаа бол, итгэгч хүн тэрхүү нүглээ улайж, гэмших ёстой. Түүнчлэн залбирч зөвлөгөө өгөх бурханлаг настай зөвлөгчид ялалт, уналтаа тайлагнаж байх ёстой.
- Сэтгэл хөдлөл юмуу харилцааны асуудал, эсвэл өнгөрсөнд болсон бэлгийн хүчирхийллээс болж гар хангалга үйлддэг болсон бол, зохих христитгэлт зөвлөгчөөс зөвлөгөө авах нь зөв.

Христийн дагалдагчдад дараах байдлаар тусламж ирдэг.

- 1. Есүс анхаарч санаа тавьдагт итгэлтэй байх (Дуулал 139:1-3, 1 Петр 5:6-10).** Тэрээр итгэгчдийн итгэл, махбодын хэрэгцээ, ариун байдалд санаа тавьдаг. Хүн болж ирснээрээ Тэрбээр бидний амсдаг биеийн болон сэтгэлийн бүх уруу таталтыг туулж, ялан дийлсэн юм. Тиймээс ялалтад маань хэрэгтэй нигүүлслийг өгөх чадал Түүнд бий (Еврей 4:14-16).
- 2. Чөтгөрийн худал үгэнд итгэхгүй байх (Иохан 8:44).** Чөтгөр итгэгчдэд хандан, “Есүс та нарыг анхаардаггүй. Хэрэв анхаардаг байсан бол ийм хэцүү байгаа ийм бэлгийн дур хүслийг зайлуулж өгөх байсан” гэх мэтээр хэлж болно (1 Петр 5:7-8). Түүнчлэн бэлгийн дур хүсэлтэй учраас нүгэлтэй гэж буруутгаж ч мэднэ (Илчлэл 12:10).
- 3. Есүс дээр анхаарлаа төвлөрүүлж, Түүний хэн болохыг магтан алдаршуулах (Дуулал 105:3-4).** Чөтгөр ийм уруу таталтаар дамжуулан итгэгч хүний итгэл, Бурхантай харилцах харилцааг устгахыг хүсдэг (Иохан 10:10). Харин Есүс сорилтоор дамжуулан хүний итгэлийг хүчирхэгжүүлж, Өөрийг нь улам алдаршуулах боломжийг өгөхийг зорьдог (1 Петр 1:5-9). Есүсийг мөргөн хүндлэхэд анхаарлаа төвлөрүүлбэл Тэр хамт байж, тусална (Дуулал 46:1).
- 4. Бурханы Үгийг тунгаан бодох (Дуулал 119:9).** Үгийг унших, сонсох, тунгаах нь уруу таталтын үед ялалт байгуулахад тусална. Есүс соригдох үедээ Бичвэрийг ашиглан, ялан дийлсэн юм (Матай 4-р бүлэг). Бид ч бас тэгэх ёстой.

---

<sup>15</sup> Dr. Tim Clinton ба Dr. Diane Langberg, *The Quick-Reference Guide to Counseling Women*, (Grand Rapids, MI: Baker Books, 2011), 185

5. **Төлөвшсөн, бурханлаг нэг юмуу хэд хэдэн хүнтэй холбоотой байх (Галат 6:2).** Илүү удаан хугацаанд итгэлийн замыг туулсан, ижил хүйсний хүнтэй нээлттэй, бүх үнэнээ хэлж ярилцах нь маш их тустай. Тэд хамтдаа залбирч, зөвлөгөө өгч чадна. Өөрийнхөө зовлон бэрхшээл, тэмцлийн талаар итгэмжтэй хүмүүстэй ярилцах нь ариун байдлаа хадгалах болон итгэлээр урамшихад тусална.
6. **Бусдад үйлчилж, бусдын хэрэгцээнд санаа тавих (Филиппой 2:3-5).** Бусдад үйлчилснээр өөрийнхөө хэрэгцээ хүслийг хэт анхаарахаас зайлсхийж чадна.
7. **Бурханы товлосон цаг ирэхэд бурханлаг хүнтэй гэрлэх (Сургаалт үгс 5:15, 18-19).**

### **Гэрлэлтээс өмнөх ёс суртахууны цэвэр ариун байдлаараа Бурханыг дээдлэх зарчмууд**

Залуус гэрлэхээсээ өмнө маш хүчтэй уруу таталттай учирдаг. Ийм үед ирээдүйн амьдралын хань нь үнэнч хүн байх ёстой гэдгийг санах нь чухал.<sup>16</sup> Тиймээс гэрлэх бодолгүйгээр богино хугацааны харилцаа хүсдэг хүнтэй үерхэж болохгүй. Түүнчлэн тууштай итгэдэггүй хүнтэй үерхэх хэрэггүй (1 Коринт 7:39). Зөвхөн гэр бүлдээ үнэнч байж, сайн эцэг эх болж чадах хүнтэй үерхэх ёстой.

Сайн гэр бүлтэй болохыг хүсэж байгаа бол өөрөө итгэмжтэй, амлалтдаа үнэнч дагалдагч байх хэрэгтэй. Тэгвэл зөв хүнийг өөртөө татаж чадна (Сургаалт үгс 3:4-8). Сайн зан чанар, зохистой даруу хувцаслалтаараа хүн өөрийгөө харуулдаг (1 Тимот 2:9-10). Эсрэг хүйстэнтэйгээ болгоомжгүй, хэт дотно маягаар харилцдаг хүмүүс буруу хүслийн үндсэн дээр харилцаанд ороход бэлэн мэт ойлголт төрүүлдэг (1 Тесалоник 4:1-7). Иймэрхүү маягаар хувцаслаж явбал буруу төрлийн хүмүүсийг л өөртөө татах нь мэдээж (Сургаалт үгс 7).

Бурхан залуу хүмүүст биеэ авч явах байдал, хувцаслалт, харилцааны зөв сонголт хийх талаар зааж өгөх эцэг эх, пастор, христэд итгэгч удирдагчдыг өгсөн байдаг. Залуус эдгээр хүмүүстээ захирагдан дагаснаар Бурханд дуулгавартай байж чадах бөгөөд Бурханаас агуу ивээл, хамгаалалтыг авч, хор хөнөөл, уруу таталтаас хамгаалагдана.

► Нэг суралцагч 1 Петр 5:5 болон Еврей 13:17 эшлэлийг бүлэгт уншина.

Эцэг эх, сүнслэг удирдагчдынхаа мэргэн ухаан, удирдамжийг дагах нь хүүхэд залуусын үүрэг. Харин эдгээр удирдагчид уруу таталтыг ялан дийлэхэд нь залууст туслах үүрэгтэй.

► Нэг суралцагч Ром 13:14 мөн 1 Коринт 10:13 эшлэлийг бүлэгт уншина.

<sup>16</sup> Сургаалт үгс 31:11-12, 1 Тимот 3:11-12, Малахи 2:14-16, Сургаалт үгс 2:16-17-г үз.

**Хэрэв** хүн өөрөө хүсээгүй л бол, Бурхан түүнийг эсэргүүцэж, зугтаж чадахааргүй тийм бэрх уруу таталттай нөхцөл байдалд оруулдаггүй. Залуу хүн уруу таталтаас өөрөө зайлсхийх үүрэгтэй (2 Тимот 2:22). Түүнчлэн эцэг эхчүүд хүүхдээ аль болох шаардлагагүй уруу таталтаас хамгаалж байх ёстой юм. Энэ тухайд эцэг эхчүүд хамгийн багадаа гурван зүйлийг хийж болно.

**(1) Онцгой зааварчилгаа өгөх.** Юу хийж болох, юу хийж болохгүй, хэнтэй байх, хаашаа явах талаар зааж өгөх ёстой (Ефес 6:1-4).

Хүүхдүүд өөрсдийгөө уруу таталтаас хангалттай хамгаалж чадах нас, төлөвшилд хүрээгүй байдаг учраас эцэг эхчүүд нь тэднийг тийм байдалд оруулж болох нөхцлөөс хамгаалах ёстой. Жишээ нь, залуу хүү охин хоёр хүнгүй газар хоёулхнаа байвал буруу юм хийх уруу таталтад орж болзошгүй юм.

**(2) Залуусын уруу татагдаж болох асуудлуудыг байнга анхаарч, хяналттай байлгах.**

**(3) Залууст Библийн дагуу зөвлөх.**

Эцэг эхчүүд хүүхдүүдээ аливаа зүйлийг Библийн зарчмын дагуу боддог бодол санаатай болгон хүмүүжүүлэх ёстой (Сургаалт үгс 4:1-9, Сургаалт үгс 7:1, 4-5). Тиймээс харагдаж буй аюулын талаар ярилцах нь зүйтэй юм. Ирээдүйд хийх олон сонголтуудаа хэрхэн зөв хийх талаар бодож тунгаахад нь тусалж болно. Уруу таталтаас урьдчилан зайлсхийх, уруу таталттай тулгарсан бол яах ёстой талаар эцэг эхчүүд зааж өгөх ёстой.

Чуулган Библийн ёс суртахууныг хамгаалж, нийгмийнхээ соёлоос ялгарч байх ёстой. Бэлгийн харилцааны нүглийг олон соёлд ноцтой зүйл гэж үздэггүй учраас гэрлээгүй залуусыг гэрлэхээсээ өмнө бэлгийн харилцаанд орохыг хэвийн зүйл гэж үздэг байна. Харин чуулган нүгэлтэй эвлэрч болохгүй. Яагаад гэвэл ёс бус явдалтай хүмүүс Христийн хаанчлалыг өвлөхгүй гэж Бурхан хэлсэн шүү дээ.

► Суралцагчид Ефес 5:3-7 мөн Еврей 13:4 эшлэлийг бүлэгт уншина.

Гэрлэхээс өмнөх үе бол бэлгийн харилцааг эхлүүлэх цаг биш. Харин хосууд сүнслэг болон Библийн зарчмуудын хувьд адил төстэй бодол санаатай байгаа эсэхээ шалгах үе юм. Энэ үедээ тэд бие биеэ илүү сайн таньж, итгэлцлээ хөгжүүлэн насан туршийн амлалт өгөхдөө бэлдэж, хөгжих хугацаа билээ. Хэрэв тэд бие биенийхээ зан чанарт итгэж чадахгүй бол харилцаагаа дуусгаж, гэрлэхээ больсон нь дээр.

Зарим газар хуримыг маш тансаг, өндөр зардалтай ёслол байх ёстой гэж үздэг. Тиймээс хүмүүс хуримаа хойшлуулж, харин хосууд гэрлэхээсээ өмнө хамт амьдарч хүүхэдтэй болсон байдаг. Зарим хосууд бүх мөнгөө хуримлах ёслолдоо зарцуулж, бүр зээл авдаг учраас хуримын зардлаа төлөх гэж олон жил өртэй зовдог. Харин чуулган бол үүнээс өөр хэв маягийг харуулах ёстой итгэлийн хамт олон юм. Христэд итгэгчдийн хурим бол бие биедээ болон Бурханд үнэнч байхаа амлах амлалт учраас өндөр зардлаас болж

гэрлэлтээ хойшлуулах, эсвэл хосын ирээдүйд хүндрэл учруулах санхүүгийн дарамтыг бий болгох ёсгүй.

► Нийгэм дэх гэрлэлтийн ёс заншлаас христитгэлийн гэрлэлт юугаараа ялгарах вэ?

### **Хэзээ ч гэрлэхгүй хүмүүс**

Гэрлэлт бол ихэнх хүний хувьд Бурханы төлөвлөгөө юм. Гэхдээ гэрлэхгүй байж болох шалтгааныг элч Паул хэлсэн. Тэрээр 1 Коринт 7:26-д “өнөөгийн зовлон гачаал”-ын учир хэмээн хавчлага гэх мэт амьдралын хүнд нөхцөл байдлын талаар дурдсан байдаг. Хүн тиймэрхүү нөхцөлд байгаа бол гэрлэхгүй байсан нь дээр гэж Паул хэлсэн юм.

Яг тухайн бүлэгт (1 Коринт 7:32-35) гэрлээгүй хүнд давуу тал байгаа талаар мөн өгүүлжээ. Гэрлээгүй хүн ханьдаа санаа зовно гэх зүйлгүйгээр Бурханы үйлчлэлд төвлөрч чадна. Хэрэв Бурхан хэн нэгнийг гэрлэхгүйгээр үйлчлэхийг дуудсан бол тэр хүн үйлчлэлдээ төвлөрөх хэрэгтэй. Тэгвэл гайхалтай үр дүн, ерөөлийг авчирна.

Зарим хүнийг Бурхан гэрлэхгүйгээр үлдээдэг өөр шалтгаанууд ч байж болно (Матай 19:10-12). Үүнийг жам ёсны эсрэг зүйл гэж бодож болохгүй. Түүнчлэн гэрлээгүй хүн бүрийг хэн нэгэнтэй заавал тааруулах ёстой гэж бодох хэрэггүй. Бид аз жаргал, бүрэн дүүрэн байдал зөвхөн гэрлэлтээр ирдэг гэж бодож болохгүй юм (Дуулал 107:9).

Харин гэрлээгүй хүн сэтгэл зүйн болон махбодын хэрэгцээнээс болоод буруу юм хийхээс болгоомжлох ёстой. Бурхан Өөрт нь бүрэн сэтгэлээ зориулсан хүнд баяр хөөр, сэтгэл ханамжийг өгдөг.

### **Гэрлэлтийн талаарх Библийн удирдамж**

► Хамтдаа 1 Петр 3:1-7 мөн Ефес 5:22-33 эшлэлийг уншина. Эдгээр эшлэлийг хэлэлцүүлгийн үеэр дахин харж, судлах учраас нээлттэй байлгаарай.

**Христ чуулганыг хайрладаг шиг нөхөр нь эхнэрээ хайрлах ёстой.** Есүс өөрийгөө чуулганы төлөө золиосолсон. Түүнчлэн нөхөр нь өөрийнхөө ашиг сонирхол, тав тух, хүсэл эрмэлзлийг эхнэрийнхээ төлөө золиослох ёстой юм. 1 Петр 3:7-д эр хүн эхнэртэйгээ ойлголцож амьдрах ёстой гэсэн байна. Энэ бол эхнэрээ ойлгохын төлөө чадах бүхнээ хийх ёстой гэсэн үг. Харин эхнэрт чинь ямар хэрэгцээ байгааг ойлгохын тулд эхнэрээ сайтар танин мэдэх ёстой.

Энэ эшлэлд эмэгтэй хүнийг “эмзэг сав мэт” гэж хэлжээ. Эхнэр хүнд нөхрийн халамж хэрэгтэй байдаг. Тиймээс нөхөр нь эхнэрээ махбодын болон сэтгэл санааны стрессээс хамгаалах учиртай.

**Эхнэр хүн нөхөртөө захирагдаж, нөхрөө хүндэтгэх ёстой.** Нөхөр нь итгэгч мөн ч бай, биш ч бай, Христэд итгэгч эхнэр хүн нөхрийнхөө удирдлагыг хүлээн зөвшөөрөх ёстой. Хэрэв эхнэр нь иймэрхүү байдлаар биеэ авч явбал үл итгэгч нөхөр нь итгэгч болох магадлал нэмэгддэг.

Эдгээр эшлэлд байгаа тушаалууд яг юу гэж хэлээд байгааг сайтар анхаарах нь чухал. Нөхөр хүн эхнэртээ эрх мэдлээ хүчээр тулгаж хэрэгжүүл гэж хэлээгүй байна. Эхнэр хүн нөхөртөө захирагдах ёстой гэж хэлэхдээ нөхөр нь эхнэрээ хүчээр дуулгавартай байлга гэж хэлээгүй. Харин нөхөр нь эхнэрээ хайрлаж, эхнэрийнхээ хэрэгцээний төлөө өөрийгөө зориулах ёстой гэж зааж байна. Үүнчлэн эхнэр хүн ч нөхрөөсөө халамж нэхэж шаардах ёстой гэж хэлээгүй, харин нөхрөө хүндэтгэх ёстой хэмээн заасан байна.

Нөхрийн гол анхаарах зүйл бол эрх мэдлээ хангахад биш, харин хайраар халамжлахад оршино. Эхнэрийн эрхэмлэн анхаарах зүйл нь өөртөө халамж анхаарал нэхэхэд бус харин нөхрөө хүндэтгэхэд оршино.

Хэрэв итгэгч хүн эхнэрээ зохих ёсоор халамжлахгүй бол залбиралд нь саад учирна гэж элч Иохан анхааруулжээ. Энэ бол **ханьтайгаа хэрхэн харилцаж байгаа нь Бурхантай харилцах харилцаанд нөлөөлнө** гэсэн үг.

Элч Иохан бас “хэрэв хүн ахан дүүсээ хайрлахгүй бол Бурханыг ч бас хайрлахгүй” гэж хэлсэн (1 Иохан 4:20). Үүнчлэн Паул, Петрийн захидлуудад ч нөхөр нь эхнэрээ анхаарч халамжилдаггүй бол Бурханыг зохих ёсоор хайрлаж чадахгүй гэсэн байна. Нөхрөө хүндэтгэдэггүй эхнэр ч бас Бурханыг хүндэтгэж чадахгүй гэсэн үг.

► Нэг суралцагч 1 Коринт 7:1-5 эшлэлийг бүлэгт уншина.

Эдгээр эшлэлд гэрлэлтийн бас нэг өөр зорилго нь бэлгийн дур хүслийг хангах явдал гэжээ. Энэ бол нөхөр эхнэр хоёр бие биедээ өөрийгөө зориулж, өөрийн биеийг мэдэх эрх мэдлээ нөгөөдөө тавьж өгнө гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл гэрлэсэн хүн зөвхөн өөрийнхөө хүссэн үед бэлгийн харилцаанд орохыг зөвшөөрнө гэсэн үг биш, харин ханийнхаа хүслийг харгалзан үзнэ гэсэн үг. Гэхдээ нэг нь нөгөөдөө хүсэл таашаалаа тулгаж болно гэж хэлээгүй. Харин нэг нь нөгөөгийнхөө хэрэгцээнд анхаарал хандуулах ёстой гэжээ.

Эдгээр эшлэлд гэрлэсэн хүмүүс энэхүү онцгой эрхээ эдлэх гэсэн ханиа хясаж болохгүй гэж байна. Мацаг барих үед түр хугацаагаар бэлгийн харилцаанаас татгалзаж болох боловч, урт хугацаагаар тусдаа байх нь хүслээ хангах гэсэн сорилтод унагаж болзошгүй. Заримдаа хосууд хол газар ажиллах эсвэл сурах зорилгоор олон сараар хол байхаар шийддэг. Иймэрхүү шийдвэр гаргахаасаа өмнө энэ нь Бурханы төлөвлөгөөнд нийцэх эсэхийг эхлээд бодолцох ёстой. Удаан хугацаанд хол байснаас янз бүрийн асуудал үүсэж болох юм.

Нэг нэгэндээ санаа тавьдаг гэр бүлийг бий болгох нь гэрлэлтийн бас нэг зорилго юм.

► Нэг суралцагч 1 Тимот 5:8 эшлэлийг бүлэгт уншина.

Чуулганы гишүүд бие биедээ санаа тавих үүрэг хариуцлагын талаар эдгээр эшлэлд өгүүлсэн. Хүн гэр бүлийнхээ өмнө хамгийн түрүүнд хариуцлага хүлээдэг. Эцэг эх нь хүүхдийнхээ хэрэгцээг хангаж, орон байр, хоол хүнс, боловсролоор хангах ёстой. Эцэг

эхчүүд энэ үүргээ нөгөөдөө даатгах бус, харин биелүүлэхийн тулд чадлаараа хичээх учиртай.

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

Энэ хичээлийн сэдвүүдийг нэлээд удаан хэлэлцэх шаардлага гардаг.

Суралцагчид өөрсдийнхөө нөхцөл байдалд Библийн зарчмуудыг хэрэгжүүлэхийг хичээх ёстой.

- ▶ Гэрлэлтийн талаар хүмүүсийн мартаад байдаг үнэн юу вэ?
- ▶ Энэ ертөнцийн уруу таталттай тулгарч буй залууст чуулган хэрхэн тусалж чадах вэ?
- ▶ Ням гарагийн хүүхдийн цуглаанаас гадна хүүхдүүдийг Христийн дагалдагч болгоход сургах амаргүй ажилд чуулганы хүмүүс хэрхэн хамтран ажиллаж, тусалж болох вэ?

### **Залбирал**

Тэнгэрлэг Эцэг минь,

Гэрлэлт гэдэг гайхалтай харилцааг бүтээсэн Танд баярлалаа. Амьдралынхаа үе шат бүрд Таны өмнө итгэмжит байхад минь туслаач. Итгэгч хүний үнэнч байдлын сайн үлгэр дуурайл болоход минь туслаач. Бусдад ч Таны хүслийг дагахад нь би тусалмаар байна.

Гэр бүлүүд, залуус, хүүхдүүдийг хүчтэй итгэлтэй, дуулгавартай байхад нь туслахын төлөө чуулганыхаа хүмүүстэй хамтран ажиллахад минь туслаач.

Таны ерөөсөн харилцаанд байх боломжтой байгаагийн төлөө Танд талархья.

Амен

### **7-р хичээлийн даалгавар**

(1) Хэрэв та гэрлээгүй бол гэрлэхийн өмнөх харилцаа болон ирээдүйн гэрлэлтийнхээ тал дээр Бурханы зарчмуудыг дагахаа амлаж, хоёр догол мөрөнд багтаан бич. Хэрэв та гэрлэсэн бол гэрлэлтийн талаарх Бурханы зарчмуудыг дагах шийдвэрээ хоёр догол мөрөнд бичнэ үү.

(2) Энэ хичээлийн сэдвүүдээс нэг юмуу хэд хэдэн сэдвийг сонгож аваад, танай нийгэмд хүн Библийн зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлж болох талаар нэг хуудас тайлбарлан бичээрэй.

Жишээлбэл:

- Гэрлэхээр бэлтгэж байгаа итгэгч эрэгтэй эмэгтэй хоёрын дунд ямар харилцаа байх ёстой талаар тайлбарлах,
- Танай нийгэмд гэр бүлийн харилцаандаа үнэнч байхыг хүсдэг хүмүүс биеэ хэрхэн авч явдгийг тайлбарлан бичих гэх мэт.



## 8-р хичээл

# Христитгэл ба байгаль орчин

### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах ойлголт, чадварт суралцсан байна:

(1) Бурхан яагаад бүх зүйлийг бүтээсэн, хүн төрөлхтөн яагаад Бурханы бүх бүтээлээс хамгийн онцгой байдгийг ойлгоно.

(2) Бүх бүтээлийг харж хамгаалах үүргийг Бурхан хүн төрөлхтөнд өгсөн болохыг ойлгоно.

(3) Бурханы бүтээлүүдийг зөв зохистой удирдаж, ашиглах аргуудыг мэдэж авна.

### Хөдөө аж ахуйн эрдэмтэн Жорж Вашингтон Карвер

Жорж Вашингтон Карвер 1860 оны үед Америкт төрсөн, боол хүн байв. Гэхдээ боолчлол халагдсаны дараа тэрээр боловсрол эзэмшихийг хүссэн ажээ. Тухайн үед боол хүүхдэд боловсрол эзэмших амаргүй байсан ч нэгэн сайхан сэтгэлт эмэгтэй түүнд “Чи сурч болох боломжтой бүхнээ сур. Тэгээд сурсан эрдмээ хүмүүст зааж өг” гэж хэлжээ. Тэгээд Жорж “Эзэн минь, надад ертөнцийн нууцыг мэдүүлээч” гэж залбирав. Харин Бурхан “Чи ертөнцийн нууцыг ойлгож чадахааргүй өчүүхэн шүү дээ” гэж хариулахад Жорж “Тэгвэл Та надад газрын самрын нууцыг мэдүүлж өгөөч” гэж залбирахад Бурхан зөвшөөрчээ. Тэр үед олон ядуу тариаланчид газрын самар тарьдаг байсан учраас их чухал ургамал байлаа. Газрын самраас олон бүтээгдэхүүн гаргаж чадвал газрын самрын ургацын үнэ өснө гэж Жорж бодов. Ингээд газрын самраас 300 гаруй, амтат төмснөөс 100 гаруй төрлийн бүтээгдэхүүн боловсруулж, гарган авчээ. Тэрээр Tuskegee институтэд 47 жилийн туршид хөдөө аж ахуйн хичээл зааж, фермерүүдэд газраа сайжруулах, ахиу ургац авах аргуудыг заасан юм. Жорж Вашингтон Карверийн итгэл хийгээд Бурханы бүтээлийг хүн зөв зохистой зохицуулж чадвал хүн төрөлхтөнд маш их ашиг тус авчирна гэж итгэдэг үзэл бодол нь агуу ивээлийг авчирсан билээ.

**Амьд биес өөр хоорондоо болон байгаль орчиндоо хэрхэн харилцан холбоотой оршдгийг судалдаг ухааныг экологи гэнэ.**

### Байгалиас дээгүүрх хүний эрх мэдэл

► Нэг суралцагч Эхлэл 1:1, 26-28 эшлэлийг бүлэгт уншина.

Бурхан өөртөө магтаал хүндэтгэлийг авахын тулд газар дэлхийг бүтээсэн (Дуулал 148). Тиймээс газар дэлхийг арчлан хамгаалах үүрэг хариуцлагыг хүн төрөлхтөн хүлээн авсан юм. Хүн Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн учраас бид газрыг Бурхан шиг удирдах ёстой. Дуулал номд “Та (хүнийг) Бурханаас арай дор болгож, алдар хүндийн титмийг

түүнд өмсгөжээ. Та түүнд мутрынхаа бүтээлүүдийг захируулж Та бүх юмсыг түүний хөл дор тавьсан” (Дуулал 8:5-6) гэсэн байдаг. Газар дэлхийд хүн онцгой үүрэг рольтой. Хүн бол амьтан биш. Бурхан хүнд газар дэлхий болон газар дэлхийд амьдрагч бүх амьтдыг удирдах эрхийг өгсөн юм.

Бурхан Адам Ева хоёрт өсөж үрж хэмээн хэлсэн бөгөөд тэдэнд газар дэлхийг эзэмш гэж тушаасан. Тиймээс хүний үр удам газар дэлхийг үргэлжлүүлэн эзэмшсээр иржээ. Газрыг эзэмших гэдэгт бол шинэ газрыг нээх, судлах, тэнд амьдрах, ашигт малтмалыг илрүүлж ашиглах, ан амьтныг гаршуулах, технологи хөгжүүлэх зэрэг олон үйл ажиллагаа багтана.

Бурхан анх бүгдийг бүтээх үед бүх юм сайхан байлаа. Хүн Еден цэцэрлэгийг арчлан хамгаалах нь байгальтайгаа зохицсон, таатай ажил байв (Эхлэл 2:15). Гэвч нүгэл орж ирснээр, байгаль орчинд хараал хүрсэн учраас хүний ажил хүнд хэцүү болсон юм (Эхлэл 3:17-19). Газар дэлхий анхны төгс байдлаа алдсан (Ром 8:18-23) боловч Бурханы бүтээсэн гайхалтай бүтцийг хадгалсан хэвээрээ байна.

Их үерийн дараа Бурхан хүмүүст амьтны махыг идэхийг зөвшөөрчээ (Эхлэл 9:3). Мосегоор дамжуулан Эзэний өгсөн хууль зааварт зарим төрлийн амьтныг идэхийг хориглосон байдаг боловч Шинэ гэрээнд хоол хүнс болгож болох ямар ч амьтны махыг идэж болохыг зөвшөөрсөн байдаг (Марк 7:19, 1 Тимот 4:4). Амьтдад хүнтэй эн зэрэгцэхүйц эрх гэж байхгүй.

### **Байгалийн нөөцийг зохицуулах үүрэг хариуцлага**

Хэдийгээр хүмүүст газрыг эзэмших эрх мэдэл өгөгдсөн боловч (Эхлэл 1:28), туйлын эрх мэдэл хүнийх биш. Бүх хүн Бурханы өмнө хариуцлагатай. Газар ба газрын бүх ургац Бурханд харьяалагддаг.

► Суралцагчид Дуулал 24:1 мөн Дуулал 50:10-11 эшлэлийг бүлэгт уншина.

Бурхан газар дэлхийг өмчилдөг. Тэрээр өөрийнхөө сүр жавхлангийн төлөө газар дэлхийг (Дуулал 19:1) бүтээхдээ хүн төрөлхтний хэрэгцээг хангах (Эхлэл 1:29), амьдрахад аятай тавтай газар байлгахаар газар дэлхийг бүтээсэн билээ. Бурхан хүнийг газар ба газраас гардаг бүх бүтээгдэхүүнийг эдэлж хэрэглэхийг хүсдэг. Газар бол Бурханы мутрын бүтээл учраас хүн газрыг шүтэж болохгүй (Ром 1:25). Нөгөө талаар хүн газар дэлхийг хөнөөлтэй аргаар ашиглан сүйтгэж ч болохгүй.

Заримдаа хүмүүс газрыг ашиглахын хажуугаар сүйтгэж байдаг. Хүмүүс ашигт малтмал олборлож авахдаа хөрсийг ашиггүй, хэрэггүй болгоод орхиж байна. Зарим нутагт хүмүүс бүх модыг тайрч авсан учраас хөрсний үржил шим борооны усанд урсаад алга болж байна. Зарим газар хүмүүс зэрлэг амьтдыг хоол хүнсэндээ хэрэглэхээр алж устгаад дуусгаж байна. Хүмүүс гол усанд хог хаяж, хэрэглэх аргагүй болтол нь бохирдуулж байна.

Бурхан газар дэлхийг үр өгөөжтэй байлгахаар бүтээсэн. Тиймээс газрыг хөнөөлтэй байдлаар ашиглах нь буруу юм. Газрыг хөнөөлтэй байдлаар ашиглах нь Бурханыг үл хүндэтгэж буй хэрэг мөн.

Бурхан дэлхийг олон мянган жилийн туршид хүмүүст үр өгөөжөө өгөх байдлаар бүтээсэн. Тиймээс бид хойч үеийнхнийхээ төлөө байгаль орчноо зөв ашиглаж, арчилж хамгаалах үүрэгтэй. Түр зуурын ашиг олохын төлөө газрыг сүйтгэж байгаа хүн хойч үеийнхээ хүмүүсийг хайрлахгүй байна гэсэн үг.

Хорин жилийн дараа хэн нэгэн хүн таны хүүхдийг дээрэмдэнэ гэж та хүлээж байна уу? Мэдээж үгүй. Гэхдээ хүүхдүүдийнхээ амьдрах байгаль орчныг сүйтгэж байгаа хүн өөрийнхөө хүүхдүүдийг дээрэмдэж байгаа хэрэг. Өөрийн төрсөн хүүхэд танд байхгүй байлаа ч, газар нутгийг чинь өвлөх ирээдүйн хүүхдүүдэд санаа тавих үүрэг танд бий.

Түүнчлэн өөрийнхөө хашаа хороог хайрлаж хамгаалдаг мөртлөө нийтийн эзэмшлийн газарт хамаагүй ханддаг хүмүүс байдаг. Бидний хүрээлэн буй орчин Бурханы өмч бөгөөд бусад хүмүүс, дараа үеийнхэн үүнийг хэрэглэнэ гэдгийг ойлгодог учраас Христэд итгэгч хүн байгаль орчноо хамгаалах тал дээр үлгэр дуурайл үзүүлэх ёстой.

Заримдаа хүмүүс “Энэ ямар миний газар биш, хогоо хаяхад яахав дээ” эсвэл “Бүх модыг нь том жижиггүй бүгдийг нь тайрч авъя” гэж боддог.

► Нэг суралцагч Дэд хууль 22:6 эшлэлийг бүлэгт уншина.

Дэд хууль номын энэ хэсэгт үүрэн дээрээ сууж байгаад амархан баригддаг шувууны тухай ярьж байна. Хэрэв өндөг шувуу хоёрыг хоёуланг нь авбал цаашдаа тэр зүйлийн шувуу устаж үгүй болно. Тиймээс эхийг нь тавьж явуулах ёстой гэжээ. Орчин үед газар орон болгоны дүрэм журам бага зэрэг ялгаатай байдаг ч, энэ эшлэлээс байгалийн нөөцийг хайрлах ёстой гэсэн санаа харагдаж байна.

### **Байгалийн үзэмжийг үнэлж талархалтай хандах нь**

Бурхан хүнсний ногоо, жимс самрыг бүтээхээс гадна үзэсгэлэнт цэцэгс, үзэмжит олон ургамал амьтныг бүтээсэн. Тэгэхээр Бурхан зөвхөн хэрэглээний зорилгоор байгалийг бүтээсэн бус, харин гоо үзэмжийг бас анхаарсан гэсэн үг (Лук 12:27). Хүмүүсийн амьдрах сайхан орчныг бүрдүүлэхийн тулд Бурхан байгалийн гоо үзэсгэлэнг бүтээжээ.

Уулс, говь цөл, гол мөрөн, тэгш тал, ой модод бүхэнд байгалийн үзэмж шингэсэн байдаг. Зарим хүн төрсөн газрынхаа гоо үзэсгэлэнг олж хардаггүй. Тэд орчиндоо дасчихсан учраас үүнийг байдаг л зүйл мэт хүлээн авдаг.

► Өөрийгөө зураач гэж төсөөлөөрэй. Та их цаг зарцуулж, маш сайхан зураг зураад найздаа бэлэглэсэн гэж бодъё. Нэг өдөр тэднийг зочилж очтол таны зурсан зураг эвдэрчихсэн, хүмүүсийн хөлд гишгэгдээд байж байна. Танд ямар санагдах бол?

Зарим улс орны хүмүүс хогоо шууд байгаа газраа хаяад явдаг. Тэд өөрийнхөө хашааг цэвэрлэдэг атлаа бусад газарт хаа хамаагүй хогоо хаядаг. Тиймээс гудамж талбай нь хогоор дүүрэн байдаг.

► Ийм хүмүүс юу ойлгох хэрэгтэй вэ?

Бид өөрсдийнхөө болон бусдын төлөө олон нийтийн газруудыг ч анхаарах учиртай.

► Орчин тойрноо өөрчлөхийн тулд чуулганыхан юу хийж болох вэ?

### **Амьтад хэрхэн хандах вэ?**

Амьтад хүнээс ялгаатай. Тэднийг Бурханы дүр төрхөөр бүтээгээгүй, бас амьтанд сүнс гэж байхгүй (Номлогчийн үгс 3:21). Хүний эрх амьтанд үйлчлэхгүй.

Бурхан хүнд амьтны махыг идэх зөвшөөрлийг олгосон. Тиймээс хүн хоол хүнсэндээ хэрэглэх зорилгоор зэрлэг ан амьтныг агнах, мал сүргийнхээ шимийг авахаар өсгөх нь Бурханаас өгөгдсөн зүйл.

Түүхийн туршид хүн төрөлхтөн амьтан тэжээх эсвэл, амьтныг ажил хөдөлмөртөө ашиглах нь түгээмэл байсан.

► Хүмүүс амьтанд хэрхэн хандаж байгааг Бурхан анхаарч үздэг үү?

► Нэг суралцагч Сургаалт үгс 12:10 эшлэлийг бүлэгт уншина.

Энэ эшлэлд мал амьтнаа сайн арчлах нь зөвт хүний нэг шинж гэжээ. Харин харгис хэрцгий зан чанар бол хорон муу хүний шинж юм.

Амьтан тэжээдэг хүн амьтнаа хоол хүнс, амьдрах байраар хангах ёстой. Харин амьтныхаа хэрэгцээг үл хайхардаг хүмүүс бол ямар нэг асуудалтай хүмүүс юм.

Бүх амьтан Бурханых гэдгийг санагтун (Дуулал 50:10-11). Бурхан амьтдыг бүтээсэн бөгөөд маш олон төрлөөр нь бүтээсэн. Зөвхөн хүнсэнд хэрэглэх, ажилд ашиглах зорилгоор цөөн хэдэн төрлийн амьтан бүтээж болох л байсан. Гэвч Бурхан шавж, өчүүхэн жижиг биетүүд гэхчлэн үй түмэн зүйлийн амьд биесийг бүтээжээ. Бурхан гайхалтай бүтээлч сэтгэлгээтэй учраас зүйл бүрийн амьтан, өчүүхэн биесийг хүртэл урласан юм.

Зарим төрлийн амьтан эзэндээ үнэнч байж, баярлаж байгаагаа илэрхийлэх чадвартай байдгаас гадна, хүмүүсийн анхаарлыг татаж, хариу үйлдэл хийж сурсан байдаг. Тэд зарим юмыг сурч чадах ухаалаг амьтад юм. Бурхан тэднийг хүмүүстэй харилцуулах зорилгоор бүтээсэн нь илэрхий байна. Бурхан амьтдыг хүнээс айж эмээдэг болгож бүтээсэн юм (Эхлэл 9:2).

Түүнчлэн амьтдыг хүнд хариу үйлдэл үзүүлэх чадвартай болгон бүтээжээ. Тиймээс амьтныг хүчирхийлэх нь Бурханы зорилгыг үл хүндэтгэсэн хэрэг юм. Ямар нэг талаараа гажуудаж эвдэрсэн хүмүүс амьтныг өвтгөж, тамлаж таашаал авдаг.

Бичвэрт хоньчны тухай маш их гардаг. Давид ч Израилын хаан болохоос өмнө хоньчин байсан юм. Тиймээс тэрээр Дуулал 23-т Бурханыг хоньчинтой зүйрлүүлсэн байдаг. Бурхан ард түмнээ яг л хонин сүргээ халамжилдаг хоньчин шиг хайрладаг гэдгийг тэр ойлгосон ажээ. Шинэ гэрээнд пасторуудыг хоньчинтой зүйрлэдэг (1 Петр 5:2 болон бусад). Хэрэв Бурхан хүмүүсийг мал амьтнаа арчилж анхаарах ёстой гэж үздэггүй байсан бол ингэж зүйрлүүлэх нь ямар ч утгагүй байх байсан.

Давид хонин сүргээ харж хамгаалж сурсан нь хожим ард түмнээ хамгаалж сурах бэлтгэл байв. Үүнтэй адилаар бидэнд Бурханы даалгасан газар нутаг, мал амьтныг харж анхаарах нь бусад хүмүүсийг анхаарч халамжлах бэлтгэл болдог.

### **Ногоон орчны үнэ цэн**

Ногоон өнгө бол ус, хөрс муутай газраас бусад газрын хамгийн түгээмэл унаган өнгө юм. Энэ өнгө хүний нүдийг амраадаг.

Хотод амьдардаг хүмүүс хотоос зайдуу байгальд гарах үедээ сэргэдэг шүү дээ.

Ногоон орчингүй хот маш олон. Тийм хотын газрынх нь ихэнх хэсэгт бетон, цардмал замаар хүчигдсэн байдаг. Тиймээс хотууддаа цэцэрлэгт хүрээлэн болон бусад төрлийн ногоон байгууламжуудыг бий болгох талаар зарим улс орнууд ихээхэн санаа тавьж байна. Мод ургамал ургуулах газрыг өргөжүүлэхийн тулд нутгийн хүмүүс бүгдээрээ хамтран ажиллах ёстой. Хүмүүсийн зугаалах газар, хүүхдийн тоглох ногоон орчинг хамгаалж, хадгалах нь хүний үүрэг. Айлууд хашаандаа мод зүлэг тарьснаар өөрсдийн гэсэн ногоон байгууламжийг бий болгож чадна.

### **Итгэгчид байгаль орчинд яагаад санаа тавьдаг вэ?**

Энэ хичээлийн эхэнд байгаль орчны талаарх тодорхойлолтыг бид харсан.

► Итгэгчид яагаад байгаль орчинд санаа тавих ёстой вэ?

Төрөл бүрийн бохирдлоос сэргийлж чадвал газар дэлхийгээ хамгаалж чадна гэж зарим хүн үздэг. Хүмүүс бид бүрэн хамгаалж чадахгүй байж болох ч, байгаа газраа чадах чинээгээрээ хамгаалахын төлөө зүтгэх ёстой. Дэлхий ертөнцийн доройтлыг буцааж эргүүлж чадахгүй гэдгийг итгэгчид мэднэ. Харин Бурхан эцсийн цаг үе болоход газар дэлхийг шинэчлэх болно (Илчлэл 21:1). Тиймээс хүн газар дэлхийг аварч чадахгүй.

Зарим хүн хүмүүнийг амьтнаас ялгаагүй гэж үздэг учраас амьтны эрхийг хүний эрхтэй эн тэнцүү байх ёстой гэдэг. Харин газар дэлхийг захирах эрх мэдэл хүмүүнд өгөгдсөн гэдгийг итгэгч бид мэднэ. Хүн бол Бурханы төрхөөр бүтээгдсэн, мөнхийн сүнстэй бодгаль учраас амьтдаас ялгаатай. Тиймээс амьтны эрхийг хүний эрхтэй харьцуулах нь утгагүй зүйл юм.

Итгэгчид газар дэлхийгээ арчлан хамгаалдаг. Яагаад гэвэл:

1. Газар дэлхий Бурханых.
2. Газар дэлхийг арчлан хамгаалах үүргийг Бурхан хүнд өгсөн.
3. Бид ирээдүй үеийнхээ төлөө газар дэлхийгээ хайрлан хамгаалдаг.

► Хүмүүст байгаль орчноо хамгаалах христэч үзэл бодол байхгүй байгааг харуулдаг ямар дадал зуршлууд танай нийгэмд байдаг вэ?

► Чуулганыхаа хашаанаас гарч явахад юу харагддаг талаар суралцагчид нүдээ аниад, санана. Чуулганы өмнөх хэсэг ямар харагдаж байна вэ? Газарт хог байна уу? Тэр газрыг хэн нэг нь арчилж цэвэрлэдэг юм шиг харагдаж байна уу? Тэр газрыг хэн хариуцах ёстой вэ? Чуулганы гишүүд тэр газрыг хэрхэн өөрчилж сайжруулж чадах вэ? Чуулганы гишүүд яагаад тэр газрыг арчилж сайжруулах талаар бодох ёстой вэ? Тэдний санаа тавьж буй байдал бусдад ямар нөлөө үзүүлэх бол? Суралцагчид яг ийм маягаар гэрийнхээ ойр орчныг мөн дүрслэн бодож болно.

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

- Та ямар зуршлаа засах ёстой вэ?
- Танай чуулганыхан үлгэр дуурайл үзүүлж, зааж сургах замаар орчин тойрондоо ямар өөрчлөлт авчирч чадах вэ?
- Хэрэв танай тэндхийн хүмүүс хамтарвал тэр хавийн орчин хэрхэн сайжирч болох вэ?

### **Залбирал**

Тэнгэрлэг Эцэг минь,

Гоо үзэсгэлэнтэй, нөөц баялагтай газар дэлхийг бүтээж өгсөнд баярлалаа. Таны бүтээсэн газар дэлхийг арчлан хамгаалах үүрэг хариуцлагыг хүмүүс бидэнд даалгасанд баярлалаа.

Таны гайхалтай бүтээлд үнэ цэн өгч, талархан амьдрахад туслаач. Газар дэлхийнхээ гоо үзэсгэлэн, нөөц баялгийг хамгаалахын төлөө хамтран зүтгэхэд маань Та туслаач.

Амен

### **8-р хичээлийн даалгавар**

(1) Энэ хичээлээс сурсан зүйлээ ашиглан байгаль орчны эсрэг үйлдсэн хуучин зуршлуудаа хэрхэн өөрчлөх талаар төлөвлөж, үүнийгээ тайлбарлан догол мөрөнд бич.

(2) Танай нийгэмд ямар буруу зуршил байна вэ? Энэ талаар нэг хуудас бич. Тэдгээр буруу зуршлуудыг яагаад өөрчлөх ёстойг хэн нэгэн хүнд тайлбарлаж байна гэж төсөөлж бичээрэй. Библийн эшлэл болон Библийн дагуух үзэл санааг нотолгоо болгож ашиглаарай.

## 9-р хичээл

### Мөнгө

#### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах ойлголт, чадварт суралцсан байна:

(1) Мөнгө, нөөц боломжоо Бурханы зарчмуудын дагуу зөв зохистой хэрэглэх шийдвэр гаргаж, даган мөрдөх.

(2) Мөнгөтэй холбоотой буруу үзэл бодол, мөнгөний буруу хэрэглээнээс үүддэг сүнслэг аюулуудыг ойлгож, хэрхэн зайлсхийх талаар суралцана.

#### Өгөөмөр Жон Весли

Жон Весли 1703-1791 онд Англид амьдарч байсан хүн юм. Чуулганууд хүлээж авдаггүй ядуу хүмүүст тэр гадаа, гудамжинд сайнмэдээ тунхагладаг байлаа. Мөнгөө зарцуулахаас эхлээд амьдралынхаа бүх асуудал дээр Бурханыг хүндэтгэхийг эрмэлзэн, нямбай амьдарч байв. Тиймээс итгэгч хүн мөнгө олж л байгаа бол, аль болох хадгалж, чадах чинээгээрээ бусдад өгч байх ёстой гэж заадаг байлаа. Тэрээр яаж санхүүгийн сахилга баттай байх талаар үлгэр дуурайл үзүүлж байв. Тиймээс өргөлийн мөнгөө нэмэгдүүлэхийн тулд жилийнхээ зарлагыг багасгадаг байжээ. Улмаар орлого нь өссөн ч зардлаа нэмэгдүүлдэггүй бөгөөд илүү гарсан бүхнээ өргөдөг байсан юм. Жон Весли насан туршдаа өндөр орлоготой байсан ч, нас барах үедээ хэдхэн зоос л үлдээжээ. Мөнгийг удирдах үүрэг хариуцлагыг Бурхан хүмүүст даатгадаг гэдгийг тэрээр мэддэг байсан төдийгүй, итгэгч хүн мөнгөтэй харьцахдаа Бурханы зарчмуудыг дагах ёстой хэмээн заадаг байжээ.

#### Танилцуулга

Шинэ гэрээнд мөнгөний тухай бусад сэдвээс илүү олон удаа дурдсан байдаг. Бурханд мөнгө чухал биш боловч мөнгөтэй холбоотой асуудал хүмүүсийн дунд их байдаг учраас ийнхүү олонтаа дурдагджээ.

Бүтээгчийн хувьд бүх хүн, бүх эд хөрөнгө Бурханых юм. Итгэгч биднийг Бурхан зольж авсан учраас бид Түүнд онцгой байдлаар харьяалагддаг. Бид Бурханы алдрын төлөө ашиглагдах ёстой хөрөнгө мөнгийг захиран зарцуулах нярав хэмээн өөрсдийгөө тооцох ёстой.

Сайхан эд юмсыг хэрэглэх нь буруу зүйл биш. Хэрэв бид бүх юмыг талархал, даруу байдлаар хүлээн авбал, Бурхан биднийг дуртайяа ивээдэг юм.

Гэхдээ мөнгөнөөс болж олон хүн сүнслэг аюулд ордог.

## Баян болох тал дээр өгсөн сэрэмжлүүлэг

► Баян хүн гэж хэнийг хэлэх вэ?

Хүнийг баян гэж тооцох янз бүрийн шалтгаан байдаг.

Хэрэв та үндсэн хэрэгцээнээсээ илүү зүйл худалдан авах мөнгөтэй бол, та энэ дэлхийн хүмүүсийн тал хувиас илүү баян байна. Хоногийн хоолныхоо төлөө өдөр бүр ажиллах ёстой болдог маш олон хүн бий. Хэрэв тэд ямар нэг шалтгаанаар ажлаа хийж чадахгүй болбол идэх хоолгүй болно.

Харин хүмүүс амьдарч буй нийгмийнхээ ихэнх хүнээс илүү мөнгө хөрөнгөтэй хүнийг л баян гэдэг. Тийм хүмүүс хэрэгцээндээ бусдаас илүү их мөнгө зарцуулах хэв маягтай. Бусад хүмүүс ч тэднийг нийгмийн дээд давхаргынхан гэж үзнэ. Тэд ихэнх хүний худалдан авч дийлэхээргүй тансаг хэрэглээтэй бөгөөд эрх мэдэлтэй хүмүүст нөлөөлж чаддаг. Тэдний эд хөрөнгө, боломж нөөцөөс болоод хүмүүс тэдэнд үйлчлэхэд бэлэн байдаг.

Харин Библид баян хүмүүст хандсан тусгай заавар, анхааруулгууд бий.

Есүс “Баян хүн тэнгэрийн улсад орох маш хэцүү” хэмээсэн нь маш ноцтой сэрэмжлүүлэг юм (Матай 19:24).

Баячуудад элч Паулын хэлсэн үгээс хөрөнгө мөнгөтэй холбоотой аюул эрсдэл их байдгийг бид ойлгож авах боломжтой.

► Нэг суралцагч 1 Тимот 6:17-19 эшлэлийг бүлэгт уншина.

Паул баян хүмүүст өөрсдийгөө бусдаас дээгүүр зиндаанд тооцохгүй байхыг анхааруулж байна. Ер нь баячууд өөрсдийгөө бусдаас илүү гэж бодох сорилттой тулгарч байдаг. Иаков ч бас чуулганы гишүүдэд хүмүүсийг хөрөнгө мөнгө, нийгмийн зэрэг зиндаанаас нь болж ялгаварлан харилцах алдааг гаргаж болохгүй хэмээн анхааруулсан байна (Иаков 2:1-4).

Баян хүн эд хөрөнгөндөө найдаж тайвшралгүй, харин Бурханд түшиглэх ёстой. Баячууд санхүүгийн хувьд боломжтой амьдардаг учраас Бурханы хангамжид найдах хэрэгцээг мэдэрч чадахгүй, сүнслэг тал дээр хайнга болох нь бий (Дэд хууль 8:6-18).

Баян хүн өгөөмөр байж, мөнгө хөрөнгөөрөө сайн зүйлсийг хийх ёстой.

Бусад хүмүүс зовж байхад энэ дэлхийн баячууд зугаа цэнгэлээр амьдарч, тансаглаж байгаа явдлыг Иаков 5:5-д буруушаасан байдаг. Ухаалгаар өгснөөр олон сайн зүйл хийж болно. Мөнгөөр аз жаргалыг худалдаж авч болохгүй ч, зовлон зүдүүрийг нимгэлж болно. Тиймээс хүн тансаг амьдарч байгаа бол бусдын зовлонг үл тоож болохгүй.

Бурхан эш үзүүлэгч Амосоор дамжуулан шударга ёсны төлөөх зүрх сэтгэлээ (ядуу, дарлагдсан хүмүүст өршөөнгүй, өрөвч сэтгэлээр хандах) “Шударга ёс ус мэт зөвт байдал мөнхийн урсгал мэт урсаг” (Амос 5:24) хэмээн илэрхийлсэн байдаг. Хүмүүс

хөгжиж дэвжээд, тайван назгай, өөрийгөө эрхэмлэж, ядуусын зовлонг үл хайхрах үед Бурхан шүүлтийг авчирдаг (Амос 6:1, 3-6; Амос 8:4-7, 11-12).

Итгэгч хүн бүр ядуус, зовж зүдэрсэн хүмүүст туслахын тулд өргөлөө өргөх ёстой. Аравны нэгээрээ нутгийн чуулганаа дэмжсэнээр сайнмэдээг түгээх ажлуудад оролцож буй хэрэг. Жон Весли тухайн үеийнхээ чуулганыг хүмүүст нөлөө үзүүлэхдээ тааруу байсныг гурван шалтгаанаас үүдэлтэй гэжээ. Үүнд:

1. Зөв эрүүл сургаалаар дутмаг,
2. Сахилга баттай байдал дутмаг,
3. Өргөл зориулалт дутмаг гэх шалтгаанууд байжээ.

### **Мөнгийг хайрлах хайр**

► Нэг суралцагч 1 Тимот 6:8-10 эшлэлийг бүлэгт уншина.

Библид мөнгөний тухай сэрэмжлүүлгийг зөвхөн баян хүмүүст хандан хэлсэн юм биш. Маш олон хүн ядуугаасаа болоод аз жаргалтай байж чаддаггүй. Харин Библи хүмүүст хандаж, мөнгийг хайрлах хайр бол бүхий л бузар муугийн үндэс юм гэж хэлсэн бөгөөд энэ сэрэмжлүүлэг бүх хүнд хамаатай.

Мөнгийг хайрлах хайр хэзээ ч ханахгүй. Мөнгөнд дуртай хүнд ханах хэмжээ гэж байхгүй (Номлогчийн үгс 5:10). Тиймээс Библи бидэнд мөнгөнд дурлахаас зайлсхийж, үндсэн хэрэгцээтэй зүйлдээ сэтгэл хангалуун байх ёстой гэж зааж байна (Еврей 13:5).

Баяжихыг хүсдэг хүн олон сорилт, уруу таталттай тулгардаг бөгөөд янз бүрийн авир ааш гаргахад хүрдэг. Баяжих гэж явсан хүн итгэлээ орхиж, баяр хөөр биш харин гуниг зовлонгоор дүүрч ч болно.

Зарим шашны удирдагчид хүмүүсийг татахын тулд шашинд нь элсвэл баян болгоно гэж амладаг. Ядуу буурай орны олон хүн хүнд амьдралаасаа болоод иймэрхүү амлалтад уруу татагддаг. Ийм удирдагчид байнга мөнгөний тухай ярьж, номлодог төдийгүй, санхүүгийн амжилтаа гайхуулдаг энэ ертөнцийн хүмүүс шиг байж чадна гэж бардамнадаг.

Харин итгэл сүсэгтэй, сэтгэл хангалуун байх нь хамгийн агуу ашиг гэж Библид хэлсэн юм (1 Тимот 6:6). Шашны аргаар баяжих гэж хөөцөлдөх нь энэ дэлхийн элдэв арга замаар баяжих гэж явдаг хүнтэй адилхан аюулд унадаг. Баян болгоно гэж амладаг чуулганууд жинхэнээсээ итгээгүй хүмүүсийг иймэрхүү хүслээр нь урхиддаг. Гэхдээ ийм чуулгануудад явсан хүн хэзээ ч хүссэндээ хүрдэггүй бөгөөд тэнд горьдлого тээсэн баахан хүн л байдаг. Эд баялгийн сайнмэдээг номлодог чуулганд баяжиж чаддаг хүмүүс нь итгэгчдээсээ өргөл хурааж авдаг тухайн чуулганы номлогч нар л байдаг.

► Нэг суралцагч Филиппой 4:10-13 эшлэлийг бүлэгт уншина.

Филиппой чуулганы итгэгчдийн явуулсан дэмжлэгт Паул ихэд талархаж байлаа. Тэрээр ямар ч нөхцөлд, өлсгөлөн дунд ч сэтгэл хангалуун байхыг сурсан гэж хэлжээ. Энэ үгээс

Паулд мөнгөгүй үе гарч байсан гэдэг нь харагдаж байна. Гэсэн ч тэрээр Бурханы тусламжтайгаар бүгдийг хийж чадна гэсэн юм. Хам сэдвээс нь харвал энэ үг ямар ч үед сэтгэл хангалуун, Бурханд итгэсээр байна гэсэн санааг илэрхийлж байна.

### **Шударга байдал**

► Нэг суралцагч Сургаалт үгс 11:1 эшлэлийг бүлэгт уншина.

Энэ эшлэлд жимс, ногоо, мах мэтийн жижиглэнгийн барааг хэмжих жин хэмжүүрийн тухай хэлж байна. Зарим хүн илүү мөнгө авахын тулд хуурамч жинлүүр хэрэглэдэг. Ийм зүйлийг Бурхан үзэн яддаг гэжээ.

Олон хүн мөнгөний төлөө шударга бус зүйлсийг хийдэг. Энэ курсын дараагийн хичээлээр бид шударга байдлын талаар үзэх болно.

### **Бурханд итгэж найдах нь**

Элч Паул филиппойчуудад бичсэн захидалдаа Бурхан тэдний хэрэгцээг хангана хэмээн бичжээ. Энэ бол гайхалтай амлалт. Гэхдээ энэ амлалт тэднийг ямар нөхцөл байдалд байхад өгөгдсөнийг харцгаая.

► Нэг суралцагч Филиппой 4:15-19 эшлэлийг бүлэгт уншина.

Тэр чуулганыхан Паулд мөнгөн тусламж илгээхэд тэрээр үүнийг Бурханд өргөсөн тахил байна гэж хэлжээ. Улмаар Бурхан тэдний хэрэгцээг хангана гэж Паул амлахдаа мөнгийг нь өсгөж өгнө гэж хэлээгүйг анхаараарай.

Энэ бол хариуцлагагүй эсвэл үрэлгэн хүмүүст биш, харин мөнгөө сүнслэг зарчмуудын дагуу зохицуулдаг хүмүүст зориулагдсан амлалт юм.

► Нэг суралцагч Матай 6:25-33 эшлэлийг бүлэгт уншина.

Бурхан шувуудыг тэжээж, цэцэгсийн үзэсгэлэнгээр гоёдог шигээ хүмүүс бидний хэрэгцээг ч бас хангах учраас бид яаж амьдрах талаар санаа зовох хэрэггүй гэж Есүс хэлж байна. Энэ эшлэлд хэрэв бид Бурханы хаанчлалыг эн тэргүүнд тавивал бүх хэрэгцээ маань хангагдана хэмээн амлаж байна.

Хүмүүс ихэвчлэн *өнөөдрийнхөө* төлөө биш, харин *ирээдүйнхээ* төлөө санаа зовдог. Бурхан бүх зүйлийг урьдаас бэлтгэж өгнө гэж амлаагүй. Хуучин гэрээний үед израилчууд дээр өдөр бүр тэнгэрээс манна бууж ирдэг байсан түүхийг санаарай (Гэтлэл 16). Яг үүн шиг өдөр бүрийн хэрэгцээнийхээ төлөө Бурханд залбирах ёстой хэмээн Есүс хэлж байна (Матай 6:11). Бурхан биднийг өдөр бүр Өөрт нь найдаасай гэж хүсдэг.

Бурхан ядуусыг итгэлдээ баян байлгахаар сонгосон гэж Иаков хэлжээ (Иаков 2:5). Санхүүгийн хувьд өөрсдийгөө аюулгүй гэж боддог хүмүүсээс илүү ядуу хүмүүст Бурханд түшиглэх боломж их байдаг.

Бурханд найдна гэдэг хариуцлагагүй байна гэсэн үг биш. Бурхан ерөнхийдөө ажил хөдөлмөрөөр маань дамжуулан бидний хэрэгцээг хангадаг (Ефес 4:28). Хэрэв хүн ажил хийх дургүй бол Бурханы хангамжийг хүлээх хэрэггүй бөгөөд бусад нь ч тийм хүнд өгөөд байх албагүй (2 Тесалоник 3:10).

Түүнчлэн Бурханы хангамж биднийг баян болгох ёстой гэж бодож болохгүй. Бурхан зарим хүнийг их баялгаар ерөөж өгдөг боловч, баян болох нь хүн бүрд зориулагдсан Бурханы төлөвлөгөө биш. Хөрөнгө мөнгийг хэт хүсэмжилдэг хүн сүнслэг тал дээр асуудалд ордог.

## **Орлогын эх үүсвэр**

Орлого олоход тусалдаг аливаа хэрэгслийг орлогын эх үүсвэр гэж хэлж болно. Жишээлбэл, газар, янз бүрийн багаж хэрэгсэл, эсвэл компьютер гэх мэт. Хүн орлогын эх үүсвэрээ ашиглан ашиг мөнгө олж болох ч, үүнийгээ арчилж тордохгүй байх юмуу зарж үрвэл үр шимийг нь хүртэж чадахаа болино. Орлогын эх үүсвэрийн тухай Сургаалт үгс 14:4-т “Шар байхгүй газар тэжээлийн тэвш хоосон, шарын хүч байх аваас орлого арвин” хэмээн хэлсэн байдаг.

Орлогын эх үүсвэрийн талаар ихэвчлэн ядуу хүмүүс сайн ойлгодоггүй. Жишээ нь, найз нь үнэтэй багаж хэрэгсэл, компьютер, машинтай бол тэр найзыгаа их мөнгөтэй л гэж бодно. Тэгээд хэрэг гарахаараа тэр найзаасаа юмуу хамаатан саднаасаа мөнгө гуйж, өөрт нь өгөх ёстой гэж боддог. Гэвч ийм эд зүйлс бол хөрөнгө мөнгө биш, харин орлогын эх үүсвэр, зарж болшгүй хэрэгсэл юм. Зарчихвал бүх орлогоо алдана гэсэн үг.

► Таны эргэн тойронд зарж болшгүй орлогын эх үүсвэр байна уу?

Хэрэв хүн бусад хүмүүсийн орлогын эх үүсвэрээ хэрхэн ашиглаж байгааг нь ойлгодоггүй бол өөртөө байгаа эх үүсвэрийг ч мөн хэрхэн ашиглахаа мэдэхгүй байх талтай. Тийм хүн магадгүй өөрт нь яг юу хэрэгтэй, ямар тусламж авбал нөхцөл байдал нь өөрчлөгдөж болох талаар тодорхой хэлж мэдэхгүй байдаг. Тиймээс амьдралыг нь үнэхээр өөрчлөх өөрчлөлтийн оронд өдөр тутмынх нь орлогыг түр сайжруулах түр зуурын дэмжлэгийг л тусламж гэж ойлгодог байж мэднэ.

Орлогын эх үүсвэрээр дутмаг байх нь ядуурлын нэг шинж юм. Хүн ядуурлаас гарахын тулд шаардлагатай үр чадварыг эзэмшиж, үүнийгээ хөгжүүлэн, орлогын эх үүсвэрээ арчилж тордохгүй л бол, бусдаас хараат байдлаасаа гарч чадахгүй.

Зарим соёлд хүн мөнгө хураах, орлогын эх үүсвэрээ хөгжүүлэх маш хэцүү байдаг. Тийм нөхцөлд амьдардаг хүнийг эргэн тойрны хүмүүс нь бүх юмаа өөрсөдтэй нь хуваалцах ёстой гэж бодно. Тиймээс хэн нэгэнд нь мөнгө хэрэгтэй байхад тэр яагаад мөнгөө цааш хадгалж байгаа юм гэж боддог. Тэд өөрсдөө хариуцлагагүй амьдарч байгаа хэрнээ, нөгөө хүнийг бүх юмаа хуваалцах ёстой гэж шаарддаг.

Соёлын чанартай ийм үзэл бодлыг Христийн дагалдагч хүн хүндэтгэх ёстой боловч, Библийн зарчмыг амьдралдаа хэрэгжүүлэх ёстой. Бичвэрт хүн өөрөө хийж чадах зүйлээ

хийдэггүй бол тийм хүнийг заавал дэмжих хэрэггүй гэдэг (2 Тесалоник 3:10). Хэрэв хүн орлогынхоо эх үүсвэрийг хариуцлагагүй хүнд тусламж болгож өгөөд байвал, эцэстээ хоёулаа ядуу хэвээрээ хоцорно.

Хүмүүс өөрсдийн гэсэн орлогын эх үүсвэртэй байх нь Бурханаас ирсэн хөгжил дэвшил гэж Бичвэрт битүүхэн хэлдэг. Ерөөгдсөн нийгэмд хүн бүр өөрийнхөө усан үзмийн мод, инжрийн модны дор аюулгүй сууна хэмээн эш үзүүлэгч Мика хэлсэн (Мика 4:4). Үүгээр хувийн өмч болон ямар нэг бүтээгдэхүүн хийх арга хэрэгсэлтэй байна гэсэн санааг илэрхийлж байна. Зарим газар тариалан хамгийн тохиромжтой ажил биш байж болно. Гэхдээ нөөц боломжоо ашиглахад шаардагдах хэрэгсэл нь ерөөгдсөн хүмүүст өгөгдсөн байдаг гэх үндсэн зарчим эндээс харагдаж байна.

Ядуу хүмүүс Христийн дагалдагч болсны дараа ихэвчлэн амьдрал нь сайжирч ирдэг. Энэ бол Бурханы шууд ерөөлөөс гадна тэдний амьдралын хэв маяг өөрчлөгдсөнтэй холбоотой. Тэд архи, мөрийтэй тоглоом, янз бүрийн зугаа цэнгэлд мөнгөө үрэхээ больж, илүү сайн ажиллаж, нэр хүнд нь дээшилдэг. Үйлчлэлд өргөсөн өргөлийг нь Бурхан ерөөж өгдөг юм. Гэхдээ итгэгчдийн хоёр дахь үе нь эхний үеийнхээсээ илүү сайхан, тогтвортой амьдралтай болдог.

► Таны эргэн тойронд байгаа хүмүүст ажил хийж, санхүүгийн байдлаа сайжруулан, хуримтлалтай болоход нь тус болох ямар арга зам байна вэ?

### **Мөрийтэй тоглоом**

Амархан мөнгө олохын тулд мөнгөө эрсдэлд оруулахыг мөрийтэй тоглоом гэнэ. Мөрийтэй тоглоомд хожсон хүн хожигдсон хүний мөнгийг зүгээр авч байгаа юм. Түүнчлэн мөрийтэй тоглоомд маш олон хүн донтож, мөнгөө алдаад зогсохгүй, гэр бүлээ анхаарахаа ч больдог. Бас эргүүлээд хожоод олчихно гэж горьдоод бусдын мөнгийг авч мөрийтэй тоглоомд зарцуулдаг хүн ч олон. Мөрийтэй тоглоомын тулд бусдын мөнгийг хулгайлаад шоронд орсон хүн ч цөөнгүй байдаг. Аз таарч их мөнгө хожихоос өөр амьдрал нь өөрчлөгдөх арга найдваргүй болсон ядуу хүмүүс бас мөрийтэй тоглодог.

Мөрийтэй тоглох нь дараах христитгэлийн зарчмуудыг зөрчиж байгаа хэрэг. Үүнд:

1. Ажил хөдөлмөр хийж мөнгө олох зарчим (Ефес 4:28)
2. Байгаа зүйлдээ сэтгэл хангалуун байх зарчим (1 Тимот 6:6)
3. Тарих ба хураах зарчим (Галат 6:7) зэрэг багтана.

Түүнчлэн, Бурхан биднийг хэн нэгнээс азаар мөнгө хожихыг бус, харин өөрсдөө ажил үйлдвэрлэл эрхэлж, хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэхийг хүсдэг.

Мөрийтэй тоглох нь Бурханд найдахын эсрэг зүйл юм. Итгэгч хүн өөрөөсөө “Бурхан надад санаа тавина гэдэгт би итгэдэг үү?”, “Хэрэгтэй зүйлсийг минь хангаж өгөхийг би Бурханаас чин сэтгэлээсээ гуйж байна уу?”, “Мөнгөө эрсдэлд оруулан мөрийтэй тоглож, хэн нэгний мөнгийг хожино гэж горьдох нь намайг хангах Бурханы арга зам мөн үү?”, “Бурхан намайг ивээгээд би мөрийтэй тоглоомноос их мөнгө хожино гэж үнэхээр бодож

байна уу?” гэх асуултуудыг асуугаад үзээрэй. Мөрийтэй тоглодог хүн санхүүгийн нөхцөл байдал дээрээ Бурханд итгэж чадахгүй байгаа хэрэг. Бид чин сэтгэлээсээ Бурханд найдах үед бидний хэрэгтэй зүйлсийг маань хангаж өгнө гэдэгт найдаж, Түүний тодорхой зааврыг дагадаг.

## **Өр зээл**

Хүн мөнгө зээлэхдээ ирээдүйд олох мөнгөөрөө буцаагаад төлнө гэж тооцоолдог. Тэгэхээр, мөнгө зээлэх нь ирээдүйд олох мөнгөө урьдчилаад зарцуулж байна гэсэн үг. Гэтэл ирээдүйд ч бас шинэ хэрэгцээнүүд гарч ирнэ шүү дээ.

Библид зээлдэгч нь зээлдүүлэгчийнхээ боол болно гэсэн байдаг (Сургаалт үгс 22:7). Зээл тавьдаг хүн эрх чөлөөгөө тодорхой хэмжээгээр хязгаарлах үүрэг хүлээж байгаа хэрэг.

Зарим төрлийн зээл бусад зээлээсээ илүү дор байдаг. Хэрэв хүн хоол хүнс гэх мэт үндсэн хэрэгцээндээ мөнгө зээлж байгаа бол нөхцөл байдал нь улам муудна гэсэн үг. Хоолоо идээд дуусна, харин өр шир л үлдэнэ. Ингээд улам л ядуурна.

Ер нь гоёл чимэглэл, хэрэгцээгүй хувцас, зугаа цэнгэл, гэр орноо чимэглэх гэх мэтээр шаардлагагүй зүйл дээр өр тавивал ирээдүйн орлогоо урьдчилан зарцуулж байгаа хэрэг. Нэгэнт мөнгөө зарцуулчихсан учраас ирээдүйд хүссэн зүйлээ авах эрх чөлөөгөө тодорхой хэмжээгээр хязгаарлах ёстой болно.

Маш өндөр хүүтэй зээл өгдөг газрууд байдаг. Тэднээс мөнгө зээлсэн хүмүүс авснаасаа ихийг эргүүлж төлдөг. Зарим дэлгүүрүүд өндөр хүүтэй зээлээр бараа өгдөг. Зээлээр бараа авсан хүмүүс эцэст нь тухайн барааныхаа үнийг нэлээд өндөр үнээр тооцож төлдөг. Тийм хүмүүс тухайн барааны ердийн үнийг төлөөд авах хүртлээ мөнгөө цуглуулах хүсэлгүй, эсвэл тэвчдэггүй аж.

Зарим хүн нийгэм соёлынхоо нөлөөнд автаж тансаг хуримын ёслол хийхээр зээл авдаг. Ингээд гэр бүлийн амьдралаа өр ширтэй эхлүүлнэ. Ийм тохиолдолд чуулганы хүмүүс итгэлийн гэр бүлийнхэн учраас тэдний төлөө чуулган шинэ ёс заншлыг дэлгэрүүлэх юмуу, их мөнгө зарцуулалгүйгээр боломжийн хурим хийх арга олоход нь туслах ёстой.

► Нэг суралцагч Ром 13:7-8 эшлэлийг бүлэгт уншина.

Эдгээр эшлэлд хүн төлөх ёстойгоо төлж байхыг сануулж байна. Бид засаг захиргаагаа хүндэтгэж, дуулгавартай дагах ёстой бөгөөд засгийн газартаа татвар төлж байх үүрэгтэй. Энд 8-р эшлэлийн эхний өгүүлбэр 7-р эшлэлд заасан санаануудыг нэгтгэн дүгнэжээ. Бид хэнд юу өгөх ёстой байна, түүнийгээ татгалзалгүй өгөх л ёстой. Мэдээж мөнгө огт зээлж болохгүй гэсэн үг биш. Гэхдээ мөнгө зээлсэн бол тохирсон ёсоороо буцааж төлөх нь өгөх ёстойгоо унжилгүй өгч байгаа хэрэг юм.

Буцааж төлөх бодолгүйгээр зээл авах, эсвэл зээлж авчихаад дараа нь төлөхгүй байхаар шийдэх аль аль нь буруу (Дуулал 37:21).

ХГ-ний хууль заавар ихэвчлэн Израил үндэстний эртний хөдөө аж ахуйд түшиглэсэн аж амьдралд хандсан байдаг. Учир нь хүмүүс ахуй амьдралдаа хэрэгцээтэй зүйлсийг өөрсдөө үйлдвэрлэж хийдэг байсан юм. Гэр бүлүүд газрыг хэдэн үеэрээ дамжуулан өмчилж байлаа. Тиймээс газар худалдан авах юмуу, ямар нэг бизнес эхлүүлэхийн тулд мөнгө зээлэх нь ховор байжээ. Хэрэв хэн нэг нь мөнгө зээлбэл тухайн хүн маш хүнд нөхцөлд орж, хоол хүнсээ ч залгуулж чадахгүй байдалд орсон гэсэн үг байв. Бурхан израилчуудыг нэг нэгийгээ халамжилдаг итгэлээр холбогдсон гэр бүл шиг байгаасай гэж хүссэн. Тиймээс тусламж хэрэгтэй хүнд хүү авалгүйгээр мөнгө зээлүүлж байхыг тушаасан юм (Гэтлэл 22:25). Хүүгүй зээл өгөх нь зөв шударга хүний шинж чанар хэмээн Дуулал 15-д дурдсан байна (Езекиел 18:5-9 мөн адил).

Түүнчлэн хэн нэгэнд бизнес эхлүүлэх мөнгө зээлүүлж байгаа бол, хөрөнгө оруулж байгаа хүн хүү авах нь буруу зүйл биш гэжээ (Матай 25:27). Энэ тохиолдолд хөрөнгө оруулагч нь тухайн бизнесийг эрхлэх боломжийг олгосны шанд хүү авч байгаа хэрэг.

Харин ядуу хүмүүст зориулан ажил үйлчилгээ явуулдаг бол зөвхөн ашиг олох тухай бодох ёсгүй (Сургаалт үгс 22:16а). Ядуу хүний сонголтгүй байдлыг ашиглан, чанар муутай бүтээгдэхүүн зарах, эсвэл хэт өндөр үнэ тогтоох нь буруу. Хүнд байдалд байгаа учраас зээлэхээс аргагүй болсон хүнд эд бараагаа хэт өндөр үнээр зээлдүүлж, өгч ашиг олох гэж оролдох нь буруу юм. Бизнес эрхлэгч хүн хэрэглэгчдийнхээ нөхцөл байдлыг сайжруулах арга замыг эрэлхийлэх ёстой.

Эш үзүүлэгч Езекиел Содомын нүгэл нь зөвхөн гажууд бэлгийн харилцаа байгаагүй, харин тэндхийн хүмүүс бас тансаглал дунд амьдарч, ядуу, тусламж хэрэгтэй хүмүүст тусалдаггүй байсан гэж хэлжээ (Езекиел 16:49). Бурхан биднийг ядууст зөвхөн өгөөд байх бус, харин тэднийг хүчтэй болгохын тулд ухаалаг, стратегитай аргаар туслаарай гэж уриалж байна.

Эртний Израилд өгсөн Бурханы хууль зааврууд нь Бурхан юуг чухалчилдаг болохыг харуулдаг. Өнөөгийн дэлхийн улс үндэстнүүдийн хууль Израилд өгсөн Бурханы хууль заавруудтай адилгүй боловч, Бурханы санаа зовнидог асуудлууд, Бурханы зарчим хэвээрээ юм. Чуулганууд ядууст туслах арга замыг эрэлхийлэх ёстой боловч, эхлээд итгэлийн гэр бүлийнхнээ анхаарах учиртай. Тэгвэл орон нутаг, нийгэмдээ өөрчлөлт авчирч чадна.

### **Санхүүгээ төсөвлөх нь**

Зарим хүн мөнгөтэй болмогцоо бүгдийг нь тэр дор нь үрж дуусгадаг. Тэгээд дахиад мөнгөтэй болох хүртлээ үргэлж хэрэгцээтэй юмаар дутагдаж явдаг. Ийм хүмүүс бусдын төлөө хариуцлага хүлээх чадваргүй юм.

Төсөвлөх гэдэг бол сарын зарлагаа зохион байгуулалтад оруулж төлөвлөнө гэсэн үг. Ихэнх хүнд урьдчилан мэдэж байдаг тодорхой зарлагууд бий. Тиймээс тэдгээр хэрэгцээнд зориулж мөнгөө хадгалах ёстой. Жишээ нь, байр түрээсэлдэг хүн байж болно. Тэгвэл сард юмуу, жилд нэг удаа түрээсээ төлөх ёстой байх. Ийм учраас тухайн

хүн орлогынхоо тодорхой хэсгийг тогтмол хадгалж байвал төлөх хугацаа ирэхэд сандрах зүйлгүй байна. Жилээр нь төлдөг бол мөнгөө удаан хугацаанд хадгалах хэрэгтэй болно. Тэгвэл тэр мөнгийг өөр юманд зарцуулах уруу татлага тулгарч л таарна. Тиймээс тэр мөнгийг тусад нь хадгалж, аль хэдийн зарцуулсан мөнгө гэж тооцох ёстой.

Мэдээж хамгийн эхэнд цааш хийх мөнгө бол аравны нэг юм (Сургаалт үгс 3:9-10). Та орлогынхоо аравны нэгийг үйлчлэлд зориулах ёстой. Мөнгөө зарцуулж дуусаад аравны нэг нь үлдэхийг хүлээж болохгүй. Таны итгэмжит байдлыг Бурхан ерөөдөг.<sup>17</sup>

Үлдсэн орлогоороо үндсэн хэрэгцээндээ зарцуулаад, цаана нь онцгой нөхцөлд зарцуулах мөнгө мөн хадгалах нь зүйтэй. Түүнчлэн амьдралынхаа орчин нөхцлийг сайжруулах зорилгоор байшин худалдаж авах гэх мэт зардалд зориулан мөнгө хураах ёстой. Үүнээс гадна орлогоо өсгөх зорилгоор хөрөнгө оруулалт хийвэл сайн. Жишээ нь нэмэлт ажил хийхийн тулд багаж хэрэгсэл худалдан авч болно.

Машин эсвэл барилга байшин зэрэг орлогын эх үүсвэртэй хүн (үйлдвэрлэл явуулах ямар нэгэн зүйл) тухайн эх үүсвэрээ арчилж сайжруулах төсөв мөн гаргах ёстой. Хэрэв хүн машинаараа мөнгө олдог мөртлөө хуримтлал үүсгэдэггүй бол машины томоохон засвар хийлгэх юмуу шинэ машин худалдаж авах чадваргүй хэвээр үлдэнэ. Эцэстээ ашиг орлого ч олж чадахгүйд хүрнэ.

Мөнгөө төлөвлөдөггүй хүн үүрэг хариуцлагаа биелүүлж чадахгүй. Ийм хүн бусдын тусламжид найддаг тул бусдад туслах боломжгүй юм. Тэр ямар нэг замаар хөрөнгө оруулалт хийдэггүй учраас нөхцөл байдал нь хэзээ ч сайжрахгүй.

Есүс шархадсан хүнд тусалсан сайн самари хүний тухай ярьсан байдаг (Лук 10:25-37). Тэр самари хүнд тодорхой хэмжээний мөнгө, шархадсан хүнийг дүүрч явах илжиг байсан. Хэрэв самари хүн илжгээ зараад, мөнгөө үрчихсэн байсан бол юу болох байсан бол? Туслах сайхан сэтгэл байвч тухайн нөхцөл байдалд туслах боломж нь хязгаарлагдмал байх байсан.

Мөнгөө төлөвлөх нь үндсэн хэрэгцээгээ хангахад бэлэн байх, өөрөөс нь хамааралтай хүмүүсийн өмнө үүрэг хариуцлагаа үүрэх чадамжтай байх, ирээдүйдээ хөрөнгө оруулах, яаралтай үед бусдад тусалж чадах, сайнмэдээний үйлчлэлд дэмжлэг үзүүлэх боломжуудыг олгодог.

## **Итгэлийн гэр бүл**

Пентэктоос хойш, анхны чуулган байгуулагдсаны дараа итгэгчид итгэлийн гэр бүлийнхээ гишүүдийн үндсэн хэрэгцээний төлөө зориулалт гаргадаг байлаа. Тэд эд хөрөнгөө дундаа хэрэглэж, хэн ч өөрийнхөө юмыг өмчирхдөггүй байсан. Олон хүн газар, эд хөрөнгөө зарж, мөнгийг нь чуулганд хандивласан юм (Үйлс 2:44-45). Мэдээж бид чуулганы амьдрал яг ийм болно гэж хүлээх хэрэггүй ч, чуулган хамгийн сайнаараа

<sup>17</sup> Shepherds Global Classroom байгууллагын *Doctrine and Practice of the Church* курсээс аравны нэгийн талаар үзнэ үү. Линк: <https://www.shepherdsglobal.org/courses>

байх үед чуулганы хүмүүсийн дунд өгөөмөр байдал, бусдыгаа халамжилсан зориулалт гардаг.

Тесалоник чуулганы итгэгчид бүх гишүүддээ хоол өгөхийг хичээдэг байжээ. Гэтэл зарим нь ажил хийдэггүй хүмүүс байв. Тэд чуулганы өгөөмөр хангамжид найдаж, юу ч хийлгүй залхууран амьдардаг. Паул чуулганы гишүүдээ хайхрахгүй байж болно гэж огт хэлээгүй, харин ажил хийх дургүй хүмүүст хоол битгий өг гэж хэлсэн юм (2 Тесалоник 3:10). Магадгүй зарим хүний хувьд цалин хөлс авах ажил байхгүй бол, чуулганы хүмүүст хэрэгцээтэй үед нь тусалж болно. Зарим хүн ажилд орж чадахгүй байж болох ч, бараг хүн бүр бусдад тус болох ямар нэг юм хийж чаддаг.

Бэлэвсэн эмэгтэйчүүдэд туслах болон пасторуудыг дэмжих талаар Паул заавар өгсөн байна (1 Тимот 5:3-18, Галат 6:6).

Итгэгчид нутгийн чуулганыхаа нэгэн хэсэг болж, чуулганы гишүүдийнхээ хэрэгцээг хангах, мөн үйлчлэлийн ажлыг дэмжихэд зориулалт гаргах ёстой юм.

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

► Чуулганы хэрэгцээг хангахын зэрэгцээ хүмүүсийг үүрэг хариуцлагаа үүрдэг болгохын тулд чуулганы гишүүд хэрхэн хамтарч ажиллах вэ?

► Танай чуулганы гишүүд хамтдаа ажиллаж, орлогын эх үүсвэрүүд бий болгож болох ямар боломжууд танай чуулганы эргэн тойронд байна вэ?

### **Залбирал**

Тэнгэрлэг Эцэг минь,

Миний хэрэгцээг хангана хэмээн амласан Танд баярлалаа. Өөрийгөө болон намайг түшиглэн амьдарч буй хүмүүсийн хэрэгцээний төлөө үүрэг хариуцлагаа итгэмжтэй үүрэхэд минь туслаач. Байгаа зүйлээ өгөөмрөөр өгдөг байхад минь туслаач. Бусдын хэрэгцээнд ухаалгаар тусалдаг байхад минь туслаач.

Би санхүүгийн ерөөлийг гуйж байна. Гэхдээ юунаас ч илүүгээр сүнслэг зүйлийг эрхэмлэж, Тантай харилцах харилцаандаа сэтгэл хангалуун байхыг хүсэж байна.

Амен

## 9-р хичээлийн даалгавар

(1) Энэ хичээлд өгөгдсөн Библийн зарчмуудын талаар залбирч, бодож тунгаагаарай. Дараах асуултад бичгээр хариул.

- Мөнгө ба нөөц боломжийн тал дээр би ямар уруу таталттай тулгардаг вэ?
- Одоо би мөнгө болон нөөц боломжийг хэрхэн олж авч байна вэ?
- Би мөнгө, нөөц боломжоо хэрхэн ашиглаж байна вэ?
- Мөнгө, орлогынхоо тал дээр Бурханд найдна гэж юу гэсэн үг вэ?
- Надад ямар орлогын эх үүсвэр байна вэ?
- Ирээдүйд бий болгох орлогын үүсвэрүүд надад бий юу? Хэрэв байгаа бол, би үүнийг хэрхэн ажил хэрэг болгох вэ?
- Би мөнгө, нөөц боломжоо яаж буруу ашиглаж байна вэ?
- Би дээр бичсэн мөнгө, нөөц боломжоо буруу ашиглаж байгаа байдлаа хэрхэн засах вэ?

(2) Энэ хичээлийн зарчмуудын талаар 1 хуудас толилуулга бич. Өөрийнхөө орчин нөхцөлд хэрэгжүүлж болох онцгой хэрэгжүүлэлтийг толилуулгадаа тусгаарай. Христэд итгэгчдийн мөнгөний талаарх ойлголтуудаас таны эргэн тойронд амьдардаг хүмүүс юу сурах, юу ойлгох хэрэгтэй вэ?

(3) Сургаалт үгс 3:13-17 эшлэлийг цээжил. Энэ эшлэлийг тунгаан бодож, нэг догол мөрөнд багтаан бич. Дараагийн хичээлийн эхэнд энэ эшлэлийг цээжээр бичиж, мөн бичсэн зүйлээ багшдаа хураалгана.



# 10-р хичээл

## Шударга байдал

### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагчид амьдралын бүх нөхцөл байдал, бүх үед шударга байх амлалт гаргана.

### Шударга хүн Абрахам Линкольн

Абрахам дэлгүүрт ажилладаг байв. Нэг өдөр хариулт мөнгөө дутуу өгснөө анзаарчээ. Гэтэл үйлчлүүлэгч хэдийн яваад өгсөн байв. Тэр эмэгтэй нэлээд хол хөдөөгийн бүсэд амьдардаг учраас түүнтэй дахиж мөд уулзахгүй гэдгээ Абрахам мэдэж байсан. Хэдийгээр хариулт бага мөнгө байсан боловч, тэр мөнгө мөнөөх эмэгтэйд хэрэгтэй байх гэж санаа зовлоо. Түүнээс гадна тэр эмэгтэй Абрахамыг санаатайгаар тэр мөнгийг авсан гэж бодуузай хэмээн бодсон тул тэр өдөр дэлгүүрээ хаагаад мөнгийг буцааж өгөхөөр хэдэн бээр газар явган алхжээ. Иймэрхүү нөхцөлд тэр дандаа ингэж хариуцлагатай ханддаг учраас найзууд нь түүнийг “Шударга Аби” гэж нэрлэдэг байжээ. Хожим нь тэрээр хуульч болж, засгийн газарт ажилласан юм. Түүний шударга байдал бусдын хүндэтгэлийг хүлээж, эцэстээ тэрээр АНУ-ын ерөнхийлөгч болсон билээ.

### Бурханы мөн чанар

Бурхан хэзээ ч худал хэлдэггүй гэж Библид хэлдэг (Тит 1:2, Еврей 6:18). Түүний мөн чанар үргэлж тогтвортой, хувиршгүй (Иаков 1:17) юм. Бурхан зөвхөн ашигтай үед л үнэнийг хэлдэг биш, мөн Тэрээр сайн үр дүнгийн төлөө ч худал хэлэхгүй. Бурханы Үг бол туйлын үнэн, найдаж болох үг гэдэгт бид итгэлтэй байж болно. Түүний үнэн бидэнд аюулгүй байдлыг өгдөг (Дуулал 40:11, Дуулал 91:4).

► Хэрэв та Бурхан үргэлж үнэнийг хэлдэг гэдэгт итгэдэггүй байсан бол Бурхантай харилцах харилцаа тань ямар байх байсан бол?

Бурхантай харилцах харилцаанд үнэн ямар чухал болохыг бодож үзээрэй. Бурхан биднийг Түүнд өөрсдийгөө бүрэн зориулахын төлөө дуудсан. Хэрэв бид бүрэн итгэж чадахгүй бол бүрэн зориулж чадахгүй.

### Бурханы үнэний хэм хэмжээ

Бурхан биднийг үргэлж үнэн ярьдаг байгаасай гэж хүсдэг. Худал хэлдэг хүн Бурханы мэлмийд зөвт бус (Сургаалт үгс 12:22).

Зарим хүн заргаа авахын тулд шүүхэд худал хэлдэг. Мөнгөтэй зарим хүн бусдын өмч хөрөнгийг авахын тулд худал мэдүүлэг өгчихөөд шүүгчийг хахуулдах явдал ч гардаг

(Иаков 2:6). Хөрөнгөтэй зарим хүн худал үгээ баталгаажуулахын тулд хээл хахууль өгч, шударга ёсыг тойрч, гэмгүй хүмүүсийг буруутгадаг (Иаков 5:1, 6).

Таны зөв гэж бодогдож байлаа ч, худал гэрчлэх нь нүгэл юм. Библид ямар ч онцгой нөхцөл байсан ч, худал гэрчийг буруутгадаг (Гэтлэл 20:16; Сургаалт үгс 6:16-19, Сургаалт үгс 14:25, Сургаалт үгс 19:5, 9). Хэрэв хор хохирол учруулахгүй, эсвэл сайн юмны төлөө бол худлаа хэлж болно гэж олон хүн боддог байх. Харин Библид үүнийг зөвшөөрдөггүй. Худлаа хэлж болох цаг үе гэж хэзээ ч байдаггүй гэдгийг Библи сургадаг.

Итгэгчид ямар ч тохиолдолд үнэнийг ярьдаг байх ёстой. Бидний харилцаанд үнэн зайлшгүй чухал (Ефес 4:25).

Ефес 4:15 эшлэлд үнэнийг ярих нь сүнслэг өсөлтөд хэрэгтэй гэжээ.

Колоссай 3:9-д худлаа хэлэх нь бидний тайлж орхисон нүгэлт амьдралын нэг хэсэг юм гэжээ.

Бурхан худалч хүмүүсийг шүүж, буруутгах болно. Бурханы хууль зааварт аймшигтайгаар буруушаасан зүйлсийн жагсаалтад худал хэлэх нь багтсан байна (1 Тимот 1:10, Илчлэл 22:15). Бүх худалч хүн тамын галд шидэгдэнэ (Илчлэл 21:8). Худалч хүмүүс Бурханы хотод орж чадахгүй (Илчлэл 21:27).

### **Ажил хэрэг, харилцаандаа шударга байдлыг баримтлах нь**

► Нэг суралцагч Сургаалт үгс 11:1 эшлэлийг бүлэгт уншина.

Энэ эшлэлд жимс, ногоо, мах зэрэг хүнсний бүтээгдэхүүн жинлэдэг хэмжүүрийн багажийн тухай ярьж байна. Зарим хүн илүү мөнгө авахын тулд жин хэмжүүрээ өөрчилсөн байдаг. Харин Бурхан ийм шударга бус байдлыг үзэн яддаг гэж энэ эшлэлд хэлж байна.

Түүнчлэн аливаа бүтээгдэхүүн зарахдаа бодит байдлыг нь худал хэлэх, эсвэл гажгийг нь нууж зарах буруу. Мөн худалдан авсан барааныхаа жинхэнэ үнийг худлаа хэлж, илүү үнээр зарах гэж оролдох ч бас буруу.

Мөнгө төлөхөөс зайлсхийж, хуурамч бичиг баримт дээр гарын үсэг зурах ч зөв зүйл биш. Ашиг олохын тулд хүмүүсийг хуурч байгаа дарга, захиралдаа туслах ч буруу.

► Таны ажигласнаар хүн хуурч мэхэлдэг өөр ямар ямар арга хэлбэрүүд байдаг вэ?

Буруу муу хүмүүс зээлж авсан мөнгөө буцааж төлдөггүй гэж Библид хэлдэг (Дуулал 37:21, Сургаалт үгс 3:28). Зарим хүн зээлж авчихаад эргүүлж төлөх үүрэг хариуцлагаа ер ухамсарладаггүй. Харин төлөх ёстой бүхнээ заавал төлж барагдуулах ёстой гэж Библид заажээ (Ром 13:7-8).

Ер нь амласнаа биелүүлж, хэлсэндээ хүрэхийг шударга байдал гэдэг. Дуулал 15-д Бурхантай зөв харилцаатай хүний тухай ингэж дүрсэлж байна. Өөрт нь хохиролтой байсан ч, амлалтаа биелүүлэх нь ийм хүний нэг зан чанар юм (Дуулал 15:4).

Түүнчлэн ажилд орчихоод хийх ёстойгоо хийхгүй, ажил олгогчоо хуурдаг бол, энэ ч бас шударга бус байдал мөн (Ефес 6:5-6).

Ажилчин хүн ажил олгогчийнхоо эд юмсыг хумслах нь буруу (Тит 2:9-10).

Худалдан авалт хийчихээд барааныхаа үнийг хуурамчаар нэмж, баримт падаан бичих буруу. Ажилтан, худалдааны зөвлөхүүд бараа зарахдаа зарах үнийг нь нэмж хэлээд, үнэ нэмэгдсэн мэтээр хууран мэхэлж мөнгө завшвал буруу.

Ажил олгогчид амласан цалин хөлсөө ажилчдадаа төлөхгүй бол буруу (Иаков 5:4).

Хэн нэг хүний хаяж гэсэн юмыг өөртөө авах нь буруу. Боломжтой бол эзэнд нь буцааж өгөх ёстой (Дэд хууль 22:1).

Хэрэв та бусдын хөрөнгө, нөөцийг (ажил олгогч юмуу чуулганы үйлчлэл) хариуцан удирдаж байгаа бол, мөнгө эд зүйлсийг зөвшөөрөлгүйгээр хувьдаа ашиглах нь буруу.

### **Шударга байхад саад болдог соёл уламжлалууд**

Зарим газар оронд хүмүүс овгийн ахлагчийнхаа халамж дор амьдардаг. Хүмүүс ахлагчдаа үнэнч байж, ахлагч нь хүмүүсийнхээ хэрэгцээнд туслах ёстой гэж тэд үздэг. Ийм нийгэмд олонх нь хувийн өмчгүй байх бөгөөд газар мэтийн хамгийн чухал өмч тухайн овгийн мэдэлд байна. Тиймээс удирдагчид эдгээр нөөцийг хүн бүрд ашигтай байхаар хуваарилах ёстой. Хэн нэгэн хүнд хэрэгцээ гарвал овгийн нөөцөөс хэрэглэх ёстой гэж тэд үздэг.

Гидеон ширэнгийн нэгэн тосгонд төржээ. Түүний гэр бүл болон тэр хавийн айлууд тосгоны эзэмшлийн газар дээр ногоо тариалж, хоол хүнсээ олдог байв. Түүнчлэн ширэнгэн ойгоос янз бүрийн хэрэгцээтэй зүйлсээ олж авна. Тэдний хэн нь ч байшин барилаа ч газраа эзэмшиж чаддаггүй байжээ. Хүнд бэрх үе ирэхэд айлууд бие биедээ тусална. Тосгоны ахлагч нь яг л эцэг хүн шиг байсан бөгөөд хүмүүс түүнийг өөрсдийнх нь хэрэгцээний төлөө санаа тавих ёстой гэж найддаг байжээ.

Гидеон насанд хүрээд мод бэлтгэлийн компанид ажилд оров. Тиймээс ажлынхаа ойролцоо амьдрахаар тосгоноосоо явлаа. Тэрээр сар бүр цалин авах боловч заримдаа хангалттай хоол хүнс ч үгүй байх нь элбэг. Учир нь цалингаа яаж зарцуулахыг Гидеон мэддэггүй байсан юм. Харин дарга нь түүнд хоол өгнө гэж бодсон бөгөөд хүн бүх зүйлийг өөрийнхөө мөнгөөр худалдаж авах ёстой гэж дарга нь хэлэх үед Гидеон маш их гайжээ. Удалгүй Гидеоны эгч өвдөж, эмч хэрэгтэй болов. Гидеон даргаасаа мөнгө гуйсан боловч дарга тусалсангүй. Үүнд Гидеон маш их уурласан байна. Түүний бодлоор дарга нь Гидеоны хүнд асуудал дээр тусламж үзүүлэх ёстой байв. Харин даргын хувьд цалингаа тавих нь л Гидеоны өмнө хүлээсэн цорын ганц хариуцлага хэмээн хэлжээ.

Даргыгаа хангалттай туслаагүй гэж үзсэн учраас Гидеон ажлаасаа гарч, зарим нэг багаж хэрэгслийг хулгайлан тосгон руугаа явжээ.

Гидеон хожим нь эхнэр хүүхэдтэйгээ хот руу нүүж, хүнсний том дэлгүүрт ажилд оров. Гидеон даргаасаа хүүхдийн сургуулийн төлбөр төлж өгөхийг гуйхад дарга нь төлж өгсөнгүй. Зарим үед гэр бүлийнхээ хэрэгцээнд зарцуулах мөнгө түүнд хүрэлцдэггүй байжээ. Тэрээр хоол хүнс зардаг дэлгүүрт ажилладаг учраас дэлгүүрийн бараанаас гэртээ авч харьж болно гэж бодсон байна. Гэхдээ дарга нь зөвшөөрөхгүй гэдгийг мэдэж байсан учраас хоол хүнсний бараанаас нууцаар авдаг болжээ.

Зарим ажилчид ажил олгож байгаа хүмүүсийнхээ ямар хариуцлага хүлээх, юуг хүлээхгүй талаарх хязгаарыг сайн ойлгодоггүй. Тэд ажилчныхаа бүх хэрэгцээг хариуцах нь ажил олгогчийн үүрэг гэж боддог аж. Тиймээс ажлын хөлснөөс гадна олон төрлийн тусламж гуйдаг. Хэрэв хэрэгтэй зүйлийг нь өгөхгүй бол, хулгайлаад авах нь зөв гэж тэд боддог. Яагаад гэвэл ажил олгогч нь ажилчдынхаа хэрэгтэй зүйлийг өгөх өртэй гэж тэд үздэг.

► Нэг суралцагч Тит 2:9-14 эшлэлийг бүлэгт уншина.

Дээрх эшлэлд ажилчин хүн ажил олгогчоосоо хулгай хийх ёсгүй гэдгийг сануулж байна. Харин 10-р эшлэлд шударга байдал нь христитгэлийг сайхан харагдуулна гэжээ. Улмаар дараагийн эшлэлд нигүүлслээр өөрчлөгдсөн хүний амьдрал ямар байх ёстойг дүрсэлж байна.

## **Найдвартай байдал**

Шударга байдал зөвхөн мөнгө хөрөнгөтэй холбоотой асуудал биш.

Калев хамтран ажиллагчтайгаа өглөөний 8:00 цагт уулзана хэмээн тохирчээ. Гэвч өглөө оройтож босоод, цайгаа уусаар бүтэн цаг гаруй хоцорч очив. Тэгээд хамтран ажиллагч хүндээ жолооч нь оройтож ирсэн учраас хоцорсон гэж хэлжээ. Харин хамтран ажиллагч нь үүнд ер гайхсангүй. Калебын бүх найзууд түүнийг хэлсэндээ хүрдэггүйг мэддэг аж.

Калев хоёр асуудал дээр шударга бус хандсан байна.

1. Тэр амласандаа хүрээгүй.
2. Хоцорсон шалтгааныхаа талаар худлаа хэлсэн.

Хүмүүс таныг ямар нэг ажлыг хийнэ, эсвэл ямар нэг газарт цагтаа очно гэж хэлэхэд итгэдэг үү? Та өөрөө бас тэгж хэлж байхдаа өөртөө итгэдэг үү? Хэрэв та ямар нэг юм амласан л бол, түүнийгээ биелүүлэхийн төлөө хичээл зүтгэл гаргана гэж давхар амлаж байгаа хэрэг. Амлалт өгчихөөд амласандаа хүрэхийн төлөө зүтгэхгүй байх нь буруу юм.

Хэрэв та амласандаа хүрээгүй бол уучлал гуйх ёстой. Мөн яагаад амлалтаа биелүүлж чадаагүй шалтгааныхаа талаар худал хэлэх ёсгүй.

Түүнчлэн алдаа гаргачихаад байгууллагынхаа хүмүүст алдаагаа тохих нь буруу. Хүмүүс таны алдаа байсныг мэдэх үедээ танд итгэхээ болино.

Итгэл даасан удирдагч хүн хүмүүсийг өөрийнхөө санаагаар дагуулахын тулд худлаа ярих гэж оролдохгүй. Стивен Кови "Бусдын итгэлийг төрүүлэх замаар үр дүнд хүрэхийг удирдахуй гэнэ" гэж хэлжээ.<sup>18</sup>

### **Харилцааны хүчин зүйл**

Олон хүн гэр бүл, садан төрлийнхөндөө худал хэлэх буруу гэж үздэг атлаа бусад хүмүүст худал хэлж болно гэж боддог. Зарим хүн өөрийгөө илүү цалин авах ёстой гэж үздэг учраас ажил олгогчоосоо мөнгө, эд зүйлс хулгайлдаг. Зарим хүн баячууд юмуу, гадаадын хүмүүсийн юмыг хулгай хийх нь зөв зүйл гэж боддог. Харин зарим нь өөр үндэстэн, эсвэл нийгмийн өөр давхаргын хүнтэй ажил хэргийн харилцаа үүсгэх үедээ шударга бус хэлцэл хийдэг.

Есүс хөршөө өөрийн адил хайрла гэсэн (Марк 12:31). Нэгэн хуульч Есүсээс "Миний хөрш гэдэг чинь хэн бэ?" гэж асууж байсныг санаарай (Лук 10:29). Тэр хуульч ямар төрлийн хүмүүсийг бид хайрлах ёстой талаар тодорхойлж өгөхийг Есүсээс хүссэн. Тиймээс Есүс "Сайн самари хүний тухай" сургаалт зүйрлэлийг ярьсан юм (Лук 10:30-37). Энэ бол анх удаа тааралдсан, өөр гаралтай хоёр хүний тухай түүх. Тэд өмнө нь ямар ч харилцаатай байгаагүйгээс гадна, тэдний үндэстнүүд хоорондоо зөрчилддөг байжээ. Самари хүн нөгөө хүний өмнө хүлээх ёстой ямар нэг хариуцлага байхгүй байсан ч, хэцүүдсэн тэр хүнд тусалсан юм. Есүс энэ түүхээр дамжуулан бидний хайрлах сэтгэлийн гадуур үлдэх ёстой хүн гэж байхгүй болохыг онцолжээ.

Бид хэнд шударга хандахаа өөрсдөө шийдэх ёсгүй. Зөвхөн сонгосон хүмүүстээ л шударга хандах ч ёсгүй. Бидний шударга бус байдал нөгөө хүнийг хохироохгүй байлаа ч, бид тэгж болохгүй. Яагаад гэвэл бид шударга байдлаараа Бурханд таалагдахыг хүсдэг (Үйлс 24:16, мөн Филиппой 1:10, 2 Коринт 5:9 эшлэлийг үз).

Та ямар хүн байхыг хүсэж байна вэ? Бурхан таныг ямар хүн байгаасай гэж хүсдэг вэ?

Хэн нэгэн хүн таны эелдэг харьцааг хүртэх эрхгүй мэт санагдаж болох ч, Бурхан таныг эелдэг байгаасай гэж хүсдэг. Хэн нэгэн хүн таны шударга байдлыг хүртэх эрхгүй мэт санагдаж болох ч, Бурхан таныг шударга байгаасай гэж хүсдэг. Хэн нэгэн хүн таны хайрыг хүртэх эрхгүй мэт танд санагдаж болох ч, Бурхан таныг хайрласан учраас, тэр хүнийг та бас хайрлаасай гэж хүсдэг.

► Суралцагчид 1 Петр 2:21-23, мөн 1 Петр 3:8-12 эшлэлийг бүлэгт уншина.

Бусдын гаргасан зан авираар та өөрийнхөө зан чанарыг битгий тодорхойлуул. Хүн танд худал хэллээ гээд та худал хэлэх ёсгүй. Хүн таны юмыг хулгайллаа гээд та өөрөө хулгай хийж болохгүй. Хүн танд бүдүүлэг хандаж ч болно. Гэсэн ч та хүндэтгэлтэй хандах ёстой юм.

---

<sup>18</sup> Stephen M. R. Covey. *The Speed of Trust: The One Thing That Changes Everything*. (New York: Free Press, 2006).

## Бодит амьдралын жишээ

Эдгээр жишээ нь бүгд бодит явдал бөгөөд нэрс болон зарим дэлгэрэнгүй мэдээллийг нь өөрчилсөн болно. Бүгд хулгай хийх, худал хэлэх юмуу хоёуланг нь хавсарсан жишээнүүд юм.

*Ангийн удирдагчид зориулсан тэмдэглэл: Суралцагчид жишээ бүрд юу болсон талаар сайн ойлгосон эсэхийг шалгаарай. Жишээнд дурдагдаж байгаа үйлдэл яагаад буруу гэдгийг суралцагчдаас асууж, тайлбарлуулаарай.*

1. Иаков үйлдвэрт ажилладаг. Тэр үргэлж цэвэрлэгээний материал, багаж хэрэгсэл, жижиг сажиг зүйлсийг гэр лүүгээ авч явдаг. Үйлдвэр угаасаа цэвэрлэгээний материал нэмж өгөхийг мэддэг учраас тэгдэг байжээ.
2. Петр нэгэн том компанид том машины жолооч хийдэг байв. Заримдаа машинтайгаа явж байгаад замын хажууд “Дизель худалдаж авна” гэсэн зар байхыг хардаг байв. Бага зэргийн түлш зарлаа гээд компани мэдэх боломжгүй учраас тэр машинаа зогсоож, бага зэрэг түлш зарчихдаг байжээ.
3. Естер ажилладаг компанийхаа компьютерын тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг хариуцдаг байв. Тэрээр дэлгүүрийн борлуулалтын ажилтнуудтай хуйвалдан худалдан авалтын үнийг өндөр бичүүлээд, зөрүү мөнгийг нь өөрөө авчээ.
4. Том хотын нэгэн цэцэрлэгт нэг хүн шатсан гэрлийн чийдэн зардаг. Худалдан авч байгаа хүмүүс нь тэр чийдэн ажиллахгүй гэдгийг мэднэ. Гэхдээ тэд худалдан аваад оффистоо аваачиж, сайн чийдэнг шатсан чийдэнгээр сольчихдог байжээ.
5. Амос бол сургуулийн захирал. Нэг өдөр нэгэн аав ирээд тооны хичээл дээр хүүдээ сайн дүн өгүүлэхийг хүсжээ. Тэгээд Амоос мөнгө өгсөн байна. Амос тэдний хүүхдэд сайн дүн тавихыг тооны багшаас шаарджээ.
6. Андрей бол их сургуулийн профессор. Түүний цалин бага. Тэрээр шалгалт маш хүнд байх учраас хариуг өөрөөс нь худалдаж авахгүй л бол хэн ч тэр шалгалтыг давахгүй гэж оюутнууддаа хэлжээ.
7. Аарон бол улсын сургуулийн захирал. Нэг өдөр сайнмэдээний үйлчлэлийн байгууллагад ажилладаг Филип гэх найз нь тэр сургуульд түрээслүүлэх өрөө байгаа эсэхийг асуужээ. Аарон үнэ тохирч, Филип мөнгөө сар бүр төлөх болов. Тэр мөнгийг Аарон хэзээ ч орлогод бүртгээгүй ажээ.
8. Филип сайнмэдээний нэгэн байгууллагад ажилладаг. Байгууллага нь өрөө түрээслэх шаардлагатай байсан тул тэрээр сургуулийн захирал, найз Аарон дээрээ очиж гуйсан байна. Тэд үнэ тохиролцсон боловч Филип байгууллагадаа илүү өндөр үнэ хэлжээ. Ингээд тэр сар бүр Ааронд түрээсээ төлөөд илүү мөнгийг нь өөртөө авдаг байв.

9. Сет шинэ байшин хэрэгтэй байгаа нэгэн сайнмэдээний үйлчлэлийн байгууллагад ажилладаг. Байгууллага нь барилга барих компани олохыг Сетэд даалгажээ. Сет хэд хэдэн барилгын компанитай ярьж үзсэн боловч, хамгийн сайн үнэ санал болгосон компанийг биш, харин байгууллагаас авах барилгын зардал мөнгөнөөс өөрт нь хувь өгөхийг амласан компанийг сонгожээ.
10. Бенжамин машинаа үзлэгт оруулах шаардлагатай байв. Гэвч зарим гэрэл нь ажиллахгүй байсан учраас үзлэгт тэнцэхгүй нь тодорхой байлаа. Тэгээд машинтайгаа үзлэгийн талбайд очтол, үзлэгт орж, бичиг баримтаа авахаар хүлээж буй машинуудын урт дараалал үүссэн байв. Үүдний ойролцоо зогсож байсан нэг хүн мөнгө өгвөл дараалал харгалзахгүй шууд үзлэгийн хуудсыг бөглөж өгнө гэж хэлэв. Бенжамин хэлсэн мөнгийг нь төлөөд тэр дороо баримт бичгээ авч чаджээ.
11. Симон машинаа зогсоолоос авахаар очжээ. Гэтэл зогсоолын ажилтан төлбөр нэхэв. Симон тэр ажилтанд арай бага мөнгө өгөөд, хариуд нь зогсоолын төлбөрийн баримт авахгүй гэжээ. Ингээд нөгөө ажилтан төлбөрийн баримтыг дараагийн машинд өгч, харин Симоны өгсөн мөнгийг өөртөө үлдээжээ.
12. Анна шалгалтдаа сайн бэлдээгүй байв. Тэгээд ангийнхаа онц сурлагатны хажууд суугаад шалгалтын хариуг нь хуулахыг хүсжээ.
13. Исаиа төрийн өмчийн том аж ахуйд трактор жолоодон газар хагалж байв. Тэрээр ажлаа эрт дуусгахыг хүсжээ. Тиймээс анжисны хошууг дээш өргөж, хөрсийг хагалах ёстой хэмжээнээс нь илүү гүехэн хагалав. Ингэснээр трактор илүү хурдан ажиллажээ. Мэдээж талбайг хагалсан мэт харагдаж байгаа ч, хөрсийг зохих ёсоор нь гүн хагалаагүй учраас ургац сайн ургаагүй.
14. Нэгэн сайнмэдээний байгууллага пастор Майклыг нэг чуулган руу илгээжээ. Сайнмэдээний байгууллага сар бүр түүнд цалин явуулж байв. Гэтэл пастор Майкл үйлчилж байгаа чуулганаасаа бас цалин авахыг хүсжээ. Тиймээс үйлчлэлийн байгууллага нь түүнийг дэмжихээ больсон гэж чуулганыхандаа хэлсэн байна.
15. Элизабетийн гэрт хулгай орж, мөнгөө алдав. Тэрээр энэ тухай найз нартаа ярихдаа хулгайчийг олон эд зүйл авсан гэж хэлсэн. Үнэндээ Элизабетэд байгаагүй эд зүйлсийг ч бас алдсан мэтээр ярьжээ. Найзууд нь түүнийг өрөвдөөд алдсан зүйлсээ дахиж авах мөнгө цуглуулж өгсөн байна.
16. Жэйсон бол жижиг тосгоны захирагч, бас тэр тосгоныхоо чуулганы удирдагч хүн юм. Тэндхийн хүмүүс боловсролгүй, бүдүүн бараг хүмүүс боловч, тосгон харин их том газартай байжээ. Гэтэл хотын бизнес эрхлэгчид ирээд тариалангийн төсөл хэрэгжүүлэх газар худалдан авах хүсэлтээ гаргажээ. Жэйсон тосгоны бүх газрыг зараад мөнгөөр нь хотод өөртөө байшин бариулжээ.
17. Фэйрфилдийн олон нийтийн чуулган жил бүр "Оны хүндэт ээж"-г шалгаруулдаг байв. Тэд Рэйчилийг чуулганд нь хандив өгнө гэдгийг мэдсэн учраас Рэйчилийг

сайн ээжийн жинхэнэ үлгэр дуурайл хэмээн тооцож, хүндэт ээжээр шалгаруулав. Энэ хүндэтгэлийн дараа Рэйчил тэр чуулганд хандив өргөж, шинэ хаалга авахад нь тусалжээ. Дараа жил нь тэр эмэгтэй мөнөөх хотоос нүүсэн боловч, чуулганыхан нь дахиад л түүнийг “Оны шилдэг ээж”-ээр шалгаруулахаар шийджээ.

18. Бартолмэй нэгэн сайнмэдээний үйлчлэлийн байгууллагад жолооч хийдэг. Тиймээс орой бүр байгууллагын машиныг авч аюулгүй газар байрлуулдаг байв. Заримдаа машинаа зогсоолд байрлуулахаас өмнө хүн хүргэх, эсвэл бараа зөөхөд машиныг хувьдаа ашигладаг байжээ.

### **Шударга бус байдлыг улс үндэстнээрээ амссан гунигт түүх**

Энэ түүх зохиомол боловч олон газар ийм явдал тохиолдсон байдаг.

Borol хотын итгэгчид зэргэлдээх аймагт нь маш олон ядуу хүн амьдардаг бүс нутаг байгааг олж мэджээ. Тэр нутгийн хүмүүс Ibanese гэх угсаатан байв. Ibanese угсаатнууд хэдэн үеэрээ эрт дээр үеийн байдлаар амьдарч, эмнэлгийн болон боловсролын тусламж үйлчилгээ авч чаддаггүй байжээ. Олонх нь хангалттай хоол хүнсгүй, зарим нь бүр өлсгөлөнд нэрвэгдсэн байв.

Ингээд Borol-ын итгэгчид Ibanese хүмүүст туслахаар мөнгө цуглуулав. Тэд чуулганаасаа төлөөлөгчид явуулж, бусад бүс нутгийн чуулгануудаас ч бас хандив гуйжээ.

Borol-ын итгэгчид Ibanese хүмүүст машин машинаар дүүрэн хоол хүнсний бараа илгээж эхэллээ. Тэр хүнсийг тараах ажлыг Ibanese-ийн чуулганы удирдагчдад хариуцуулав.

Харин Ibanese-ийн чуулганы удирдагчид ирсэн хүнсийг зарж борлуулахаар худалдааны цэгүүд байгуулжээ. Ингээд зөвхөн мөнгөтэй хүмүүс л хүнс худалдан авч, харин өлсгөлөнд нэрвэгдсэн хүмүүст юу ч очсонгүй. Зарим хүнсийг нь илүү үнэ төлж чадах өөр улсад зарахаар гадаад руу ачуулжээ. Олсон ашгийг чуулганы удирдагчид найзуудтайгаа хувааж авсан байна.

Харин Borol-ын итгэгчид хүнсийг яг хэрэгтэй байгаа хүмүүст нь үнэгүй өгөхийг шаардаж байв. Ibanese-ийн чуулганы удирдагчид жолоочтой ачааны машин түрээслэх, туслах хүмүүсийн цалин гэх мэт зардлыг тусгасан хүнс тараах ажлын төсөв боловсруулжээ. Ингэхдээ гарах зардлыг ердийнхөөс илүү өндөр тогтоож, илүү мөнгийг нь өөрсдөө авчээ. Borol-ын итгэгчид тайлан шаардах үед Ibanese-ийн чуулганы удирдагчид худлаа тайлан явуулжээ.

Тэдний шударга бус үйлдлийг илрүүлэх бүрдээ Borol-ын итгэгчид бухимдан урам нь хугардаг байв. Тэд Ibanese-ийн өөр удирдагчидтай холбоо тогтоож, энэ ажил дээр тусалцаа авах гэж оролдсон боловч мөн адил асуудлуудтай тулгарчээ. Ингээд Borol-ын олон итгэгчид хандив өгөхөө болив. Зарим нь өгсөөр л байлаа. Цөөн хэдэн Ibanese пастор Borol-ын итгэгчдийн дэмжлэгээр сайхан машин, орон байртай болжээ. Тиймээс

бусад пасторууд нь атаархаж, Вогол-ын итгэгчидтэй холбоо тогтоохыг хүссэн байна. Харин өлсгөлөнд нэрвэгдсэн алслагдсан нутгийн хүмүүсийн олонх нь хэзээ ч тусламж авч чадаагүй юм.

### **Төгсгөлийн жишээ**

Воррен Баффет бол Berkshire Hathaway компанийн гүйцэтгэх захирал байсан хүн. Тэрээр Walmart-ын эзэмшиж байсан McLane гэх түгээлтийн компанийг худалдан авахыг хүсжээ. Худалдан авах үнэ 23 тэрбум доллар болов. Ердийн үед ийм том наймаа хийхийн тулд бүх бичиг баримтыг шалгасаар хэдэн сарыг зарцуулдаг. Харин Воррен Баффет Walmart-ын удирдлагуудтай ганц удаа уулзаад, шууд гэрээ байгуулсан аж. Тэрээр өмчийг шалгуулахаар хэн нэгнийг явуулаагүй. Хожим тэрээр “Би бүх зүйлийг Walmart-ын удирдагчдын хэлсний дагуу байгаа гэдэгт итгэсэн. Үнэхээр ч тийм байсан” гэж хэлсэн байдаг. Энд удирдагчид бие биедээ итгэж байсан учраас энэхүү асар том худалдан авалтын гэрээ хэлэлцээр маш хурдан дууссан байна.<sup>19</sup>

Одоо өмнө өгүүлсэн жишээний тухай бодоорой. Тэд итгэл даах хүмүүс байгаагүй учраас тэдний хэн нь ч ийм төрлийн гэрээ хэлэлцээр байгуулж чадахгүй. Яагаад гэвэл бүх зүйлийг нь шалгах гэсээр асар их цаг хугацаа, зардал мөнгө зарцуулагдах байсан.

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

- ▶ Зайлсхийхэд хэцүү шударга бус ямар зан заншил танай соёл уламжлалд байдаг вэ?
- ▶ Үүнийг өөрчлөхийн тулд та ямар дадал зуршлыг хэрэгжүүлэх хэрэгтэй вэ?

### **Залбирал**

Тэнгэрлэг Эцэг минь,

Та бол зөвт байдал хийгээд үнэний Бурхан учраас Таныгаа хүндэтгэн магъя. Та бидэнтэй үргэлж үнэнээр харилцдаг учраас баярлалаа.

Таны тогтоосон шударга байдлын хэм хэмжээг дагах хүчийг бидэнд өгөөч. Хэлж ярьж, хийж байгаа бүх зүйлдээ үнэнч шударга байх зарчмуудыг хэрэгжүүлэхэд Та бидэнд туслаач.

Биднийг хангаж, замчилж өгдөг Эцэг минь болсонд баярлалаа. Та биднийг анхааран халамжилна гэдэгт бид итгэж найдахыг хүсэж байна.

Амен

---

<sup>19</sup> Stephen M. R. Covey. *The Speed of Trust: The One Thing That Changes Everything*. (New York: Free Press, 2006), 15

## 10-р хичээлийн даалгавар

(1) Дараах даалгавар тус бүр дээр нэг догол мөр бич.

- Бурханы зан чанар (үнэн) болон Бурханаас бидэнд тавьсан хэм хэмжээ (шударга байх) хоёрын уялдаа холбоог тайлбарла. Бурхан яагаад биднийг бүхий л харилцаандаа үнэн шударгаар хэлж ярьж байхыг шаарддаг вэ? Үүнийг тайлбарлана уу!
- Библи шударга байдлын талаар юу хэлсэн байдгийг товч дүгнэж бич. Дүгнэлтдээ багадаа 3 эшлэл ашиглаарай.
- Шударга ба шударга бус байдал бусадтай харилцах харилцаанд хэрхэн нөлөөлдөг талаар багадаа 4 жишээ авч тайлбарла.

(2) Үнэнч шударга байдлын талаарх Библийн зарчмыг өөрийнхөө нутгийн соёл уламжлал дунд танилцуулах толилуулга бэлтгэ. Бурханы хэм хэмжээний талаарх Библийн үндэслэлийг тайлбарлаад, тодорхой нөхцөл байдалд хэрхэн хэрэгжүүлж болохыг тайлбарла.

# 11-р хичээл

## Хүмүүний үнэ цэн

### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах ойлголт, чадварт суралцсан байна:

- (1) Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн учраас хүн бүр үнэ цэнтэй, хүндлэгдэх эрхтэй
- (2) Таны эргэн тойронд зүй бус харилцаанаас болж гадуурхагдаж байгаа хүмүүсийн төлөө шударга ёс, энэрэнгүй сэтгэлийн тусыг үзүүлэх үүрэг хариуцлагыг гартаа авах
- (3) Ямар ч нөхцөлд бүх хүнд хүн ёсоор хүндэтгэлтэй хандах шийдвэр гаргах гэх мэт

### Хүмүүний үнэ цэнийг эрхэмлэгч Дэйл Карнеги,

Дэйл Карнеги *How to Win Friends and Influence People* [Нөхдөө өөртөө татаж, бусдад нөлөөлөх нь] гэдэг номоороо их алдаршжээ. Тэрээр хүн бүрийг угаасаа үнэ цэнтэй учраас анхаарал, хүндэтгэлийг хүлээх ёстой гэж үздэг байв. Түүний зарчмуудыг зааж сургах зорилгоор Dale Carnegie Institute байгуулагдсан юм.

Нэгэн удаа Dale Carnegie Institute бизнес эрхлэгчдэд зориулсан оройн анги нээж, хүмүүстэй хэрхэн найрсаг байж, харилцаа тогтоох талаар заажээ. Суралцагчид дараа нь шалгалт өгөх үедээ нэг асуултад ихэд гайхав. Тэрхүү санаанд оромгүй асуулт нь “Таныг ангиас гарах бүрд коридорыг цэвэрлэж байдаг эмэгтэйн нэр хэн бэ?” гэсэн асуулт байв. Суралцагчид хичээл тараад гэртээ харихаар олон удаа тэр эмэгтэйн хажуугаар зөрж өнгөрч байсан. Гэхдээ ер анхаарал хандуулж байсангүй. Уг нь тэд хүмүүстэй найрсаг харилцаж, холбоо харилцаа тогтоох хичээлд сууж байсан шүү дээ. Тэд шинээр сурсан чадвараа зөвхөн чухал хүмүүстэй харилцаа тогтооход л ашиглах ёстой гэж бодсон байж.

### Христигэл дэх хүмүүний үнэ цэн

Есүс Христэд итгэлээ өгсөн бүх хүн “Христийн бие”-ийн эрхтэн юм. Тиймээс “Иудей ч, грек ч гэж байхгүй, боол ч, чөлөөт хүн ч гэж байхгүй, эр ч, эм ч гэж байхгүй. Та нар бүгд Христ Есүс дотор нэг болой” (Галат 3:28) гэжээ.

Лукийн сайнмэдээнд нэгэн хуульч Есүстэй ярилцсан түүх бий. Тэр хүн хөршөө өөрийн адил хайрлах ёстой хуулийг мэддэг боловч, тэрхүү хайр нь зөвхөн тодорхой хэсэг бүлэг хүмүүст л хамаарна гэж боддог байсан юм. Тиймээс тэр хүн Есүсээс “Миний хөрш гэдэг чинь хэн бэ?” (Лук 10:29) гэж асуусан байдаг. Үүгээр тэр хүн бүх хүнийг хайрлах шаардлагагүй гэж боддог байсан нь харагдаж байна.

Ямар ч соёлоос гаралтай байсан, хүмүүс бүгд ёс суртахууны тал дээр төстэй ойлголттой байдаг. Хулгай, аллага, дарлал буруу гэдгийг бүгд мэднэ. Гэвч хүн бүртэй шударга

харилцах ёстой гэдгийг сайн ухаардаггүй. Хүмүүс магадгүй найз нөхдөөсөө хулгай хийдэггүй байж болох ч, танихгүй хүний юмыг хулгайлдаг. Магадгүй өөрийнхөө үндэстний хүнийг хөнөөхгүй байж болох ч, харийн хүмүүсийг хөнөөх боломжтой. Магадгүй хамаатан саднаа дарладаггүй боловч, үзэн яддаг өөр угсаатны хүмүүсээ дарладаг.

Харин Христийн дагалдагчид хүн бүрийг Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн учраас үнэ цэнтэй гэж үздэг.

Бичвэрийг харвал, тэнгэрэлч нар хүнд үзэгдэх бүрдээ эхлээд “Битгий ай” гэж хэлсэн байдаг. Яагаад гэвэл тэнгэрэлч нарын оршихуй сүр хүчтэй, гайхамшигтай байдаг гэсэн үг. Зарим хүн тэнгэрэлч нарын өмнө өвдөг сөхөрч, мөргөж хүндлэхээр сандарч байсан.<sup>20</sup> Гэтэл хүмүүс өөрсдөө тэнгэрэлч нараас илүү чухал оршихуй юм (1 Коринт 6:3).

Магадгүй нийгмийн доод давхаргын, гуйлгачин, боловсролгүй, ухаан муутай, хүмүүжил муутай, чадваргүй, нөлөөгүй, гадаад төрх нь муухай, зэвүүн зан чанартай хүнтэй та тааралдаж болно. Гэсэн ч тэр хүн сайнмэдээг хүлээн авч, мөнхийн үр дүнд хүргэх шийдвэрийг гаргаж болно. Хэрэв тэр хүн Бурханаар аврагдвал, газар дээр бидний харж байсан ямар ч агуу хүнээс илүү агуу байх болно.<sup>21</sup> Тиймээс түүнийг хүндэтгэх ёстой.

► Нэг суралцагч Галат 3:28 эшлэлийг бүлэгт уншина.

Энэ эшлэлд хүмүүсийг яс үндэс, нийгмийн анги давхарга, хүйс гэх гурван ангилалд хуваажээ. Нийгмийн анги давхарга нь санхүүгийн байдлыг хамаардаг. Түүнчлэн бид мөн нас, боловсролын түвшин, ур чадвар гэх мэт бусад олон ангиллыг нэмж болно. Гэхдээ эдгээр ангиллын аль нь ч хүнийг үнэлэх Бурханы үнэ цэнд нөлөөлөх ёсгүй юм.

► Хэн нэгэн хүн бусдаасаа илүү үнэ цэнтэй байж болох уу? Тайлбарлана уу!

Мэдээж ухаантай, боловсролтой, чадвартай, хүчтэй, удирдах туршлагатай, эсвэл мөнгөтэй хүн зарим ажлыг гүйцэтгэхэд илүү хэрэг болж болно. Гэвч ийм давуу талуудаас нь болоод хэн нэгэн хүнийг бусдаас илүү үнэ цэнтэй хүн гэж үзэх нь буруу. Энд дурдсан ур чадварууд нь нийгэмд ашиг тустай чадварууд мөн боловч, Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн хүмүүний мөн чанарт мөнхийн үнэ цэн агуулагддаг.

## Ялгаварлан гадуурхах

Хүмүүс зарим ястан үндэстний хүмүүсийг ийм тийм зан чанартай гэж боддог. Заримдаа ийм үгийг арьс өнгөтэй нь холбож “Цагаан арьстнууд үргэлж \_\_\_\_\_” эсвэл “Хар арьстнууд бүгд \_\_\_\_\_” гэх мэтээр ярьдаг.

<sup>20</sup> Нэгэн жишээ: Илчлэл 22:8-9, “Иохан, би бол эдгээр зүйлсийг үзэж, сонссон нэгэн юм. Би үзэж, сонсоод эдгээр зүйлсийг надад үзүүлсэн тэнгэрэлчид мөргөхөөр хөлд нь унав. Тэр надад —Үзэгтүн, бүү ингэ. Би бол чиний болон эш үзүүлэгч ах дүүсийн чинь, мөн энэхүү номын үгсийг сахигсдын хамтран зүтгэгч боол билээ. Бурханд мөргө гэв”

<sup>21</sup> Амилал тохиох үед Христэд итгэгч хүмүүсийн бие махбод ямар гайхамшигтай хувирах талаар 1 Коринт 15-р бүлэгт тайлбарласан байдаг.

Заримдаа иймэрхүү үгийг улс үндэстнээр нь хамааруулж, гаитичууд шиг ийм, германчууд тийм, япончууд ингэдэг гэх мэтээр ярьдаг. Заримдаа улс дотроо тодорхой угсаатан ястнаар нь хамруулж муулдаг.

Иймэрхүү маягаар хэсэг бүлэг хүмүүсийг хочилсон үг яриа нь цөөн тооны магтаалыг агуулах боловч ихэнхдээ муулсан өнгө аястай байдаг. Тиймээс тухайн үндэстэн, ястны хүмүүст бүгдэд нь адилхан дутагдал байгаа гэж үздэг.

Энд өөр үндэстэн, ястан, хэсэг бүлэг хүмүүсийг муулж хэлсэн жишээг жагсаалаа. Хоосон зайд ямар хүмүүсийн тухай хэлж байгааг бичнэ үү.

- \_\_\_\_\_ залхуу.
- \_\_\_\_\_ дандаа архиддаг.
- \_\_\_\_\_ боломж гарвал хулгай хийдэг.
- \_\_\_\_\_ үргэлж зодоон хийдэг.
- \_\_\_\_\_ хэзээ ч ажлаа олигтой хийдэггүй.
- \_\_\_\_\_ хичээл номдоо толгой муутай.
- \_\_\_\_\_ түргэн ууртай.
- \_\_\_\_\_ үргэлж худлаа ярьдаг.

Мэдээж үндэс угсааны ялгаатай тал дан ганц гадаад төрхөөр зогсохгүй. Зарим угсаатнууд биеийн болон оюуны чадвараасаа шалтгаалаад зарим спорт, эсвэл тодорхой зарим төрлийн ажилд илүү чадварлаг байж болно.

Бүх үндэстэн ястанд өөрийн гэсэн соёлын онцлог бий. Соёл хүнийг тодорхой нөхцөл байдалд тодорхой төрлийн хариу үзүүлэхэд сургадаг учраас бид зарим өөр соёлтой хүмүүсийн гаргадаг нийтлэг хариу үйлдлийг нь мэддэг.

Мэдээж гадаад төрхийн ялгаа болон соёлын онцлогийг анзаарах нь буруу зүйл биш. Гэхдээ угсаа гарвал, үндэс соёлоор нь хүний зан чанарыг тодорхойлох буруу. Аль ч үндэс угсааны хүмүүс дунд бурханлаг, үнэнч шударга, элэгсэг хүмүүс байдаг. Тиймээс хувь хүнийх нь хувьд мэдэхгүй байж, үндэс угсаанаас нь болж хүнийг ийм тийм зан авиртай биз гэж бодох нь буруу.

Бидний амссан туршлага бусдыг хэрхэн харж дүгнэхэд маань нөлөөлдөг. Хэрэв хүн өөр үндэстний хүмүүсээс муу харилцаа хандлага мэдэрсэн бол, эхэндээ тухайн үндэстний бүх хүнийг тиймэрхүү гэж бодож магадгүй. Иймэрхүү байдлаар тухайн үндэстний хүмүүсээс дахин дахин муу харилцаа хандлагыг хүлээж авах юмуу, бага насанд нь ийм үйл явдал олон тохиолдсон бол тэднийг муугаар бодох нь улам хүчтэй болдог.

Хоёр угсаатны хооронд удаан хугацаанд үргэлжилсэн зөрчил мөргөлдөөнөөс болж, нөгөө үндэстэн угсаатнаа ялгаварлан гадуурхах хандлагатай үе үеийн хүмүүс бий болдог.

Түүнчлэн насанд хүрэгчид ямар нэг үндэстэн угсаатны талаар сайн муу үг ярьж байхыг байнга сонсдог хүүхэд тэр үндэстэн угсаатны талаар яг тийм ойлголтыг авдаг.

Итгэгч хүн бусад үндэстэн угсаатан, хэсэг бүлэг хүмүүсийн талаар ямар хандлагатай байдгаа өөрөө шалгаж, шударга байдал, хайрыг үзүүлж чадахын төлөө Бурханд залбирах ёстой. Бурхан бидэнд санаа тавьдаг шигээ тэдэнд ч бас санаа тавьдаг тул бидний шударга бус хандлагыг таашаахгүй гэдгийг санаарай.

### **Үйлчлэл дэх ялгаварлал**

Хуучин гэрээний Ионагийн түүх их сургамжтай. Тэрээр яагаад Бурханаас зугтсан тухайгаа ингэж тайлбарлажээ.

ЭЗЭНд залбирч —Өө ЭЗЭН, би нутагтаа байхдаа хэлээгүй бил үү? Таныг нигүүлсэнгүй Бурхан мөн өрөвч, уурлахдаа удаан, хайр энэрлээр бялхам, гай гамшгийг зөөлрүүлэгч Нэгэн гэдгийг би мэднэ. Иймд би Таршиш руу хурдхан зугтсан юм. Одоо ЭЗЭН! Амийг минь аваач, амьд явснаас үхсэн минь дээр гэв. (Иона 4:2-3).

Иона ассирчуудыг маш ихээр үзэн яддаг байв. Тиймээс Ионаг Ниневе хотод үйлчлүүлэхээр дуудаж байгаа нь Бурхан тэдэнд нигүүлсэнгүй хандаж магад гэж тэр бодоод зугтжээ.

Ер нь арьс өнгө, угсаа гарвал бол Библиэс гарсан ойлголт биш. Харин Библид “Бурхан газрын цээжээр амьдруулахаар нэг хүнээс хүмүүн төрөлхтний үндэстэн бүрийг бүтээж, тэдний цаг хугацаа болон нутаглах хил хязгаарыг тогтоож өгсөн нь” (Үйлс 17:26) гэж хэлснээрээ бүх хүн төрөлхтнийг нэг л “хүмүүн төрөлхтөн” гэж үзэж байна.

Бурхан газар дэлхийн бүх үндэстэн угсаатанд сайнмэдээг хүргэх дуудлагыг итгэгчдэд өгсөн (Үйлс 1:8). Ямар үндэстэн байх нь хамаагүй, бүх хүний сүнс бүгд адилхан.

### **Үл хүндлэгддэг төрлийн хүмүүс**

Хүмүүс энэ ертөнцийн зүйлс, ертөнцийн эрхэмлэдэг юмсыг амархан хүлээн зөвшөөрдөг учраас хүмүүний үнэ цэнийг буруу шалгуураар тогтоох гэж оролддог. Дэлхийн олон улсад зарим төрлийн хүмүүсийг чухал биш ангилалд оруулж, хүнээс дор харьцдаг.

Энд янз бүрийн улсын тодорхой хэсэг бүлэг хүмүүсийг хэрхэн ялгаварлаж харьцдаг байсан жишээнүүдийг жагсаалаа. Зарим нь түүхэн үйл явдал, зарим нь одоо ч байсаар байгаа үйл явдал юм.

Зарим хүмүүсийг үл хүндэтгэж буй бодит жишээг дурдвал:

- Настай хүмүүсийг ашиггүй гэж үзээд үхэх хүртэл нь тусгаарлан орхидог,
- Өөр үндэс угсаатай хүмүүсийг боол болгон эзэмшиж, хүссэнээрээ харьцах,
- Зарим үндэс угсааны хүмүүсийг зарим ажилд авахгүй хэмээн зарлах,
- Эмэгтэйчүүдийг өмч гэж үзэж, нөхөр нь хүссэнээрээ харьцах,
- Зарим айл нярай охидыг хүү биш учраас үхүүлэхээр гадаа хаях,

- Зарим тодорхой бүс нутагт амьдарч байгаа тодорхой нэг угсаатан ястныг хүйс тэмтрэхийн тулд тухайн улсын засгийн газраас цэрэг илгээх,
- Сэтгэцийн өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй төрсөн учраас зарим хүүхдийг хаях,
- Зарим улсад эмэгтэйчүүдийг машин барих, их сургуульд сурахыг хориглох хууль гаргах,
- Улсын зонхилох үндэстний хэлээр ярих, харин сургуульд байхдаа хэрэглэж байсан хэл аялгаараа төр засгийн байгууллагад ярих эрхгүй байх,
- Африк биш, англи нэртэй хүнийг ажилд авах,
- Эцэг нь охиноо боолчлол, биеийг нь үнэлүүлэхээр худалдах,
- Ээжүүд хүүхэдтэй болоход бэлэн биш гэх шалтгаанаар төрөхөөс нь өмнө аборт хийлгэх,

гэх мэт олон жишээг дурдаж болно. Зарим философи, шашны урсгалынхан зарим төрлийн хүмүүстэй ялгаварлан харьцахыг зөвшөөрдөг.

Хувьслын онолд итгэгчид хүмүүсийг Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн гэдэгт итгэдэггүй. Тэдний хувьд эртний хүмүүс хоорондоо өрсөлдөн тэмцэлдэж, оюуны чадвараар сул доройгоо устгасаар орчин үеийн хүн бий болсон гэж үздэг. Тэд “зохицож, шалгарч чадсан” нь амьд үлддэг зарчим хүнийг бий болгосон гэж боддог. Хэрэв энэ онол үнэн юм бол, хүн төрөлхтөн сул доройчуудаа цаашид ч устгах нь зөв гэх санаа харагдаж байна. Харин хүмүүн бол Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн, тэр хэрээрээ Бурханд онцгой бүтээл гэдгийг бид мэднэ.

Дэлхийн олон улс оронд эмч нар үр хөндөхийг зөвшөөрдөг. Зарим засгийн газар хүн амын хэт өсөлтөөс болоод төрөхөөс нь өмнө хүүхдийг аборт хийхийг шаарддаг ч тохиолдол байна. Олонх улсад эхчүүд хүүхэд төрүүлэх нөхцөл бололцоо байхгүй гээд хэвлий дэх хүүхдээ авахуулахыг хүсдэг. Өөрөөр хэлбэл төрөөгүй хүүхдэд Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн хүн биш, үнэ цэнгүй юм мэтээр хандаж байна гэсэн үг. Төрөөгүй хүүхдүүд өөрсдийгөө хамгаалж ярьж, дуугарч чадахгүй учраас тэдний эрхийг зөрчиж байгаа хэрэг юм.

Хиндү болон буддын шашинд хүмүүсийг урьд насандаа хийсэн нүглээсээ болж зовдог гэж үздэг. Тиймээс дарлагдан зовж байгаа хүмүүсийг хүртэх ёстойгоо хүртэж байна гэж боддог. Тэднийхээр бол зовж байгаа хүн зовлонгоо сайн тэсвэл, дараагийн төрөлдөө илүү сайхан амьдрах аж. Ийм шашнууд дарлагдаж зовсон хүнд туслах ёстой үндэслэлийг хэлж өгөхгүй. Харин тухайн зовж байгаа хүнийг зайлшгүй туулах ёстой замаа туулж байна гэж үздэг.

Буруу шашин, философиос болж хүмүүсийн зарим хэсэг нь аймшигтай доромжлол амсан амьдарч байна. Түүнчлэн зарим улсуудад ноцтой шударга бүс байдлыг хэвийн мэт хүлээн зөвшөөрч байна. Харин итгэгчид өөр юм. Библийн сургаалд хүнийг Бурханы

дүр төрхөөр бүтээгдсэн гэж үздэг. Энэ бол хүмүүний үнэ цэнийг батлах хангалттай үндэслэл мөн.

► Танай нийгэмд ямар хүмүүсийг үл хүндэтгэх нь хэвийн зүйл мэт байдаг вэ?

### **Сайн хөрш**

Есүсийн ярьсан олон сургаалт зүйрлэлийн адилаар энэ сургаалт зүйрлэл ч бас сонсож буй хүмүүсийг цочирдуулсан юм (Лук 10:29-37). Шархадсан хүний дэргэдүүр тахилч болон леви хүмүүс туслахгүй зүгээр өнгөрч одсон тухай ярихад хэн ч гайхаагүй. Эндээс хүмүүс тахилч ба левичүүдийг мөнгө, эрх мэдлээс болж гажуудсан гэж үздэг байсан нь харагдаж байна. Уул нь тэд иудейн шашны гол хөдөлгөгч хүчин байсан.

Сонсогчид гурав дахь хүнийг энэ түүхийн гол баатар гэж хүлээж байтал, тэр нь самари хүн байх нь тэр. Самаричууд нь иудей болон өөр үндэстэнтэй цус холилдсон, шашны ойлголт нь ч бас холилдсон үзэл санаатай хүмүүс байжээ. Тиймээс иудейчүүд тэднийг жигшдэг байв.

Нэг хуульч Есүсээс “Миний хөрш гэдэг чинь хэн бэ?” гэж асууж байсныг эргэн санаарай. Тэр хүн хайрлах ёстой хүмүүсийнхээ хүрээг нарийвчлан тогтоохыг хүссэн учраас Есүсээр үүнийг хэлүүлэхийг хүссэн хэрэг. Тэр хуульч дэлхийн ихэнх хүмүүсийн нэгэн адил ёс суртахууны үүрэг хариуцлага нь зөвхөн тодорхой хэсэг бүлэг хүмүүст л хамаарах бөгөөд өөр бусад бүлгийн хүмүүст анхаарал тавих ёсгүй гэж бодож байсан юм.

Харин ямар ч хүнд анхаарал халамж тавих ёстой гэсэн санаа Есүсийн хариултад байсан юм. Бидэнтэй тааралддаг хүн бүр бидний хөрш. Гэхдээ Есүс хэний ч асуугаагүй асуулт болох “Миний хөрш гэж хэн бэ?” юмуу “Ямар хүн ийм хайрыг бусдад үзүүлж чаддаг вэ?” гэх асуултад бас хариулсан. Нийгэмд үл тоогддог хүн ч Бурханыг баярлуулж, Бурханы хүссэн хайрыг харуулж чаддаг гэдгийг Есүс үүгээр илэрхийлсэн юм.

Чуулганыхан энэ ертөнцийн хэм хэмжүүрээр хүнд хандаж болохгүй гэж элч Иаков анхааруулсан байдаг.

► Нэг суралцагч Иаков 2:1-9 эшлэлийг бүлэгт уншина. Таны бодлоор чуулганууд энэ хэсэгт гарсантай төстэй ямар зүйл хийдэг вэ?

Энэ ертөнцөд чухал гэж тооцогддог олон хүн Бурханы хүндлэлийг хүлээхээр хүмүүс биш байхад, Бурханыг баярлуулдаг олон хүн энэ ертөнцөд үнэ хүндгүй байх нь бий. Үүрд мөнхийн цаг ирэхэд олон хүний байр суурь эсрэгээрээ солигдоно гэж Есүс хэлсэн. (Матай 19:30).

Христэд итгэгч ахан дүүс хамтдаа цуглах үед энэ ертөнцөд байр суурьгүй ядуу нэгэн байр суурийг олдог бол, харин энэ ертөнцийн хувьд байр суурьтай баян хүн байр сууриа алдаж байдаг. Баян хүн мөнгөтэй учраас бусдаас дээгүүр тооцогдох ёсгүй юм (Иаков 1:9-10).

## **Боолчлол**

Өөр хүний өмч хөрөнгө гэж тооцогддог хүнийг боол гэнэ. Боолчлолыг зөвшөөрдөг улс оронд боол хүнд ямар ч хүний эрх байхгүй. Эзэн нь боолыг амьтан, эсвэл машин тэрэг мэт үзэж, хүссэнээрээ харьцана. Боолын хүсэл зорилго нь эзнийхээ л хүсэлд захирагдах. Нөхөр эхнэрийг хол байлгах, хүүхдүүдийг эцэг эхээс нь салгаж авах зэргийг эзэн нь хийж болдог аж.

Хуучин гэрээнд Бурхан боолчлолыг хязгаарлаж, боолын эрхийг тодорхой хэмжээгээр хамгаалж байсан (Гэтлэл 21:1-11, 26-27). Тухайн үед боолын эрхийн төлөө санаа тавих гэдэг ойлголт бараг байдаггүй байжээ. Харин Шинэ гэрээнд Бурхан өөрийгөө бүх хүн төрөлхтний Эзэн бөгөөд хэнийг ч байр сууринаас нь хамаарч онцгойлохгүй гэсэн. Түүнчлэн боолын эзэд эелдэг, шударга байх ёстой гэж хэлсэн байна (Ефес 6:9). Боол хүнтэй хүн ёсоор харьцах ёстой гэсэн Библийн зарчмаас хамгийн их нөлөө авсан улс орнууд энэ дэлхийгээс боолчлолыг халсан юм.

Гэвч боолчлол өнөөдөр ч олон газар оронд янз бүрийн хэлбэрээр оршсоор байна. Жишээ нь зарим газар эцэг эхчүүд нь хүүхдээрээ ажил хийлгэх юмуу бэлгийн мөлжлөгт худалддаг. Зарим газар өвчин, хараалыг зайлуулах тахилд хүүхдийг өргөдөг. Зарим газар эмэгтэйчүүдийг хүчээр биеийг нь үнэлүүлдэг. Зарим газар хүмүүсийг боолчлохоор нууцаар хил давуулан хулгайлан авч явдаг асуудлууд байсаар байна.

## **Эдийн засгийн дарамт**

Эдийн засгийн доройтолд орсон зарим улс оронд боолчлолтой төстэй нөхцөл үүссэн байдаг. Тэнд хүмүүс бизнесээ чөлөөтэй явуулах эрхгүйгээс гадна хүн ажлаа сольж сайжруулах боломж асар хомс. Зарим хүн гэр бүлээ дөнгөж гол зогоох хэмжээнд тэжээж хүрэх цалингаар ажилладаг учраас үндсэн хэдэн хүнсний бараанаас өөр юу ч худалдаж авах чадамжгүй амьдардаг. Тэд эмнэлгийн төлбөр төлөх ямар ч чадваргүй. Хэчнээн их хөдөлмөрлөвч, мөнгө нь үндсэн хэрэгцээндээ ч хүрэлцдэггүй учраас илүү сайхан орон байранд амьдарна гэж саналтгүй. Ажил олгогчид өчүүхэн цалингаар ажиллуулах хүнийг ядах юмгүй олдог учраас цалингаа огт нэмдэггүй аж.

Санхүүгийн дарамт бол их төвөгтэй асуудал бөгөөд зөвхөн ажил олгогчдын буруугаас болж ийм байдал үүсдэггүй. Зарим улсад ажиллах хүч хангалттай боловч, ажиллуулах үйлдвэр, томоохон бизнес цөөн байдаг. Хэрэв засгийн газар нь авилгад автсан бол өндөр татвар, хээл хахууль нэхэх зэргээс болоод томоохон бизнес явуулахад саад их тулгардаг. Хэрэв бизнес эрхлэх орчин сайн байсан бол ажилчид хаана ажиллахаа сонгох боломж ихсэж, үүнийгээ дагаад ажлын байрууд ч сайн цалин нөхцөл санал болгох байсан биз. Тэгвэл цалин хөлс ч илүү өндөр байх байсан. Гэтэл ажлын байр цөөн учраас ажилчдад сонгох боломж бага, цалин хөлс нь ч доогуур байдаг аж. Иймээс ажилчид санхүүгийн хэрэгцээгээ хангалттай хангаж чадах орлого олох боломжгүй болдог.

Ард түмнийхээ эрх ашгийг хангаж, элдэв төрлийн халдлагаас хамгаалан, ард түмэндээ үйлчлэх нь засгийн газрын гол зорилго юм. Харин үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, ашиг орлоготой ажил хийх, өмч хөрөнгө эзэмших зэрэг нь хүний үндсэн эрх. Хүн үндсэн эрхээ эдэлж чадахгүй байгаа бол хүн гэж тооцогдохгүй байна гэсэн үг.

Иймэрхүү газарт амьдардаг зарим итгэгчид дээр өгүүлсэн нөхцөл байдлыг хэвийн зүйл мэт хүлээн зөвшөөрч, эдийн засгийн дарлалд өртсөн хүмүүст туслахыг оролддоггүй аж.

Жулиа ажил олоход амаргүй нэгэн жижиг тосгонд амьдардаг. Тиймээс гурван хүүхдээ эмээтэй нь үлдээгээд хот руу нэгэн пасторын гэрийн үйлчлэгч хийхээр явжээ. Энэ ажил тун бага цалинтай, бас дээр нь Жулиа хүүхдүүдтэйгээ их цөөхөн уулздаг болов. Эх хүнийг хүүхдүүдээс нь ингэж холдуулж байгаа ажил бол дэмий ажил гэж олон хүн бодож байлаа. Тэр тусмаа итгэгч хүмүүс Жулиаг хөлсөлж байгаа шүү дээ. Гэтэл гэртээ ажиллуулж байгаа тэр хүмүүс “Бага мөнгөөр ажиллах хүн хаа сайгүй байхад яагаад их цалин өгөх ёстой юм? Түүнчлэн хэрэв Жулиа өөрөө хүүхдүүдээ орхиод ажиллахаар шийдсэн бол бид яагаад хүүхдүүдийнх нь төлөө санаа зовох ёстой вэ?” гэж хэлдэг байв.

► Жулиагийнх шиг ийм нөхцөл байдалд итгэгч хүмүүс оролцох ёстой юу? Яагаад?

Амос номд эдийн засгийн дарлалын тухай нэлээд дурддаг. Шүүгчид хахууль авч мөнгөтэй хүний талд орсноор ядуус шударга ёсыг амсаж чадахгүй байгаа тухай Амос 5:11-12-т өгүүлж байна. Түүнчлэн Амос 8:4-6 эшлэлд хуурамч жинлүүр ашиглан ядуу хүмүүсийг мэхэлдэг худалдаачдыг эш үзүүлэгч буруушаадаг. Амос 4:1-д тэрээр ядуусыг дарлаж олсон нөхрийнхөө мөнгөөр тансаг сайхан амьдарч байгаа эхнэрүүд ч бас буруутай гэж эш үзүүлэгч хэлсэн байдаг. Амос шударга ёс гол мэт урсах ёстой гэж хэлсэн нь (Амос 5:24) хүн бүр шударга ёсыг амсаж эдлэх ёстой гэсэн утгатай юм.

### **Хүмүүний үнэ цэн ба эрх мэдэлтнүүдийн үүрэг оролцоо**

Хүн бүр хэмжээлшгүй үнэ цэнтэй. Гэхдээ хүмүүсийн дунд эрх мэдлийн зэрэг дэв байх ёстой юм. Адилхан үнэ цэнтэй гэдэг бол адилхан эрх мэдэлтэй гэсэн үг биш. Жишээлбэл, ариун Гурвалын бодгаль бүр нь бүрэн дүүрэн, энэ тэнцүү Бурхан мөн боловч, Хүү Бурхан Эцэг Бурханд захирагддаг (Иохан 6:38). Үүнчлэн Бурхан эхнэр хүнийг нөхөртөө захирагдах ёстой гэсэн нь эхнэр хүнийг нөхрөөс нь дорд үзсэнийх биш (Ефес 5:22). Бурхан хүүхдүүдийг эцэг эхдээ дуулгавартай байх ёстой гэж хэлсэн нь хүүхдүүдийг эцэг эхээс нь дорд үзсэнийх ч биш. Хүүхдүүд өсөж хөгжөөгүйгээрээ л эцэг эхээсээ ялгаатай (Ефес 6:1).

Бурхан төр засгийг тогтоож өгсөн (Ром 13:1-5). Түүнчлэн чуулганд ч эрх мэдлийн бүтцийг тогтоож өгсөн юм (Еврей 13:17).

Тиймээс удирдагч бүр өөрсдийгөө үйлчлэгч гэдгийг санаж байх учиртай (Матай 20:25-28). Удирдангаа үйлчилнэ гэдэг бол удирдуулж байгаа хүмүүсийнхээ ашиг тусын төлөө удирдана гэсэн утгатай. Удирдагч хүн хувийн ашиг хонжоог хайх бус, харин удирдуулж байгаа хүмүүсийнхээ төлөө өөрийнхөө ашиг сонирхлыг золиослох ёстой юм.

► Бүх хүн адилхан үнэ цэнтэй гэсэн байтал яагаад зарим хүн бусдаасаа илүү чухал байр суурьтай байдаг вэ? Тайлбарлана уу?

### **Итгэгчид эдгээрийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх вэ?**

Чуулган итгэлийн гэр бүлийнхээ бүх хүнийг анхааран халамжлах ёстой.

- Ахмад настнуудыг марталгүй, хэрэгтэй үед нь тус дэм болж чаддаг уу?
- Хүүхдүүдийг чухал хэмээн тооцож, нас сэтгэхүйд нь тохирсон сургаал зааж, урам зоригийн үгийг хуваалцдаг уу?
- Танай чуулган ядуу хүмүүсийг дотноор угтан авч, тухтай байлгадаг уу?
- Танай чуулган хүмүүсийг эд хөрөнгө, албан тушаалаар нь онцгойлон хүндэтгэхээс зайлсхийж чаддаг уу?
- Танай чуулган бүх ястан угсаатныг нээлттэй хүлээн авч, чуулганыхаа амьдрал үйлчлэлд оролцуулдаг уу?
- Таны амьдарч буй газарт сайнмэдээ сонсох шаардлагатай бага ястан угсаатны хүмүүс байдаг уу?
- Таны амьдарч буй орчинд дарлагдсан, өмнөөс нь дуу хоолойгоо өргөж, өмгөөлөх шаардлагатай байгаа хүмүүс байгаа юу?

Бурханлаг гэр бүлүүд бүх хүн үнэ цэнтэй гэдгийг хүүхдүүддээ зааж өгдөг. Эхнэр нөхрийн аль аль нь хүндлэл хүртэх эрхтэй бөгөөд хэн хэнийх нь хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх учиртай. Хүүхдүүдийг өчүүхэнд тооцох, үл тоомсорлох ёсгүй. Харин хүүхдүүдийг сахилга баттай болгох ёстой юм. Хүн хөршөө зодож болохгүйтэй адил, нөхөр хүн эхнэр, хүүхдэдээ хүчирхийлэл үйлдэх ямар ч эрхгүй.

Түүнчлэн ядуу хүмүүст туслахдаа хүмүүн мөн чанарыг нь хүндэтгэхээ мартаж болохгүй. Өөрийгөө өргөмжлөх сэдлээр олон нийтийн өмнө ядуу хүнд өглөг бэлэг өгөх нь буруу. Харин ядуу хүнд өөрөө орлого олж хэрэгцээгээ хангах боломжийг олговол, тэр өөрөө сонголтоо хийж, нэр төрөө ч хамгаалж чадах болно. Ядуу хүнд нөхцөл байдлаа сайжруулах боломж олгох нь хамгийн сайн тусламж юм.

Бурхан ард түмнээ дарлалаас аварч, эрх чөлөөтэй байлгахыг хүсдэг хэмээн ХГ-ний эш зүүлэгч Исаиа хэлсэн байдаг (Исаиа 58:6).

Харин ШГ-нд Есүсийг ядуусын дунд байгаагаар онцлон бичсэн байдаг (2 Коринт 8:9). Тэрээр малын хашаанд мэндэлсэн билээ (Лук 2:7). Түүнчлэн Есүсийн найзууд болон дагалдагчдын олонх нь энгийн ажилчин, ядуу зүдүү хүмүүс байв. Есүс тухайн нийгэмдээ хэрэггүй мэт тооцогдсон ядуу, уяман өвчтэй, бэлэвсэн, цагаач хүмүүс болон балчир хүүхдүүдийг халамжлан анхаардаг байжээ (Лук 7:22). Тэрбээр ядууст сайнмэдээ тунхаглахаар ирсэн бөгөөд сайнмэдээ бол дарлагдсан хүмүүсийг чөлөөлөх хүчтэй билээ (Лук 4:18-19).

Чуулган анх үүссэн цагаас л итгэгчид нийгэмдээ идэвх, оролцоотой байж ирсэн. Тэд хаягдсан хүүхдүүдийг асран хамгаалж, боолуудыг чөлөөлж, өвчтэй хүмүүст тусалж байлаа. Өөрөөр хэлбэл нийгэмд гадуурхагдсан хүмүүст итгэгчид санаа тавьдаг байсан юм.

Бурханы хаанчлал ирж, Бурханы хүсэл тэнгэрт биелдэг шигээ газар дэлхийд ч бас биелэхийн төлөө залбир гэж Есүс хэлсэн (Матай 6:10). Бурханы хаанчлал газар дээр бүрэн тогтох үед бүх төрлийн дарлал устана. Тиймээс тэр цаг иртэл бид энэ дэлхийн дарлагдсан хүмүүсийн төлөөх үйлчлэлд Бурханы оролцоог гуйн залбирах учиртай.

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

Энэ сэдвээр ярилцах үед бүлэгт ихэвчлэн удаан яриа өрнөдөг. Зарим суралцагчид үзсэн, харсан хувийн туршлагаасаа болоод илүү их сэтгэл хөдлөлд автаж магадгүй.

► Хүн бүр Бурханд ямар үнэ цэнтэй болохыг ойлгосон учраас одоо бусад угсаатан ястны хүмүүсийн талаарх таны өмнөх хандлага хэрхэн өөрчлөгдсөн бэ?

► Та одоо хүмүүний үнэ цэнийн тухай сайн мэддэг болсон учраас урьд нь буруу хийсэн, одоо “Арай өөрөөр хийчихгүй дээ” гэж бодогдох зүйл байна уу? Бусдын хийсэн зүйлийг ярьж, уур бухимдлаа илэрхийлэхээс илүүгээр суралцагчид өөрсдөө амлалт, шийдвэр гаргаж, үүнийгээ хуваалцахад илүү анхаараарай.

► Хүмүүн үнэ цэнтэй хэмээх энэ үнэн чуулганы үйлчлэлд хэрхэн нөлөөлөх ёстой вэ?

## **Залбирал**

Тэнгэрлэг Эцэг минь,

Өөрийнхөө дүр төрхөөр биднийг бүтээсэнд баярлалаа. Бүх хүнийг хүндэлдэг болоход минь туслаач. Хүмүүсийг ялгаварлан гадуурхаж, дургүйцэн хорсож байсан тохиолдол бүрийнхээ төлөө гэмшихэд минь туслаач.

Дэлхий дээр угсаа гарал, нас, хүйс, эсвэл бусад ялгаатай байдлаасаа болоод гадуурхал, ялгаварлалд өртөж байгаа хүмүүс дээр шударга ёсыг авчраач хэмээн Танаас гуйж байна.

Бүх хүнд адилхан шударга ханддаг нийгмийг байгуулахын төлөө дарлагдсан хүмүүсийг өмгөөлөн босоход минь туслаач. Чуулган, итгэгч хүн бүр Таны хайрыг энэ дэлхийд ямар нэг байдлаар харуулж чаддаг болоход туслаач.

Амен

## **11-р хичээлийн даалгавар**

(1) Хүмүүсийн бие биедээ хандах буруу хандлагыг өөрчлөхийн тулд Бурхан ямар үүрэг хариуцлагыг чуулганд өгсөн бэ? Энэ талаар бичээрэй.

- Танай чуулган юу хийх ёстой вэ?
- Итгэгч хүн бүр юу хийх ёстой вэ?
- Та юу хийх ёстой вэ?

(2) Дэд хууль 24:10-22 эшлэлийг уншиж судал. Хүмүүний үнэ цэнийг илэрхийлсэн тушаалуудыг жагсааж бич. Эдгээр тушаал бүр ямар санаа зорилгоор өгөгдсөнийг тайлбарлаарай.



# 12-р хичээл

## Төр засаг

### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах ойлголт, чадварт суралцсан байна:

- (1) Бурханаас төр засагт өгсөн үүрэг хариуцлага болон хязгаарлалтын талаар ойлгох
- (2) Засаг захиргаатай холбоотой Библийн заавар, зарчмуудыг дагах
- (3) Нийгэмд зөвт байдлыг дэлгэрүүлэхийн төлөө нөлөө үзүүлдэг хүн болох

### Хүн төрөлхтнийг хамгаалагч Вильям Вилберфорс,

Вильям Вилберфорс (1759-1833) Их Британийн парламентийн гишүүн хүн байв. Тэрээр итгэгч болсныхоо дараа боолчлол, хүүхдийн хөдөлмөр, ядууст ёс бус хандаж буй зэрэг асуудлын эсрэг тэмцэж эхэлжээ. Тиймээс Африкаас олзлогдсон хүмүүсийг Британийн хаант улс даяар худалдаалдаг боолын наймааны тогтолцоог зогсоох хуулийг батлуулахын төлөө бараг 20 жилийн турш зүтгэжээ. Бусад гишүүд энэ асуудалд огт санаа тавихгүй байгаад тэрээр их бухимддаг байв. Нэг удаа тэрээр парламентын гишүүдийн олонхийн дэмжлэгийг авч чадсан байна. Гэвч хуралдаан болох өдөр эсэргүүцэгчид зарим гишүүдэд театрын тасалбар өгсөн тул тэд хуралдаандаа ирсэнгүй. Ингээд уг хууль батлагдаж чадаагүй гэдэг. Ингээд 1807 онд боолын наймааг зогсоох хууль батлагдсан боловч, боолчлолыг хууль бус гэж үздэггүй хэвээр байсаар байв. Тиймээс Вилберфорс боолчлолыг бүрэн халуулахын төлөө тэмцлээ үргэлжлүүлсэн юм. Британийн хаант улс даяар 1833 онд боолчлолыг бүрэн халжээ. Вилберфорс энэ хууль батлагдах тухай сонссоноос гурав хоногийн дараа насан эцэслэжээ.

### Танилцуулга

Түүхийн туршид итгэгчид засгийн газартайгаа олон янзаар харилцаж иржээ. Зарим цаг үед зарим улс оронд чуулган нь засгийн газартайгаа нягт холбоотон байлаа. Харин зарим цаг үед өөр зарим газар оронд төр засаг нь чуулганыг хууль бус хэмээн үзэж, хавчин гадуурхаж байв. Зарим улс оронд бүх шашныг хүлээн зөвшөөрдөг бөгөөд төр засаг аль нэг шашныг илүүд үзэхгүй гэж мэдэгддэг.

Итгэгчид ба төр засгийн хоорондох харилцаа нь олон төвөгтэй асуудлыг бий болгож болно. Зарим улсад чуулган нь засгийн газартайгаа сайн харилцаатай байж болдог байхад, зарим улс оронд төр засгийн тогтолцоо нь өөр учраас ийм харилцааг бий болгох боломжгүй байдаг.

Энэ хичээлээр үүнтэй холбоотой асуудал бүрд хариу өгөх боломжгүйгээс гадна, Христэд итгэгч хүн бүр ямар нөхцөлд юу хийх талаар тайлбарлаж чадахгүй. Гэхдээ итгэгч хүн төр засагтайгаа хэрхэн харилцах ёстой талаарх Библийн зарим зарчмаас суралцана.

► Нэг суралцагч Ром 13:1-7 эшлэлийг бүлэгт уншина. Төр засгийн талаар эдгээр эшлэлд юу хэлсэн байна вэ?

Бурхан хүмүүний засаг захиргааг тогтоосон гэж Библид хэлдэг. Нэгэнт Бурхан үүнийг тогтоож өгсөн болохоор хүн төр засагтаа захирагдах ёстой бөгөөд төр засгаа эсэргүүцэх нь Бурханыг эсэргүүцэж буй хэрэг юм (Ром 13:1-2).

► Эдгээр эшлэлд төр засгийн зорилгыг юу гэж тодорхойлсон бэ?

Хууль зөрчсөн гэмт үйлдлийг шийтгэх нь засаг төрийн нэг зорилго юм (Ром 13:3). Төрийн эрх бүхий хүн гэмт этгээдийг шийтгэх нь Бурханд үйлчилж, Бурханы зорилгыг биелүүлж буй хэрэг (Ром 13:4).

► Нэг суралцагч 1 Тимот 2:1-2 эшлэлийг бүлэгт уншина.

Бид төр засгийнхаа төлөө залбирах ёстой. Тэгвэл бид амар тайван, аюулгүй амьдрах болно. Засаг төр зохих ёсоороо ажиллах үед нийгэм амар тайван байдаг гэх санаа эндээс харагдаж байна.

### **Христитгэлийн нөлөө**

► Матай 5:13-16 эшлэлийг унш. Есүс биднийг гэрэл, давс шиг бай гэж хэлэхдээ ямар санааг илэрхийлэх гэсэн бэ?

Зарим итгэгчид энэ дэлхий дээрх төр засгууд ард түмнээ христитгэлийн зарчмаар захирдаггүй учраас Христэд итгэгчид энэ дэлхийн төр засгийн төлөө сонгуульд оролцох, төрийн албан тушаал хаших ёсгүй гэж үздэг. Харин зарим нь улс нийгэм хэтэрхий завхарсан учраас итгэгчид нийгмээс тусдаа амьдардаг өөрсдийн бүлгийг үүсгэх ёстой гэж үздэг.

Эш үзүүлэгч Иеремиа эх орноосоо цөлөгдөж, харь нутагт амьдрахаар явсан иудейчүүдэд хандан захидал бичсэн тухай Библид тэмдэглэсэн. Тэд өөрсдийн хүслээрээ нутгаасаа яваагүй. Энэ бол Бурханд итгэдэг хэн нэг ба хэсэг бүлэг хүн нийгмийнхээ харилцаанаас яах ч аргагүй тусгаарлагдсан жишээ юм. Тэд сайн дураар тэнд очоогүй, мөн тэдний очиж амьдарсан газар нь харь шүтлэгтэй, төр засаг нь дарангуйлагч, иудейчүүдийн улс орныг сүйрүүлсэн тийм улс байлаа. Тиймээс иудейчүүд тэндээс явах өдрийг хүлээж байв.

Гэхдээ Бурхан эш үзүүлэгчээрээ дамжуулан тэдгээр иудей хүмүүст ийнхүү хэлжээ:

Миний та нарыг цөлж явуулсан хотод сайн сайхныг эрэлхийлж, өмнөөс нь ЭЗЭНд залбир. Учир нь түүний сайн сайхан нь та нарын сайн сайхан болно (Иеремиа 29:7).

*Шалом* гэх энэ еврей үг амар тайвнаас гадна, амар тайвныг дагалдаж ирдэг ерөөлүүдийг ч бас илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл Бурханы ерөөл гэсэн үг. Тэр үед Бурханыг мэддэггүй, Бурханы ард түмнийг хавчин гадуурхаж байсан харь үндэстний нийгэмд тэдгээр иудей мөргөлчид Бурханы ивээлийг авчрахыг оролдож байв. Ингэх үедээ тэд өөрсдөө Бурханы ивээл ерөөлийг амсаж байсан юм.

Бурханд үйлчилдэг хүмүүс Бурханы хүслийг нийгэмдээ тусгахын төлөө бусдад нөлөө үзүүлэх ёстой. Тэгвэл тухайн нийгэм нь ч дагаад ерөөгддөг. Тэд зөвхөн сайнмэдээ тараагаад зогсохгүй, бүх нөхцөл байдал, бүх шийдвэртээ Бурханы тогтоосон зарчмуудыг хэрэгжүүлж байх учиртай юм.

Төр засаг, нийгмийн аль аль нь Бурханы Үгэн дээр суурилах ёстой. Учир нь Бурханы илчлэгдсэн үнэнээс ёс зүй (зөв үйлдэл хийх дүрмүүд) бий болдог. Ёс зүйгээс улс төр (шударга ёс, эрх чөлөөг дээдэлсэн засаг төр) болон эдийн засгийн (нөөц баялгийг зохицуулах) харилцаа бий болдог. Иймд, эхлээд үнэн, дараа нь ёс зүй, тэгээд төр засаг, эцэст нь эдийн засаг гэсэн зөв дараалал гарч ирдэг.

1. Библи
2. Ёс зүй
3. Улс төр
4. Эдийн засаг

Гэтэл хүмүүсийн байгуулсан нийгэм энэ дарааллын эсрэгээр нь явах хандлагатай. Хүмүүс эдийн засгийн асуудлыг хамгийн чухал гэж үздэг учраас шударга ёс, эрх чөлөөнд нь аюул учирч мэдэхээр байсан ч хамаагүй, өөрсдийнх нь хүссэн зүйлийг өгнө гэж амласан удирдагчдыг дэмжиж, хүслийг нь хангах хууль дүрэм батлагдахад дуртай ханддаг. Тэгээд өөрсдийн хийж буй үйлдэлдээ ёс зүйгээ тохируулан бүрдүүлээд, эцэст нь энэ бүхнээ зөвтгөхийн тулд элдэв шашныг хүртэл үүсгэдэг. Ингээд эхлээд эдийн засаг, дараа нь улс төр, тэгээд ёс зүй, эцэст нь шашин гэсэн дараалал үүсдэг.

1. Эдийн засаг
2. Улс төр
3. Ёс зүй
4. Шашин

Ингэж гарч ирсэн шашнууд буруу зарчим дээр суурилсан байдаг учраас үнэн гэх зүйл бараг байдаггүй.

Чуулган нийгмийнхээ нүглийг зэмлээд өнгөрөх ёсгүй. Үүн дээрээ нэмээд нийгэм ямар байх ёстойг зааж, бодит үлгэр дуурайлыг харуулж, Библийн үнэний талд бат зогсох ёстой. Хэрэв Христэд итгэгчид нийгэм ямар байх ёстой талаар тайлбарладаггүй, үлгэр дуурайл болж чаддаггүй бол Библийн үнэнийг мэддэггүй хүмүүс үүнийг хэрэгжүүлж чадахгүй нь мэдээж шүү дээ.

Итгэгчид нийгмээ шүүмжлээд л байх биш, харин нийгмийнхээ нэг хэсэг байх ёстой юм. Итгэгч хүн идэвхтэй нийгмийн оролцоотой байж, байгаа газар, хамт олон дундаа

шударга ёсны төлөөлөл байх учиртай. Итгэгчид бүх харилцаа, үйл ажиллагаандаа үргэлж ёс зүйтэй байвал бусдад зөвт байдлаар нөлөө үзүүлж чаддаг. Хэрэв христитгэлийн зарчмуудад харшлахгүй бол, итгэгч хүн нийгэм ба төр засагт нөлөөлдөг байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох ёстой. Боломжтой бол христитгэлд ойр зан чанарыг харуулдаг хүмүүсийг улс төрд дэмжиж саналаа өгөх нь зүйтэй.

► Зарим чуулган нийгмээс ирэх дарамтаас болж, Библийн үнэнд суурилсан шийдвэр гаргахын оронд эдийн засгийн ашиг тусын төлөө шийдвэр гаргадаг. Ийм ямар ямар дарамт байдаг вэ? Жишээ хэлнэ үү.

### **Итгэгчид ба хүний хууль дүрэм**

Төр засаг нь христитгэлийн зарчмыг баримталдаггүй улс орны итгэгчид Библийн зарчмыг хэрхэн дагаж амьдрах талаар мэдэхийн төлөө түүхийн туршид зүтгэж ирсэн юм. Заримдаа энэ зөрчил маш хурц болж, төр засгийнхаа шаардсан зүйлийг итгэлийнхээ улмаас хийхгүй тэвчсэн итгэгчид маш их зовж байв.

Библи бидэнд төр засгаас шаардаж буй татварыг төлөх ёстой гэдгийг заадаг (Ром 13:7, Матай 22:21).

Түүнчлэн улс үндэстнийхээ хууль дүрмийг дагах ёстой гэж Библид заадаг (Тит 3:1). Гэхдээ Бурханы хууль заавар хүний хууль дүрэмтэй зөрчилдөх үед бид Бурханы тушаалыг дагах ёстой гэж Библи хэлж байна (Үйлс 5:29).

Зарим төр засаг шударга бус хэрэг явдалд итгэгч цэргийн албан хаагчийг дайчилж болох юм. Хүн амын хэт өсөлтийг багасгахын тулд засаг төр нь нярай хүүхдүүдийг хөнөөх тогтоол ч баталж болзошгүй. Магадгүй төр засгаас тодорхой нэг ястан угсаатныг боолчлох ажилд итгэгч хүнийг оролцохыг шаардаж ч болно.

Заримдаа шүтлэг бишрэлтэй холбоотой асуудал үүсэж болно. Христийн дагалдагчид төрсөн овог аймаг, угсаатан эсвэл гэр бүлийнхээ шүтлэг бишрэлийг дагахаас татгалзах үед хавчигдан гадуурхагдаж болно. Төр засаг нь өөр шашныг чухалчилж үздэг улсад Христэд итгэгчид хавчигдах нь элбэг.

Зарим улс оронд сайнмэдээ түгээх, Библи тараахыг хуулиар хориглодог. Тиймээс итгэгчид сайнмэдээ хуваалцах үедээ хавчигддаг. Зарим улсад эцэг эхчүүд хүүхдэдээ Бурхан Эзэний талаар зааснаасаа болж шийтгэл хүртдэг.

Библид захирагч удирдагчдынхаа шударга бус тушаалыг дагаагүй итгэгчдийн жишээ олон бий. Залбирахыг хуулиар хориглосон үед ч Даниел залбирсаар байсан юм (Даниел 6:10). Түүнчлэн Даниелын гурван найз хааны хөшөөнд мөргөхөөс татгалзаж байсан (Даниел 3:16-18). Израилын нярай хүүхдүүдийг хөнөөх Фараоны зарлигийг эх баригчид дагаагүй (Гэтлэл 1:17).

Түүхийн туршид хууль бус гэж тооцогдож байсан үед ч, итгэгчид сайнмэдээг түгээсээр ирсэн юм. Итгэгчид Библийг нууцаар хил давуулан авчирдаг байв. Түүнчлэн итгэгчид нууцаар цугларан, мөргөл хүндэтгэлээ өргөсөөр иржээ. Итгэгчид үр хөндөлт хийдэг

эмнэлгүүдийн үйл ажиллагаанд саад болж, зогсоож байв. Итгэгчид бас оргон зугтсан боолуудад тусалсаар ирсэн юм.

Олон итгэгчид иймэрхүү хүнд нөхцөл байдалтай тулгарахгүй амьдрахыг хүсдэг. Гэхдээ ёс зүйн хувьд зөрчилдөөнтэй энэ мэт асуудлууд үүсэх үед итгэгч хүн золиос гаргаад ч хамаагүй зөвийг л хийх ёстой. Хэрэв шударга бус явдлыг зогсоох, эсвэл сайнмэдээг хуваалцах боломж гарч ирсэн бол, үүнийг хийх үү, үгүй юу гэдгээ шийдсэн тэр мөчид итгэгч хүн маш чухал шийдвэр гаргаж байгаа хэрэг юм.

► Танай улсад итгэгч хүний хувьд дагаж боломгүй хууль дүрэм байдаг уу? Байдаг бол тэрхүү зөрчилдөөнтэй байдлыг тайлбарлаж ярина уу?

### **Хээл хахууль**

Нэг пастор гадаад улс руу явжээ. Хэдийгээр бичиг баримт бүрэн байсан хэдий ч, цагдаа нар түүнийг хэд хэдэн удаа зогсоож, бага хэмжээний мөнгө нэхэж байв. Хэрэв мөнгө өгөхгүй бол аяллыг нь саатуулж, төвөг удаж байв.

► Ийм нөхцөл байдалд пастор хүн юу хийх ёстой вэ?

Ямар нэг зөвшөөрлийг авахын тулд эрх бүхий хүнд өгч буй тодорхой хэмжээний мөнгийг хахууль гэнэ. Хийх ёсгүй зүйлийг нь хийлгэхийн тулд хахууль өгөх нь буруу. (Дэд хууль 16:19). Жишээлбэл, барилга юмуу авто машинд зөвшөөрөл авах гэтэл стандартын шаардлага хангахгүй байна гэж бодъё. Тэгээд шаардлагатай гарын үсгийг зуруулахын тулд хахууль өгвөл буруу. Шүүгч эсвэл цагдаагийн шийдвэрт нөлөөлөх гэж хахууль өгөх нь ч буруу.

Заримдаа эрх бүхий хүмүүс үүрэгт ажлаа хийж байгаа мөртлөө хахууль нэхдэг. Ийм тохиолдолд шударга бус зүйл хийлгэхийн төлөө мөнгө төлж байгаа хэрэг биш боловч, албан тушаалтан хүн хахууль нэхэх буруу (Лук 3:14). Магадгүй төлж байгаа хүн яах ч аргагүй байдалд орсон байж болох юм. Зүгээр авч болох зөвшөөрлийг мөнгө төлж авах, эсвэл гэмгүй хүнийг суллуулахын тулд мөнгө өгөх тохиолдол гарч болдог. Заримдаа хахууль яг дээрэмтэй адил байдаг. Дээрэм буруу зүйл боловч хохирогчийг буруутгаж болохгүй.

Бурхан хахууль авдаг хүмүүсийг буруутгадаг боловч, өгөхөөс өөр аргагүй байдалд орсон хүнд өршөөнгүй хандсан байдаг (Гэтлэл 18:21, Гэтлэл 23:8; Дэд хууль 10:17, Дэд хууль 16:19, Дэд хууль 27:25). Итгэгч хүн аливаа асуудлыг хялбарчлах зорилгоор хахууль өгөх ёсгүй. Харин авилгад идэгдсэн албан тушаалтны шахалтаас болж, аргагүй байдалд ороод хахууль өгсөн бол гэм буруутайд тооцогдохгүй.

► Буруу хээл хахуулийн ямар ямар жишээ байна вэ?

### **Цэргийн алба**

Маш олон итгэгчид цэрэгт явах, цэргийн алба хаах нь буруу гэж боддог. Тэд энэхүү үзэл бодлоо Библийн зарим эшлэлээр зөвтгөдөг. "Хүн нэг хацрыг маань алгадвал

нөгөөгөө тавьж өг” гэж Есүс заасан (Матай 5:39). Түүнчлэн Есүсийн хаанчлал бол энэ дэлхийнх биш учраас итгэгч хүн дайн тулаан хийх ёсгүй гэж бас хэлсэн (Иохан 18:36). Үүнчлэн элч Паул “бидний зэвсэг бол махбодынх биш” гэж хэлсэн (2 Коринт 10:4). Тиймээс эдгээр итгэгчид бусдын эсрэг хийх ямарваа хүчирхийлэл бүгд буруу гэж үздэг байна. Тэдний олонх нь эрх чөлөөгүй, төр засаг нь итгэгчдийг хавчин гадуурхдаг улсад амьдарч байна.

Харин бусад нь эх орноо хамгаалахад бэлэн байх ёстой гэж үздэг. Библид Бурхан төр засгийн эрх мэдлийг тогтоосон учраас тэд бузар мууг шийтгэхийн тулд зэвсэг хэрэглэх эрхтэй гэж бий (Ром 13:4). Түүнчлэн эр хүн гэр бүлээ хамгаалах нь Бурханы өгсөн үүрэг учраас цэрэг дайны хэлбэрээр довтолж буй халдлагаас эрчүүд гэр бүлээ хамгаалахын тулд зохион байгуулалтад орох нь зүй ёсны хэрэг. Нэгэн цэрэг баптисч Иоханаас хэрхэн гэмших талаар асуух үед Иохан түүнд хахууль авахгүй, хүчирхийлэл үйлдэхгүй бай гэж хэлсэн юм. Гэхдээ түүнийг цэргээс халагд гэж хэлээгүйг анзаараарай (Лук 3:14). Мөн Есүс нэг хацрыг нь алгасан хүн рүү нөгөө хацраа эргүүл гэж хэлэхдээ бид өөрсдийгөө довтолгооноос хамгаалж болохгүй гэсэн утгаар хэлээгүй. Харин алгадах мэтийн доромжилсон үйлдэлд хариу барих гээд байх хэрэггүй гэсэн утгатай. Есүсийн дагалдагчид газар дэлхий дээр Түүний хаанчлалыг байгуулахын төлөө дайн хийх шаардлагагүй бөгөөд Тэрбээр ийм маягаар хаанчлалаа тогтоохгүй гэж хэлсэн. Хэрэв засаг төрийг Бурхан тогтоосон бөгөөд төр засаг нь ард түмэндээ үйлчлэх ёстой юм бол, итгэгчид төрдөө үйлчилж, үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь туслах ёстой.

Чуулганы түүхийн туршид олон улс орны маш олон итгэгч хүн цэргийн алба хааж, бүр дайн тулаанд оролцож явсан. Яагаад гэвэл тэд эх орноо муу халдлагаас хамгаалахад хувь нэмрээ оруулах ёстой гэж үздэг байсан юм.

Цэрэг болж, дайн тулаанд оролцох тал дээр улс орон бүрийн итгэгчид өөр өөр санаа бодолтой байдаг. Тиймээс энэ асуудал дээр итгэгч хүн Библиэ уншин залбирч, ухаалгаар тунгаан бодож, өөрийнхөө итгэл үнэмшлээ дагах нь зөв.

► Танай улсад чуулганууд цэргийн алба хаах талаар ямар байр суурьтай байдаг вэ?

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

Дээр өгүүлсэн асуудлуудын хувьд, олонх итгэгчид хүчтэй байр суурьтай байдаг. Итгэгчид цаг үе, амьдарч байгаа газар орноосоо хамаараад эдгээр асуудал дээр бүгд адил санаа бодолтой байдаггүй гэдгийг бид ойлгох ёстой. Үзэл бодлын хувьд биднээс өөр байж болох учраас бусдыг шүүж шүүмжлэхээс зайлсхийх нь зүйтэй.

► Танай улсад чуулган ба төр засгийн хоорондох харилцаа ямар вэ? Хэрхэн үнэлэх вэ? Өөрчлөгдөх ёстой зүйл байна уу?

## **Залбирал**

Тэнгэрлэг Эцэг минь,

Хүмүүнийг хамгаалж, эрх чөлөөг өгөхийн төлөө төр засгийг бий болгож өгсөнд баярлалаа.

Бусдыг хамгаалж, нийгэмдээ нөлөө үзүүлэх үүрэг хариуцлагаа биелүүлж чадахад минь Та туслаач.

Таны хаанчлал бүрэн төгс ирэх болтугай.

Амен

## **12-р хичээлийн даалгавар**

(1) Бурхан Эзэн засаг төрийн хүмүүсээр дамжуулан ард түмнийхээ амьдралд хүсэл зорилгоо биелүүлж байсан тухай олон түүх Библид бий. Тиймээс Сургаалт үгс 21:1-д “Хааны зүрх ЭЗЭНий мутар дахь усны урсгал Хаа таалсан зүгтээ Тэрээр хааныг чиглүүлнэ” гэсэн байна. Дараах багц эшлэлээс нэгийг сонгоод судлаарай.

- Эхлэл 41:14-49, Эхлэл 42:1-3, Эхлэл 45:4-7
- Естер 4, 7-8
- Нехемиа 1-2

Юу ажигласнаа бич.

- Бурханы хүмүүсийн амьдралд юу хэрэгцээтэй байсан бэ?
- Бурхан үл итгэгч, шударга бус хааныг хэрхэн ашиглаж, зорилгоо биелүүлсэн бэ?
- Бурхан хэрхэн бурханлаг хүнийг ашиглаж зорилгоо биелүүлсэн бэ?

(2) Дараах сэдвээс нэгийг сонгоорой.

- Христитгэлийн нөлөө
- Христитгэл ба хүний хууль дүрэм
- Хээл хахууль
- Цэргийн алба

Сонгож авсан сэдэвтэйгээ холбоотой эшлэлүүдийг Библиэс хайж олоорой. Тухайн асуудлаар Библид юу гэж заасан байдаг талаар нэг хуудас тайлбарлан бич.



# 13-р хичээл

## Итгэгч хүний бие махбод

### Хичээлийн зорилго

Энэ хичээлийн төгсгөлд суралцагч дараах ойлголт, чадварт суралцсан байна:

(1) Бие махбодын асуудлууд сэтгэл зүй ба сүнслэг эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдгийг ойлгоно.

(2) Бие махбодоо Бурханд зориулж, Эзэнийг хүндэтгэх шинэ дадалд суралцана.

### Бурханы зарц Мартин Лютер

Бурханд үйлчлэхэд өөрийгөө бүрэн зориулах хамгийн сайн арга бол санваартан болох явдал хэмээн Мартин Лютер боджээ. Тухайн үед санваартан болсон хүн хоол хүнсээ хязгаарлаж, мацаг барих, даруу хувцаслах, хөрөнгө мөнгөгүй байх, гэрлэхгүй байх зэрэг дэг журмыг дагадаг байв. Биеэ Бурханд зориулах гэсэн халуун хүслээсээ болоод Мартин өөрийгөө ташуурдан шийтгэж байсан ч удаатай. Гэхдээ бие махбодоо зовоолоо гээд Бурханы нигүүлслийг хүртэж чадахгүй гэдгийг ухаарчээ. Харин итгэл, нигүүлслээр авралыг хүртдэг гэдгийг ойлгосон юм. Ингээд санваартны тангарагаа Бичвэрийн үндэслэлгүй зүйл хэмээн няцааж, урьд нь гэлэнмаа байсан Катерин хэмээх бүсгүйтэй гэрлэн, зургаан хүүхэдтэй болсон билээ.

### Танилцуулга: Коринтын чуулганы төөрөгдөл

Христийн дагалдагчид биеэр амилна гэдэгт Коринт чуулганы зарим хүн итгэдэггүй байв. Тиймээс хүн үхэхэд бие нь устаж, зөвхөн сүнс нь л тэнгэрт очно гэж үздэг байжээ.

Зарим нь “Нэгэнт махбод үхээд дуусах юм чинь, одоо бие махбодоо яаж ч ашиглаж болно. Бие махбод үнэ цэнтэй зүйл биш учраас нүгэлд ашиглахад ч болохгүй зүйлгүй” гэж хэлдэг байжээ.

Харин амиллыг үгүйсгэдэг зарим нь “Махбодын хүсэл тачаалууд муу зүйл. Тиймээс бие махбод эцэстээ хаягдана. Тэнгэрт очих үед бидэнд ямар ч махбодын хүсэл байхгүй болно. Махбодын хүслүүд муу учраас бид хүслээ хязгаарлах ёстой. Бид сайхан хоол идэх ёсгүй, тухтай хувцас өмсөж болохгүй, гэрлэлээ гэхэд бэлгийн харилцаанд орж болохгүй. Махбодоо орхих хүртлээ бид боломжтой бүх аргаар махбодын хүслээ дарж байх ёстой” гэж хэлдэг байжээ.

Үнэндээ энэ хоёр үзэл хоёулаа буруу байсан. Аль аль нь алдаан дээр суурилсан үзэл бодол учраас буруу юм. Тиймээс 1 Коринт 15-р бүлэгт элч Паул амиллын тухай сургаал яагаад чухал болохыг тайлбарласан байдаг.

Хэдийгээр махбодын асуудлаас сүнслэг асуудал илүү чухал боловч, бие махбод нь сүнслэг амьдралд нөлөө үзүүлдэг учраас энэ талаар бид ярих л ёстой. Бурхан биднийг дан сүнс болгож бүтээгээгүй шүү дээ. Бидэнд бие махбод байгаа. Бид бол зүгээр нэг махбодын амьтан биш, бас махбод дотор түр л оршин суух сүнс төдий бодгаль биш ээ.

### **Бурханд өөрийгөө зориулах нь**

► Нэг суралцагч 1 Коринт 6:19-20 эшлэлийг бүлэгт уншина.

Бурхан биднийг зольж авсан учраас бидний бие махбод Бурханд харьяалагддаг гэдгийг эдгээр эшлэлд хэлж байна. Бидний бие бол Ариун Сүнсний сүм юм. Тиймээс бид биеэ нүгэлд ашиглах ёсгүй.

Хүн бие махбодоо бүхэлд нь Бурханд зориулах ёстой гэж Библид заадаг.

► Нэг суралцагч Ром 12:1 эшлэлийг бүлэгт уншина.

Энэ эшлэлд бид биеэ ариун байлгаж, Бурханд зориулах ёстой гэжээ. Бурхан биднийг бүрэн дуулгавартай байгаасай гэж хүсдэг бөгөөд энэ бол Бурханы хүсдэг мөргөл хүндэтгэл юм.

Хэрэв бид махбодынхоо хүслээр удирдуулж явдаг бол Бурханд тасралтгүй үйлчилж чадахгүй. Зуршил болсон аливаа нүгэл бол донтолттой адил зүйл.

Хоёр эзэнтэй нэг амьтан байна гэж төсөөлье. Нэг эзэн нь тушаал өгсөн боловч, нөгөө эзэн нь гинжээр хүлчихсэн учраас өнөөх амьтан яаж ч чадахгүй байв. Гинжилсэн эзэн нь өнөө амьтнаа хүссэн газар луугаа чирэн авч явдаг гэнэ. Харин өнөөх амьтан нөгөө эзнээ илүү хайрладаг боловч, дагаж явж чаддаггүй ажээ. Донтолт гэж ямар байдгийг үүнээс харж болно. Хүн Бурханд үйлчлэхийг хүсэж болох ч, донтолтод автсан бол эсэргүүцэж чадахгүй гинжинд орсонтой адил.

Донтолт болон нүглийн аливаа хэлбэр нь хүний бие махбод, оюун санааг гэмтээдэг. Бидний бие махбод Бурханы өмч бөгөөд Бурханд үйлчлэхэд зориулагдсан учраас бид биеэ гэмтээж болохгүй. Дээр уншсан Ром 12:1-д биднийг биеэ Бурханд тааламжит тахил болгон өгөх ёстой гэж хэлж байна. Гэхдээ бид биеэ удирдаж чадахгүй бол үүнийг хийж чадахгүй.

► Нэг суралцагч 1 Коринт 9:24-27 эшлэлийг бүлэгт уншина.

Таны бие махбод бол таны үйлчлэгч. Тиймээс та биеэ хянаж байх ёстой. Бие тань таны үйлчлэгч бол сайн хэрэг. Харин та биеэ хянаж чадахгүй бол бие чинь таны эзэн болно. Гэхдээ маш муу эзэн шүү. Элч Паул махбодын аливаа хүсэлдээ захирагдахыг өөртөө огт зөвшөөрөхгүй гэж хэлсэн байдаг (1 Коринт 6:12).

► Нэг суралцагч Ром 6:13 эшлэлийг бүлэгт уншина.

Махбод бол таны эзэмшилд байгаа иж бүрэн багаж хэрэгсэлтэй адил. Тэр багаж хэрэгсэл таны хяналтад байна. Тиймээс та энэ багаж хэрэгслээ нүгэлд биш, Бурханд үйлчлэхэд ашиглах ёстой юм.

### Төрөлх хүсэл

Хүмүүс бидэнд төрөлхийн дур хүслүүд байдаг учраас нүглээс зугтаж чадахгүй гэж зарим хүн үздэг. Мэдээж биднийг нүгэлд өдөөдөг төрөлхийн мөн чанар бидэнд байгаа. Тэрхүү мөн чанарт бие махбодын болон оюун санааны дур хүсэл, мөн нүгэлд татагддаг дотоод хүслүүд цөм багтдаг. Бурханы Ариун Сүнсээр шинэчлэгдээгүй хүн зарим нүглийг тэвчиж чаддаг боловч, нүгэл үйлдэхээ бүрмөсөн больж чаддаггүй. Тиймээс хүн нүглийг үргэлж ялж амьдарч болно гэдэгт үл итгэгчид итгэж чадахгүй байх нь аргагүй.

Ер нь төрөлхийн хүсэл гэдэг ерөөсөө асуудал биш. Бурхан үүнийг бүтээсэн. Адамд төрөлхийн дур хүслүүд байсан. Тэрээр Бурханд дуулгаваргүй байхыг сонгох хүртлээ нүгэлгүй байсан юм. Төрөлхийн дур хүсэл бол Бурханы бүтээлийн нэг хэсэг учраас нүгэл биш. Гэхдээ төрөлхийн хүслүүдээс болоод уруу таталтад орох боломжтой.

► Төрөлх хүслийн хэдэн жишээ хэлнэ үү?

Дараах хүснэгтэд төрөлх дур хүслийн бүх жишээг багтааж чадаагүй боловч, заримыг нь дурдаж, тэдгээр хүслүүд хэвийн байдлаар илрэх зам болон уруу таталтад нөлөөлж болох зарим нөхцлийг орууллаа.

Төрөлх дур хүсэл гэхээр заавал махбодын хүсэл байх албагүй. Эдгээр нь хүний мөн чанараас үүдэлтэй боловч, бүгд махбодын хүсэл биш.

Төрөлх хүслийн ангилал	Төрөлх хүсэл хэвийн илрэн гарах жишээ	Болзошгүй нүгэл
Өөрийгөө хамгаалах	Аюулгүй байдлын арга хэмжээ авах	Хулчгар зан гаргах
Хүнээр сайшаалгах	Аятайхан хувцаслах, эелдэг байх	Бардамнах, атаархах
Бие махбодын ханамж	Идэх, унтах, гэрлэлт дэх бэлгийн харилцаа	Хүслээ дур зоргоор нь тавих
Нийгмийн харилцаа	Бусадтай нөхөрлөх	Хов ярих, дээрэнгүй авирлах
Бие махбодын тав тух	Амар хялбарыг илүүд үзэх	Залхуурах, эд юманд шунах
Санхүүгийн аюулгүй байдал	Хэмнэх, хөрөнгө оруулах	Шунах, шударга бус байх

► Үргэлж дагаад байдаг ямар төрөлх хүсэл танд байдаг вэ?

Та ямар ч төрөлх хүсэлд захирагдаж болохгүй. Таны хувьд юу зөв болохыг дур хүсэл ялгаж мэдэхгүй учраас аюулгүйгээр дагаж болох төрөлх хүсэл гэж байхгүй. Жишээлбэл, таны өлсөх мэдрэмж ба идэх хүсэл чинь өөрийн хоол, өрөөлийн хоол, эсвэл төлж чадахгүй хоол зэргийг ялгаж мэдэхгүй шүү дээ.

Зарим үед зөв замаар илэрч байгаа төрөлх хүслийг ч дарах шаардлага гарна. Хүн өлслөө гээд бусдын хоолыг авч болохгүй. Амрахыг хүсэж байвч, ажиллах хэрэгтэй үе гэж байна. Аюулаас сэрэмжлэх нь хүний төрөлх хүсэл боловч, хэн нэгнийг хамгаалх ёстой учраас аюулаас зугтах төрөлхийн хүслээ эсэргүүцэж ч болно.

Төрөлх дур хүсэл гажууд болох, мөн дур хүслээ буруугаар хангасаар байх юм бол, хүн өөрийнхөө мөн чанарыг алддаг. Иймээс зарим хүн туйлын гажууд, эсвэл харгис үйлдлүүд хийдэг байна. Буруу заавар сургаал, муу бодол санааны хэвшилтэй болох, нүгэлтэй орчин эсвэл бусдын нүгэлтэй үйлдлээс болж хүний төрөлх дур хүсэл гажих юмуу, буруу чиглүүлэгддэг.

Итгэгч хүн бүр төрөлх дур хүслээс үүдэлтэй уруу таталттай тулгарна. Бурханы нигүүлсэл хүний төрөлх дур хүслийг арилгахгүй ч, үйл хөдлөлөө хянах, дур хүслээ зөв чиглүүлэх хүчийг өгдөг.

Сүнслэг ялалт байгуулахын тулд төрөлх хүслүүдийг дэг журамд оруулах хэрэгтэй. Нигүүлсэл байлаа гээд хүн Библийн заавар сургаалыг мөрдөх, мөргөл хүндэтгэлд оролцох, махбодоо захирах, залбирах, Библи судлах зэргээс чөлөөлөгдөхгүй. Сүнслэг ялалтаа хадгалахыг хүсэж буй итгэгч хүн өөрийнхөө сул талуудыг мэдэж, хязгаарлалт тавих ёстой.

Уруу таталт үнэхээр сэтгэл татагдмаар байдаг боловч, Бурханы хүслийг зүрх сэтгэлдээ бат суулгасан бол, хүн уруу таталтыг ялж чадна (1 Иохан 5:3). Өөрийг нь жаргалтай болгох зүйлээс татгалзаж байна гэж огт бодохгүй. Бурханы хориглосон зүйлсийн хор хөнөөлийг итгэгч хүн шууд харж чадахгүй боловч, итгэлээрээ тэдгээрийн хор хөнөөлийг ойлгож, биеэ барьдаг (Дэд хууль 6:24). Харин хор хөнөөлгүй зүйлсэд Бурхан хориг тавихгүй. Тиймээс Бурханы хориглосон зүйлс хүнийг жаргалтай болгохгүй гэдгийг итгэгч хүн итгэлээрээ мэддэг. Яагаад гэвэл түүний сэтгэл Бурханаар ханадаг (Дуулал 16:2, Дуулал 84:11).

### **Хоол хүнс ба дасгал хөдөлгөөн**

► Библид хоол хүнсний талаар юу хэлсэн байдаг вэ?

Библид хоол хүнсний талаар ямар нэг хориг байхгүй. Хуучин гэрээний итгэгчдийн дагадаг хоол хүнстэй холбоотой журмыг Шинэ гэрээний итгэгчид дагахгүй байж болно (1 Тимот 4:4, Марк 7:19). Гэхдээ Бурханд бус шүтээнд өргөсөн тахилын хоолноос идэх талаар асуудал гарч байсан. Асуудал тэр хоолонд байгаагүй, харин тэр хоолыг шүтээний мөргөлд хэрэглэсэн учраас хориглосон юм (1 Коринт 8).

Эрүүл, хүчтэй байхын тулд зөв хоолны дэглэмтэй байх чухал. Бид Бурханы үйлчлэгчид учраас бие махбод маань эрүүл байх учиртай. Тиймээс биеэ гэмтээх, эрүүл мэндийг муутгах хоол хүнснээс зайлсхийх ёстой. Санхүүгийн боломж, худалдан авах чадвартаа тааруулж хоол хүнсээ авахаас өөр аргагүй болдог, олон төрлийн хүнс идэх боломжгүй хүн олон байдаг. Хэрэв та тийм хүмүүсийн нэг бол боломждоо тааруулаад хамгийн зөв сонголтыг хийх ёстой. Түүнчлэн үр хүүхдэдээ зөв хоол хүнсийг сонгож сургах хэрэгтэй.

Гэтэл хүнсэнд зарцуулах хангалттай мөнгөтэй атлаа эрүүл шим тэжээлтэй хоолыг бус, харин өөрт таалагддаг амттай хоолоо сонгож, хэтрүүлэн иддэг хүмүүс байдаг. Түүнээс гадна хүмүүс эрүүл бус хоолонд илүү их мөнгө зарцуулах уруу таталттай байнга тулгардаг. Зарим хүн үйлчлэлийн сургалтын ном худалдан авч чадахгүй, боломжгүй гэдэг мөртлөө чихэр, коланд тэр байтугай мөнгийг зарцуулж орхисон байдаг.

Эрүүл байхыг хүсвэл заавал дасгал хөдөлгөөн хийж байх учиртай. Дасгал хийдэггүй хүмүүс хүч чадал муутай, эсвэл хэт таргалсан байдаг. Бид Бурханд үйлчлэх боломжоо биеийн байдлаасаа болж алдах ёсгүй. Хэрэв биеийн хүчний ажил хийдэг бол нэмэлт дасгал хөдөлгөөн хэрэггүй байж болно. Эс бөгөөс бие махбодоо эрүүл чийрэг байлгахын тулд сахилга баттай байх хэрэгтэй.

Бие махбод маань Бурханд харьяалагддаг учраас итгэгч бид хоол хүнс, дасгал хөдөлгөөнөө анхаарч байх ёстой. Гэхдээ Библид хоол хүнс, дасгал хөдөлгөөнтэй холбоотой заавар байхгүй. Тиймээс хүмүүс өөрсдийнхөө нөхцөл байдалд тааруулан, биеэ Бурханд зориулах зарчмыг амьдралдаа хэрэгжүүлэх нь зүйтэй. Мэдээж бид бусдыг буруутган шүүмжлэх ёсгүй. Гэхдээ зарим бүлэг, хамт олон тодорхой дэг журмыг дагахаар шийдсэн бол, үүнийгээ сүнслэг амьдралын дүрэм болгох ёсгүй.

► Нэг суралцагч Ром 14:4 эшлэлийг бүлэгт уншина.

Бид Библийн зарчмуудыг тодорхой байдлаар хэрэгжүүлэх ёстой. Гэхдээ Библид өөрөөр заагаагүй л бол, биднийхээс өөр хэлбэрээр Библийн зарчмыг хэрэгжүүлж байгаа хүмүүсийг бид шүүх ёсгүй.

### **Махбодын гайхалтай эдгэрэл**

► Нэг суралцагч Ром 8:18-23 эшлэлийг бүлэгт уншина.

Өвчин гэдэг энэ дэлхийд нүгэл анх орж ирсний дараа бүх бүтээл дээр буусан хараалын үр дагавар юм. Гэхдээ эцэстээ бүх бүтээлийг эргүүлэн сэргээж, бүх зовлон шаналлыг дуусгах төлөвлөгөө Бурханд бий. Сэргээлт нэг мөсөн гэнэт тохиолдохгүй гэдгийг эдгээр эшлэлд хэлж байна. Хүн аврал авсан байлаа ч, Бурханы авралын төлөвлөгөө хэрэгжиж дуусах хүртэл газар дэлхийд хөгшрөл, өвчин үргэлжилсээр байх болно.

Хэдий тийм ч, Бурхан гайхамшиг үйлдсээр ирсэн билээ. Библид олон гайхамшигтай эдгэрлийн тухай өгүүлдэг. Чуулганы хүмүүс итгэлээр залбирвал Бурхан эдгэрлийг өгнө гэдгээ амласан байдаг (Иаков 5:14-15). Өвчтэй хүн эдгэрэхийн тулд тэр өөрөө заавал

итгэлтэй байх шаардлагагүй, харин түүний төлөө залбирч байгаа чуулганы хүмүүс бат итгэлтэй байх ёстой. Тиймээс өвчтэй хүнийг итгэлгүй гэж буруутгах хэрэггүй юм.<sup>22</sup>

Итгэдэг хүн хэзээ ч өвдөхгүй гэж бодож болохгүй. Иов хэдийгээр Бурханд итгэмжит байсан ч, Бурхан түүнийг хэсэг хугацаанд бие махбодын зовлон амсахыг зөвшөөрсөн байдаг (Иов 2:8).

Бурхан Паулыг даруу байлгаж, Өөрт нь найдсан хэвээр байлгахын тулд “махбодод нь өргөс” өгсөн гэж Паул хэлжээ. Үүнээс чөлөөлөгдөхийн тулд Паул гурван удаа гуйсан боловч Бурхан эдгэрлийг биш, харин тэсвэрлэх хүчийг өгөхийг хүсжээ (2 Коринт 12:7-9). Энд дурдагдаж буй “махбодод минь өргөс өгөгдөж” гэдэг үг нь яг юу байсан нь тодорхой бус. Бие махбодын өвчин байсан байх магадлалтай.

Паул галатчуудын дунд сайнмэдээ тунхаглаж байхдаа бие нь тааруу байжээ (Галат 4:13-15). Галатчууд түүнийг хайрлаад бүр нүдээ ухаад өгөхөд ч бэлэн байсан гэж хэлснийг нь харвал Паул тэр үед нүдний асуудалтай байсан болов уу. Тэр дараа нь эдгэрсэн эсэхийг бид мэдэхгүй. Гэхдээ тухайн үед тэр даруй эдгээгүй. Мэдээж үүгээр Паул итгэгч хүн бүр үргэлж өвчин эмгэггүй байх ёстой гэж заагаагүй нь ойлгомжтой. Нөгөөтэйгүүр, галатчууд Паулын өвчнийг, тунхаглаж буй сайнмэдээтэй нь зөрчилдөж байна гэж бодоогүй.

► Нэг суралцагч Филиппой 2:25-30 эшлэлийг бүлэгт уншина.

Епафродит үхлүүт өвчин тусчээ. Тэрээр Паулд туслахын тулд хэт их ажилласнаас болоод өвдсөн аж. Паул түүнийг Христийн ажлын төлөө үхэх шахан зүтгэсэн хүн учраас хүндлэл хүртэх ёстой гэсэн байна.

Бид Паул, Иов, Епафродитын жишээнээс өвдсөн хүнийг итгэлээр бага гэж буруутгаж болохгүйг харж байна. Түүнчлэн тэднийг нүглийнхээ улмаас шийтгэл хүртэж байна гэж бодож ч болохгүй. Аливаа хүний өвчин зовлонгийн ард сүнслэг учир шалтгаан байгаа эсэхийг зөвхөн Бурхан л мэднэ. Түүхийг харвал, агуу итгэлтэй хүмүүсийн зарим нь удаан хугацаанд ужиг өвчнөөр зовж байсан нь харагддаг.

Итгэгч хүн эм тариа хэрэглэхийг Библид зөвшөөрдөг. Бид эдгэрлийн төлөө залбирдаг ч, байгаа тусламжийг ашиглах нь буруу зүйл биш юм.

Гэхдээ өөрийгөө эдгээгч сүнслэг хүчтэй гэж зарладаг хүмүүс юмуу, элдэв сүнснүүдэд үйлчилдэг хүмүүсээс эдгэрэл гуйх нь буруу. Бид Сатаны үйлчлэгчид биш учраас түүнээс ашиг тус эрэлхийлж болохгүй. Бид Бурхан Эзэнийхээ өгсөн ивээл ерөөлд сэтгэл хангалуун байж, Түүнд үнэнч байх ёстой. Хэрэв Тэр биднийг эдгээхгүй байхаар шийдсэн бол, бид Түүнээс өвчнийг давах нигүүлсэл, хүч чадал, итгэмжит байдлыг гуйх учиртай юм.

---

<sup>22</sup> Есүс саа өвчтэй хүнийг найзуудынх нь итгэлээс болж эдгээсэн (Марк 2:5).

## **Мансууруулах бодис**

Зарим хүн таашаал мэдрэх гэж янз бүрийн хортой бодисуудыг хэрэглэдэг.

Хар тамхины хольцтой эм бодисуудыг зарим тохиолдолд эмчилгээний зорилгоор хэрэглэж болох боловч, таашаал авах гэж хэрэглэх ёсгүй. Мансууруулах бодисууд нь биеийг гэмтээж, оюун санааг солиоруулан, донтолт үүсгэдэг. Тиймээс дэлхийн олон улсад эмчийн жор, хяналтаас гадуур хар тамхины хольцтой эм бодис хэрэглэхийг хуулиар хориглодог.

Архи дарс ч мөн багахан амсахаас цааш хэтэрвэл, хүний сэтгэцэд нөлөөлдөг. Ингээд хүн эрүүл байхдаа хэзээ ч хийхгүй байсан элдэв үйлийг хийдэг. Архи ч мөн донтолт үүсгэнэ. Их хэмжээгээр хэрэглэхэд эрүүл мэндэд хохирол учруулна. Хаана ёс суртахуунгүй, зугаа цэнгэл хөөж байна, тэнд архидалт байдаг. Библид архи дарсыг шууд хориглоогүй. Гэхдээ архи хүний зан авир, зөв шүүн тунгаан бодоход сөрөг нөлөө үзүүлж, донтуулах, ёс бус үйлдэл хийхэд хүргэх үр дагавар авчирдаг учраас чуулганууд архи дарсыг хориглодог. Зарим итгэгчид болгоомжтой жаахан хэрэглэж, биеэ хянаж чадна гэж боддог. Ингэх нь бусад хүмүүст, ялангуяа хүүхэд залууст буруу үлгэр дуурайл үзүүлж байгаа хэрэг юм.

► Нэг суралцагч Сургаалт үгс 20:1 болон Сургаалт үгс 31:4-5 эшлэлийг бүлэгт уншина.

Тамхи байнга татах, эсвэл зажилж хэрэглэх нь донтолт үүсгэж, амь насыг хэдэн жилээр богиносгоно. Тамхи татдаг хүмүүс хорт хавдраар илүү өвчлөх хандлагатай байдаг.

Библид мансууруулах бодис, архи дарс, тамхийг онцгойлон дурдаж хорьсон үг байхгүй. Гэхдээ эдгээрийн хор хөнөөлийг ойлгодог ихэнх хүн Христийн дагалдагчдыг ийм зүйл хэрэглэх ёсгүй гэж үздэг. Дээр үед архи, тамхи, мансууруулах бодис ямар хор хөнөөлтэйг сайн мэддэггүй байсан учраас зарим газар оронд эдгээрийг хориглодоггүй байжээ.

Архи, тамхи, мансууруулах бодисийн хамгийн том аюул бол донтолт юм. Донтолт хүний амьдралыг удирдаж, цаг, мөнгө, хүч энергийг нь шавхаж дуусгадаг. Улмаар хүний сэтгэхүйд нөлөөлж, энэ мэт буруу үйлдлээ зөв гэж тайлбарлахад хүргэнэ. Донтсон хүн гэр бүл, ажил гээд бүхнээ хаядаг. Түүнчлэн донтсон хүн элдэв шашинд орсон хүн шиг мансууруулах зүйлийнхээ араас шургуу, тууштай явдаг. Иймээс донтолт нь Бурханд үнэнч байхтай зөрчилдөнө.

Итгэгч хүн согтуурах ёсгүй, харин Бурханы Сүнсээр дүүрэх байх ёстой гэж Ефес 5:18 эшлэл бидэнд сануулж байна.

## **Цэвэр цэмцгэр байдал ба гадаад үзэмж**

Итгэгч хүн цэвэр цэмцгэр байх ёстой бөгөөд ариун цэврийн тал дээр өссөн соёлынхоо тогтсон хэм хэмжээнээс доошоо орж болохгүй. Хүмүүсийн өмнө муухай үнэр, бохир үс, хиртэй эсвэл хуучирч муудсан хувцастай явах ёсгүй. Ядуу хүн гадаад төрхөө арчлаад байх боломж муу байж болох юм. Гэхдээ чадах чинээгээрээ цэвэр цэмцгэр байх ёстой.

Хэрэв найз нөхөд чинь таны гадаад үзэмж, ариун цэврийн талаар шүүмжилбэл хүлээж аваарай. Эцэг эхчүүд хүүхдэдээ багаас нь биеэ цэвэр цэмцгэр авч явахыг заах ёстой.

Итгэгч хүн энэ дэлхийн хэв маягаар хөөцөлдөх, өмсөж зүүснээрээ өөрийгөө бусдаас дээгүүр гэж харуулахыг хичээх ёсгүй. Гэхдээ бохир хувцас өмсөх, гадаад төрхөө анхаарахгүй байх нь уулзаж байгаа хүмүүсээ дорд үзэж байгаа мэт сэтгэгдлийг төрүүлж болно. Жишээлбэл, та уулзалтад очихдоо хааш яаш хувцаслаад очлоо гэж бодъё. Тэгвэл таныг уулзаж байгаа хүмүүсээ үл хүндэтгэж байна гэж тооцох боломжтой. Христэд итгэгч хүн Бурханыг ч, бусдыг хүндэтгэж байгаагаа гадаад төрхөөрөө бас илэрхийлж байх ёстой юм.

Өнө мөнхийг эрэлхийлдэггүй хүмүүс өмссөн зүүсэндээ хэт ач холбогдол өгч, биеэ онцгой болгохыг хичээдэг. Эрчүүд нь булчин шөрмөсөө гайхуулах, эмэгтэйчүүд нь эрчүүдэд таалагдах бие галбиртай болохыг хүсдэг. Харин итгэгч хүн биеэ тоох, хувцас чимэглэлээрээ бусдын анхаарлыг өөртөө татах гэсэн буруу хандлагатай байж болохгүй.

### **Хэлэлцүүлгийн асуултууд**

Бурханд өөрийгөө зориулах нь амьдралын хэв маягтаа өөрчлөлт хийхэд хүргэдэг. Суралцагчдыг энэ талаар тунгаан бодохыг уриалаарай.

► Таны дадал, зуршлууд таны бие махбод Бурханд харьяалагддаг гэдгийг харуулж чаддаг уу?

Итгэгчдийн баримтлах хоолны дэглэм юмуу, бусад хориглох дүрэм журмын талаар урт удаан хэлэлцүүлэг, маргаан хийхээс зайлсхийгээрэй.

► Та яагаад зарим бодис хэрэглэдэггүйгээ хүнд яаж тайлбарлах вэ?

### **Залбирал**

Тэнгэрлэг Эцэг минь,

Биднийг эхлээд газар дэлхийд, дараа нь тэнгэрийн улсад амьдрах гайхамшигт боломжийг өгсөнд баярлалаа.

Та намайг бүтээж, нүглээс зольж авсан гэдгийг сайтар ухаарч, өөрийгөө Танд бүрэн зориулж амьдрахад минь туслаач.

Танд үйлчлэх, мөргөн хүндэтгэхэд минь саад болох аливаа зүйлсээс намайг хол байлгаж өгөөч.

Таны Ариун Сүнсний сүм байх эрхэм хувь тавилангийнхаа төлөө Танд маш их талархаж байна. Би Таныг өргөмжилсөн амьдралаар амьдармаар байна.

Амен

### 13-р хичээлийн даалгавар

(1) Дараах асуултуудын хариуг хувийн тэмдэглэл дээрээ бичээрэй (Үүнийг ангийн удирдагчдаа хураалгах шаардлагагүй).

- Та өөрийгөө Бурханд бүрэн зориулдаг уу? Бурханд өөрийгөө бүрэн зориулна гэж юу гэсэн үг вэ?
- Өөрийг чинь махбодын дур тачаалд уруу татдаг төрөлхийн ямар хүсэл танд байдаг вэ?
- Эдгээр уруу таталтыг ялж гарахад чинь туслах Библийн цээжилсэн эшлэлээсээ 2 юмуу 3-ыг бичнэ үү!
- Энэ хичээлийг үзэж байх явцад Бурханд танд ямар өөрчлөлт хийх ёстой гэж сануулсан бэ?

(2) 1 Коринт 15-р бүлгийг судал. Эхлээд жижиг сэдэв бүрээр нь хэдэн хэсэгт хуваа. Хэсэг тус бүрийн гол санааг тайлбарлан догол мөрөнд бичээрэй. Энэ хичээлтэй холбоотой амьдралд хэрэгжүүлж болох ямар заавар чиглүүлэг байна вэ?



# Санал болгох эх сурвалжууд

Энэ хичээлийн сэдвүүдийг гүнзгийрүүлэн судлахыг хүсвэл дараах эх сурвалжуудыг ашиглаарай.

## **1-р хичээл – Христитгэлийн үнэнч байдал**

McDowell, Josh, and Bob Hostetler. *Right from Wrong*. Nashville: W Publishing Group, 1994.

Sider, Ron. *The Scandal of the Evangelical Conscience*. Grand Rapids: Baker Books, 2005.

## **2-р хичээл – Бурханд дуулгавартай байдлыг хэрэгжүүлэх нь**

Keep, Tim and Becky. *It's All about Obedience*. Shoals: Whispering Pines Publishing, 2016.

*Spiritual Formation* (course from Shepherds Global Classroom). Available online or in print at: <https://www.shepherdsglobal.org/courses>

## **3-р хичээл – Ажил**

McQuilkin, Robertson. *An Introduction to Biblical Ethics*. (Second Edition). Wheaton: Tyndale House Publishers, Inc., 1995.

## **4-р хичээл – Харилцаа**

Chapman, Gary. *The Five Love Languages*. Chicago: Northfield Publishing, 2015.

Carnegie, Dale. *How to Win Friends and Influence People*. New York: Pocket Books, 1936.

## **5-р хичээл – Бурханы удирдамж**

Duewel, Wesley. *Let God Guide You Daily*. Greenwood, IN: One Mission Society, 1988.

## **6-7-р хичээл – Гэрлэлт**

Drescher, John. *For Better, For Worse*. Morgantown, PA: Masthof Press, 2012.

Eggerichs, Emerson. *Love and Respect*. Nashville: Thomas Nelson, 2004.

Thomas, Gary. *Sacred Marriage*. Grand Rapids: Zondervan, 2000.

## **8-р хичээл – Христитгэл ба байгаль орчин**

Schaeffer, Francis, Udo W. Middelman, Lynn White Jr., and Richard Means. *Pollution and the Death of Man*. Wheaton: Tyndale House, 1970.

### **9-р хичээл - Мөнгө**

Ramsey Dave. *The Financial Peace Planner*. New York: Penguin Books, 1998.

Wesley, John. "The Use of Money" (номлол). Цахимаар дараах линкээр хандах боломжтой <https://holyjoys.org/john-wesley-on-the-use-of-money/> (2022 оны 10 сарын 12-нд хандсан).

### **10-р хичээл – Шударга байдал**

Covey, Stephen M. R. *The Speed of Trust: The One Thing that Changes Everything*. New York: Free Press, 2006.

### **11-р хичээл – Хүмүүний үнэ цэн**

Lewis, C. S. *The Abolition of Man*.

Colson, Charles and Nancy Pearcey. *How Shall We Now Live?* Wheaton: Tyndale House Publishers, 1999.

### **12-р хичээл – Төр засаг**

Schaeffer, Francis. *A Christian Manifesto*. Wheaton: Crossway Books, 1981.

### **13-р хичээл – Итгэгч хүний бие махбод**

Foster, Richard. *Celebration of Discipline*. New York: HarperCollins Publishers, 1978.

## Даалгаврын тэмдэглэл

Суралцагчийн нэр \_\_\_\_\_

Дараах хүснэгтэд даалгавар бүрийг бүрэн хийж дуусгасан өдрөө тэмдэглээрэй. Shepherds Global Classroom байгууллагаас гэрчилгээ авахын тулд бүх даалгаврыг амжилттай гүйцэтгэсэн байх ёстой.

Хичээл	Даалгавар 1	Даалгавар 2	Даалгавар 3
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			
9			
10			
11			
12			
13			

Shepherds Global Classroom байгууллагаас төгсөлтийн гэрчилгээ авах өргөдлийг манай [www.shepherdsglobal.org](http://www.shepherdsglobal.org) вебсайтаар орж бөглөх боломжтой. Суралцагчдынхаа өмнөөс өргөдөл илгээсэн багш, сургагч нарт SGC байгууллагын ерөнхийлөгч төгсөлтийн гэрчилгээг цахим хэлбэрээр илгээх болно.